ЧИНГИС ХААНЫ НЭРЭМЖИТ
ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ИХ ЗАСАГ

СЭТГҮҮЛ № 20

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

ЧИНГИС ХААНЫ НЭРЭМЖИТ
ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ИХ ЗАСАГ СЭТГҮҮЛ

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

№20

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч: Доктор (Sc.D), профессор Ж.Цэцэгмаа
Нарийн бичгийн дарга: Доктор (Ph.D), дэд профессор Д.Одгэрэл
Зөвлөлийн гишүүд: Доктор (Ph.D), дэд профессор Г.Туяа
Доктор (Ph.D), профессор Ц.Цэлмэг

СЭТГҮҮЛИЙН ХАЯГ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Б.Доржийн гудамж, Их Засаг Олон Улсын их сургууль,
Улаанбаатар-210349, шуудангийн хайрцаг-349
Тел: +976-70157761,70157767
Факс: +976-70155736
Э.шуудан: publisher.ikhzasag@gmail.com

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

DDC 378.04'517
Ц-976

ИХ ЗАСАГ СЭТГҮҮЛ

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

№20

Хянан тохиолдуулсан: Доктор (Sc.D), профессор Ж.Цэцэгмаа
Эмхэтгэсэн: Доктор (Ph.D), дэд профессор Д.Одгэрэл
Хэвлэлд бэлтгэсэн: О.Золбоо
Цаасны хэмжээ: 210*297мм
Хэвлэлийн хуудас: 17,5хх
Хэвлэсэн газар: «SPR» ХХК

Их Засаг сэтгүүл
© ИЗОУИС

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

Улсын бүртгэлийн дугаар: 650
ISBN: 978-99929-3-077-2

АГУУЛГА

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

■ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛ 5

Р.БУЛГАМАА
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нөхцөл /Хүчиндэх гэмт хэргийн жишээн дээр/ 5

Б.ГАНБАТ
Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх түвшин, эдгээрийг өнгөөр ялгах асуудал 8

Б.ЖАРГАЛСАЙХАН
Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын үүсэл хөгжлийн асуудал 12

М.НАРАНЦЭЦЭГ
Цахим орчин дахь зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтанд тулгамдаж буй зарим асуудал 16

Д.МАЙЦЭЦЭГ
Байгаль орчны салбар дахь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, эрх зүйн орчны төлөв байдал, тулгамдсан асуудал 20

Г.НАРАНБААТАР
Олон улсын эрх зүйн хэм хэмжээг өмгөөллийн үйл ажиллагаанд хэрэглэх нь 26

Ц.ЦЭЛМЭГ
Оросын Холбооны Улс болон Монгол Улсын эрүүгийн хуулийн харьцуулсан судалгааны зарим асуудал 30

С.ӨӨДЛӨХ
Ашигт малтмалыг эрүүгийн хуулиар хамгаалах шаардлага, тулгамдсан асуудал 34

Т.САЙНБАЯР
Ашигт малтмалыг хамгаалж, ашиглаж ирсэн монголын хууль цаазын түүхэн уламжлалыг судалсан нь 39

А.ХАНДМАА, Н.ЦЭДЭНБАЛЖИР
Бүгд Найрамдах Хятад Ард Улсын шинэ эрин үеийн хуульчийн мэргэжлийн ёс зүйг судлах нь 45

Г.ХИШИГСҮРЭН
Тэнсэх институтын шинэлэг зохицуулалт, үр нөлөөг дээшлүүлэх арга зам 49

Г.ХИШИГСҮРЭН
Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хохирлыг тооцох, хохирлыг барагдуулах арга зам 53

■ ТҮҮХ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ 56

БАНЗАР
Найман зуун жилийн өмнөх агуу хүн Чингис хааны төрсөн нутгаар аялсан нэг удаагийн ганзага дүүрэн хээрийн дадлага 56

Ж.ЦЭЦЭГМАА
Жамсрангийн Цэвээн-Монголын боловсрол, шинжлэх ухааны байгууллагын үндэслэгчдийн нэг болох нь 62

Д.ЧИНБАЯР
ЗХУ-ын гадаад бодлогод дипломатч Г.В.Чичериний гүйцэтгэсэн үүргийн тухай 67

Х.ТӨМӨРБААТАР
Хабул хаан Монгол Улсын анхны хаан мөн үү? 71

БОЛОВСРОЛ СУДЛАЛ, ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ЧИГЛЭЛ **74**

Л.БАТТОГТОХ
Сургалтын орчин дахь багш нарын хамтын ажиллагаа тулгамдаж буй асуудал 74

А.БИБИШ, Д.ЭЛБЭГЗАЯА
Багшийн хөгжилд тулгамдаж буй асуудлууд 76

В.МАНДУХАЙЦЭЦЭН
Багш нарын сэтгэлгээг шинэчлэхэд ахмад багш нарын үүрэг оролцоо 80

Б.ИНДРА
Багшийн ёс зүй, түүнд тулгамдаж буй асуудлууд 87

Б.МӨНГӨНТУЯА
Багшийн бүтээлч чадварыг дээшлүүлэх зарим арга 92

Ч.ОТГОНЧИМЭГ
Англи хэлний сургалтад дуу, дүрсний хэрэглэгдэхүүн болон техник хэрэгсэл ашиглах нь 94

Н.ТУНГАЛАГТАМИР, С.ТҮМЭНДАРЬ
Дээд боловсролын шинэчлэл- тулгамдсан асуудал 98

Н.ТУУЛ
Авиан зүйн тухай 102

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, АНАГААХ УХААНЫ ЧИГЛЭЛ **105**

М.ТУНГАЛАГ
Зүрхний бичлэгийн чанарт боловсруулалт хийх 105

Э.ТЭЛМҮҮН, Ж.ОЮУН
Зарим номхотгоогүй эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн химийн эрдэсжилтийн судалгаа 110

ШИНЭ НОМЫН ТАНИЛЦУУЛГА БУЛАН **113**

Их Засаг олон улсын их сургуулийн багш нарын шинэ номын танилцуулга

ЧӨЛӨӨТ БУЛАН **114**

Хорвоогийн сонин хачинаас

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛ

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

/Хүчиндэх гэмт хэргийн жишээн дээр/

Р.Булгамаа

Их Засаг ОУИС-ийн докторант, өмгөөлөгч

Тулхүүр үг: Хүүхдийн бэлгийн халдашгүй байдал, хүчиндэх гэмт хэрэг, бага насны хүүхдийн эсрэг хүчирхийлэл.

Гэр бүлийн хүчирхийлэл нь жендерийн асуудалтай ямагт холбоо, хамааралтай байдаг бөгөөд хохирогчдын 90 хувь нь эмэгтэйчүүд байдаг. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлд шууд болон дам хохирогч болох хүүхдийн эрх ашиг байнга хохирч байгааг дагнан судлах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хүчирхийлэл нь зөвхөн гэр бүлийн хүрээний асуудал бус нийгмийн глобал асуудал бөгөөд зөвхөн хүүхэд эмэгтэйчүүд төдийгүй нийгэм тэр чигээрээ өртөж байдаг онцлогтой. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, амьдралын баяр баясалгүй, өөртөө итгэх итгэлгүй, амьдявах хүсэлгүй болж байгаа нь ирээдүйд гэр бүл зохиохгүй байх, үр хүүхэдтэй болохоос татгалзах зэрэг олон сөрөг нөлөөлөл үзүүлдэг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь нэг хүний ганц удаагийн санамсаргүй, тохиолдлын зан үйл бус тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл төдийгүй бусдыг зовоон тарчлаах гэмт хэрэг гэж судлаачийн зүгээс үздэг.

Өөрөөр хэлбэл хүмүүс /голчлон эрэгтэй нь эмэгтэйгээ/ нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоон, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцааг гэр бүлийн хүчирхийлэл гэнэ./1/

Хэн нэгэн этгээд өөрийн хүч, эрх мэдэл, бие махбодын болон бусад давуу байдлаа ашиглан хүүхдийн халдашгүй байх эрх,эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар завдсан, хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүйг "Хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэж болно. /2/

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нийгэм,сэтгэл хөдлөл, сэтгэл зүйн хохирол амсах, хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх, эрт бэлгийн харилцаанд орох, сэтгэл зүйн дарамтанд орох, ой тогтоолт нь буурах, эмх цэгцээ алдах, түрэмгийн зан авиртай болох, уушиг зүрх,элэгний өвчлөл,бэлгийн замаар дамждаг өвчнүүд,үр зулбах зэрэг сөрөг үр дагаваруудтай.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь ямагт санаатай үйлдэгддэг бөгөөд бие махбодийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, үл хайхрах хүчирхийлэл гэсэн 4 төрөлтэй байна.

Бие махбодийн хүчирхийлэл: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед ямар нэгэн хэмжээгээр халдах, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэл байна./3/

Илрэх хэлбэр нь хүүхдийг алдаа гаргасан, буруу зүйл хийсэн, үгэнд ороогүй, хүмүүжүүлэх гэсэн шалтаг, шалтгаанаар алгадах, зодох, чимхэх зэрэг хөнгөнөөс хүнд хэлбэрийн тарчлаан зовоох шинжтэй өндрөөс шидэх, түлэх, гадаа зогсоох, зүсэх зэргээр хүүхдийн бие махбодод олон тооны гэмтэл шарх, сорви, бэртэл үүсэх байдлаар илэрнэ.

Сэтгэл санааны хүчирхийлэл: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд өөрийн хүч давуу байдлаа ашиглан үг хэл,үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтад оруулсаныг, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. /4/

Илрэх хэлбэр нь хүүхдийг дорд үзэж тохуурхах, нэр хоч өгөх, байнга шүүмжлэх, доромжлохоос эхлэн хараах, найз нөхдөөс нь салгах, ганцаардуулах, гадуурхах, шоовдорлох, хянаж цагдах зэргээр нийгмээс тусгаарлах, айлган сүрдүүлэх, заналхийлэх, гүтгэх, өөрийн үзэл бодлоо тулгах зэрэг сэтгэл зүйн хувьд амгалан байх нөхцлийг үгүй хийх зэрэг байдлаар илэрдэг.

Бэлгийн хүчирхийлэл: Хүүхдийн бэлгийн халдашгүй дархан байдлыг зөрчсөн, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу

татсан, шаардсан, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйг ойлгоно. Энэ хүчирхийлэл нь хүүхдийн эсрэг онцгой хүнд хэлбэрийн хүчирхийлэл бөгөөд ихэвчлэн насанд хүрсэн хүмүүс тэр дундаа гэр бүлийн хамаарал бүхий хүмүүс үйлдэж байгаа нь судалгаанаас харагдлаа./5/

Бэлгийн хүчирхийлэл нь хүрэлцэх болон үл хүрэлцэх гэсэн хэлбэрээр илэрдэг ба хүчирхийлэгчид заль мэх гаргах, хуурч мэхлэх аргаар хүүхдийг хүчирхийлдэг.

Хүүхдийг гомдол гаргахгүй, дуугүй байлгахын тулд янз бүрийн арга хэрэглэдэгээс дурдвал "ингэж тоглодог юм,энэ эрхтэндчинь байгаа бондгор зүйлийг авах гээд үзье" гэхчлэн хэлдэг нь шүүхийн тогтоолд дурдагдсан бөгөөд хэрэв чи энэ талаар хүнд хэлбэл хэн ч чамд итгэхгүй, хүүхдүүд чамайг шоолно, ээж чинь мэдвэл бид гэрээсээ хөөгдөх болно гэх зэргээр дарамталдаг./6/

Хүүхэд өсөж томрохын хэрээр арга барил нь нарийсч бодит байдлыг эрс гуйвуулдаг ч өөрт нь тохиолдсон асуудал жирийн бус зүйл болохыг ойлгож эхэлдэг.

Үл хайхрах хүчирхийлэл: хэн нэг этгээд хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж аюулгүй байдлыг хангах зэрэг суурь хэрэгцээг гачигдуулсаны улмаас хүүхдэд гэм хор учирсан,учруулахаар завдсан,эсхүл энэхүү нөхцөл байдлыг нь мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй санаатай болон хайхрамжгүй байдлаар илэрнэ.

Эрүүл мэндийн хувьд үл хайхрах, бие махбодын хувьд үл хайхрах, сэтгэл санааны хувьд үл хайхрах,боловсролын хувьд үл хайхрах,хүүхдийг эрсдэлд оруулах нөхцөл бүрдүүлэх зэрэг хэлбэрээр илэрдэг.

Хайр халамжаар дутаж байгаа хүүхдийн шинж тэмдэг нь өлсгөлөн байх, хог түүх, хувийн ариун цэвэр муу,байнга бохир хувцастай байх,ядруу дорой царайлах, хайр халамж хүссэн байдалтай байх, цаг агаарт тохиромжгүй хувцаслах, бусдыг үзэн ядах зэрэг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 530 хоригдол байгаа нь нийт ялтны 15 орчим хувийг эзлэж байна./7/

Тэдгээрээс 0-14 хүртэл насны буюу бага насны хүүхдийг хүчиндсэн 387 хүн, 15-18 насны хүүхэд хүчиндсэн 63 хоригдол, 18-с дээш насны хүнийг хүчиндсэн 80 хоригдол тус тус ял эдлэж байна.

2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 18 хүн амиа алдсан, 953 хүн гэмтэж иргэдэд 929 сая төгрөгийн шууд хохирол учирсан нь өмнөх онтой харьцуулбал нас барсан хүн 2,3 дахин,гэмтсэн хүн 31 хувь,учирсан хохирол 57,7 хувиар өсжээ. /8/

Монгол Улсын хувьд дэлхийн улс орнуудад тархаад буй Covid-19 цар тахлын нөхцөл байдал бага насны хүүхдийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байгааг дараах судалгаанаас харж болно. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тоон мэдээнд хүчиндэх гэмт хэргийн улмаас шинжилгээ хийлгэсэн хохирогчдын 45,6 хувь нь буюу 881 нь 0-18 насны хүүхэд, 108 тусламжийн утсанд 2014 онд 46,2015 онд 131,2016 онд 169, 2017 онд 214, 2018 онд 253, 2019 онд 277, 2020 онд 210 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай дуудлага мэдээлэл ирсэн байна./9/

Энэ нь зөвхөн мөсөн уулын орой буюу бүртгэгдсэн,мэдээлэгдсэн тоо бөгөөд нуугдмал гэмт хэргийг тооцвол энэ тоо даруй 3-10 дахин өснө. /10/

Бага насны хохирогчдын 26,3 хувь нь бэлгийн хүчирхийлэлд давтан өртсөн, үүнээс 30,4 хувь нь 3-7 жилийн хугацаандбэлгийн хүчирхийлэлд байснаас үзэхэд бага насны хохирогч нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн дарамтанд орж үйлдэгдсэн хэргийн талаар хүндхэлэхгүй байх,хэлбэл ойр дотны хүмүүст нь муу зүйл болохоор сурдүүлэх, дарамтлах нь хүүхдийн сэтгэлзүйд хүчтэй нөлөөлдөг бөгөөд хохирогч болсоноо бусдаас удаан хугацаагаар нуух, ичих,айх зэрэг байдлаас шалтгаалж гэмт этгээдийн халдлагад дахин өртөх, бие махбодын болон сэтгэл зүйн хүнд хор уршиг бий болгох зэрэг нөхцөл бүрддэг байна.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч нь нуугдмал, далд орчинд үйлдэгддэг гэмт хэргийн халдлагад өртсөний улмаас өөрсдийнхөө аюулгүй байдал, хамгаалалтанд эргэлзэж сэтгэл зүйн дарамтанд байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Бэлгийн хүчирхийллийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхдээ хохирогчийн нэрийг дурддаггүй ч оршин суугаа хаяг, анги, сургууль, нас, эцэг эхийн нэр зэрэг мэдээллийг оруулсанаар цөөхөн хүн амтай суурин газарт хохирогч хэн болохыг таних, тааварлах боломжтой байгаа нь хохирогч цаашид энгийн амьдралын хэв маягтаа эргэн орох,шинэ хүрээлэлд ороход том саад болдог.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад хүүхдийн эрх байнга зөрчигдөж нийгмийн хамгааллаас гарах, гадуурхагдах, хүчирхийлэл үйлдсэн гэм буруутай этгээдэд хариуцлага тооцохгүй байх явдал нь түгээмэл байна. Хүүхдийг бие махбодын болон бэлгийн,сэтгэл санааны хувьд дарамтлах,үл ойшоох, хайхрамжгүй байх зэрэг нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд бөгөөд гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн ихэнх нь гэр бүлийн хүрээнд ойр дотны хүний бэлгийн хүчирхийлэлд өртжээ.

Тухайлбал, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл 2019 оноос 2020 он хүртэл нэг жилийн хугацаанд 15,6 хувь өссөн байгаагаас 0-14 насны буюу бага насны хүүхэд хүчирхийлэлд өртсөн хэрэг илүүтэй өсжээ.

Энэ нь гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийг улам даамжруулах эрсдэлтэй бөгөөд хүүхэд төрсөн болон хойд ээж аавдаа зодуулах, хүчирхийлэлд өртөх нь байж болох үзэгдэл хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага нь хүчирхийллийг даамжруулж далд үйлдэгдэх нөхцлийг нэмэгдүүлж байна.

САНАЛ

Хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэргийн халдлагад өртсөн хохирогчдын хувьд чөлөөтэй ярилцах,хууль зүйн туслалцаа авах хүн нь өмгөөлөгч тул өмгөөлөгч нарыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж өмгөөлөгчийг мэргэшүүлэх шарадлагатай байна.

Хүүхэд нь өөрсдийн хохирсон талаар мэдэх, мэдээлэх үйл явц нь хязгаарлагдмал тул “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулийн 19 дүгээр зүйлд заасан “гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа бол хамгаалуулах эрх үүснэ” гэснийг хэрэгжүүлэхийн тулддараах зүйлийг судлах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн нөхцлийг заавал тогтоож хэвшүүлэх ёстой. Үүнд:

-хохирогчийн хууль ёсны төлөөлөгч үүргээ биелүүлж чадаж байгаа эсэх, мөн төлөөлөх боломжгүй нөхцлийн талаар судлах;

-эрсдэлтэй, эргэлзээ бүхий үндэслэл буюу хохирогч сэтгэл зүйн хувьд тогтворгүй, мэдүүлэг өгөх чадваргүй,айдастай байгаа эсэхэд үнэлэлт өгөх;

-хууль ёсны төлөөлөгч нь гэр бүл, төрөл садангийнхаа нэр төрийг хамгаалахаар хохирогчид нөлөөлөх нөхцөл тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хууль ёсны төлөөлөгчийн ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоолгох хүсэлт гаргаж биелэлтийг хангуулж үр дүнг тооцдог байх;

-хүчирхийллийн халдлагад өртсөн бага насны хүүхдийг халдлагад өртсөн орчноос тусгаарлах, сум хорооны Засаг даргаар ахлуулсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн үүрэг,оролцоог нэмэгдүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

1. Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл. Гарын авлага,УБ хот,2016 он
2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн судалгаа Даваасүрэн. Д, Энхжин. Э, Нансалмаа.Ш ГССҮТ-ийн НЭМА.
3. https://safefuture.mn веб хуудас. Хүүхдийн эсрэг үндэсний төвийн хийсэн судалгаа
4. ЭМЯ, ХЭҮТ, ДЭМБ, Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн монгол дахь байдал Улаанбаатар, 2007 он
5. ХЭҮТ, ГССҮТ-ийн НЦҮ, Нийслэлийн цагдаагийн урьдчилан сэргийлэх алба,ХЭҮТ–ийн харъяа Улаанбаатар хотдах эмэгтэйчүүдийн хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн бүртгэлд хийсэн анализ,Улаанбаатар,2007
6. ГССҮТ, ГССҮТ-ийн НЦҮйлчилгээний төвийн сүүлийн 3 жилийн хохирогч даван туулагчийн тоон мэдээлэл,2016 он.
7. ГССҮТ, UNFPA,Гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэгдэх оролцоо, нөлөөлөл, цаашдийн чиг хандлага,Улаанбаатар, 2014 он.
8. ДЭМБ,Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ, Улаанбаатар,2010 7. Батхишиг.А, Мягмар.О, Нямдорж.М, Хүүхэд хамгааллын үйлчилгээ, Улаанбаатар,2009
9. ЭМЯ, ДЭМБ, Гэмтэл согог сэргээн засах клиникий нэмнэлэг,МУ дахь хүчирхийлэл ба эрүүл мэндийн тухай илтгэл,Улаанбаатар,2006
10. Ц.Цэлмэг. Криминологи. УБ хот,2015 он.

ГАМШГИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ ТҮВШИН, ЭДГЭЭРИЙГ ӨНГӨӨР ЯЛГАХ АСУУДАЛ

Б.Ганбат
Их засаг ОУИС-ийн Чингис Соосэ ОУХС-ийн АБХС-ын ахлах багш, бэлтгэл хурандаа

Түлхүүр үг: гамшиг, өнгө

Хураангуй: Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээг хүлээн авдагтайн адил цар тахлын үеийн мэдээ мэдээлэл, урьдчилан сэргийлэх мэдээллийг өнгөөр ялган илэрхийлэхад чиглэгдэнэ. Цар тахлын үеийн мэдээллийг түр журмаар биш Гамшгаас хамгаалах тухай хуульд тусгах шаардлагатай байна.

1. Олон улсад гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио хүргэх түвшин, өнгө

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулахын мөн чанар тухайн аюулд өртөх магадлалтай хүн ам аюул тулгарсан үед амь нас, эрүүл мэндээ хамгаалах оновчтой арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх төдийгүй хүн ам тухайн зарлан мэдээллийн дохиог сайтар ойлгодог байхад оршино.

Хүн амд зарлан мэдээлэх ажиллагаа нь тухайн эрсдэлтэй хүн ам аюулгүй байдлаа хангах арга хэмжээг шуурхай, оновчтой авах боломжийг бүрдүүлсэн урьдчилан мэдээлэх ба түгшүүрийн дохионы нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

Зарлан мэдээллийн дохионы өнгө нь эрсдэлд байгаа хүн амд тухайн нөхцөлд аюулгүй байдлаа хангах ямар арга хэмжээ авах шаардлагатайг оновчтой мэдээлнэ.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах олон түвшин байна. Эдгээрээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэлбэр нь анхаарал хандуулах, ач холбогдол өгөх түвшнээрээ эрэмблэгдсэн watch-сэрэмжлүүлэх, warning-анхааруулах болон alert-түгшүүрийн гэсэн 3 түвшин юм. Эдгээр нь мөн харилцаа холбооны хэрэгслээр дамжуулагдахдаа ихэвчлэн ногоон, шар ба улаан гэсэн өнгөөр илэрхийлэгдэх нь түгээмэл. Улаан нь хамгийн чухал үе шатыг илэрхийлэх ба энэ хэлбэрээр зарлан мэдээллийг дамжуулахдаа тухайн өнгөний талаарх нийгмийн болон хүн амын дундах ойлголт, соёлын ялгааг харгалзаж үзэх шаардлагатай[1].

Олон улсын цөмийн ба цацрагийн ослын зэрэглэлийг тогтоох ангилалд тохиолдол ба осол гэсэн 2 түвшин, ердийн нөхцөлөөс томоохон осол хүртэлх 7 дэд түвшинд зэрэглэж ногоон, шар, улаанаас тогтсон өнгөөр ялгасан 7 дэд түвшинтэй байна[2].

Энэтхэгийн Гамшгийн менежментийн газраас гаргасан Байгалийн гамшгийн хор уршгийг арилгах төлөвлөгөөнд Гамшгийн аюулын зарлан мэдээллийг хүргэх түвшингийн зэрэглэлийг дараах байдлаар ангилсан байна[3].

Түвшин ба өнгөний код	Мэдээлэх хугацаа	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Улаан—Warning—Анхааруулах	Засгийн газарт болон нийтэд 3 цаг тутамд шинэчилж мэдээлэх ба шаардлагатай тохиолдолд үүнээс богино давтамжтайгаар мэдээлэх	Бүх байгууллагууд мэдээллийг нэн даруй дамжуулж цаашид 20 минут тутамд нөхцөл байдлыг тодруулна.
Улбар шар — Alert — Түгшүүр	Засгийн газарт болон нийтэд 12 цаг тутамд шинэчилж мэдээлэх ба улаан түвшинд хүрвэл хугацаа харгалзахгүй мэдээлэх	Бүх байгууллагууд мэдээллийг хүлээн авч бэлэн байдалд ажиллана. 30 минут тутамд нөхцөл байдлыг тодруулж ажиллана.
Шар — Watch—Сэрэмжлүүлэх	Засгийн газарт мэдээлэл хүргэхгүй.	Шуурхай удирдлагын төв орон нутагт мэдээлэл дамжуулна. Холбогдох яамд, төрийн байгууллагад мэдээлэл хүргэж шаардлагатай арга хэмжээ авахад бэлтгэнэ.

1 *UNESCAP/WMO (2014). Manual on Synergized Standart Operating Procedures (SSOP) for Coastal multi-hazards Early Warning System. p.11*
2 *International nuclear and radiological event scale (INES) www-ns.iaea.org/tech-areas/emergency/ines.asp*
3 *Disaster management Division. Ministry of Home Affairs (2010) Standart Operating Procedures for Responding to natural disasters. p.73*

Тус улсын хувьд байгалийн гамшгийн төрөл тус бүрээр зарлан мэдээлэл дамжуулах ангилал, шалгуурыг ялгаатай байдлаар тогтоож өгсөн.

Европын холбооны улс орнуудад ус цаг агаарын гаралтай аюултай үзэгдлийн зарлан мэдээллийг нийтэд дараах хэлбэрээр хүргэдэг байна.

Зарлан мэдээлэх дараах 3 ангилал/ түвшинтэй[4]. Үүнд:

Шар түвшин – сэрэмжлүүлэх (**Be Aware**) –эрсдэлтэй хүн амд мэдээлэл хүргэж, сэрэмжлүүлэх утгатай. Шар түвшин тухайн аюулт үзэгдэл хүн амд шууд нөлөө үзүүлэхгүй, харин газар нутаг, үйл ажиллагаа нь өртөж болзошгүйг илэрхийлнэ.

Улбар шар түвшин – бэлэн байх (**Be Prepared**) – өртөж байгаа газар нутгийн хүн амд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлэхүйц цаг агаарын нөхцөл үүссэнийг анхааруулах утгатай. Улбар шар түвшин тухайн газрын бүх хүн амыг үүсч болзошгүй нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах бэлэн байдлаа хангах шаардлагатайг илэрхийлнэ.

Улаан түвшин - арга хэмжээ авах (**Take Action**) – хүн амыг амь нас,эд хөрөнгөө хамгаалж аюултай бүсээс түр нүүх, гадагшаа гарахгүй байх зэргээр тохирох арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх ёстойг илэрхийлнэ.

Олон улсын туршлагаас харахад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх 3 түвшин,эдгээр нь ногоон, шар, улбар шар, улаан гэсэн өнгөөр илэрхийлэгдэх нь түгээмэл байна.

Зарлан мэдээллийн дохионы өнгөний томъёоллыг хэрхэн хийх талаар олон улсын стандартын байгууллага нь Guidelines Color coded alert ISO 22324:2015 гэсэн стандартыг батлан гаргасан. Тус стандарт нь аюулын түвшинг илэрхийлэх өнгөний код, нэмэлт мэдээлэл өгөх өнгөний код, хүний хүчин зүйл, өнгөний сохрыг зарлан мэдээллийн дохио өгөхөд харгалзах нь гэсэн 3 дэд хэсгээс бүрдсэн. Тус байгууллага энэхүү стандартыг ямар ч оронд,мөн бүх төрлийн аюулын үед хэрэглэж болно гэж тодорхойлжээ. Иймд тус стандартыг цаашидөөрийн орны онцлогт нийцүүлэн ашиглах боломжтой.

2. Монгол орны гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио өгөх хэлбэр

Одоогоор манай улсад болзошгүй аюулт үзэгдэл,гамшгийн талаар хүн амд зарлан мэдээлэл хүргэх чиглэлээр МУ-ын Засгийн газрын 2 тогтоол мөрдөгдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339 тоот тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх" журамд "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл" гэж хүн амд учирч болзошгүй гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг төвлөрсөн мэдээллийн хэрэгсэл,тусгай хэрэглээний холбоо, орон нутгийн болон олон нийтийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр нэн даруй хүргэхийг хэлнэ гэж тодорхойлсон. Тус журамдгамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дараахь байдлаар ангилсан байна. Үүнд:

- гамшгийн аюулын тухай дохио;
- сэрэмжлүүлэх мэдээлэл.

"Гамшгийн аюулын тухай дохио" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас үүссэн гамшгийн хохирлыг бууруулж,хүний амь нас,эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор бий болсон нөхцөл байдлыг зарлан мэдээллийн хэрэгслээр богино хугацаанд оновчтой хэлбэрээр мэдээлэх, "Сэрэмжлүүлэх мэдээлэл" гэж мэргэжлийн байгууллагын дүгнэлт, мэдээллийн үндсэн дээр болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор зарлан мэдээллийн хэрэгслээр урьдчилан мэдээлэх гэж тус тус тодорхойлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 286 дугаар тогтоолоор батлагдсан "Ус, цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам"-д Цаг агаарын урьдчилсан мэдээг

- урьдчилан сэргийлэх
- сэрэмжлүүлэх
- анхааруулах
- өдөр тутмын

гэж 4 түвшинтэй байхаар тодорхойлжээ.

Монгол оронд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах арга хэлбэрийг тодорхойлсон эдгээр баримт бичгүүдэд гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дохиог анхаарал хандуулах, ач холбогдол өгөх түвшнээр нь эрэмбэлж үзвэл:

- гамшгийн аюулын тухай дохио;
- урьдчилан сэргийлэх мэдээ
- сэрэмжлүүлэх мэдээ
- анхааруулах мэдээ
- өдөр тутмын мэдээ

гэсэн түвшингүүдэд хуваагдаж байна.

4 http://www.met.ie/nationalwarnings/warnings-explained.asp

Эдгээр түвшингүүдийг олон улсад ашиглагддаг түвшинтэй харьцуулан өөрийн орны онцлогт тохируулан хүн амд зарлан мэдээллийн дохио дамжуулах түвшин, 5g өнгөний кодыг дараах байдлаар тодорхойлох боломжтой гэж үзэж байна (1-р хүснэгт).

Зарлан мэдээллийн дохионд анхаарал хандуулах ач холбогдлоор нь гамшгийн аюулын тухай дохио нь хүн амыг нэн даруй аюулгүй байдлаа хангах арга хэмжээ авах шаардлагатайг илэрхийлж улаан өнгөөр, урьдчилан сэргийлэх мэдээ нь хүн амыг үүсч болзошгүй нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах бэлэн байдлаа хангах шаардлагатайг илэрхийлж улбар шар өнгөөр, сэрэмжлүүлэх мэдээ нь аюул өртөж болзошгүй анхаарал, сэрэмжээ дээшлүүлэх хэрэгтэйг илэрхийлж ногоон өнгөөр гэж дараалуулан өнгөөр ялгаж дамжуулах нь тохиромжтой гэж үзэв.

1-р хүснэгт. Гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах түвшин, өнгөний код

Өнгөний код	Зарлан мэдээлэх дохио дамжуулах төлөв	Зарлан мэдээлэл хүргэх хэлбэр	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	
			Онцгой байдлын алба, гамшгаас хамгаалах улсын алба, нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага	Иргэд
Улаан	Аюулын тухай дохио **alert**	Үүссэн гамшгийн хохирлыг бууруулах зорилгоор бий болсон нөхцөл байдлыг зарлан мэдээллийн хэрэгслээр богино хугацаанд оновчтой хэлбэрээр мэдээлэх	Бүх нийтийн бэлэн байдалд ажиллана.	Аюулгүй байдлаа хангах арга хэмжээг нэн даруй авна. Төрийн болон мэргэжлийн байгууллагаас өгсөн зааварчиглэлийн дагуу ажиллана.
Улбар шар	Урьдчилан сэргийлэх мэдээ **warning**	Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ гэсэн дуут дохиотойгоор аюулт үзэгдэл эхлэх хүртэлх хугацаанд цаг тутам нийтэд мэдээлэх	Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллана.	Болзошгүй аюулаас амь нас, эд хөрөнгөө өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
Ногоон	Сэрэмжлүүлэх мэдээ **watch**	Болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор зарлан мэдээллийн хэрэгслээр урьдчилан мэдээлэх		Сэрэмжлүүлэх мэдээнд тусгагдсан аюулын хүрээнд анхаарал, сэрэмжээ дээшлүүлнэ.

Ихэнх улс орнууд гамшгийн төрөл тус бүрээр зарлан мэдээлэл дамжуулах ангилал, шалгуурыг ялгаатай байдлаар тогтоож өгсөн бөгөөд тухайн улс манай оронд тохиолддог гамшгийн төрлүүдээр дохио дамжуулах түвшин бүрт харгалзах шалгуурыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Манай оронд тохиолддог бусад гамшгийн төрөл тус бүрээр зарлан мэдээллийн дохио дамжуулах түвшин бүрт харгалзах шалгуур үзүүлэлтийг холбогдох шинжлэх ухааны болон төрийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдлаа.

Олон улсад гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах олон түвшин байна. Эдгээрээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэлбэр нь анхаарал хандуулах, ач холбогдол өгөх түвшнээрээ эрэмблэгдсэн watch-сэрэмжлүүлэх, warning-анхааруулах болон alert-түгшүүрийн гэсэн 3 түвшин юм. Эдгээр нь мөн харилцаа холбооны хэрэгслээр дамжуулагдахдаа ихэвчлэн ногоон, шар ба улаан гэсэн өнгөөр илэрхийлэгдэх нь түгээмэл байна. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 21 өдрийн 45 дугаар тогтоолоор Короновирус халдвар(ковид-19)-ын тархалтын түвшин тогтоох,хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журмаар халдварын тархалтыг 4 түвшингээр илэрхийлэн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд ажиллаж байна.

Зарлан мэдээллийн дохионд анхаарал хандуулах ач холбогдлоор нь эрэмблэн гамшгийн аюулын тухай дохио нь хүн амыг нэн даруй аюулгүй байдлаа хангах арга хэмжээ авах шаардлагатайг илэрхийлж улаан өнгөөр, урьдчилан сэргийлэх мэдээ нь хүн амыг үүсч болзошгүй нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах бэлэн байдлаа хангах шаардлагатайг илэрхийлж улбар шар өнгөөр, сэрэмжлүүлэх мэдээ нь аюулд өртөж болзошгүй анхаарал, сэрэмжээ дээшлүүлэх хэрэгтэйг илэрхийлж ногоон өнгөөр гэж дараалуулан өнгөөр ялгаж дамжуулах нь тохиромжтой гэж үзэв.

Цаашид түгээмэл тохиолддог гамшгийн төрлүүдээр зарлан мэдээллийн дохио дамжуулах түвшин бүрт харгалзах шалгуурыг боловсруулж мөрдөх, зарлан мэдээллийн дохионы өнгөний томъёоллыг хэрхэн хийх талаар олон улсын стандартын байгууллагаас батласан Guidelines Color coded alert ISO 22324:2015 стандартыг үйл ажиллагаандаа ашиглах хэрэгцээ байна.

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

Б.Жаргалсайхан
Их Засаг ОУИС-ийн Чингис Соосэ ОУХС-ийн ахлах багш
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Түлхүүр үг: шагнал, урамшуулал, хааны эрх,ашиг орлого

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хэдий үеэс оюуны өмчийг өмчийн түвшинд хүлээн зөвшөөрч хамгаалах болсон талаар болон түүнийг хамгаалах хэрэгцээ шаардлага урган гарсан шалтгаан нөхцлийн талаар гадаадын судалгааны ажил, ном бүтээлийг гол эх сурвалжаа болгон судаллаа.

ОРШИЛ: Дэлхийн улс орнуудын хөгжлийн шинэ гарцад оюуны өмчийг нэрлэж энэ талаар сонирхон судлагчид өсөн нэмэгдэж, ихэнх аж ахуйн нэгжийн оюуны өмчийн эрхийн эдийн засгийн үнэ цэнэ 70-иас дээш хувиар үнэлэгдэж[1] байгаа өнөө үед оюуны өмчийг түүхэн үүднээс судалсан энэхүү бэсрэг судалгаа сонирхон судлагч та бүхний судалгааны ажилд хувь нэмрээ оруулан гэдэгт найдаж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ: Оюуны өмч хэмээх ойлголт нь олон зуун жилийн түүхтэй бөгөөд ашиг орлого болон нэр алдар хүртэх гэсэн хүсэл эрмэлзэлтэй салшгүй холбоотойгоор үүссэн байна. Өөрөөр хэлбэл бүтээлийн зохиогчид шагнал, урамшуулал олгох тухай ухагдахуун нь дараах түүхэн үйл явдлаас эхлэлтэй юм. НТӨ IV зууны үед Грект улсдаа ашигтай нээлт хийсэн иргэнд нэр алдар хүртээх тухай хууль санаачилж байсан нь оюуны өмчийн анхны хууль зүйн ойлголт бий болсон хэмээн үздэг.[1] Тухайн үед Хипподомус /Hippodamus/ Аристотели хоёр "Милет[2] хотын төлөвлөлтийн тухай"[3] маргаан үүсгэж байсан тухай түүхэнд мөн тэмдэглэгдэн үлдсэн байдаг бөгөөд үүнийг оюуны өмчийн маргаан гэж эрдэмтэдүздэг.[4]

Оюуны өмчийн эрхийг төрөөс баталгаажуулж, системтэйгээр хамгаалах болсон нь Италийн сэргэн мандалтын үеэс эхтэй.[5] XI зууны Италийн сэргэн мандалтын үе нь шилэн бүтээгдэхүүнээрээ алдартай байсан бөгөөд Венецийн төрөөс шилэн бүтээгдэхүүний экспортыг идэвхтэй дэмжиж, эдийн засгийн бодит ашгийг нэмэгдүүлэхийн тулдбүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологийг задруулахыг хориглож байсан байна. Шилэн бүтээгдэхүүний экспортын худалдааны эхэн үедНэгдэл (Guild)-ийн тусламжтайгаар шилэн бүтээгдэхүүн (үйлдвэрлэл)-ий технологи, бусад мэдээллийн нууцыг зохих ёсоор хамгаалж байсан ч худалдаа идэвхжсэнээр технологи эзэмшигчид өөр нутаг руу шилжих нь нэмэгдэж нууц задрах эрсдэл ихэссэн. Улмаар Венецийн төрөөс шилэн бүтээгдэхүүн (үйлдвэрлэл)-ий технологид хамаарах тусгай эрхийг хүлээн зөвшөөрөх бодлого барьж ажиллажээ.

XIII зууны үед шилэн эдлэл үйлдвэрлэх технологидпатентолгосон бөгөөдтүүний гол зорилго нь шилэн эдлэл үйлдвэрлэх технологийг Венециэс гадагш задруулахгүй байхад оршиж байсан.

Эдгээрээс түүхэн дэхь патентын үүсэл нь технологи шилжүүлэх асуудалтай холбоотой гэж дүгнэж болно.

XV зууны үед патентыг хамгаалах зорилгоор нэгдлүүдэд урамшуулал олгох болон Венецид шинэ технологи авчирсан гадны иргэдэд шагнал өгч эхэлсэн байна. XVIII зуунаас л Их Британи, АНУ зэрэг улсуудад шинэ технологи инновацийг дэмжиж, амьдралын түвшинг дээшлүүлэх хөшүүрэг болгон хэрэглэх болжээ.[6]

Зохиогчийн эрхийн хувьд оюун ухааны бүтээлийг дэмжих зорилго гэхээсээ илүү хэвлэн

1 *Jeremy Lack, The Growing Need for ADR in IP Disputes, Intellectual Property Magazine, December 2010, http://www.intellectualpropertymagazine.com/patent/the-growing-need-for-adr-in-ip-disputes-88619.htm?origin= internal Search (last visited April 10, 2016).*

2 *Carlos A. Primo Braga et al., Intellectual Property Rights and Economic Development, World Bank, 2000, at 5.*

3 *Түркийн Айдын мужийн Балат тосгоны ойролцоо байрладаг. НТӨ VI зууны дундуур Персийн довтолгооноос өмнө Милетийг Грекийн хамгийн том, хамгийн баян хот гэж үздэг байв.*

4 *Милет хотын төлөвлөлтийн тухай нийгмийн дэг журмыг тодорхой тусгаж, тодорхой болгож чадна гэсэн санаат үндэслэгч хэмээн үзэж" энэхүү санаан дээр оюуны өмчийн маргаан үүсгэн үүсгэн маргалдаж байсан хэмээн үздэг.*

5 *Carlos A. Primo Braga et al., Intellectual Property Rights and Economic Development, World Bank, 2000, at 5.*

6 *Мөн тэнд.*

нийтлэх үйл ажиллагааны журам тогтоох гэсэн бизнесийн зорилготой байв.[7]

Сэргэн мандалтын үеийн Италидхэвлэлийн компани онцгой эрхтэй байсан ба хэвлэмэл бүтээлийг компаний зөвшөөрөлгүй гуравдагч этгээд хэвлэх, импортлохыг хориглож байв. XVI зууны үед сэргэн мандалтын үе шиг хэвлэлийн компаний онцгой эрх (бүтээлийн зохиогч эсвэл өвлөгчөөс зөвшөөрөл авсан байхыг шаардах болж)-ийг зохиогчийн эрхийн тухай хуулиар зохицуулсан. Энэ үед Европын бусад улс орнуудад ч зохиогчийн эрхийн тухай ойлголт үүссэн бөгөөдихэвчлэн хэвлэн нийтлэхийг хориглох,зохиолуудыг хянах зорилгоор ашиглаж байжээ. Тухайлбал Их Британид 1476 онд хэвлэх төхөөрөмж нэвтэрснээс хойш зохиогчийн эрхийн тухай асуудал эхэндээ хааны эрхийг эсэргүүцсэн хэвлэмэл бүтээгдэхүүнийг хянах өөрөөр хэлбэл хэвлэн нийтлэх үйл ажиллагааг журамлах зорилгоор ашиглаж байжээ. Хааны эрхэнд суурилсан хэвлэлийн зөвшөөрөл (royal privilege) болон ном хэвлэх үйлдвэрүүдийн нэгдэл (Stationer's Company)-ийн үйл ажиллагаанаас бүтээлийг хянах, тараахад монополь эрх олгож байсныг харж болно.

Үүний дараа гарсан нэр төрийн хувьсгалын үр дүнд бүтээлийн талаарх зохиогчийн үндсэн эрхийг өмчийн эрх хэмээн үзэх болсон бөгөөд хэвлэх үйлдвэрт ном хэвлэх эрхийг хэн ч эдэлж болох болжээ.

1710 онд Анне хатны хууль (The Statute of Anne) батлагдснаар тодорхой монополь эрхийг тодорхой хугацааанд олгож, уг хугацаанд хууль бусаар олшруулан хувилахыг хориглон зохиогчийн эрхийг хамгаалж байсан бөгөөдуг хугацаа дууссаны дараа тухайн мэдээллийг түгээж, соёл-урлагийн бүтээлийг дэмжих зорилготой орчин үеийн зохиогчийн эрхийн хуулийн үндсийг тавьжээ. [8]

1709 онд анхны зохиогчийн эрхийн тухай хуулийг Австри улсадбатлан гаргасан байна. [9] Энэ үеэс зохиогчийн эрхийг бусад улс хүлээн зөвшөөрч эхэлжээ. [10] Гэвч өөрийн бүтээлээ гадаад оронд ашиглуулах тохиолдолд хүндрэл гарч байв. Ингээд Европын зарим оронд XIX зууны дунд үеэс эхлэн бүтээл туурвигчид нь олон талын гэрээгээр эрхээ хамгаалуулж эхэлсэн байна. [11]

Олон улсын харилцаа хөгжин тэлсэнээр нэг улсын оюуны өмчийг нөгөө улсад хамгаалах шаардлага тулгарчээ. Ийнхүү 1883 оны 3 сарын 20-ны өдөр "Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай" Парисын конвенци, 1886 оны 9 сарын 9-ны өдөр "Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай" Бернийн конвенцийг дэлхийн улс орнууд батлан гаргасан байна. Энэ үеэс оюуны өмчийг олон улсад хамгаалах тогтолцоо бүрэлдэн тогтсон байна.

Дээрх конвенцид нэгдэн орсон улсууд зохиогчийн эрхийг хамгаалахын тулд Парисийн конвенцийг түшиглэн Парисийн холбоог, Бернийн конвенцийг түшиглэн Бернийн холбоог байгуулан ажиллаж эхэлсэн байна.

Улмаар дэлхийн оюуны өмчийн байгууллага нь 1967 онд Швед улсын Стокгольм хотноо батлагдсан ДОӨБ-ын конвенцид нийцүүлэн 1970 онд байгуулагджээ. [12] Тус байгууллагад Монгол улс 1979 онд гишүүнээр элссэн бөгөөд ДОӨБ-аас гаргасан гэрээ конвенцуудад нэгдэн орсон байна. Ийнхүү нэгдэн орсноороо Монгол улсын оюуны өмчийн бүтээл гадаад оронд мөн адил хамгаалагдах болсон байна.

Гэвч Монгол улс гадаадын улс орнуудтай харьцуулахад харьцангуй хойн буюу анх 1944 оны 5 сарын 19-ний өдрийн БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн "Шинэ юм зохион олох ба үйлдвэрт оновчтой сайн санал гаргагчдыг шагнаж, урамшуулах тухай заавар" хэмээх 63-р тогтоол гаргасаар оюуны өмчийг хамгаалах эрх зүйн үндэс тавигдсан юм. Энэхүү тогтоол нь 4 зүйлтэй бөгөөд 1-р зүйл нь шинэ юм зохион олсон, оновчтой санал гаргасан хүмүүст мөнгөн шагнал олгож байхаар байхаар заажээ. Тогтоолын энэхүү заалтанд тусгагдсан "шинэ юм" гэдэг нь шинэ бүтээл гэсэн санааг илэрхийлж байжээ.

Уг тогтоолын 1-р зүйлийн агуулга агуулга нь оюуны өмчийг үнэлэх,оюуны бүтээл туурвигчдын бүтээлийг нэвтрүүлэн ашигласны хөлсийг мөнгөөр мөнгөөр тооцож олгож байхаар заасан байна.

1944 оны уг тогтоолын шинэ бүтээл туурвигчдад олгох шагнал урамшуулал олгох тухай

7 *Мөн тэнд.*

8 이기수 "디지털환경에 대한 저작권법의 대응", 한국지적재산권법제연구원, 2004, 15면;ИГиСҮ, "*Дижитал орчны зохиогчийн эрх зүйн тухай хуулийн үйлчлэл*". *БНСУ-ын Оюуны өмчийн тухай хууль тогтоомжийн судлаагааны институт, 2004, 15 дахь тал;*

9 김홍석, "미분배 보상금의 공익목적 사용에 대한 연구", 강원법학, 제40권, 2013, 139-40면 참조.*(Ким Хун Сог "Хуваарилаагүй урамшууллын талаарх нийтийн эрх ашгийн зорилгын талаарх судалгаа". Канвоны хууль зүйн сургууль. 40-р боть, 2013 он, 139-140дэхь тал)*

10 *Д. Ганхуяг /орчуулсан/. ДОӨБ. Оюуны өмч бол эдийн засгийн хөгжүүлэгч хүчирхэг хэрэглүүр.. Уб, 2004 он, 3 дахь тал*

11 *Д. Эрдэнэчимэг, Барааны тэмдэг, зохиогчийн эрх хоорондын зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зам.. хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл.. ДХИС. 2019 он, 22 дахь тал*

12 *Мөн тэнд*

үндсэн зарчим нь 1960 онд гарсан "Нээлт, шинэ бүтээл,оновчтой саналын дүрэм",1970 ондшинэчлэн найруулсан "Нээлт,шинэ бүтээл,оновчтой саналын дүрэм"-д тусгалаа олсон байдаг.

1944 оны "Шинэ юм зохион олох ба үйлдвэрт оновчтой сайн санал гаргагчдыг шагнаж, урамшуулах тухай заавар" хэмээх 63-р тогтоолыг үндэслэж 1946 онд БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн 6-р тогтоолоор Чойбалсангийн нэрэмжит шагнал бий болгосноор оюуны бүтээл туурвигчдыг төрөөс шагнах болсон байна. Үүнээс улбаалан өдгөө төрийн шагнал хүртээх болсон байна.

Харин оюуны өмчийг хамгаалах тухай анх 1952 оны иргэний хуульд "Зохиогчийн эрх" гэсэн нэртэй 18-р бүлгийн 269-289 дүгээр зүйлд тусгасан заасан байдаг.

Үүний дараа 1963 оны Иргэний хуульд нээлт, шинэ бүтээл, зохиогчийн эрх, оновчтой санал гэх мэт... дэлгэрэнгүй зохицуулалт хийгдэж байв. Мөн өөрийн болон зохиомол нэрээр эсвэл нэргүйгээр бүтээл хэвлүүлэх, тараах, зохиолын халдашгүй дархан эрх, зохиогчийн санал гэх мэт эрхийг тусгасан бол 1994 оны Иргэний хуульд "Иргэний гүйлгээндоролцогчдын эрх зүйн байдлыг тодорхойлж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус амины харицааг, уг харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал, хүсэл зоригийн болон эд хөрөнгийн бие даасан байдлыг үндэслэн зохицуулна"[13] гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 7-р зүйлд "Монголын ард түмний түүх, соёлын дурсгадт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв нь төрийн хамгаалалтанд байна хэмээн заажээ. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн" гэж заажээ. Үндсэн хуулийн энэхүү заалтаас үзэхэд оюуны бүтээлийг оюуны өв, оюуны үнэт зүйлс гэж хоёр нэр томъёогоор тодорхойлсон байна. Харин иргэний туурвисан, өөрөөр хэлбэл зохиогч нь мэдэгдэж буй бүтээлийг зохиогчийн өмч гэсэн агуулгад хамааруулан заасан байдаг.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын үүсэл нь хувь хүний үндсэн эрхийн хамгаалалтаас илүүтэйгээр нийгэм, эдийн засгийн ашиг сонирхол, бодлогын зорилготой шууд хамааралтай. Дээр дурдсанчлан нийгэмдашиг тустай нээлтэсвэл соёлын үнэт зүйлсээр баялаг бүтээлийг тасалдуулахгүй байхын тулд бүтээгч, зохиогчоос бусад гуравдагч этгээд хөдөлмөрлөхгүй ашиг олох(free riding) буюу шударга бус ашиг орлого олохыг таслан сэргийлэх тогтолцоо зайлшгүй шаардлагатай байна.

13 *Б. Жаргалсайхан. Олон улсын эрх зүй.. Уб. 2020 он. 100 дахь тал*

ДҮГНЭЛТ

Оюуны өмчийн эрхийн агуулгыг нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах буюуолон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах талаас харж болох бөгөөд илүү нарийвчлан хэлбэл оюуны өмчийн эрхийг хамгаалах нь нийтийн эрх ашгийг хамгаалах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоог сайжруулах хэрэгсэл болж байжээ. Улс орон бүр олон нийтийн эрх ашгийг хамгаалах тодорхой бодлого явуулдаг бөгөөдтухайн нийгмийн соёл,эдийн засгийн түвшинд тохирсон бодлогын зорилго, холбогдогч талуудын эрх ашгийн харилцан тохиролцсон тэнцвэр (balance) шаардлагатай бөгөөд оюуны өмчийг хамгаалах цар хүрээ, хэм хэмжээг ашиг сонирхлын тохиролцоо болон ашиг сонирхлын тэнцвэрийн дагуу тогтооно. Тиймээс өөр нэг утгаараа оюуны өмчийн эрхийг чөлөөт зах зээлийн эдийн засгийн эрсдэлд хариу үзүүлэхтэй уялдан гарч ирсэн гэж болно.

Оюуны өмчийн хамгаалалт үүссэн цагаасаа эхлэн ашиг сонирхлын зөрчил,маргааныг дагуулсан бөгөөд улс орнууд хууль тогтоомж, тогтолцоо бүрдүүлэн уг эрхийг хамгаалах, маргаанаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх талаар анхаарч байна. Улс орнуудын энэхүү хүчин чармайлт, цар хүрээний ялгаа болон оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбоотой нийгэм, эдийн засаг, ашиг сонирхлын зөрүүнээс хамаарч улс орон бүр өөрийн гэсэн бодлого баримтлана. Олон улсын худалдаа нэмэгдэж, шинжлэх ухаан, харилцаа холбоо хөгжсөнөөр улс орнуудын улс төр, эдийн засгийн бодлого нягт холбоотой болж байгаа хэдий ч зарим тохиолдолд эрс зөрчилддөг. Улс орон бүрийн оюуны өмчийн бодлого ялгаатай тул оюуны өмчийн эдийн засгийн үнэ цэнэ өсөхийн хэрээр оюуны олон улсын өмчийн эрх зүйн зөрчилдөөн илүү гүнзгийрэх шинжтэй болж байна.

Монгол улсын хувийн оюуны өмчийн тухай ойлголт,түүнийг хамгаалах тухай асуудал бий болоод 80 орчим жилийг ардаа орхижээ. Тиймээс энэхүү салбарыг хөгжүүлэх асуудал бидэнд тулгараад байна. Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор улс орон хөгжих үндэс суурь тавигддагийг ухамсарлаад удаагүй байна. Тухайлбал энэ оны эхээр Оюуны өмчийн тухай хуулийг батлан гаргаж, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах тухай ярьж эхэлсэн нь сайшаалтай юм.

Ашигласан материал:

Нэг. Монгол хэлээр

1. Д. Ганхуяг /орчуулсан/, ДОӨБ, Оюуны өмч бол эдийн засгийг хөгжүүлэгч хүчирхэг хэрэглүүр.,Уб,2004 он,
2. Д. Эрдэнэчимэг, барааны тэмдэг, зохиогчийн эрх хоорондын зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зам., хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл.,ДХИС,2019 он,
3. Б. Жаргалсайхан, Олон улсын эрх зүй., Уб, 2020 он,
4. БНМАУ-ын хууль тогтоомжийн системчилсэн эмхэтгэл,VIII боть,Уб,2010 он.,

Хоёр. Гадаад хэлээр

1. 안효질 외, "전통의약 분야의 법적·제도적·보장 방안 연구", 경희법학, 36권, 2호, 2001, (Ан Хюу Жил нар,"Уламжлалт анагаах ухааны хууль эрх зүй,тогтолцоо,хамгаалалын судалгаа", Kyung Hee Law,36-р боть,2001 он,№ 2,)
2. 이기수 "디지털환경에 대한 저작권법의 대응", 한국지적재산권법제연구원, 2004; (И Ги Сү, "Дижитал орчны зохиогчийн эрх зүйн тухай хуулийн үйлчлэл", БНСУ-ын Оюуны өмчийн тухай хууль тогтоомжийн судалгааны институт,2004)
3. 김홍석, "미분배 보상금의 공익목적 사용에 대한 연구", 강원법학, 제40권, 2017.(Ким Хун Сог "Хуваарилаагүй урамшууллын талаарх нийтийн эрх ашгийн зорилгын талаарх судалгаа", Канвоны хууль зүйн сургууль, 40-р боть,2013 он)
4. Carlos A. Primo Braga et al.,*Intellectual Property Rights and Economic Development*,World Bank, 2000
5. Jeremy Lack,The Growing Need for ADR in IP Disputes Intellectual Property Magazine December 2010, http://www.intellectualpropertymagazine.com/patent/the-growing-need-for-adr-in-ip-disputes-88619.htm?origin= internal Search (last visited April 10,2016).

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

М.Наранцэцэг
Их Засаг ОУИС-ийн ХЗС-ийн багш

Түлхүүр үг: Зохиогчийн эрх, оюуны өмч, хариуцлага

Хураангуй: Оюуны өмч гэдэг ойлголт нь маш өргөн утгатай бөгөөд аж үйлдвэр, шинжлэх ухаан, утга зохиол уран сайхны салбарт хамаарах, оюуны бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон бүтээл дэх эрх зүйн боломж, эрх юм. Дийлэнхи улс орнууд хууль тогтоомжоороо оюуны өмчийг үндсэн хоёр шалтгаанаар хамгаалдаг. Оюуны бүтээл туурвигчдад эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины эрх, түүнчлэн бүтээлийг олон нийтэд хүртээх эрхийг хуулиар олгох,нөгөө нь эдийн засаг нийгмийн хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор оюуны бүтээл туурвигчдыг төрөөс дэмжих урамшуулах бизнесийн шударга систем тогтоох зорилготой байдаг.[1] Монгол Улс 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэнээс эхлэн оюуны өмчийн хамгаалалт жинхэнэ утгаар хөгжих болсон. Энэ үеэс эхлэн оюуны өмч нь төрийн өмч байж, зохиогч эд хөрөнгийн бус эрх болон шагнал авах эрх эдэлдэг байсан юм[2].

Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5.2-т *"Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална"* Долдугаар зүйлийн 7.1-т *" Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл бол зохиогчийнх нь өмч, хамгаалалтанд байна"*,

Оюуны өмч **(INTELLECTUAL CREATION)** гэдэг нь зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалт бүхий биет бус эд хөрөнгө юм.[3]

Оюуны өмч гэсэн ойлголтод багтах объектын талаар Монгол Улс 1979 онд гишүүнээр элссэн. Дэлхийн Оюуны өмчийн байгууллагын (ДОӨБ) нийт 14 улсын гэрээ, хэлэлцээр, конвенцид нэгдэн орсон. ДОӨБайгууллагыг байгуулах тухай конвенцид (1967) зааснаар нь олон улсын түвшинд хамгийн анхны удаа оюуны өмчийн агуулгыг тодорхойлсон чухал заалт болсон юм. Уг конвенцийн 2-р зүйлд "Оюуны өмч нь:

- Шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээл
- Уран бүтээлчдийн тоглолт дуу авианы бичлэг, шугамаар нэвтрүүлэх
- Хүний хэрэгцээний бүх салбар дахь шинэ бүтээ
- Шинжлэх ухааны нээлт
- Бүтээгдэхүүний загвар
- Барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, худалдааны нэр илэрхийлэл
- Шударга өрсөлдөөнөөс хамгаалах болон үйлдвэрлэл, шинжлэх ухаан, уран зохиол уран сайхны салбарт оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон бусад зүйлд хамаарах эрхийг агуулна" гэж заажээ.

Зохиогч **(CREATOR)** гэдэг нь "бүтээл туурвисан этгээд, техник технологийн шинэ санаа сэдэгч этгээдийг хэлнэ".

Зохиогчийн эрх эдлэх этгээд **(LEGAL ENTITY WITH COPYRIGHTS)** гэдэг нь "бүтээл туурвисан Монгол Улсын иргэн,тус улсын нутаг дэвсгэрт байнга оршиг суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсад анх удаа нийтийн хүртээл болгосон гадаадны иргэн, дүрслэх урлагийн бүтээлээ тус улсын нутаг дэвсгэрт байнга байршуулсан зохиогч" хэлнэ.[4]

Зохиогчийн эрх зүй нь Монгол Улсын иргэний эрх зүйн нэг салбар, бие даасан эрх зүйн институтмөн гэж үзэж болно. Зохиогчийн эрх зүйн харилцаа нь шинжлэх ухаан, урлаг утга зохиолийн бүтээлийн үүсэл ашиглалттай холбогдон үүсдэг.[5]

Зохиогчийн эрх:

1. Эдийн бус баялагтай холбоотой эрх (Эд хөрөнгийн бус амины эрх)
2. Бүтээл ашиглах онцгой эрх (Эдийн баялагтай холбоотой)[6]

1 *Э.Мягмардорж "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд" УБ 2003 он 4 дэх тал*

2 *"Оюуны өмч-Хөгжлийн ундарга, хүний цэвэр зувчигдах эрх" ОУ-ын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл УБ 2013 он 9 дэх тал*

3 *Ю.Энхтөвшин "Оюуны өмчийн эрх" тайлбар толь УБ 2004 он 63 тал*

4 *Ю.Энхтөвшин "Оюуны өмчийн эрх" (тайлбар толь) УБ 2004 42 дахь тал*

5 *"Оюуны өмчийн эрх зүй" Их засаг Их сургууль, Иргэний ЭЗүйн тэнхим УБ 2004 он 19 тал*

6 *Д.Цолмон " Оюуны өмчийн эрх зүй" УБ 2003 он 20 дахь тал*

Монгол Улсын Үндсэн хуулийн долдугаар зүйлийн 7.2-т *"Иргэний туурвисан оюуны цэнэт зүйл бол зохиогчийнх нь өмч. Монгол Улсын үндэсний баялаг мөн"* гэж заасан байдаг.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1. *"Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй"*.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. *"Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг бүтээсэн цагаас эхлэн"* 9.5. *"Зохиогч хүсвэл өөрийн бүтээл, түүнтэй холбоотой бүтээл ашиглах онцгой эрхийг бусдад шилжүүлэх гэрээ, хэлцлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сайн дурын үндсэн дээр бүртгүүлж болно"*.

Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн(1886) долоодугаар зүйлийн 7.1-д "Зохиогч нь тус Конвенцээр олгох хамгаалалтыг насан туршид эдлэх ба түүнийг нас барснаас хойш тавин жилд уг хамгаалалт хүчин төгөлдөр байна" ,**Зохиогчийн эрхийн тухай ДОӨБ-ын гэрээний** зургаадугаар зүйлийн 6.1-д "Утга зохиол,уран сайхны бүтээлийн зохиогчид нь өөрийн бүтээлийн эх хувь болон хуулбарыг худалдах буюуэсвэл бусдадөмчлүүлэхээр шилжүүлэх замаар нийтэдтанилцуулхыг зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ"[7] гэж тус тус заажээ.

Зохиогчийн эрхийн харилцааг Зохиогчийн эрх болон түүндхамаарах эрхийн тухай хууль,Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенци, Зохиогчийн эрхийн тухай ДОӨБ-ын гэрээгээр тус тус зохицуулсан байдаг. Зохиогчийн туурвисан бүтээл бол хуулиар хамгаалагдсан хувийн өмч тул зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хууль бусаар нийтэд түгээх,нийтлэхийг хориглоно.

Цахим орчин дахь зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтанд тулгамдаж буй зарим асуудал, шийдвэрлэх арга зам, харьцуулсан судалгаа

1.1. Цахим орчин дахь зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа

ФРАНЦ УЛС

"Онцгой эрх олгох" системээс зохиогчийн эрх рүү шилжих хөгжилт нь суурь үндсэн өөрчлөлтийг авчрах хувьсгалыг хийж чадсан байна. 1791, 1793 онд Франц улсад болсон "Сонгогчдийн чуулган"-аас хоёр шийдвэр /хууль/ гаргасан ба энэ нь франц загварын зохиогчийн эрхийн системийг бий болгох үндэс нь болжээ.[8]

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн Нэгдсэн Улсын хувьд зохиогчийн эрхийн хөгжлийн товч түүхийг авч үзвэл 1976 оны хуулийг батлагдан гарах хүртэл зохиогчийн эрхийн хууль нь үндсэндээ Англи улсын "Эннийн дүрэм"-ийн зохицуулалтад тулгуурлаж байна. 1790 онд Америкийн холбооны "Зохиогчийн эрх"-ийн анхны хууль гэрч үүгээр дээрхи "Эннийн дүрэм"-ийн зохицуулалт илэрлээ олсон байв. Тухайлбал, энэ актаар ном, газрын зураг, бүдүүвч зураг нь анх хэвлэгдсэнээс хойш 14 жилийн хугацаанд хамгаалагдах бөгөөд анхны хугацаа дуусахад зохиогч нь амьд байвал хугацаа сунгагдах боловч заавал дахин бүртгүүлж,хураамж төлөх хатуу шаардлага тавигдаж байжээ.Дээрхи зохицуулалт АНУ-д 1976 оныг хүртэл үргэлжилсэн. 1976 онд уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, зохиогчийн эрхийг хамгаалах хугацааны үргэлжлэлийг насан туршид нь болон нас барснаас хойш 50 жилийн хугацаанд байхаар өөрчилжээ.Иймэрхүү өөрчлөлт өөр бусад орны зохиогчийн эрхийн хуульд ч нэгэн адил хийгдэж байв. Гэсэн хэдий ч 1976 оны хууль нь бүртгэлийн болон хураамжийн 1709 оны "Эннийн дүрэм"-ийн шаардлагыг хэвээр хадгалж үлдсэн байна.[9]

МОНГОЛ УЛС

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн хорин тавдугаар зүйлийн 25.1-д *"Интернетийн цийлчилгээ түгээгч нь өөрийн серверт байршуулсан вэб хуудсанд зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогч болон эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй"*. *25.2.Интернетийн*

7 *"Монгол Улсын оюуны өмчийн Олон улсын гэрээ "УБ 2003 он*

8 *Э.Мягмардорж "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд" УБ 2003 он*

9 *Д.Цолмон "Оюуны өмчийн эрх зүй" УБ 2003 он*

цйлчилгээ тцгээгч нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хцлээн авах нөхцөлийг бцрдццлэх, зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн вэб хуудсыг хаах ццрэг хцлээнэ". 25.3.Энэ хуулийн 25.1, 25.2 дахь хэсэгт заасан ццргээ биелццлээгцй интернетийн цйлчилгээ тцгээгчид Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна". 25.4.Вэб хуудсыг хаасантай холбоотой маргааныг шццх шийдвэрлэнэ" гэж заасан байна.

Зөрчлийн тухай хуулийн наймдугаар зүйлийн 8.3. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль зөрчих *"Зохиогчийн эрх болон тццнд хамаарах эрхийн тухай хуулийг зөрчсөн нь эрцгийн хариуцлага хцлээлгэхээргцй бол зөрчил цйлдэхэд ашиглагдсан эд зцйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, цйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хцнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон*

1.2. Цахим орчин дахь зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтанд тулгамдаж буй зарим асуудал, шийдвэрлэх арга зам

"Шүүхийн шийдвэрийн цахим сан"-гаас харахад анхан шатны шүүхээс зохиогчийн эрхтэй холбоотой 10 маргааныг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд дээрх хуулийн 25 дугаар зүйлийг хэрэглэж шийдвэр гаргасан тохиолдол гараагүй байна.[10]

Харин "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль"-ийн "Интернетэд зохиогчийн эрхийг хамгаалах"-тай холбоотой эрх зүйн маргаан шүүхийн өмнөх шатанд буюу шүүхийн бус журмаар нэлээн өргөн хүрээнд зохицуулагдаж байна. Тодруулбал,Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны 08 тооттогтоолын хавсралт"Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага"-ын 4.11-т зааснаар Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12.1, 12.2, 20.1, 21.1, 22.1, 25.1 –д заасныг зөрчиж, зохиогч эсхүл эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг нь ашигласан агуулга буюу контентийг хууль бус контентод хамааруулсан. Энэ нь хуулийн заалтыг интернетийн орчинд хэрэгжүүлэхтэй холбоотой тусгайлсан зохицуулалт юм. Тус ерөнхий нөхцөл, шаардлагын 7.3-т заасны дагуу интернет орчин дахь агуулга зохиогчийн эрхийг зөрчсөн эсэх хяналтыг холбогдох хуульд заасан эрх бүхий хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

Өнөөдрийн байдлаар нийт 228 вэб сайт холбогдох хуулиудыг зөрчсөн байна. Үүнээс 187 вэб сайт нь зохиогчийн эрхийг зөрчсөн байна. Үүнтэй холбоотойгоор

- 2017 онд 50 гаруй сайтуудыг хаасан
- 2018 онд 85 очим сайтуудыг хаасан
- 2019 онд 18 сайтуудыг хаасан байна[11]

Энэ талаар тухайн веб сайт руу хандахад ямар зөрчлийн улмаас хандалтыг хязгаарласан болон хаашаа хандах талаарх мэдээлэл гарч ирнэ. Харин зөрчлийг арилгасан тохиолдолд Оюуны өмчийн газрын улсын байцаагчийн дүгнэлт, эрх бүхий байгууллагын шийдвэрээр "зөрчилтэй домэйны жагсаалт"-аас хасч, хандалтыг нээх боломжтой.

Монголын залуу уеийнхнээс судалгаа авч үзэхэд сүүлийн үеийн кино, зохиолийг ихэвчлэн фэйсбүүк хаягаар үзэж, уншиж мэдээллийг авдаг гэж хариулсан. Сүүлийн үед сайт гэхээсээ илүү фэйсбүүкээр хуурамч аккаунт нээж зохиогчийн эрхэнд халдах тохиолдол ихэссэн байна.

Хэдийгээр манай улс нь хууль тогтоомжоороо ийнхүү тусгаж өгсөн нь өнөөдрийн цахим харилцаанд гарч буй оюуны өмчийн эрхийн зөрчлийг бүрэн зохицуулж чадаагүй гэж хэлж болох юм. Одоогийн түвшинд цахим харилцаанд оюуны өмчийн дараах нийтлэг асуудлууд гарч байна. Цахим хэлбэрээр оюуны өмчид халдсан үйлдлийг олох, эзэн холбогдогчийг тогтоох, Оюуны өмчид халдсан тохиолдолд учирсан хохирлыг хэрхэн арилгуулах зэрэг асуудал гарч байгаа юм.

Цахим харилцаанд эрх зөрчсөн үйлдлийг олж тогтоох болон эрх зөрчсөн субъектийг олоход бэрхшээлтэй. Учир нь интернэтийн үйлчилгээ үзүүлэгч нь интернэт сервэртээ бусдын линк хаягийг иш татаан байршуулсан, иш татсан, хэрэглэгчид түүнийг нь хуулбарласан зэрэг нь хэн нь зөрчлийн субъект гэдгийг тодорхойлоход маргаантай байна.

Мөн эрх зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх ойлголтонд Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай хуульд Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ гэж заасан ч тухайн зохиогч этгээд эд хөрөнгийн хохиролд юуг хамааруулан ойлгох, зохиогч эд хөрөнгийн хохирлоо хэрхэн барагдуулах тодорхой бус байна. Мөн хуульд зохиогчийн эрх зөрчиж, зөохиогчийн эрхийн бүтээл,

10 *Shvukh.mn*

11 *Оюуны өмчийн газар*

зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг хуулбарлахад ашигласан техник хэрэгслийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураан авч улсын орлого болгоно гэж заасан нь цахим харилцаанд зохиогчийн эрхийн зөрчил компьютер, техник хэрэгсэл үйлдэгддэг нь түүнийг хураах үндэслэл болно гэж ойлгогдож байгаа ч үүнийг хэрэглэсэн нь одоогоор байхгүй байна. Үүнээс харахад хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа гэж дүгнэж болно.

ДҮГНЭЛТ

Иймд судалгаагаа дүгнэн үзвэл цахим харилцаа нь шинэлэг, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн харилцаа боловч иргэн бидний эрх, эрх чөлөөндхалдаж байгаагаараа сөрөг талтай байна. Дэлхий нийтээрээ цахим орчны зохиогчийн эрхийн зөрчлийг арилгах,зөрчилтэй тэмцэх зорилго бүхий байгаа бөгөөд Монгол Улс ч мөн зорилго болгон ажиллах шаардалагатай болоод байна. Хэдийгээр хууль тогтоомжиндоо цахим харилцааны талаар тусгаж өгсөн ч хяналт үйл ажиллагааг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгтэй юм. Судалгаатай холбоотойгоор дараах саналыг дэвшүүлж байна.

1. Цахим сайтуудын хяналтыг сайжруулахын тулд Оюуны өмчийн газар, Харилцаа холбооны зохицуулах газар, Монголын Сайтын холбоо, Монголын мэдээллийн сайтуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гаргаж дэлхийн жишигт нийцсэн хяналтын үйл ажиллагааг бий болгох. Хамтын удирдлагын байгууулагыг байгуулан ажиллуулахыг дэмжих.
2. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 25-р зүйлд заасан заалтын хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллага анхаарч ажиллах. Зохиогчийн эрхийг зөрчсөн зөрчлийн субъектийг холбогдох хуулинд тодорхой болгож зүйлчлэх.
3. Зохиолч сайн дурын үндсэн дээр зохиолоо бүртгүүлж гэрчилгээ авах бус заавал бүртгүүлж, гэрчилгээ авах үүргийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулинд тусгаж өгөх
4. Зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг өндөрсгөж тодорхой болгох. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 25.2.Интернетийн үйлчилгээ түгээгч нь зохиогч болон зохиогчийн эрхэдхамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх,зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн вэб хуудсыг хаах үүрэг хүлээнэ" гэж заасан заалтанд өөрчлөлт оруулах. Зөрчил гаргасан этгээд хаасан вэб сайтыг дахин сэргээх боломжтой байдаг тул Зөвхөн хаах нь хариуцлага ногдуулах хэлбэр болохгүй бөгөөд шууд зөрчлийн тухай хууль болон эрүүгийн хуулиар хариуцлага ногдуулдаг байх гэсэн саналуудыг тус тус дэвшүүлж байна.

Ашигласан материал

- "Оюуны өмч- хөгжлийн ундарга, хүний үл зувчигдах эрх" Оюуны өмчийн газрын бүтээл УБ 2013 он
- Ю.Энхтүвшин "Оюуны өмчийн эрх(тайлбар толь)" УБ 2004 он
- Э.Мягмардорж "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд" УБ 2003 он
- "Оюуны өмчийн эрх зүй" Их засаг Их сургуулийн бүтээл УБ 2004 он
- Д.Цолмон "Оюуны өмчийн эрх зүй" УБ 2003 он
- Монгол Улсын оюуны өмчийн олон улсын гэрээ УБ 2003 он
- "Монгол Улсын Үндсэн хууль" 1994 он
- "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль" 2006 он
- "Зөрчлийн тухай хууль" 2018 он
- " Эрүүгийн хууль" 2018 он
- "Иргэний хууль" 2002 он
- Google.mn
- Ligalinfo.mn
- Shvvkh.mn
- Оюуны өмчийн газрын сайт

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР ДАХЬ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Д.Майцэцэг
Их засаг ОУИС-ийн докторант, өмгөөлөгч

Түлхүүр үг: Төр-хувийн хэвшлийн түншлэл (Public-Private Partnerships)

Хураангуй: байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх,судалгаа шинжилгээний салбарт төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлхэд учирч буй хүндрэл бэрхшээл,хууль эрх зүйн орчны нөлөөлөл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон.

Монгол Улсад бизнес эрхлэх орчин тааламжгүй, төрийн байгууллага, албан тушаалтны олон шат дамжлага,хүнд суртал,авлига хээл хахууль газар авсан, төрөөс хувийн хэвшлийг дэмжих талаар олон хүн ярьдаг боловч нүдэнд харагдхуйц бодит тодорхой алхам хийхгүй өдөр хоногийг аргацаасаар л.

Өнөөдөр дээр доргүй ухаалаг төр, хувийн хэвшил болон төрийн хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийн талаар ярьж байгаа боловч ажил хэрэг болж байгаа нь цөөн байгаа учир төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон хувийн хэвшилд шилжүүлэх, лиценз тусгай зөвшөөрлийн тоог багасгах, хүнд суртлыг халах хэрэгтэй гэж улс төрчид тунхаглах боловч 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа төрийн албан хаагчдын тоо 195000 хүрч төрийн үйл ажиллагааны зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 60 орчим хувийг эзлэх болсон (2) бол хөгжингүй орнуудад 15-20 хувиас хэтэрдэггүй.

Монголын төр өнөөдөр ч хувийн хэвшил, иргэддээ үл итгэх байдлаар хандаж байгалийн баялаг, төрөл зүйлийг зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтан хариуцан хамгаална гэсэн үзэл баримтлалаас татгалзаж Засгийн газраас төр,хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж хөгжүүлэхийг оролдож байгааг үгүйсгэсэнгүй.

Зах зээлийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь хувийн хэвшил бөгөөд төр бол аж ахуйн ажилтай зууралдах бус гаднхүү бизнес эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлж,хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргээ биелүүлэх шаардлагатайг бүгд ойлгох цаг ирсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "...Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан **төрийн нийтийн** өмч мөн" (3) гэсэн байдаг учир байгаль орчны салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад хууль эрх зүйн таатай орчин, тогтвортой бодлого зайлшгүй хэрэгтэй.

Төр бүгдийг өөрөө хийх, бүхнийг хяналтандаа байлгахыг оролдох нь эцэстээ ганцаардахад хүрч байгалийн баялгийг ашиглах, хамгаалах үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа нь өдөөс өдөрт тодорхой болж байгаа учир байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах бүхий л асуудлыг иргэн,хувийн хэвшил,төр хамтарч гүйцэтгэхээс өөр сайн замгүй.

Төрийн зүгээс бизнес эрхлэх таатай орчин бий болгож санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих,хууль эрх зүйн орчныг тогтвортой, уян хатан, ухаалаг болгох зэргээр дэмжлэг үзүүлэх хэрэгтэй бөгөөд ингэсэнээр тоо толгой нь цөөрсөн ховор ан амьтад, ой мод, ширгэж буй гол,нуурын хамгаалалтыг төр- хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд нөхөн сэргээх, хамгаалах үр дүнтэй тогтолцоо бүрдэнэ. (4)

Байгаль орчны яамнаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээ,тусгай зөвшөөрөл авахад хүнд суртал, авлига байгаа эсэх, ажил урагшлахад саад болж байгаа хүчин зүйлс, хууль эрх зүйн орчны төлөв байдал, цаашид боловсронгуй болгох арга замын талаар хөндлөнгийн шинжээчдийн багаар судалгаа хийлгэх шаардлагатай.

2020 онд бүрэлдсэн Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон зарим бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэнд, байгаль орчин, боловсролын салбарт дэд бүтцийг хөгжүүлэх болон санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд хувийн хэвшлийн оролцоог дэмжихээр (5) заажээ.

Хүрээлэн буй орчныг хамгаалах ажилд хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, хөрөнгө оруулалтыг татах, тэдний мэдлэг туршлагыг ашиглахын тулд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бүрдүүлэн ажиллах" шаардлага чухлаар тавигдаж байна.

УИХ-с төр-хувийн хэвшлийн түншлэл (цаашид ТХХТ гэх)-ийн талаар Төрөөс баримтлах бодлогыг 2009 онд батлан гаргасан ч (6) байгаль орчны салбарт хөрөнгө оруулалт хийх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг багасгах чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байгаа ч төдийлөн үр дүнд хүрээгүй л байна.

УИХ-ын 2009 оны 64-р тогтоолын хавсралтын 4.1.5-д "төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэлбэр нь байгаль орчны салбарын түншлэл байна", 4.4 дэх зүйлд "...байгаль орчны салбарын түншлэлд нэгдүгээрт: экологи, хоёрдугаарт: хог хаягдлын удирдлага хамаарна гэжээ. (7)

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг анх Франц улсад 200 жилийн өмнөөс эхлүүлж, нийслэл Парис хотынхоо дэд бүтцийн төслүүдийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж (8) байжээ.

1970-аад оноос олон улс орнуудад Төр-хувийн хэвшлийн түншлэлийг түгээмэл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд дараах 3 чиглэлд хэрэгжиж байна. Үүнд:

1. Төр, хувийн хэвшлийн түншлэл / PPP- Public Private Partnership/
2. Хувийн хэвшлийн хэлэлцэл /PPD- Public Private Dialogue / (9)
3. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх /Outsourcing/

Харин Хувийн хэвшлийн хэлэлцэл /PPD/ нь төрийн зүгээс хөгжлийн бодлого боловсруулах үйл явцад хувийн хэвшлийг оролцуулах, тэдний санаа бодлыг оролцооны аргад тулгуурлан тусгахад чиглэгдсэн арга хэрэгсэл, төрөөс дунд болон урт хугацааны хөгжлийн баримт бичиг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулах тухай ойлголт юм.

Хамтын ажиллагааны гурав дахь чиглэл " Аут сорсинг" буюу төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх хэлбэр нь Баруун европ, хойд Америкийн орнуудад XX зууны дунд үед бий болсон түүхтэй. (10)

Төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хамтатган авч үзэх үү, салангид авч үзэх үү гэсэн асуулт урган гарах бөгөөд ТХХТ нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа дотроо багтдаг, хэрэгжилтийн тал дээр нь түлхүү анхаарч авч үзэх нэг хэлбэр бөгөөд энэ нь нийгмийн болон дэд бүтцийн салбарт үйлчилгээг шаардлагатай мэдлэг чадвар, хөрөнгө оруулалт, технологи ашиглан хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, учирч болзошгүй санхүүгийн, технологийн үйл ажиллагааны гэх мэт эрсдэлийг талууд гэрээнд заасан нөхцөлийн дагуу харилцан хуваана.

Тулгуур ойлголт нь төрийн зүгээс авах гэж буй үйлчилгээндээ төлбөр төлөх, эсхүл хувийн хэвшилд хэрэглэгчээс ашиглалтын хураамж хураах эрхийг нь олгох, хэрэгжилтийг төрөөс хянаж, үүнд олон нийтийн оролцоог хангах, ил тод байдлын зарчмыг баримтлах ба (11) хувийн хэвшлээс өөрийн хөрөнгөөр тогтоосон үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлнэ.

Түншлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн оролцоотой хамтарсан хуулийн этгээд байгуулж хувийн хэвшлээс хөрөнгө оруулах, эсвэл урт хугацааны гэрээний явцад хамтран ажиллах нөхцөлөө тохирдог ба төрөөс байгаль орчныг хамгаалах, нөөцийн ашиглалтыг дэмжиж ан амьтан, ургамлын тоо толгойг өсгөх, экосистемийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зэрэг үүргээ биелүүлэхэд хувийн хэвшлийг татан оролцуулах, хувийн хэвшлээс бага зардлаар зохистой менежментийг нэвтрүүлж ашиг олох хүсэл сонирхлыг уялдуулах замаар байгаль орчны салбарт түншлэлийг өргөжүүлнэ.

Төр, өөрийн чиг үүрэг, хариуцлагаа хууль ёсны дагуу тодорхой хугацаанд гэрээний үндсэн дээр хувийн хэвшилд шилжүүлэх үйл ажиллагаа бөгөөд гэрээний гол зарчим нь нэг нь нөгөөгөө захирахгүй, эрх тэгш байдлын үндсэн дээр харилцах, хариуцлагыг талууд гэрээнд заасан нөхцөлөөр хуваана.

ТХХТ нь зөвхөн концессийн гэрээний үндсэн дээр дэд бүтцийг хөгжүүлэх төслүүд биш төрийн тодорхой үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх, эдийн засаг дахь төр болон хувийн хэвшлийн зохистой харьцааг бий болгох, олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө, мөнгө олох өрсөлдөөнийг дэмжих зэрэг өргөн хүрээтэй ойлголт юм.

Төрийн байгууллагын үүргийг хувийн хэвшил гүйцэтгэдэг болсон нь бүх талд ашигтай бөгөөд үйлчилгээний салбарт өрсөлдөөн болон үр бүтээмжийг дээшлүүлэн хамрах хүрээг өргөжүүлэн, үйлчилгээг хүргэх зардлыг багасгадаг. (12)

Ямар ч Засгийн газартүйлдвэрлэл,үйлчилгээ, дэд бүтцийг өргөжүүлэх, үр ашигтүй ажиллаж буй

улсын үйлдвэрийн газруудыг дэмжих хангалттай санхүүгийн эх үүсвэр байдаггүй, төрийн өмчийн байгууллагын үйлчилгээний чанар муу байдагт олон нийт сэтгэл дундуур байдаг бол хувийн хэвшил илүү хүчтэй менежментийн чадавхитай, шинэ технологи хэрэглэдэг,төрөлжиж мэргэшсэн дэлхийн зах зээлийн хэрэгцээ шаардлага,өрсөлдөөнд хурдан дасан зохицох чадвартай байдаг.

Төр,хувийн хэвшлийн түншлэл нь эрсдэлийг хамгийн сайн менежментээр зохицуулж төр ба хувийн хэвшлийн салбарын хоорондох эрсдэлийг хамгийн тохиромжтой байдлаар хуваарилах боломж өгдөг, хувийн хэвшлийн оролцоо нь тухайн төсөл, хөтөлбөрийг худалдааны болон санхүүгийн сахилга баттай, найдвартай төлөв байдалд оруулдаг, хувийн хэвшлийн салбар нь бараа үйлчилгээг хүргэхдээ хангамж үйлчилгээний сүлжээг засгийн газрын агентлагуудаас илүү үр бүтээлтэй зохион байгуулж чаддаг,төсөл хөтөлбөрийг боловсруулах шинэ санаа, хэрэгжүүлэх илүү хүчин чармайлтыг авчирдаг, засгийн газрын зардлыг ихээр бууруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой. (13)

Монгол Улс нь хүн ам цөөн, байгалийн баялаг ихтэй,өргөн уудам нутаг дэвсгэртэй бөгөөд эдийн засаг нь уламжлалт арга буюу "хүрэн эдийн засаг" бүхэлдээ байгалийн нөөц баялгийг ашиглах хэлбэрээр хөгжиж байна.

Цаашидэдийн засгийн энэ уламжлалтаргаар дэлхийн өсөн нэмэгдэж буй хүн амын хоол хүнс, цэвэр ус зэрэг наад захын хэрэглээг найдвартай хангах боломжгүй болж байгааг нийтээр хүлээн зөвшөөрч сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний хэмнэлт, нийтийн тээвэр, тогтвортой хөдөө аж ахуй, биологийн төрөл зүйл, ус, ой, амьтан зэрэг байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлж буй олон улсын туршлагаас дүгнэхэд төрийн зүгээс аливаа бизнесийн үйл ажиллагаанд аль болох саад болохгүй байх, бүхий л харилцааг эрхзүйн зохицуулалтаар нэг бүрчлэн зохицуулах боломжгүй нөхцөлд бизнест чөдөр тушаа болж буй хууль тогтоомжийг хүчингүй болгож өөрчлөх,нэмэлт өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын аргуудыг ашиглах зэрэг уян хатан бодлогоор зохицуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Өнөөгийн эрхзүйн орчны хувьд гэрээ хэлцлийн түвшинд Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх эрхзүйн орчин бүрдсэн боловч оролцогч талуудын идэвхи санаачлага дутмаг, мэдээлэл муу, туршлага дутмаг, дүрэм журмуудын давхардлын улмаас үр дүн гарахгүй, тунхагийн шинжтэй байсаар л.

Түүнчлэн төрийн бодлогын залгамж чанар алдагдсан, хүнд суртал, төрийн албан хаагчдын харьцааны доголдол, хувийн хэвшлийн зүгээс хүссэн мэдээллээ авах эрх нь нээлттэй боловч энэ чухал харилцааг зохицуулсан журам байхгүй тул мэдээллийг хэрэгтэй үедээ олж авч чаддаггүй зэрэг олон хүчин зүйл Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа нь миний судалгааны явцад харагдлаа. (14) Тухайлбал,

- Маргааныг шийдвэрлэх хуулийн заалтууд хангалтгүй; Төрийн байгууллагын бүрүүтай үйлдлийг Захиргааны хэргийн шүүхэд өгөх эрх бүрэн хангагдаагүй; Хариуцлагын тогтолцоо нь ихэвчлэн иргэд, байгууллага, хувийн хэвшилд чиглэсэн нь Төр-хувийн хэвшлийн түншлэлийн гол зарчим болох Төр нь захирахгүй, эрх тэгш байдлын үндсэн дээр харилцах, хариуцлагыг талууд харилцан хүлээхээр зохицуулагдаж чадахгүй байна.
- Хууль тогтоомж нь гол төлөв ой, амьтан, ургамлыг хамгаалах, ашигт малтмалыг олборлох чиглэлээр боловсрогдсон бөгөөд ихэнх тохиолдолд газрын асуудлаас нь салгаж шийдвэрлэсэн нь хувийн хэвшлээс хөрөнгө оруулалт хийхэд саад болдог.
- Байгалийн нөөц баялгийг ашиглах асуудлыг газар өмчлөх,газар төлөвлөлтийн асуудлаас нь салгаж хуульчилсан. Олон улсын жишгээр байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах чиг хандлага нь гол төлөв газрын эрх, түүнийг тогтвортой ашиглах үзэл баримтлал дээр тулгуурладаг.
- Байгалийн нөөц баялгийг ашиглах тухай захиргааны шийдвэр гаргахдаа судалгаа шинжилгээний мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж, шинжлэх ухааны онолын дүгнэлт, бодитой баримт, мэдээлэлд тулгуурласан байх зарчмыг хэвшүүлэх, гаргасан шийдвэрээ олон нийтэд нээлттэй болгох;
- Санхүүжилтийн механизм. Байгаль орчны үйл ажиллагааг гол төлөв улсын төсөв, хандивлагч орны хөрөнгөөр санхүүжүүлэх, өөр эх сурвалжийн талаар хуулиудад дурьдаагүй;
- Орон нутагт шийдвэр гаргахад нутгийн

иргэдийн оролцооны асуудлыг тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй;

- Хуулиуд тунхагийн шинжтэй, хоорондоо зөрчилтэй, уялдаа холбоо муу, хэрэгжүүлэх процессийн нарийн заагаагүй;
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын ялгааг зааглаагүй, эрх зүйн орчны тодорхойлолт байхгүй зэрэг болно.

Бусад асуудлууд:

- Байгаль орчны салбарын бодлого, хуулиудын хэрэгжилт, зохион байгуулалт, менежментийн асуудал дутагдалтай;
- Төрийн холбогдох байгууллага,орон нутгийн байгууллага, хувийн хэвшлийн чадавхийн болон хүний нөөцийн,хөрөнгө санхүүгийн болон техник технологийн чадавхи дутмаг;
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар нийгэмд нэгдсэн ойлголтонд хүрээгүй, орон нутгийн болон иргэд, хувийн хэвшлийн ойлголт дутмаг, туршлага бага;
- Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа уялдаа холбоо муу, салбар дундын зохицуулалт байхгүй;
- Ил тод өрсөлдөх боломжийг бүрдүүлээгүй, хөрөнгө оруулагч төрийн олон институттэй харилцдаг тус тусдаа олон гэрээ байгуулах болдог;
- Тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хуульд заасан хугацаанд олгодоггүй, нээлттэй ил тод биш;
- Төрийн албаны тасралтгүй байх зарчим залгамж холбоо муу, улстөрийн нөлөөлөл хувийн хэвшлийн үйл ажиллагаанд нөлөөлдөг;
- Олон нийт болон төрийн бус байгууллагуудын шийдвэр гаргах, хянан шалгах үйл ажиллагаанд оролцох оролцоог хуульд заасан нь төдийлөн хэрэгждэггүй;
- Байгаль орчны салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад эдийн засгийн хөшүүргийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах /экологид ээлтэй техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх болон худалдан авсан хэрэглэгчийг банкны хөнгөлөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлтөнд хамруулах/ зэрэг болно.

Энэ бүхнээс дүгнэхэдбайгаль орчны салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дараах чиглэлд хөгжүүлэх нь зохистой гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

Нэг. Ойн менежментийн талаар:

Монголын нийт газар нутгийн 8 хувийг эзэлдэг ойн нөөцийн 76 хувь хөгширч байгаа учир ашиглах шаардлага тулгарсан. Монгол орны мод модон материалын хэрэгцээ жилд 3 сая шоо метр байхад 1 сая орчим шоо метр модбэлтгэх зөвшөөрөл олгож байгаа нь төрийн бодлого алдагдаж хууль бусаар мод огтлох, худалдаалах, авлига дэлгэрэх, аж ахуйн нэгжүүд хууль бус үйл ажиллагаа явуулах, мод ашигласны төлбөрөөс олох ашиг багасах зэрэг олон сөрөг үр дагаварт хүргэж байна. (15)

Мод бэлтгэлийн үйл ажиллагаа хууль ёсоор, ил тод явагдахгүй байгаагаас төсөвт орох ихээхэн хэмжээний орлого хаагдсаар байгаа бөгөөд жилд зах дээр зарагдаж байгаа модноос зохих төлбөрийг авч чадвал жилд 5-9 сая ам. доллар олох боломжийг алдаж байна.

Татварын ерөнхий газрын тайланг үзэхэд модны аж ахуй эрхэлдэг 700 орчим аж ахуйн нэгжээс жилд дунджаар 1,1 тэрбум төгрөгийн татвар цугларч байна. Модны бизнесийн 85 хувь нь нууцаар явагдаж байгаа гэсэн судалгааны дүнгээр тооцоход жилд зөвхөн татвараас 200-300 тэрбум төгрөг цуглуулах боломжтой. (16)

Хууль бус модны арилжаа нь Монгол оронд тогтвортой ойн салбарыг хөгжүүлэх, шударга бизнесийн орчинг бий болгоход саад тотгор болж байна. Хууль бусаар ажиллагчид татвар, хураамж төлдөггүй, хүний хөдөлмөрт хамгийн бага зардал гаргадаг нь хуулийн дагуу шударга бизнесийн өрсөлдөөнд байгаа хүмүүсийг цохиж модны үнийг буулгахад хүргэдэг. Модыг жинхэнэ өртгөөс нь бага үнээр зарж байгаа нь Монголын ойн салбарт оруулах эдийн засгийн үр өгөөжийг бууруулж байна.

Мод бэлтгэлийг хүчээр бууруулахын оронд Засгийн газрын бодлого нь модны эрэлт, хэрэгцээ ба нөөцийн харьцааны балансыг барьж модны хэрэгцээг ангилалд оруулах, модыг орлуулах материал үйлдвэрлэж байгаа компаниудыг татварын бодлогоор дэмжих зэрэг асуудлуудыг тусгасан хэрэгжүүц бодит, үр ашигтай стратеги боловсруулах шаардлагатай.

Ойн нөхөрлөлүүд, мэргэжлийн байгууллагуудыг менежментийн төлөвлөгөөг боловс-яруулахад удирдлагаар хангах, хөрөнгө оруулах, туслах, ойн ангийг бэхжүүлэх, тэднийг мэргэжсэн ажилчдаар хангах, хүнд сурталь олон шат дамжлагыг багасгах, төрөөс хөрөнгө санхүү, мэдээллээр хангах, харъяа ойн ангиудад сургалт явуулах, ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолт

хийж бэлтгэсэн модыг зах зээлд борлуулах эрх олгох зэргээр чадавхижуулах арга хэмжээ авах шаардлагатай.

Зах зээлийн эдийн засагт шилжих үед Монгол Улсын мод, модон материал, түлшний хэрэгцээг хангадаг ойн аж ахуй дампуурсанаар бодит эрэлт хэрэгцээг хангах орон зайг хууль бусаар мод бэлтгэгчид эзлэж жил бүр дунджаар 200 тэрбум төгрөгийн орлого төсвөөс алдагдаж далд эдийн засаг уруу урссаар байна.

Ой хамгаалах гол арга зам бол нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийг түшиглэсэн бодлого бөгөөд нутгийн иргэдэд ойн санг гэрээгээр эзэмшүүлэх явдлыг дэмжих, ойн нөхөрлөлүүдийг байгуулахыг дэмжиж, мэргэжлийн байгууллагуудыг өндөр технологи нэвтрүүлэхийг дэмжих, чадавхижуулах талаар төрөөс тодорхой бодлого боловсруулах шаардлагатай.

Хоёр. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент

Тусгай хамгаалалттай газруудад газар ашиглах эрхийг 5 хүртэл жил байхаар хуулиар зохицуулсан нь амьдралд нийцэхгүй, иргэд хувийн хэвшлийнхэнд эргэлзээ үүсгэж хөрөнгө оруулалт хийхэд саад болж байна. Компаниуд 5 жилийн хугацаатай ашиглахаар авсан газар дээрээ барилга байгууламж сүндэрлүүлж, хоорондоо арилждаг болж, авлига цэцэглэсэн нь нууц биш.

Өнөөдрийн байдлаар 99 тусгай хамгаалалттай газар байгаагийн гуравны нэг орчмыг хамгаалалтын захиргаатай болгон тэдгээрт улсаас жил бүр 6-7 тэрбум төгрөг зарцуулж байна. (17)

Энэ асуудлыг шийдвэрлэх цорын ганц гарц нь хамгаалалтын захиргааг хувийн хэвшилд шилжүүлэх бөгөөд ингэж чадвал жилд 600 орчим тэрбум төгрөгийг улсын төсвөөс хэмнэх боломжтой. /Хустайн нурууны жишээ сайн туршлага болж байна/ Иймээс Тусгай хамгаалалттай газруудын менежментийг хувийн хэвшилд шилжүүлсэнээр төр их хэмжээний төсөв хэмнэх, хувийн хэвшлийн ашиг орлого нэмэгдэж ажлын байр нэмэгдэх, улмаар татварын орлого өсөх, байгаль орчны хамгаалалт сайжрах зэрэг олон талын ач холбогдолтой.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийгдсэн тохиолдолд 5 жил хүртэл ашиглана гэсэн хуулийн заалтыг өөрчлөх шаардлагатай бөгөөд цаашдаа 50 жил хүртэл ашиглах, хуулиар оногдуулсан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа Аж ахуйн нэгж, байгууллагад газрыг нь эзэмшүүлэх эрхийг нээж өгөх нь зохистой.

Гурав. Хог хаягдлын менежмент

Хог хаягдлын асуудал аливаа улс орны хөгжлийн бодлоготой уялдаж байдаг ба Улаанбаатар хотод орчны бохирдол, хог хаягдал тулгамдсан гол асуудал болж байна. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах, ангилах дахин боловсруулах ажиллагааг сайжруулахаар нийслэлээс тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж авч байгаа ч хог хаягдлын менежмент хоцрогдсон хэвээр байна.

Нийт хог хаягдлын 90 хувийг дахин ашиглах боломж байсаар байтал өнөөдөр дөнгөж 10-15 хувийг хог хаягдлаар бизнес эрхлэгч компаниуд худалдан авч байна. Хог хаягдлыг ангилах, булшлах ажилд тавигдах стандартуудыг тогтоох шаардлага тулгамдаж байгаа, цаашид хогийг ангилдаг, ялгадаг үйлдвэрүүдийг хувийн хэвшилтэй хамтран барьж байгуулах шаардлагатай. (18)

Тиймээс хувийн хэвшлийн зүгээс Засгийн газартай хог хаягдлын менежментийн талаархи хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрөө одооноос боловсруулах хэрэгтэй. Төрөөс дэмжих асуудал нь татварын хөнгөлөлт чөлөөлөлт бөгөөд хаягдал өөрөө онцлогтой олон төрөл байдаг учраас боловсруулж угааж цэвэрлэхэдих хэмжээний зардалтай. Мөн хог түүж, цуглуулах, ачих, тээвэрлэх явцад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нян бактеритай ажилладаг учир хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалсан, хөдөлмөр хамгааллын арга хэмжээг авах шаардлагатай.

Дөрөв. Хуучин автомашиныг ашиглалтаас хасах, нөхөн олговор олгох талаар

Монгол Улсад 900,000 гаруй автомашин бүртгэгдсэнээс 400,000 гаруй автомашин өдөр тутам нийслэл хотын замын хөдөлгөөнд оролцож түгжрэл үүсгэж байгаагаас гадна агаарын бохирдлын 20 хувийг хуучин автомашинаас гарч байгаа утаа, тортог эзэлдэг. Автомашины түгжрэлээс болж манай улсад сард 55 тэрбум төгрөгийн шатахуун утаа болон замхарч дотоодын нийт бүтээгдэхүүний 2,7 хувийг үр дүнгүй алдаж байна. (19)

Цаашид байдал энэ хэвээр үргэлжилбэл 2022 он гэхэд Улаанбаатар хотын замын хөдөлгөөн 0 зогсолт хийх бөгөөд өдөр бүр 400 хуучин автомашин импортоор орж ирж байхад ашиглалтаас хасагдаж байгаа машины тоо жилдээ 1000-с хэтэрдэггүй. Дэлхийн ихэнхи орнууд хуучин автомашиныг үйлдвэрлэснээс хойш 5 жилийн дараа хянан баталгаажилт хийлгэх шаардлага тавьдаг, /энэ нь их үнэтэй учир Япон иргэд 5 жил болсон автомашинаа хямд зарахыг эрмэлздэг,

түүнийг нь Монголчууд импортолдог/ 10 жил болсон бол хөдөлгөөнд оролцуулахыг хориглодог.

Монгол Улс хуучин автомашиныг импортлоход тодорхой хязгаарлалт тавьдагтүйгээс хуучин автомашины оршуулгын газар болоход хүрээд байгаа бөгөөд нийт автомашины 70-с дээш хувь нь үйлдвэрлэснээс хойш 15-с дээш жил эдлэгдсэн бол дөнгөж 20 хувь нь 7 хүртэл жилийн насжилттай гэсэн статистик мэдээ байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Бурууталдаа хүрдтэй болон үйлдвэрлэснээс хойш 10-с дээш жил болсон автомашин импортлохыг үе шаттай хориглох; үйлдвэрлэсэнээс хойш 1-5 жил болсон автомашинуудад экологийн татварыг шатлалтайгаар ногдуулах, онцгой албан татварыг 2-3 дахин нэмэгдүүлэх замаар хуучин машины импортыг хязгаарлах; 15 жилээс дээш ашиглагдаж байгаа болон техникийн үзлэгт тэнцээгүй автомашинуудыг хөдөлгөөнд оролцохыг хориглох, ашиглахыг хориглосон автомашиныг төрөөс нөхөн олговор олгох замаар авч дахин боловсруулах үйлдвэрт цуглуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх; шинэ автомашины онцгой татварыг тэглэх замаар импортыг урамшуулах зэрэг болно.

Түүнчлэн хуучин дугуй импортлох нь аюултай хог хаягдлыг валютаар сольж байгаа хэрэг бөгөөд хуучин дугуйг шатааснаар агаар мандлыг нэн хортой хорт хавдар үүсгэгч бодисоор бохирдуулж байгаа учир 2021 оноос автомашины хуучин дугуйг импортлохыг хориглож шинэ дугуй импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх боломжтой юм.

Ашигласан материал

1- Д.Отгонтөгс. "Байгаль орчны салбар дахь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, эрх зүйн орчны төлөв байдал, тулгамдсан асуудал" сэдвээр бичиж буй докторын судалгааны ажлын хавсралт. 2020 он.
2- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын веб хуудас.
3- www.Legalinfo.mn веб хуудас. Монгол Улсын Үндсэн хууль.
4- Шүүх эрх мэдэл сэтгүүл. 2015 оны II улирлын дугаар. Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Ц.Цэлмэг. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал.
5- Мөн тэнд үзэх
6- www.Legalinfo.mn веб хуудас. УИХ-ын 64 дүгээр тогтоол.
7- Asian development bank, *Public-Private Partnerships (PPP) Handbook (Manila, 2008)*
8- ДЖефри Дэлмон. Төр, хувийн хэвшлийн түншлэл дэд бүтцийн төсөлд. Гарын авлага. УБ хот, 2019 он, 19 дэх талд
9- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сорилт, боломж. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ хот, 2017 он.
10- *Water projects; A Commercial and Contractual Guide (Kluwer Law international 2000)*
11- Department of treasury and finance, Partnershi ps Victoria (Melbourne, 2002)
12- Esty, Modern Project Finance; A casebook (2003)
13- Delmon, Private sector investment in frastructure; Project Finance, PPP project and risk (Kluwer law international and World bank 2009)
14- Отгонтөгс. "Байгаль орчны салбар дахь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, эрх зүйн орчны төлөв байдал, тулгамдсан асуудал" сэдвээр бичиж буй докторын судалгааны ажлын хавсралт. 2020 он.
15- Ц.Цэлмэг. Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологи шинж. УБ хот, 2012 он. Докторын диссертаци. 53 талд
16- Мөн тэнд
17- Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2019 он.
18- www.Legalinfo.mn веб хуудас. УИХ-ын 256 дугаар тогтоол.
19- www.Unuudur.mn веб хуудас. Өнөөдөр сонин. Нийслэлийн ЗДТГ-ын *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөвлөх С.Энхтөрийн ярилцлага. 2020 он.*

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭХ НЬ

Г.Наранбаатар
Их Засаг ОУИС-ийн ШУС-ийн захирал
доктор Ph.D. дэд профессор

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ"[1]. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын Олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ".[2] Монгол Улсын Олон улсын гэрээг хэрэглэх хандлагын хувьд эрх зүйн моннист тогтолцоотой улс юм.[3] Энэхүү тогтолцоо ёсоор нэгдэн орсон Олон улсын гэрээ нь үндэсний хууль тогтоомжийн нэг хэсэг болж, түүнтэй адил хүчин чадал бүхий баримт бичигт тооцогддог.[4]

Эдүгээ өмгөөлөл, хүний эрхийн салбарт түгээмэл холбогдох нийт 60 шахам гэрээ конвенц үйлчилж байгаагаас шүүхийн өмнөх,шүүхийн шатанд нотолгоог хэрэгжүүлэхэд өмгөөллийн оролцоог хангахад шууд хамаарал бүхий гол гол олон улсын гэрээ,конвенцоос энд тухайлан авч үзье.

Өмгөөлөгчид НҮБ-ын "Хүний эрхийн түгээмэл тунхаглал", "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт" болон бусад хүний эрхийг хамгаалахтай холбоотой пакт, гэрээ, конвенциуд, "Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаарх Олон улсын барын холбооны стандарт", Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчигчтэй харилцах талаар 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан НҮБ-ын 8 дугаар хурлаар батлагдсан "Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд", "Өмгөөлөгчийн үүргийн талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд", НҮБ-аас 1988 онд баталсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах цогц зарчмуудын тухай" конвенц, "Европын Хүний эрхийн хороо, НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг комиссын зөвлөмж, мэдэгдэл", НҮБ-аас 1979 онд баталсан "Хуулийг гүйцэтгэн хэрэгжүүлэх албан тушаалтан зан үйлийн тухай" конвенц,Монгол Улс 2000 онд нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг" конвенц зэрэг өмгөөлөгчийн үйл ажиллагаанд шууд хамаарах Олон улсын хууль зүйн хэм хэмжээг сайтар судалж үйл ажиллагаандаа мөрдөх зайлшгүй шаардлагатай байна.

1. НҮБ-аас 1948 онд баталсан Хүний эрхийн тунхаглал:

Уг тунхаглалын 11 дүгээр зүйлд: "... Гэмт хэрэгт сэжиглэгдэн яллагдаж буй хүн бүр өөрт тулгасан хэргийг өмгөөлүүлэх буюу өөрөө өмгөөлөх бүрэн боломжтойгоор хуулийн дагуу ил хэлэлцэж, гэм бурууtай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй". 12 дугаар зүйлд: "... Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байр, хувийн харилцааны нууц, нэр төрд нь дураараа халдах ёсгүй, тэгж оролцож, тийнхүү халдах гэвэл хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй"гэж заажээ.

Тунхаглалын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр адилхан хамгаалуулах эрхтэй" гэсэн бол 8 дугаар зүйлд "...Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдсөн хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй" гэж тус тус заажээ.

Дээр дурдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалт, зарчмууд нь өмгөөллийн зайлшгүй шаардлагыг нөхцөлдүүлж буй хүний халдашгүй эрхийн наадзахын хэм хэмжээг эрүүгийн процессын шатанд тууштай ханган баталгаажуулах эрх зүйн суурь нөхцөл,тодорхойлогч үндэслэл болж байгаагаараа онцлог юм.

2. НҮБ-ын 1966 онд баталсан "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын тухайд:

Энэ пактын 2 дугаар зүйлд: "...Энэхүү

1 "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем" Үндсэн хууль http://www.legalinfo.mn/law/details/367
2 Мөн тэнд
3 Pieter Koojimans, international publiekrecht in vogelvlucht / Wolter-Noordhoff. Groningen. 1994/ 82.
4 Joseph Gabriel starke, 'Monism and dualism the Theory of international law' /1936/ 17 british year book of international law. 66.

пактаар хүлээн зөвшөөрөгдсөн эрх нь зөрчигдсөн хүмүүс болон хохирогчийг хууль зүйн талаар хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээ авах,хууль зүйн хамгаалалтын /өмгөөлөл/ хэрэгслийг олгосон үед түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэглэх явдлыг хангах". 10 дугаар зүйлд: "Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүртэй өөрт нь хувь хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэн хүлэг ёсоор харьцах ёстой". Мөн 14 дүгээр зүйлд: Өөрийн сонгон авсан өмгөөлөгчтэй уулзаж,өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бодит боломцоотой байх..."[5] эрхтэй байхаар заасан.

3. НҮБ-аас 1988 онд баталсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах цогц зарчмуудын тухай конвенцийн тухайд:

Энэ конвенцийн 1 дүгээр зүйлд: "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгээ энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндээ хүндэтгүүлэх эрх эдлэх ёстой" гэж заасны дээр 18-р зарчимд "Саатуулагдсан болон хоригдсон этгээдийг хяналт, шалгалтгүй, бусдыг байлцуулахгүйгээр, өмгөөлөгчтэйгээ холбоо барих, харьцах, зөвлөлдөх, уулзах эрхийг олгоно, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн онцгой байдлаас бусад тохиолдолд түр зуур хүчингүй болгох буюу ямар нэг байдлаар хязгаарлаж болохгүй"[6] гэж заажээ.

Дээр дурдсан Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэдөмгөөлөл,тэр тусмаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах талын нотолгоог хэрэгжүүлэх хүрээнд нотолгооны цагаатгах баримт сэлтийг гарган оролцож буй өмгөөлөгчийн үйл ажиллагаа нь ямар нэг хөндлөнгийн хяналт, саадгүйгээр хэрэгжих ёстой жишиг, зарчим болгон тусгасныг харж болно. Түүнчлэн шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд эрүүгийн журмаар сэжигтэн, яллагдагчаар татагдаж мөрдөгдөн шалгагдаж буй хэн боловч өмгөөлүүлэх, өмгөөлөгч авах эрхээр чөлөөтэй хангагдах[7], ингэхдээ цаг хугацааны болон бодит хүчин зүйлээр хязгаарлагдахгүй байх шаардлагаар илэрнэ.

ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 3-т: "Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих нь /шүүхээс өмнө/ нийтлэг журам байх ёсгүй" гэж заасны дээр НҮБ-ын Хүний эрхийн хорооны зөвлөмжид "...Урьдчилан хорих нь зайлшгүй авах арга хэмжээ биш, хуулиас гадуур ангид зүйл юм[8] гэж тэмдэглэсэн" байдаг.

Судлаачдын үзэж байгаагаар пактаар хүлээн зөвшөөрөгдсөн эрх нь зөрчигдсөн хүмүүс, хохирогчийг хууль зүйн талаар хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээг авах хууль зүйн хамгаалалт(өмгөөлөл)-ын хэрэгслийг олгосон үед түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэглэх явдлыг хангах "Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр өөрт нь хүнлэг бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэх, хүн ёсоор хандах эрх эдэлнэ." зэрэг нь дээр дурдсан Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд Монгол Улс нэгдэн орсон болон тэдгээрийг соёрхон баталсан үеэс үндэсний хууль тогтоомжийн адил үйлчилдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл өмгөөлөгч тэдгээрийг заавал үйл ажиллагаандаа мөрдөнө гэсэн үг. Хэрэв энэхүү эрх зөрчигдвөл эрүүгийн процессын Олон улсын эрх зүйн зарчимд огт нийцэхгүй зүйл..." юм.[9] Тийм учраас болж өнгөрсөн нөхцөл байдлын бодит үнэнийг тогтоохын тулд хууль, Олон улсын гэрээнд тогтоосон үндэслэл, тодорхойлсон журмын дагуу эрх бүхий байгууллагын албан тушаалтнаас хуульчилсан үүргийн дагуу хэрэгжүүлж байгаа дэс дараалалтай, нарийн уялдаатай үйл ажиллагааны цогц гэж ойлгож болно.

4. Европын Хүний эрхийн хороо, НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг комиссын зөвлөмж, мэдэгдэлд:

Эдгээр Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд зааснаар "... Шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд гэм буруутай эсэх нь нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй үед таамаглан сэжиглэгдэж баривчлах, яллах явдлыг хуулиар зөвшөөрч хэзээ ч болохгүй. Цагдан хорих арга хэмжээг хавтгайруулан хэрэглэж болохгүй, онцгой тохиолдолд л хэрэгжүүлэх ёстой, удаан хугацаагаар цагдан хоригдож байгаа болон ийм нөхцөлд байхдаа хүнлэг бус, заналхийлэл, хэрцгий хандлага, харьцааг амсаж байгаа нь Эрүү шүүлтийн эсрэг конвенцийг зөрчиж буй явдал юм..."[10] гэж дурдсан байдаг.

5. Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмуудад хүн бүр өөрийн эрхийг хамгаалахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд өөрийгөө хамгаалахын тулд хуульчид (өмгөөлөгч) хандах эрхтэй.

5 *Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх – НҮБ УБ., 1996 он. 101-102 дахь тал.*

6 *Мөн тэнд үзэх.*

7 *Мөн тэнд үзэх.*

8 *Эмнести Интернэшнл. Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь Гарын авлага УБ., 2004 он. 129 дэх тал.*

9 *Truber D Human rights: Legal and polisy issues Oxford 1984 vol 1 p.19-21.*

10 *Эмнести Интернэшнл. Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь Гарын авлага УБ., 2004 он. 129 дэх тал.*

Засгийн газар нь баривчлагдсан буюу хоригдсоноос хойш 48 цагаас хэтрүүлэхгүйгээр хуульчид нэн даруй хандах явдлыг хангана. Баривчлагдсан, саатуулагдсан, шоронд хоригдсон бүх этгээд хуульчтай уулзах зохих боломж хугацаа, нөхцөл, түүнтэй саадгүй, бусдын оролцоогүй, бүрэн ганцаарчлан харьцах,зөвлөлдөх,тийм зөвлөгөө хууль хэрэгжүүлэх албан тушаалтны дэргэд,тэгэхдээ тэд нар сонгох боломжгүйгээр хийлгэх явдлыг хангах ёстой.[11] Манай эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үүнд нийцүүлэн өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.1 дүгээр зүйлд "Гэрч,сэжигтэн,яллагдагч,шүүгдэгчтэй ганцаарчлан даруй уулзах,түүнээс мэдүүлэг авахад байлцах,асуулт тавих эрхтэй" талаар хуульчилсан.

6. НҮБ-аас 1979 онд батлалсан "Хуулийг гүйцэтгэн хэрэгжүүлэх албан тушаалтан зан үйлийн тухай" конвенцид:

Энэхүү конвенц буюу тухайн зан үйлийн хуулийн 5 дугаар зүйлд: "Хуулийг гүйцэтгэн хэрэгжүүлж буй ямар ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр... хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон /басамжлан/ харьцах, өдөөн хатгах, залхаах, цээрлүүлэх, хуурч мэхлэх... зэргээр харьцаж болохгүй" бөгөөд ийнхүү хандсан явдлыг"... дээд шатны албан тушаалтны тушаал, захирамж, дайны байдал дотоодын улс төрийн тогтворгүй байдал зэргээр зөвтгөж болохгүй..."[12] гэж заажээ.

Түүнчлэн НҮБ нь өмгөөлөгчдөд ажил, үүргээ биелүүлэхэд нь тус дэмжлэг үзүүлэх, зохих боломж нөхцлөөр хангах зорилгоор НҮБ-аас 1990 онд 45/121 тоот тогтоол баталсан.

7. НҮБ-аас 1990 онд батлан гаргасан "Өмгөөлөгчдийн ажил, цүргийн талаарх үндсэн зарчим" гэсэн конвенц:

Тус конвенцийн 13 дугаар зүйлд заасанчлан өмгөөлөгч нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах замаар эрүүгийн процесст оролцох... өмгөөлөл явуулснаар үүрэг хариуцлага хүлээхээр тусгасны дээр 14, 15 дугаар зүйлд зааснаар харилцагч, үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд үнэнч шударгаар үйлчлэх, үндэсний төдийгүй Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр олгосон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөвшөөрөгдсөн хуулийн хүрээнд өөрийн итгэл, ёс зүйн дагуу хараат бусаар ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа чөлөөтэй явуулах чиг үүрэгтэй ажиллах ёстойг заасны дээр "... Өмгөөлөгчийн ажил, үүргээ гүйцэтгэх явцад айлган сүрдүүлэх, саад учруулах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, мөрдөн мөшгих, хөндлөнгөөс зүй бусаар нөлөөлөх, оролцох явдал гаргуулахгүй байж, тэдний аюулгүй байдалд заналхийлэл учирвал төрийн байгууллага, албан тушаалтан зохистойгоор хамгаалахыг улс орнуудын төр, засгийн газарт үүрэг болгохоор..."[13] заажээ.

Энэхүү конвенц нь өмгөөллийн үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус, мэргэжлийн бөгөөд процесс ажиллагаа мөн болохыг нь Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсний баталгаа болсон төдийгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд өмгөөлөгчийн идэвхтэй оролцох шаардлагыг Олон улсын эрх зүйн түвшинд хангахад чухал алхам болсон байна.

8. Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаарх Олон улсын Барын Холбооны стандартад:

"... Өмгөөлөгч нь үйл ажиллагаа, статусын хувьд бие даасан байх нь хүний эрхийг хангах баталгаа бөгөөд өмгөөлөгч нь үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэхэд шууд ба шууд бус байдлаар элдэв саад учруулах, хүндэтгэх шалтгаангүйгээр хууль ёсны шаардлага, хүсэлт тавихад нь үл тоомсорлон харьцах, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хориг, хязгаарлалт тавих зэргийг гаргуулахгүй байх баталгааг бүрдүүлэх талаар улс орнууд хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэх талаар заасан нь бий.[14]

9. Монгол Улс 2000 онд нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад

Хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг" конвенц:[15]

Уг зарчмын агуулгаас үзэхэд: "...Өмгөөлөгч нь эрүүдэн шүүх замаар авсан мэдүүлгэн нотлох баримтыг нотолгооны хүчин чадалгүйд тооцох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын хууль зөрчсөн ажиллагаанаас учирсан хохирлыг арилгах эрх зүйн үндэс бүрдсэн зэргийг харгалзан үйлчлүүлэгчдээ туслах ажиллагааг идэвхтэй явуулах..." шаардлагатай.

---

11 *"Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх – НҮБ" УБ., 1996 он. 101-102 дахь тал*

12 *Международные акты о правох человека Сборник документов М., 2004 с.40-41.*

13 *Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл /Эрүүгийн эрх зүй. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. эмхтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо/ УБ., 2012 он.*

14 *Өмгөөлөл судлал I-р боть УБ., 2011 400 дэх тал.*

15 *Хүний эрх: Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл УБ., 1988 он, 50 дахь тал.*

Түүнчлэн Хүүхдийн эрхийн конвенцийн "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг", "Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны наад захын дүрэм" зэрэг холбогдох бусад Олон улсын гэрээ, конвенцид мөрдөн шалгах ажиллагаа болон үзлэг, нэгжлэг, мэдүүлэг зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой тохиолдол, харьцаа үүсэх бүрд хүний салшгүй эрхийн үнэт зүйлс, халдашгүй байдлыг хүндэтгэн харгалзах, өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хүлээцтэй бөгөөд чиг үүргийг нь хүндэтгэн хүлээн зөвшөөрч хандах шаардлага, зарчмыг хангаж ажиллахыг уриалсан.

10. Монгол Улс 1990 онд соёрхон баталсан "Хүүхдийн эрхийн конвенц":

"Хүүхдийн эрхийн конвенц"-ийн 19 дүгээр зүйлд оролцогч улсуудад эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч болон хүүхдийн төлөө анхаарал халамж тавих бусад хүмүүсийн зүгээс доромжлох бусад үүргээ хортойгоор ашиглах анхаарч халамжлахгүй байх, хайхрамжгүй харьцах зэрэг бие бялдар, сэтгэл санааны талаар хүчирхийлэх бүх хэлбэрээр хүүхдийг хамгаалах талаар олон талын арга хэмжээг авах, нэг ч хүүхдийг тамлан зовоох хэрцгийгээр харгислах,хүний ёсноос гадуур харьцаа, нэр төрийг гутаан харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийг үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу ямар нэгэн хөнгөлөлтгүйгээр бүх насаар гянданд хорих ял оногдуулахгүй байх, эрх чөлөөг хасахгүй байх, хүүхдийг баривчлах, албадан саатуулах, гянданд хорих явдлыг хуулийн дагуугүйцэтгэх бөгөөдгагцхүү эцсийн арга хэмжээ болгож аль болох богино хугацаагаар хорихыг (37 дугаар зүйл үүрэг болгосны өмгөөлөгчид мэдэж байх учиртай. Энэ конвенц болон НҮБ-ын насанд хүрээгүй хүмүүсийн талаарх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмийг 1985 онд ерөнхий ассемблейн 40/33 дугаар тогтоолоор батлагдсан) үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлан хуульчилж тогтоохдоо өмгөөлөгчийн үүрэг оролцооны эрх зүйн байдлын дээрдүүлсэн. Дээр дурдсан НҮБ-ын наад захын жишиг дүрмийн 13-т зааснаар шүүхээс өмнө цагдан хоригдож байгаа насанд хүрээгүй хүмүүс хоригдлууд харьцах наад захын жишиг дүрэм түүнчлэн Иргэний болон улс төрийн эрх тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд 2,6 ,10 дугаар зүйлийн 2(В) болон 3 дахь заалтанд дурьдсан бүх эрх баталгаа, түүнчлэн өмгөөлүүлэх, эрх зүйн туслалцаа авах эрхээр хангагдана.[16]

Бүхэлдээ тоймлон дүгнэж үзвэл өмгөөлөгчийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, зарчмыг тодорхойлоход НҮБ-аас гаргасан Олон улсын гэрээ, конвенцууд онцгой ач холбогдолтой бөгөөдялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэрэгжүүлэх, хүний эрхийг хангах хамгаалахад өмгөөлөгчийн оролцоо эрүүгийн процесс ажиллагаанд чухал төдийгүй хяналтын механизмыг хэрэгжүүлэх боломжоор хангагдах зэрэг хүний эрхэд суурилсан эрх зүйт төрийн үндсэн шинж байхаар эрх зүйн зохицуулалтын шинэ орчныг бий болгох баталгааг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Цаашдаа процесст оролцож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогчийн эрхийг тэнцвэртэй, зохистойгоор хангах, мөрдөгч, прокурорын яллах чиг үүрэг бүхий процессын харилцаан дахь хэтдавуубайдлыг хязгаарлах,нотлох баримтыг цуглуулах зарим эрхийг өмгөөлөгчид олгох, өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг улам бүр сайжруулж, нэгдэн орсон болон соёрхон баталсан Олон улсын гэрээ, конвенцид заасан зарчим, хэм хэмжээний дагуу үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох зэрэг олон тулгамдсан асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

16 *"Хүний эрх: Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл" УБ.. 1988 он. 5/ьч Жиллиан Даггин бэлтгэв./*

ОХУ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Ц.Цэлмэг

Их Засаг ОУИС-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор доктор (Ph.D), профессор

Монгол Улс нь хууль цаазын эртний уламжлалтай орон бөгөөд 1206 онд Чингис хааны "Их засаг" хууль нь анхны бичмэл Эрүүгийн хуулийн шинжийг агуулдаг билээ.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хууль нь 2015 ондМонгол Улсын Их Хурлаар батлагдаж 2017 оны 07 сарын 01-нээс эхлэн үйлчилж байгаа харьцангуй шинэ хууль юм.

Монгол Улс нь 1921-2015 он хүртэл ЗХУ болон ОХУ-ын Эрүүгийн хуулийг загвар болгон хуулбарлан хэрэглэдэг байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар зөвхөн нэг улсын хуулийг хуулбарлаж батлах бус гадаадын хөгжингүй орнуудын Эрүүгийн хуулиуд, Эрүүгийн хуулийн загваруудыг харьцуулан судлаж, нутагшуулан хэрэглэх боломжтой сайн туршлага, зүйл заалт, институтыг авах замаар зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтийг хийсэн бөгөөд эдгээр хэм хэмжээ,институтын талаар ОХУ-ын хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтуудтай харьцуулан судалсанаа толилуулая.

Нэг. Монгол Улсад 2017 оноос эхлэн гэмт хэргийн бүрэлдэхүүн (состав преступления) гэх ойлголтыг Эрүүгийн хуульд хэрэглэхгүй болсон.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн гэх ойлголт нь "corpus delicti" гэсэн латин үгнээс гаралтай ба Германы "Tatbestad" буюу хуулийн бүрэлдэхүүн, ОХУ-д "состав преступления", БНХАУ-д "ялын бүрдэл" зэргээр томъёолсон[1].

Их Британи, Америкийн Нэгдсэн Улс зэрэг нийтийн эрх зүйн бүлийн орнуудын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүн гэсэн ойлголт байхгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхэд объектив болон субъектив үндэслэл болох гэмт этгээдийн хууль зөрчсөн үйлдэл (actus reus) тухайн этгээдийн гэм буруу (means rea) байх шаардлагатай ба эдгээр нь нотлогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг жишгийг Монголын шинэ хуулиар бүрдүүлсэн.

Харин Орос-Зөвлөлтийн эрүүгийн эрх зүйн эрдэмтэд гэмт хэргийг объект, объектив тал, субъект, субъектив тал гэсэн бүрдэл хэсэг, шинжүүдээс тогтох 4 элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг боловсруулан хөгжүүлсэн бөгөөд энэ онол хуучнаар социалист системийн болон ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудын эрүүгийн эрх зүйд дэлгэрч одоог хүртэл байр сууриа хадгалсаар байна.

Хоёр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Монгол Улсад 2017 оноос эхлэн гэмт хэрэг үйлдсэн хувь хүнээс гадна хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг болон олон нийтийн эрх ашгийг хөндсөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 38 гэмт хэрэгт хувь хүнээс гадна хуулийн этгээдэд торгох ял[2] оногдуулахаар заасан. Жилд дунджаар 3 хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа ба голчлон байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэрэглэжээ. Хуулийн этгээдэд 10 саяас 400 сая төгрөгийн торгуулийн ял оногдуулахаар зааснаас (200,000-8000.000 рубльтэй тэнцэнэ) гадна эд хөрөнгийг хураах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хуулийг этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээг давхар авч болохоор хуульчилсан онцлогтой.

Хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах практик шаардлага нь компаний эзэд хөлсний ажилтан,менежерүүдийн ард ямар нэгэн хариуцлага хүлээхгүй үлддэг, хууль зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, менежер, гүйцэтгэх захирал зэрэг албан тушаалтнууд хариуцлага хүлээж компаний жинхэнэ эзэд хариуцлага хүлээхгүй байгаа явдлыг халах зорилгоор хийгдсэн өөрчлөлт юм.

Гурав. Гэмт хэргийн ангилалтын талаар:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 15 дугаар

1 *Г.Гантөмөр. Б.Энхболд. С.Гантулга. Ж.Төгс-Очир нар. Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги /сурах бичиг/. УБ хот. 2020 он. 168 дахь тал*

2 *http://www.consultant.ru cons_Уголовный кодекс Российской Федерации*

зүйлд гэмт хэргийг нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнээс хамааруулан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна[3] хэмээн заасан нь Монгол Улсын 1941-2015 он хүртэлх Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангилалтай адил байна.

2015 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн[4] шинэчилсэн найруулгын 2.6 дугаар зүйлд гэмт хэргийг ялын төрөл хэмжээг нь шалгуур болгон хөнгөн болон хүнд гэсэн хоёр ангилалтай байхаар тусгажээ. Энэ нь Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой зарим орнуудад хэрэглэгддэг "felony" and "misdemeanor" ойлголттой агуулгын хувьд ойролцоо болсон.

Хүнд гэмт хэрэг нь хорих ялын доод хэмжээг 2 жил түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хамруулдаг бол хөнгөн гэмт хэрэг нь хорих ялын дээд хэмжээг 5 жилээс доош оногдуулахаар заасан, эсвэл хорих ял оногдуулахгүй хэргийг хамруулна.

Дөрөв. Гэмт хэргийн хөнгөн хэлэлцэх хугацааны талаар:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "..хөнгөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш ба шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл тоолно" гэжээ[5].

Монгол Улсын хувьд 2017 он хүртэл хөнгөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр хүртэл тоолдог байсан бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд, тэдгээрийн өмгөөлөгч нар нь эрүүгийн хэргийг шүүхээс мөрдөн байцаалтанд буцаалгах, элдэв арга саам хэрэглэн хөнгөн хэлэлцэх хугацаа дуусгаж ял завшдаг үзэгдэл олширсон тул Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...хөнгөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно" гэж өөрчилсөн.

Өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалтын ажиллагаа эхэлсэн үеэс хөнгөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох болсон нь ял завших нэгэн үүдхаалгыг хаасан гэж тайлбарладаг.

Түүнчлэн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 83 дугаар зүйлд "Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөнөөр ялаас чөлөөлөх" тухай заалт байх бөгөөд шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсоноос хойш тодорхой хугацаанд биелэгдээгүй бол ял эдлүүлэхээс чөлөөлөхөөр заажээ. Монгол Улсын хувьд 1961-2002 оны хооронд дээрхтэй төстэй заалт Эрүүгийн хуульд байсан боловч 2015 оноос эхлэн шүүхийн шийтгэх тогтоолыг хугацаа өнгөрсөнийг харгалзаалгүйгээр биелүүлэх үзэл баримтлалтай болжээ.

Тав. Ялыг тэнсэх талаар:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлд "...Шүүх хүмүүжлийн ажил хийлгэх, цэргийн албыг хязгаарлах, сахилгын цэргийн ангид байршуулах, найм хүртэлхи жилийн хугацаагаар хорих ял оногдуулахдаа түүнд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж болно" хэмээн заажээ. Монгол Улсын тухайд 1961-2015 оны хооронд зөвхөн 1-5 жилийн хугацаатай хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсдэг байсан бол 2017 оноос эхлэн ял оногдуулахгүйгээр тэнсдэг болсон.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "...Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно" хэмээн заажээ.

Энэ нь Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой зарим орнуудад хэрэглэгддэг "probation" ойлголттой дүйх агуулгатай байдлаар хуульчилсан бөгөөд тэнсэх үед үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг[6] хамт хэрэглэхээр заасан онцлогтой.

Зургаа. Ялын төрөл хэмжээний талаар:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд доорх 12 төрлийн ялыг хуульчилсан байна. Үүнд: Торгох, Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах, Албадан ажил хийлгэх, Хүмүүжлийн ажил хийлгэх, Цэргийн албыг хязгаарлах, Эрх чөлөө хязгаарлах, Баривчлах, Сахилгын цэргийн ангид байршуулах, Тодорхой хугацаагаар хорих, Насан туршид нь хорих, Цаазаар авах эрэгт болно.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрөл нь торгох, нийтэд тустай

3 *www.Legalinfo.mn Монгол Улсын хууль тогтоомжийн нэгдсэн веб сайт.*

4 *Мөн тэнд үзэх*

5 *http://www.consultant.ru cons_Уголовный кодекс Российской Федерации*

6 *www.Legalinfo.mn Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7.2 болон 7.3 дугаар зүйлийг үзэх.*

ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял, эрх хасах гэсэн 5 төрлийн ялаас бүрдэнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуульд байгаа 12 төрлийн ялаас Монгол Улсад

1. Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах;
2. Хүмүүжлийн ажил хийлгэх;
3. Цэргийн албыг хязгаарлах;
4. Баривчлах;
5. Сахилгын цэргийн ангид байршуулах;
6. Цаазаар авах гэсэн 6 төрлийн ялыг хуульчлаагүй, хэрэглэдэггүй болно.

Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт протоколд[7] Монгол Улс 2012 онд нэгдэн орж улмаар 2015 онд Эрүүгийн хуулиас цаазаар авах ялын тухай заалтыг хассан.

Судлаачийн хувьд аливаа улсын Эрүүгийн хуульдялын төрөл,хэмжээ илүү сонголттой байхыг дэмждэг бөгөөд энэ ч утгаараа Монгол Улс нь ОХУ-ын Эрүүгийн хуульд байгаа Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах, Цэргийн албыг хязгаарлах, Баривчлах, Сахилгын цэргийн ангид байршуулах зэрэг ялын төрлийг нутагшуулан авах нь зүйтэй гэсэн саналыг гаргадаг.

Тухайлбал, Монгол Улсад "Генерал" цолтой 4 хүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоолоор яллагдсан бөгөөд "Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах" ял байхгүйгээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Генерал" цолыг хураан авсан боловч саяхан улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан нэг генералын цолыг буцаан сэргээх зэргээр ямар ч хуулийн үндэслэлгүй, үзэмжээр хандах явдлыг эцэс болгож Эрүүгийн хуульд нэмэгдэл ял хэлбэрээр хуульчлах цаг болжээ.

Долоо. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх талаар:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлд[8] "Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх", 76 дугаар зүйлд "Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлага чөлөөлөх", 80.1 дүгээр зүйлд "Нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хариуцлагаас чөлөөлөгдөх" зэрэг энэрэнгүй ёсны зарчмын илрэл болсон хэд хэдэн заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгах нь зүйтэй байна.

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг удирдлага болгож хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн хэргээ илчилж ирсэн, хохирогчтой эвлэрээд байхад холбогдох хэргийг заавал шүүхэд шилжүүлж хорихоос өөр төрлийн ял оногдуулж байгаа нь хүмүүсийн эрх зүйн байдлыг дордуулж байгааг яаралтай засах шаардлагатай.

Найм. Ялтай байдлын талаар:

Монгол Улсын хувьд 1961-2015 он хүртэл "Ялтай байдал" хэмээх заалтыг Эрүүгийн хуульдаа тусгаж байсан ч 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг батлах үед энэ ойлголтыг халсан.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд "...Ялтан шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түүнийг ялгүйд тооцох буюу ялгүй болох хүртэл хугацаанд ялтайд тооцогдоно", Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж яллагдсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш гурван жил өнгөрсөн, Хүнд гэмт хэрэг үйлдэж яллагдсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш зургаан жил өнгөрсөн, Онц хүнд гэмт хэрэг үйлдэж яллагдсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш зургаан жил өнгөрсөн тохиолдолд сая ялтай байдал дуусаж ялгүйд тооцогдохоор байна.

Монгол Улсад хариуцлагаа хүлээсэн л бол дараа нь нийгэмд хэвийн амьдрах боломжийг байх ёстой гэж үздэг бөгөөд Олон улсын нийтийн эрх зүйн жишгээр нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэсэн суурь зарчимд нийцүүлсэн гэж ойлгодог.

ДҮГНЭЛТ

Монгол Улс хэдий хууль цаазын эртний түүхэн уламжлалтай орон хэдий ч 1924-2002 он хүртэл ЗХУ-ОХУ-ын Эрүүгийн хуулийг шууд хуулбарлан хэрэглэдэг байв. Шинэ үеийн Монголын сэхээтнүүд тухайн үеийн ЗХУ-д хууль зүйн боловсрол эзэмшиж эрүүгийн хэргийг мөрдөх, шалгаж шийдвэрлэх процесс ч мөн Зөвлөлтийн сургагчдын арга барил,үзэл баримтлалд тулгаарлаж байсан.

1992 онд Монгол Улс шинээр Үндсэн хуулиа батлан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулах зорилтын хүрээнд хууль тогтоомжийн реформ хийж эхэлсэний үр дүнд 80 орчим хуулиар нийгмийн харилцааг зохицуулж

7 *Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights. opened for signature 15December 1989, 990 UNTS 3 (entered into force 11 July 1991) ('OP2')*

8 *http://www.consultant.ru cons_Уголовный кодекс Российской Федерации*

байснаа 2021 оны байдлаар 650 гаруй хуулиар зохицуулж байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэл 2002 оноос эхэлсэн бөгөөд Германы хуульч эрдэмтдийг Монголд урьж шинээр боловсруулсан эрүүгийн материалаг болон процессийн хуулийн төсөлд саналыг нь тусгасан.

ОХУ болон Монголын Эрүүгийн хууль нь төрөлжүүлж нэгтгэсэн хууль бөгөөд Герман, Франц зэрэг улсууд шиг /зэрэгцсэн Эрүүгийн хуультай улсууд/ өөр хуульд гэмт хэргийн шинж, эрүүгийн хариуцлагын талаар тусгадаггүй байдлаараа адил.

2015 оноос Монгол Улс нь эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийг гүнзгийрүүлж Эрүүгийн материаллаг болон процессийн хуулийг шинэчлэн баталсан бөгөөд Герман, ОХУ, Франц улсуудын хууль тогтоомж болон Англо-Американий эрх зүйн тогтолцоотой орнуудын хууль тогтоомжоос сайн туршлага, жишгийг нутагшуулан авах замаар шинэчлэлийг хийсэн.

Энэ илтгэлээрээ ОХУ болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн гол 8 институын хүрээндхарьцуулсан судалгаа хийснээ та бүхэнд толилууллаа, цаашид судалгааны ажлаа гүнзгийрүүлж ерөнхий ангийн бусад зүйл заалт болон тусгай ангид заасан онцлог гэмт хэргүүдийн бүрэлдэхүүн, шинжийг харьцуулан судлах болно.

АШИГТ МАЛТМАЛЫГ ЭРҮҮГИЙН ХУУЛИАР ХАМГААЛАХ ШААРДЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

С.Өөдлөх
Их Засаг ОУИС-ийн докторант

Түлхүүр үг: Ашигт малтмал, Эрүүгийн хууль тогтоомж

Хураангуй: Ашигт малтмалын хамгаалалт, ашиглалтыг Монгол Улсын Үндсэн хуульд хэрхэн тодорхойлсон, Эрүүгийн хуулиар хамгаалах шаардлагатай эсэх, энэ төрлийн гэмт хэргийн статистик, бүртгэгдсэн болон нуугдмал гэмт хэргийн харьцаа, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт, байгаль орчинд учирч буй хохирол хор уршигийг хэрхэн үнэлэх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй практик зэрэг тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар өөрийн дүгнэлт, саналыг товч илэрхийлсэн.

Монголчуудэртдээр үеэс амьдарч буй орон нутгийнхаа байгалийн зүй тогтлыг танин мэдэж байгаль орчноо хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээхэд үлэмж анхаарч зан үйл, ёс заншил, шашин шүтлэгээрээ зохицуулж ирсэнээс гадна төрийн бодлогоор хууль цаазтогтоож ирсэн байгаль дэлхийгээ хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн.

Бидний өвөг дээдэс арга-билгийн ухааны мөн чанар, дотоод шалтгааныг гүнзгий танин мэдсэн учраас байгаль дэлхийгээ тахин шүтэх олон шүтлэгийг бий болгож нутаг орныхоо онцлог хэсгийг дархлан хамгаалж иржээ.

Хүн төрөлхтөн байгальтай ухаалаг бус шунахай сэтгэлээр харьцсаны хор уршиг их бөгөөд ирээдүйдоршин тогтнох байгаль ахуйн орон зайтай байя гэвэл байгаль орчноо хамгаалах нь хүн бүрийн амин чухал ашиг сонирхол, иргэний үүрэг болжээ.[1] Өнгөрсөн нийгэмд байгалийг хүнээс хамгаалдаг байсан бол өдгөө хүний төлөө байгалийг хамгаалах шинжлэх ухааны үзэл баримтлал төлөвшөөд байна.[2]

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан ёсоор ашигт малтмал нь бусад байгалийн баялгийн нэгэн адил Монголын ард түмний мэдэл, төрийн хамгаалалт болон өмчлөлд оршдог[3].

Ашигт малтмал нь хүний амьдралын чанар, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлдэг, хөгжил дэвшлийн тулгуур хэрэглэгдхүүн болдог ач холбогдолтой, өндөр үнэ цэнэтэй, нөхөн сэргээгддэггүй зэрэг онцлогтой байгалийн баялаг юм.

Ашигт малтмал буюу геологийн хөгжил, хувьслын дагуу хэдэн сая жилийн өмнө манай эх орны газрын хэвлийд буй болсон, хөрөнгийн асар өндөр үнэлгээ бүхий эрдэс бодисын хуримтлалыг хэн өмчлөх, эзэмших, юуны тулд ямар зорилго, арга хэлбэрээр ашиглаж, захиран зарцуулах, ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох, боловсруулах, худалдах эрх олгох процесс, дэг журмын зохисыг олж тогтоох үүрэг монголын ард түмэнд ногддог гэж судлаачийн зүгээс үздэг.

Монгол Улс 1992 онд Шинэ Үндсэн хуулиар ашигт малтмалын өмчлөл, ашиглалтын эрх зүйн суурь үндэслэлийг тунхагласанаас хойш Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996) -аар байгалийн баялгийг нийтийн зориулалттай төрийн өмч болохыг хуульчилж түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг УИХ хэрэгжүүлэх учиртайг зааж, тэдгээртэй холбоотой харилцааг хуулиар тусгайлан зохицуулах чиглэлийг тогтоожээ[4].

Ашигтмалтмалын тухай хуулийг 1994,1997, 2006 онд гурван удаа батлаж, ашигт малтмалыг эрэх, хайх, ашигт малтмалын орд ашиглах болон хайгуулын талбай, уурхай эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тогтоосон билээ.

Гэтэл сүүлийн буюу 2006 онд шинэчлэн баталсан Ашигт малтмалын тухай хуульд эдүгээ нийт 33 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн үр дагавраар бий болсон замбараагүй олгогдсон

1 *Д.Содномгомбо, Р. Дарьхүү нар. Философи. УБ хот, 2004 он, 61 дэх тал*

2 *О. Амархүү. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ хот, 2004 он, 52 дахь тал*

3 *www.Legalinfo.mn веб хуудас. Монгол улсын Үндсэн хууль. 2019.11.14-нд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр дээрх "төрийн өмч" гэсэн тодорхойлолт "төрийн нийтийн өмч" болон өөрчлөгдсөн.*

4 *Д.Батболд. Ашигт малтмалын өмчлөл, ашиглалтын үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Нэг сэдэвт бүтээл. УБ хот, 2020 он, 5 дахь талд*

лицензцэгцлэх нэртэй их ажил нийгэмд тулгарч, экологийн хувьд эмзэг, эрсдэлтэй нутаг дэвсгэр дэх тусгай зөвшөөрлийг цуцлах, газар нутгийг улсын тусгай хэрэгцээндээ авах, тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг хууль гаргаж түр зогсоох зэрэг олон ажил төр засагт үүсэж энэ нь асар их хэмжээний нөхөн төлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлөх үүргийг Засгийн газар, түүний эх үндэс болсон монголын ард түмэнд буй болгодог.

Байгаль орчныг Эрүүгийн хуулиар хамгаалах зайлшгүй шаардлагын үүднээс улс орнууд Эрүүгийн хуульдаа экологийн эсрэг гэмт хэргүүдийг төрөлжүүлэн хуульчилж, оногдуулах ялыг чангатгах, хариуцлага гарцаагүй байх механизмыг тодруулж, экологийн цагдаагийн газар байгуулж гэмт үйлдэл, зөрчил нэг бүрийг илрүүлэн цээрлүүлж учруулсан хохирлыг үнэлж нөхөн төлүүлэх зэргээр тэмцэж байна.

Байгаль орчны хохирол гэж хүрээлэн буй орчин бохирдох, байгалийн нөөц баялаг хомсдох, экологийн тогтолцоо алдагдах зэргээс хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд аюул занал үүсэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөхийг хэлнэ[5].

Үнэлгээг тогтоохдоо эвдрэл, бохирдолд өртсөн объект тус бүрээр ялгавартайгаар авч үзэх, эсвэл орчных нь хэмжээнд (агаар, ус, хөрс, ургамал, газар) хохирлыг тооцно. Байгаль орчны бохирдлын эдийн засгийн үнэлгээнд бохирдлыг бууруулах зардлыг тооцсон хэмжээг үйлдвэрлэлийн байгаль орчны зардал гэнэ. Хохирлын үнэлгээний аргачлалд бохирдлын бодит хэмжээ, түүний аюул, үр дагаврыг бүсчлэн тогтооно. Эдийн засгийн эцсийн шийдэлд байгаль орчны хохирлыг үнэлж, нөхвөр зардал гаргах замаар үндэсний баялаг, байгалийн нөөцийг аж ахуйн эргэлтэнд зүй зохистойгоор оруулан бие хүн болон нийгмийн эрх ашгийг хамгаалах нөхцөл бүрдэнэ[6].

Монгол Улсад 1990-2000 он хүртэл жилд дунджаар 10 орчим байгаль орчны эсрэг гэмт хэрэг, 1500 орчим зөрчил бүртгэгддэг байсан бол 2018 оноос жилд дунджаар 350 орчим гэмт хэрэг, 15000 орчим зөрчил бүртгэгдэх болж олон дахин нэмэгдсэн[7].

Манай улсад жилд дунджаар 350 орчим экологийн эсрэг гэмт хэрэг бүртгэгдэж байгаагийн 40 орчим хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг, 30 орчим хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг, үлдсэн хувийг хууль бусаар ан агнах, ой хээрийн түймэр тавих гэмт хэргүүд эзлэж байна.

2019 онд 350 гэмт хэрэг, 2020 оны эхний 9 сарын байдлаар 520 экологийн гэмт хэрэг бүртгэгдсэнээс хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг 2019 онд 85 бүртгэгдэж байсан бол 2020 оны 09 сарын байдлаар 202 гэмт хэрэг бүртгэгджээ[8].

Гэхдээ энэ тоо баримт экологийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдлыг бүрэн тодорхойлж чадахгүй бөгөөд өнөөдрийг хүртэл манай судлаачид зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн хүрээндл судалгааг хийж энэ төрлийн гэмт хэрэг өсөж байна, буурч байна гэсэн дүгнэлт хийж ирсэн нь өрөөсгөл бөгөөд энэ нь мөсөн уулын оройг л харж ярьж байгаа хэрэг юм.

Гэмт хэрэг бол мөсөн уултай адил үзэгдэл бөгөөд уснаас цухуйж байгаа орой хэсэг нь бүртгэгдсэн гэмт хэргийг харуулдаг бол далд байгаа гол хэсэг нь нуугдмал гэмт хэрэг байдаг, харьцаа нь нэг бүртгэгдсэн гэмт хэргийн ард 3-10 гэмт хэрэг нуугддаг зүй тогтолтой бол зарим онцлог гэмт хэргийн тухайд 1:50, 1:100 байх ч боломжтой[9].

Аливаа гэмт хэргийн нуугдмал шинж тэр дундаа байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн нуугдмал шинжийг судлах шаардлага зайлшгүй бөгөөд нуугдмал гэмт хэргийн түвшинг бодитой тогтоохгүйгээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа амжилтад хүрэхгүй.

Тэгэхээр албан ёсоор бүртгэгдсэн хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах 202 гэмт хэргийн цаана 10100 орчим энэ төрлийн гэмт хэрэг нуугдаж байх магадлалтай гэсэн үг.

Тухайлбал, зуны дэлгэр цагаар 80,000 орчим хувираа ашигт малтмал олборлогч иргэн /нинжа гэж хар ярианд нэрлэдэг/ зөвшөөрөлгүй байгаль орчинд халдаж байгаа нь хор уршиг шаардахгүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсон 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар бараг л 80,000 гэмт хэрэг үйлдэгдэж байна гэж үзэж болно, түүнчлэн тусгай зөвшөөрөлтэй компаниуд нөхөн сэргээлт хийхгүйгээр нөхөн сэргээлт хийсэн мэтээр цаасан тайлан гаргадаг, эсвэл зүгээр л хаяж оддог, хайгуулын лицензавсан атлаа олборлох үйл ажиллагаа явуулж байгаа олон компани байгаа зэргээс харахад дээрх тоо бодитой болох нь

5 *Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал. БОАЖЯ, ред. Ц.Банзрагч. УБ хот. 2010 он. 18 дахь талд*

6 *Мөн тэнд*

7 *Ц.Цэлмэг. Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн ЭЗЗ-н болон криминологийн асуудал. Докторын зэрэг хамгаалсан бүтээл. УБ хот. 2012 он. 26 дахь талд*

8 *www.police.gov.mn ЦЕГ-ын веб хуудас. Гэмт хэргийн статистик. 2020 он.*

9 *Селянин. А.В. Криминология. М.. 2015. с-56*

харагдана.

Экологийн эсрэг хэргийн улмаас шууд хохирсон хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага байдаггүй, хохирогч нь дам утгаараа төр, бүс нутгийн болон улсын нийт иргэд байгаа нь энэ гэмт хэрэг илрэхгүй, нуугдмал байх гол шалтгаан болдог, байгаль орчныг хамгаалах үүрэгтэй эрх бүхий албан тушаалтнууд гэмт хэргийг илрүүлж чадахгүй, идэвх санаачлагагүй ажиллаж байгаа, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул, хууль тогтоомжийн хийдэл, боловсронгуй бус байдал болон хууль тогтоомжийн хэрэгжилт муу байгаа явдал экологийн гэмт хэргийг нуугдмал байхад нөлөөлж байна.

Энэ бүхнийг онцлон дурьдаж байгаагийн учир дор хаяж 10,000 гэмт хэрэг бодитой үйлдэгдэж байхад зарим ухвар мөчид түшмэд "... байгаль орчны эсрэг 500 хүрэхгүй гэмт хэрэг гарч байгаа нь анхаарал татах асуудал биш" гэж үздэгт хариу өгч энэ төрлийн гэмт хэргийн бодит гаралт хэд болох, нуугдмал гэмт хэрэг болон бүртгэгдсэн гэмт хэргийн харьцаа, ялгаатай талыг ойлгуулах, энэ гэмт хэргийн хор уршигийг нийтэд таниулж, хууль тогтоомжийн хийдэл, тулгамдсан асуудлыг тодорхойлсоноор Эрүүгийн болон Ашигт малтмалын хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтыг боловсронгуй болгоход өөрийн санал дүгнэлтээ таниулахаар энэхүү сэдвийг сонгон авсан болно.

2017 оноос шинэ Эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнээс хойш гэмт хэрэг үйлдсэн хувь хүнээс гадна хуулийн этгээдэдэрүүгийн хариуцлага хүлээлгэхээр 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 9 дүгээр бүлэгт заасан бөгөөд энэ зарчмын өөрчлөлтөөр сүүлийн 3 жилийн хугацаанд хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг үйлдсэн 3 хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулсан[10] байна.

Хуулийн этгээд гэмт хэргийн субъект байх цндэслэл нь нэг талаас Эрццгийн хуулиар хориглосон гэмт хэргийг тухайн хуулийн этгээд өөрийн нэрээр зориуд цйлдсэн нь ямар нэгэн албан тушаалтанд хариуцлага хцлээлгэх нөхцлийг цгцйсгэх байдал бий болсоноор, нөгөө талаас гэмт цйлдэл нь тухайн байгууллагад ашигтай, давуу байдал бий болгоход чиглэгдсэн буюу зарим тохиолдолд албан тушаалтны хцлээх ялтай давхардахцйцээр хуулийн этгээд тусдаа эрццгийн хариуцлага хцлээх шаардлага зайлшгцй бий болсон зэргээр тайлбарладаг.[11]

Ашигт малтмалын тухай хуулийг ноцтой зөрчиж байгаа субъект нь аж ахуйн нэгж,компаниуд байдаг бөгөөд зөвхөн хувь хүндэрүүгийн хариуцлага оногдуулна гэсэн зарчмын дагуу хөлсний менежерүүдэд хариуцлага оногдуулж компаниуд хууль зөрчдөг,хэрэв илэрвэл хөлсний менежерүүдэд хэргээ тохож ирсэн ирсэн практикийг ийнхүү шинэ Эрүүгийн хуулиар өөрчилсөн нь дэвшилтэт алхам болсон.

Хуулийн этгээд нь эрүүгийн хариуцлагын субъект байх нөхцөл хийгээд ял оногдуулах үндэслэлийг Эрүүгийн хуулийн тодорхой заалт, институт болгон тогтоосон 35 орон байна.[12]

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд "Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг **"Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо** "...Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан бол 5400-27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэжээ[13].

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо "...тусгай зөвшөөрөлтэйгээр ашигт малтмалын хайгуул, ашиглалт,олборлолт,боловсруулалтявуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэсэн бол 3 дахь хэсэгт энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ хэмээн тус тус заажээ.

Өнөөдрийн байдлаар манай улсад байгаль хамгаалах 10 гаруй хууль, 210 дүрэм журам,

10 *www. Shuukh.mn веб хуудас. Шццхийн шийдвэрццдийн эмхэтгэл.*

11 *Rassat M.L. Driot penal. Paris. 1987. P 338. Аванесов О.Г. Реформа уголовного права Франции 1990 с 29-30*

12 *https://cyberleninka.ru/article/n/ научной статьи по праву. автор научной работы — Минязева Татьяна Фёдоровна. Серебренникова Анна Валерьевна.*

13 *www.Legal info.mn веб хуудас. Эрццгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2015 он.*

Үндэсний хэмжээний 30 бодлого, хөтөлбөрийн чанартай төлөвлөгөө байгаль орчны харилцааг зохицуулахад үйлчилж байна[14].

Байгаль орчинд учирсан экологийн бодит хохирлыг тогтоох асуудал нь одоо Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын боловсронгуй бус байдлаас шалтгаалан шийдвэрлэхэд хүндрэлтэй,гэмт этгээдүүд ял завших, хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаанд саадучруулж байгаа бөгөөд цаашид байгаль экологид учирсан хохиролын эдийн засгийн үнэлгээг тогтоохдоо тухайн үеийн нөхцөл байдалд уялдуулан уян хатан байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Байгаль орчны эсрэг гэмт хэргүүд шүүхийн шатнаас "Гэмт хэргийн хохирлыг бодитой тогтоон ирүүлэх" гэсэн үндэслэлээр мөрдөн байцаалтанд буцаж байгаа нь Эрүүгийн харилцлага гарцаагүй байх зарчим практикт хэрэгжихгүй, цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн 53 хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж,үлдсэн 47 хувь нь мөрдөн байцаалт, прокурорын шатанд хэрэгсэхгүй болох, түдгэлзүүлэх зэргээр гэмт этгээдүүдэдял завшуулж байгаа нь хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал, тухайн гэмт хэргийг нотлох мөрдөн байцаагчийн ур чадвар,иргэдийн дэмжлэггүй болон авилга зэргээс шалтгаалж байна.

Монгол Улсын байгаль орчны засаглал хүнд байдалд байгаа бөгөөд байгаль орчны тулгамдсан асуудлаа тодорхойлж, тогтвортой хөгжлийн бодлогыг сонгон өнгөрсөн 20 жилийн хугацаанд байгаль орчны чиглэлийн олон хууль тогтоомж баталж, Олон улсын 14 гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон ч төрөөс байгаль орчны сайн засаглалын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө зарцуулж,боловсон хүчний нөөц чадавхийг бүрдүүлж чадсангүй[15].

Монгол Улс "Аархусын конвенц[16]" буюу байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангаж, мэдээллийг нээлттэй болгох тухай хэлэлцээрт нэгдэн орох шаардлагатай бөгөөд ингэсэнээр нутгийн иргэдийн болон олон нийтийн хяналт бодитойгоор хэрэгжиж хууль зөрчих явдал багасна.

Өөрөөр хэлбэл ашигтмалтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгох, олборлолтын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үндэс нь Аархусын конвенц бөгөөд манай улс нэгдэн орсоноор холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орно. Аливаа ашигт малтмалын лицензийг орон нутгийн иргэдийн нийтийн хурал, нийт иргэдээс зөвшөөрөл авсаны үндсэн дээр олгох ба хэрэв нутгийн иргэдтэй хийсэн гэрээг зөрчвөл уг тусгай зөвшөөрөл цуцлагдах учиртай юм. Ингэсэнээр нийслэлээс хэн нэгэн авилгач түшмэл биш баялгийн эзэн нутгийн иргэд зөвшөөрөл өгч хяналт тавьсанаар байгаль орчны олон нийтийн хяналтын тогтолцоо бүрдэх болно.

Олон нийтийн хяналтыг бодитой хэрэгжүүлэхийн тулд иргэдийн экологийн болон эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдах бөгөөд эдгээр чиг үүргийг Төрийн бус байгууллагуудад шилжүүлэх нь ур дүнтэй.

Манай байгаль хамгаалах төрийн бус байгууллагууд ч гэсэн зөвхөн төсөл, хөтөлбөр мөнгө хөөцөлдөх бус байгаль хамгаалах үйлсэд чин сэтгэлээсээ зүтгэж төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн авахад өөрсдийгөө бэлдэх учиртай.

Олон нийтийн хяналт гэдэгт зөвхөн нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөл төдийгүй одоо үйл ажиллагаа явуулж байгаа байгаль хамгаалах чиглэлийн 700 орчим төрийн бус байгууллага, 600 гаруй идэвхтэн байгаль хамгаалагч, эрдэмтэн судлаач нарыг хамааруулдаг.

Байгаль орчныг хамгаалах болон бусадхууль, тэдгээрийн дагалдан гарсан журмууд, зөвшөөрлийн тогтолцоо нь уян хатан бус, хүнд суртал, олон шат дамжлагатай, хэрэгжихэд төвөгтэй байна.

Хууль хэрэглэгч байгууллагуудын чиг үүргийг нарийн зааглаагүй, хуулийг хэрэгжүүлэх хүсэл зориг байхгүй зэрэг шалтгааны улмаас байгаль орчныг хамгаалах хуулиуд хэрэгжихгүй байна. Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн үндсэн шалтгаан нь:

- төр, засгийн түвшинд хуулийг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт боловсронгуй бус, төрийн захиргааны төв байгууллагуудын ажлын уялдаа, идэвх санаачлага сул;
- хуулийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр дутмаг;
- хуулийн хэрэгжилтэнд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй, хяналтын байгууллагуудын чадавхи, ажлын уялдаа холбоо сул;
- зөвшөөрлийн тогтолцоо хэт төвлөрч, орон нутгийн төр, захиргааны байгууллагын эрх,

14 *Д.Батболд. Ашигт малтмалын өмчлөл, ашиглалтын үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Нэг сэдэвт бүтээл. УБ хот. 2020 он. 15 дахь талд*

15 *Ц.Цэлмэг. Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн ЭЭЗ-н болон криминологийн асуудал. Докторын зэрэг хамгаалсан бүтээл. УБ хот. 2012 он. 126 дахь талд*

16 *http//www.unece.com Convention developed from UNECE-с батлан гаргасан байгаль орчны шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах тухай конвенц.*

үүрэг зарим тохиолдолд хязгаарлагдмал;

- хуулийг хэрэгжүүлэхэд иргэд, төрийн бус болон төрийн үйлчилгээний мэргэжлийн байгууллагын оролцоо бага;
- байгаль орчны мэдээллийн тогтолцоо бүрдээгүй,хуулийн сурталчилгаа хангалтгүй;
- иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг;
- төр, захиргааны бүх шатны байгууллагын удирдлагын болон байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч нарын мэдлэг боловсрол дутмаг, ажлын дадлага, туршлага бага;
- байгалийн баялгийн нөөцийг хууль бусаар ашиглах,ашиг хонжоо хайгчдын тоо олширч, зохион байгуулалттай үйлдэх хандлагатай болсон;
- байгаль орчны байгууллагуудын чадавхи сул байгаа нь боловсон хүчний тогтвор суурьшил муу, өндөр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх,давтан бэлтгэх үйл ажиллагаа, тэдэнд тавих шаардлага сул;
- байгаль орчныг хамгаалах болон ойн хууль тогтоомж боловсронгуй бус, хууль дотроо болон хууль хоорондын зөрчил, хийдэл, эрх үүргийн давхардал их;
- хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцооны эрх зүйн зохицуулалт, ялангуяа хууль зөрчиж шийдвэр гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул;
- байгаль орчны бодлого, хууль тогтоомжид мониторинг хийж, өнөөгийн шаардлагад нийцүүлэн богино хугацаанд боловсронгуй болгох талаар идэвх санаачлагатай ажиллах явдал хангалтгүй байгаа зэрэг болно.

Монголын өнөөгийн нийгмийн нэг онцлог нь 600 гаруй хууль батлагдан гарсан боловч байгаль орчныг хамгаалах хуулиуд тунхагийн шинжтэй, хэрэгжих механизм муутай, хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа учир дутагдалтай байдгаас тухайн хууль амьдрал,практикт хэрэгжиж чадахгүй байна.

Тухайлбал, урт нэртэй хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа учир ТББ-д Засгийн газрыг шүүхэд дуудаж улмаар хуулийг хэрэгжүүлэхийг даалгасан шүүхийн шийдвэр гарсан зэрэг нь улс төрийн хүсэл зориг байгаль хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллагаанд дутагдаж байгааг илчилнэ.

Усны эх бүрдэх,ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлохыг хориглосон уг хууль нь байгаль орчныг хамгаалахад голлох үүрэгтэй бөгөөд хуулийг хэрэгжүүлэхэд саад болоод байгаа компаниудын нэхээд байгаа нөхөн олговрыг шийдвэрлэх ёстой. Тэдгээр компаний экологид учруулсан хохирлыг тооцож, нэхэмжлээд байгаа төлбөр нь үнэдслэлтэй эсэхийг сайтар хянахад Засгийн газраас мөнгө төлөхгүйгээр асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжоотой юм.

Хуульд хэрэгжих механизыг суулгаагүй, хууль хэрэглэгч байгууллагуудын чиг үүргийг нарийн зааглаагүй, эсвэл хуулийг хэрэгжүүлэх хүсэл зориг байхгүй зэргээс байгаль орчыг хамгаалах хуулиуд хэрэгжихгүй байна.

Иймд байгаль орчны багц хуулиудыг боловсронгуй болгох, хэрэгжих механизмыг хуульд суулгах, хууль хэрэглэгч албан тушаалтан, ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх сургалтанд хамруулах, хариуцлагын тогтолцоог чангатгах зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

Докторантын хувьд цаашид цувралаар судалгааны ажлынхаа үр дүнг нийтлэх бөгөөд Ашигт малтмалын болон Эрүүгийн хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтыг боловсронгуй болгох арга замын талаар дараагийн нийтлэлдээ тусгах болно.

АШИГТ МАЛТМАЛЫГ ХАМГААЛЖ, АШИГЛАЖ ИРСЭН МОНГОЛЫН ХУУЛЬ ЦАЗЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛЫГ СУДАЛСАН НЬ

Т.Сайнбаяр
Их засаг ОУИС-ийн докторант, өмгөөлөгч

Түлхүүр үг: Ашигт малтмал, эрдэс баялаг, Монголын хууль цааз.

Монголчуудэртдээр үеэс амьдарч буй орон нутгийнхаа байгалийн зүй тогтлыг танин мэдэж байгаль орчноо хамгаалах,байгалийн баялгийг нөхөн сэргээхэдүлэмж анхаарч зан үйл,ёс заншил,шашин шүтлэгээрээ зохицуулж ирсэнээс гадна төрийн бодлогоор хууль цаазтогтоож ирсэн уламжлалтай.

Сэлэнгэ мөрний сав газарт буй МЭӨ I зууны үеийн "Ивонгийн суурин", мөн Ноён уул, Хүний гол, Наймбын толгой, Дуулга уул, Сэлбэ голын бэлхэг зэрэг хэд хэдэн газраас Хүннүгийн хаадын ба жир иргэдийн булш,дурсгалуудолдсон нь Хүннүг эртний улсууддотроос төмөрлөг[1] ба төмөр боловсруулалтын эд мөрийг хамгийн их үлдээсэн улс гэж зүй ёсоор хүргэжээ. Археологийн удаа дараа малтлагын үр дүндИвонгийн сууринаас "мал аж ахуй,газар тариалангийн ба гэр ахуйн хэрэгсэл, зэр зэвсгийн дурсгал болох хүрэл, гууль, ширмэн эдлэл,багаж хэрэгсэл, зэр зэвсэг тэдгээрийн үлдэц олдсон[2].

Мөн төмөр, ширмэн хүдэр хайлж байсны гэрч болох хайлш, шаар илэрсэнээс гадна энд их илч гарах түлшинд чулуун нүүрс хэрэглэж байсны үлдвэр гарчээ[3].

Энэхүү археологийн баримтаас үзэхэд Хүннүчүүд хүрэл, гууль, төмөр, чулуун нүүрс, алт зэрэг эрдэс баялаг олборлож амьдрал ахуйдаа ашигладаг байсныг харуулж байна.

Хүннүгийн үед эрдэс баялаг ашиглах харилцаа байсан гэх баттай баримт байгаа хэдий ч түүнийг зохицуулсан хааны зарлиг гэх мэтийн бичмэл хэм хэмжээ хараахан олдоогүй.

Бидний өвөг дээдэс арга-билгийн ухааны мөн чанар, дотоод шалтгааныг гүнзгий танин мэдсэн учраас байгаль дэлхийгээ тахин шүтэх олон шүтлэгийг бий болгож үзэсгэлэн төгс нутаг орныхоо онцлог хэсгийг дархлан хамгаалж иржээ.

Монгол орон байгалийн унаган төрхөө алдаагүй, түүний баялаг бүрэн бүтнээр бидний үед өвлөгдөн ирэхэдмонгол тумний үе үеийн мэргэдийн боловсруулан мөрдөж ирсэн хууль цааз онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Монголчууд байгаль орчноо хайрлан хамгаалах баялаг уламжлалтай ард түмэн бөгөөд өнөөдөр бидэнд өвлөгдөн ирсэн хөндөгдөөгүй шахам байгаль бол өвөг дээдсийн нөр их хөдөлмөр, хатуу хууль, төрийн зөв бодлого, уламжлалт зан заншлын хэм хэмжээтэй шууд холбоотой бөгөөд байгаль дэлхийгээ эзэнтэй, хамаагүй хөндвөл эзэн хилэгнэнэ,лус савдагийн хорлол болно гэх зэргээр хамгаалж ирсэн түүхэн уламжлалыг бидний үеийнхэн мартах учиргүй.

Чингис хааны "Их засаг" хууль.

Судлаачдын бүтээлээс үзэхэд "Их засаг" хуулийн агуулгыг төр засах цааз, иргэний аж байдлын цааз, эрүүгийн бодлого гэсэн гол асуудлуудад төвлөрүүлэн зангидаж тайлбарласан[4] ба байгаль орчныг хамгаалахтай холбоотойзаалтууд нь ихэвчлэн зан заншил, аж ахуй, онгон шүтлэгтэй холбоотой байв.

"Их засаг" хуульдбайгалийн унаган төрхийг хадгалах, нутаг бэлчээрийг зүй зохистой ашиглах, газар шороо, хөрс шороог хамаагүй сэндийчихгүй байх, усыг цэвэр ариун байлгах,ой модыг түймрээс хамгаалах зэрэг заалтууд тусгагджээ.

Чингис хааны үеийг эрдэмтэд төмөрлөг, төмрийн гар үйлдвэрлэлийг түүхийн III үед хамруулан судалжээ. Академич Х.Пэрлээ энэ үеийг эрдэс баялаг олборлож бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсныг археологийн баримт болон Монголын нууц товчооноос иш татан дэлгэжээ[5].

1 *Энэ цейг академич Х.Пэрлээгийн судлаагаа гол болгосон ба тэрээр төмөрлөг, төмөр хөрөг ялгаж төмөрлөг гэдэгт алт, мөнгө, зэс тэргүүтэй металлуудыг оруулан томъёолжээ. Х.Пэрлээ. Эрдэм шинжилгээний өгүүллүүд. II. УБ хот. 2001 он. 268 тал*

2 *Д.Батболд. Ашигт малтмалын өмчлөл, ашиглалтын үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Нэг сэдэвт бүтээл. УБ хот. 2020 он. 25 дахь тал*

3 *А.В.Давыдова. Раскопки Иволгинского городища в 1956 г. "Записка Бурят-Монгольского научно-исследовательского института культуры XXII Улан-Удэ. Х.Пэрлээ. Эрдэм шинжилгээний өгүүллүүд. II. УБ хот. 2001 он. 262 тал*

4 *Ж.Болдбаатар. Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ хот. 1997 он. 79 дэх тал*

5 *Х.Пэрлээ. Монголын нүүдэлчдийн металлургi*

"Их засаг" хуульд "..өвс ногоо ногоорсон хойно газрыг нүхэлбээс нэгэн гэрийг алмой[6] гэсэн ба газар нүхлэх гэдэг зан үйлд газрын хэвлийгээс эрдэс баялаг олборлохоор түүнийг хөндөх, ухах, малтах,тэсэлж дэлбэлэх зэрэг ажиллагаа агуулгын хувьд багтана. Эрдэс баялгийн ашиглалт гэдэг бол газар ашиглах харилцаатай салшгүй холбоотой бөгөөд газрыг нүхлэлгүйгээр түүний доор байгаа баялгийг авна гэж байхгүй учир өвс ногоорсон хойно хэн ч газрын хэвлийн баялгийг ашиглах эрхгүй гэдгийг хуульчилсан[7].

Их Юан гүрний "Нэвтэрхий хууль" нь нийгэм улс төр,эдийн засаг,ахуй амьдралын бүхий л хэв шинжийг агуулсан,"Их засаг" хуулийн нөлөө, Монгол зан заншил ихээр тусгагдсаны дотор байгаль хамгаалахтай холбоотой олон зүйл заалтууд орсон, өмнөх хууль, зарлигуудын эмхтгэл байсан бөгөөд 60 бүлэг,2391 зүйлтэй байжээ.

Монгол нутгаар 17 жил аялал хийсэн Марко Поло тэмдэглэлдээ "...Хятайн муж даяар нэгэн хар өнгийн сонин чулуу бий,түүнийг уулнаас худэр олборлох мэт малтаж гаргаж авах ба тэр чулуу нь түлээ шиг сайхан шатдаг[8] гэж бичсэн нь цаг хугацааны хувьд Юан гүрний үед холбогдоно.

Юан гүрний хууль цаазаар алт мөнгө,гууль, төмөр, тугалга, байван, илүү хужир, чулуун нүүрс, хулс, модны үйлдвэрүүд тогтмол хэмжээний гааль хураалгадаг[9] байна. Түүнчлэн өргөн хэрэглээний архи, дарс, давс, цай мэтийн орлого сайтай зүйлүүд дээр цом улсын онц эрх тогтоон төрийн мэдэлд авсан. Төгстөмөр хааны үед нэг жилийн дотор ганц давснаас орсон орлого 7 сая 660 мянган лан мөнгө болж байв[10].

Алтан хааны цааз бичиг : 1507-1582 оны хооронд амьдарч байсан Түмэдийн Алтан хааны үед батлагдсан.

XYI зууны Монголын томоохон цааз бичгүүдийн нэг бөгөөд оршил буюу айлтгал үгийн хамт 12 хэсэг, 117 зүйлээс бүрддэг.[11] Тэнд "..алтан аяга, алтан малгай, мөнгөн бүс, алт мөнгө ихийг хулгайлбал 6 ес,бага бол 3 ест[12] гэж заажээ.

Монгол цаазын бичигт Монголын үзэсгэлэнт байгалийг дархлан хамгаалж, онголон тахих, хамгаалах тухай заалт, хэм хэмжээ арвин бөгөөд байгаль орчныг сүйтгэсэн үйлдлүүдийг 3 ангилан хуваасан байна.

- газар эдэлбэрийн тогтоосон хэм хэмжээ зөрчих;
- ой хээрийн түймэр тавих;
- хууль бусаар ан хийх,ховор ургамал түүх,ой модыг огтлох;

Нүүдэлчин Монголчуудын хувьд нутаг бэлчээр,ой модыг хамгаалах түүнийг эвэ зохистой ашиглаж малаа адгуулан маллах нь эртнээс улбаатай бөгөөд түймэр алдаж ой бэлчээр устгасан,ой модыг огтолсон,гэмтээсэн,газрын хэвлийг сэндийчсэн бол 3-6 есөөр торгохоор заажээ[13].

Халх журам хуульд байгаль хамгаалах асуудал тодорхой байр суурь эзлэж байсан ба өмнөх хуулиудын уламжлалыг баяжуулан бататгаж ой мод, ан амьтан, усыг хамгаалах, ой хээрийн түймрээс сэргийлэхээс гадна "...Сангийн чулуун нүүрс, шохой хулгай хийвэл гурван ест гэжээ. Сан гэдэг нь Жавзандамба хутагтын сан хөмрөгийг хэлж байгаа тухай С.Жалан-Аажав, академич Х.Пэрлээ нар тус тус тайлбарлан бичжээ[14].

МУИС-ийн багш, доктор (Ph.D) Б.Баярсайхан дээрх заалтыг тайлбарлахдаа байгалийн баялгийг тогтоосон журмаас гадуур олборлохыг гэмт хэрэгт тооцсон заалт гэвэл энэ тухай өөрийн бүтээлдээ "Манж Чин улсын үе буюу 18 дугаар зууны сүүлчийн хагаст Монгол нутагт алт, эрдэнийн чулуу бусад ашигт малтмалыг малтан авч ашиглахыг хориглож Засагт хан, Сайн ноён хан аймгийн нутагт Бүхүй алтан ууланд тусгай харуул гаргаж түүнийг алтны харуул гэж нэрлэж байжээ[15].

Гурван этгээдээс гэдэг нь хүрээний захирагч,шашин сүм хийдболон хүрээндоршин суугч энгийн ардуудаас тус бүр нэг төлөөлөгч байхыг хэлж байсан бөгөөд элч гэдэг нь өнөөгийн байгаль хамгаалагчтай ижил зиндааны алба хариуцагчийг хэлж байсан бололтой.[16]

Элч нь эргэж шалгахын зэрэгцээ гаднаас хүрээнд ирсэн ноёд, зочдод мод, мөчир огтлохыг

боловсруулалтын асуудалд. Эрдэм шинжилгээний өгүүллүүд. II. УБ хот. 2001 он. 271-272 тал

6 *Сайшаал. Чингис хааны товчоон. Хөх хот. 1987 он. 34 дэх талд.*

7 *Д.Батболд. Нийтийн эрх зүйн тулгамдсан асуудал. УБ хот. 2018 он. 150 дахь талд*

8 *Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ хот. 1987 он. 119 дэх тал*

9 *Юан улсын судар. 94 дүгээр бүлэг. (дам шилэв. Монгол Улсын түүх. дэд боть. УБ.. 2003 он. 220 дахь талд)*

10 *Мөн тэнд*

11 *Э.Авирмэд. Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль. УБ хот. 1997 он. 19 дэх талд*

12 *Ш.Бира. XVI зууны нэгэн монгол цаазын бичиг. ШУА-н мэдээ сэтгүүл. 1975 он. №3 40 дэх тал*

13 *Д.Батболд. Нийтийн эрх зүйн тулгамдсан асуудал. УБ хот. 2018 он. 152 дахь талд*

14 *С.Жалан-Аажав. Халх журам. УБ хот. 1993 он. 19 дэх талд*

15 *Б.Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь. УБ хот. 2003 он. 20 дахь тал*

16 *О.Амархүү. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ хот. 2009 он. 82 дахь тал*

хориглосон тухай таниулж, хуулиа сурталчлан ойлгуулж байх үүрэгтэйг хуульчилсан байв. Хүрээнд болон түүний ойролцоо газарт ой модыг хамгаалах журам тогтоохдоо "хуурай модыг огтолсон нь нойтон модыг хуга дайрсан бол сүхийг ав" гэсэн нь зүлзаган модыг хамгаалах чухал ач холбогдол бүхий заалт байжээ.

Богд хаант Монгол Улсын хууль цаазны гол эх сурвалж нь "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль цаазын бичиг" бөгөөд байгаль хамгаалах асуудлыг өргөн хүрээтэй авч үзжээ.

Энэ үед аль олборлолт Монгол нутгаар багагүй дэлгэрсэн байсан ба Автономит засгийн үед алтны 22 уурхай ажиллаж байсан гэж доктор Д.Батболд[17] бүтээлдээ онцолжээ. "Монголор" алтны уурхайн нийгэмлэгийн талаарх материалууд Үндэсний төв архивт цөөнгүй бөгөөд энэ нийгэмлэг нь 1903-1921 оны хооронд хэд хэдэн уурхайтай 18 жил ажилласан бөгөөд 10,5 сая долларын үнэ бүхий алт олборлон гаргасан[18] гэж бичжээ.

Засгийн газар (бүгд ерөнхийлөн захирах яам)-наас Олноо өргөгдсөний 13 дугаар (1913 он) оны 12 сарын 20-нд бусад яамнууд өөр өөрийн эрхлэн шийдэх асуудлын хэрэг зүйлийг хянан хэлэлцэн байж "Олон зүйлийн уурхай нээн шийдэх дүрэм"-ийг[19] баталсан нь эрдэс баялгийн талаархи хамгийн анхны төрөлжсөн хууль маягийн эх сурвалж болж байна.

1913 оны Олон зүйлийн уурхай нээн шийтгэх дүрэм бүтцийн хувьд бүлгийн системчлэл байхгүй, 38 зүйлээс тогтох ба уг дүрэмд зохицуулалтын хүрээг тодорхойлсон заалт байхгүй хэдий ч агуулгаар нь түүнийг ерөнхийлөн тоймлож болно. Үүнд:

Нэг. Зөвшөөрлийн тогтолцоотой холбоотой харилцаа: Эрдэс баялгийг эрж үзэх, хайж үзэх, нээх тус бүрд тэмдэгт бичгийг Засгийн газраас авах ба тэмдэгт бичиг авсанаас хойш үүсэх харилцаа бүрд өөр өөрийн эрх зүйн дэглэм бүхий хэм хэмжээ үйлчилнэ. Хэрэв зөвшөөрөл авах гэж байгаа газар нь "эрхэм сүлд тахилга"-д холбогдох бол тэмдэгт бичиг олгохоос татгалзах ёстой. Энэ нь уг дүрэмд заагдсан Засгийн газрын зүгээс зөвшөөрөл олгохоос татралзах ганц үндэслэл байв. Энэхүү шалгуур Богдын засгийн газраас эх дэлхийгээ бишрэн шүтэж, хайрлан хамгаалж ирсэн шашин суртал, уламжлалыг өөрийн үйл ажиллагаандаа удирдлага болгодог байсантай холбоотой гэж академич Майский тайлбарласан байдаг. Зургаан сарын хугацаа бүхий эрж үзэх тэмдэгт бичиг хүлээн авахад албаны хэрэглэлд чилков цаас (хаант Оросын мөнгөн тэмдэгт) нэг зуун хуудсыг тушаана.[20] Эрж үзэх хугацаанд заан мэдээлсэн газарт гацхүү газрын хөрсийг малтаж уурхайн судлыг ажиж үзнэ.

Уурхай эрж үзсэн хүндмалтаж үзэх тэмдэгт бичгийг 15 дөрвөлжин газраас илүүгүй хэмжээгээр 6 сарын хугацаатай олгож албаны хэрэглэлдОросын чилков 100 хуудсыг хураадаг байжээ.[21] Уурхай эрж үзсэн хүнд малтаж үзэх тэмдэгт бичиг авсан хүн уурхайн судлыг дагаж хэд хэдэн нүх малтаж үздэг бөгөөд үргэлжлүүлэн ухахыг хориглоно. Нүхний уудмын хэмжээ 5 тохойгоос хэтрэх ёсгүй мөн уг дүрмийн дагуу уурхай нээн шийтгэх эрхээ хасуулаагүй, тийнхүү нээн шийтгэхийг хүссэн хүн гэрээ бичиг байгуулж түүнд баталгаа гаргаж өгсөн өөрийн харъяат түшмэл эсхүл худалдааны томоохон пүүсээр гэрээгээ хэлэлцүүлж батлуулдаг байсан нь байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө юм.

Ардын хувьсгалын эхэн үеийн байгаль хамгаалах хууль тогтоомж

БНМАУ-ын анхны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд "...улсын хязгаарын доторхи газар, уурхай, ой мод, ус зэрэг баялаг нь эрт цагаас нааш ард нийтийн өмч байсаар ирсэн бөгөөд хувийн өмчид байж болохгүй"[22] гэжээ.

Ардын Засгийн газар улс орондоо Үндсэн хуульт байгуулал тогтоохыг эрмэлзэхийн зэрэгцээ түүний өмнө нийгмийн чухал чухал харилцааг зохицуулсан төрөлжсөн болон Үндсэн хуульчлагдсан актууд баталсан. Тэдгээрт бидний судлан буй 1923 оны "Ардын засагт Монгол Улсын уурхайн дүрэм", мөн оны "Нутгийн захиргааны дүрэм" даруй хамаарна.

1923 оны 06 дугаар сарын 28-нд Засгийн газрын хуралдааны 19 тоот тогтоолоор "Ардын засагт Монгол Улсын уурхайн дүрэм"-ийг баталсан нь эрдэс баялгийн талаархи харилцааг зохицуулсан 2 дахь төрөлжсөн акт байсны сацуу 1913 оны дүрмийн гол санааг өвлөж хөгжүүлсэн онцлогтой.

Энэ дүрэм Нийтийн хэмжээ, Уурхай захирах дүрэм, Уурхай шинжлэн эрэх тухай,

17 *Д.Батболд. Нийтийн эрх зүйн тулгамдсан асуудал. УБ хот. 2018 он. 156 дахь талд*

18 *Известия Улаанбаатор хото. №350 1927.01.22. Ц.Пунцагноров. дурдсан бүтээл 114 дэх тал*

19 *Үндэсний төв архив. Фонды №А-2. Дансны №1. Х/Н 105. ШУА-ны түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн фонд.*

20 *Олон зүйлийн уурхай нээн шийтгэх дүрэм. 7 дугаар зүйл. Үндэсний төв архив. Фонды № А-2. Дансны №1. Х/Н 105*

21 *Мөн дүрэм. 10 дугаар зүйл.*

22 *БНМАУ-ын Их. бага хурлын тогтоол. Үндсэн хууль, тунхагууд. УБ хот. 1986 он. 52 тал*

Битүүлгээр тэмтрэн үзэх тухай, Уурхайг нарийвчлан тэмтрэн үзэх тухай, Уурхайг малтах тухай,Уурхайг малтуулах түрээсийн тухай,Уурхайн дотоод байдлын тухай гэсэн 8 бүлэг,52 зүйлтэй.

Дүрмийн үйлчлэх хүрээ нь 2 дугаар зүйлд тодорхойлсоноор "Дотоод газаадын энгийн хүмүүс ба хоршоо нарт алт, мөнгө, төмөр, зэс, тугалга зэрэг металл ба чулуун нүүрс,бэл,хүхэр,чулууны шөрмөс зэргийн минерал хэмээх ба гал бадраах тосон зүйлийн эрх олгож...нэр бүхий зүйлүүдийг энэхүү дүрмийн ёсоор тэмтрэн үзэж малтаж болно, үүний дотор эрдэнийн чулууны зүйл үл оролцмой.[23]

Мөн дүрмийн 9 дүгээр зүйлд "...уурхайн үйлдвэр нь нутгийн ардын нүүдэл ба бэлчээр тариалан буюу хадлан боогдуулах зүйл гарваас томилогдон түшмэл тэмдэгт бичиг олгохын хамт уурхайн хүмүүнийг нутгийн эрх баригчид лугаа хэлэлцүүлж олон ардын сүйтгэлийг (хохирлыг) тогтоомой. Хэрэв хэлэлцэн тохирохгүй аваас түшмэлээс шударгыг барьж шийтгэлийн хэмжээг таслан зогсоовоос зохимой. Үүн дор гомдол бүхий этгээд бий аваас учрыг шүүх явдлын яамнаа мэдэгдэж болохоос гадна шүүх явдлын яамнаас шийтгэн тогтоосныг хоёр этгээд эрхгүй дагаваас зохимой[24] гэжээ.

Өнөөгийн Ашигт малтмалын тухай хуульд нутгийн иргэдийн ашиг сонирхлыг олигтой баталгаажуулаагүйгээс лиценз эзэмшигчид дур зоргоороо авирлах, нутгийн иргэд малаа бэлчээх газаргүй, үндсэн аж ахуй болсон мал аж ахуйгаа эрхлэх боломжгүй болж хохирсоор байгаа билээ.

1926 оны Шүүх цаазын бичиг- Уг хуулийн 15 дугаар бүлгийн 103 дугаар зүйлд "...байгалийн баялгийг ашиглах тухай дүрэм зөрчигсдийг 3 сар хүртэл хорино"; 117 дугаар зүйлд "...аливаа малтсан газрыг эс таглаж тэгшилвээс нэг сар гяндлан хорино" гэжээ. [25]

1940-1990 оны хооронд мөрдөж байсан эрдэс баялгийн хууль тогтоомжууд:

- 1940 оны БНМАУ-ын Үндсэн хууль;
- 1957.11.27-ны "Улсын геологи-шинжилгээний ажлын тухай СНЗ-ийн 461 дүгээр тогтоол;
- 1958.06.18-ны "БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Улсын ашигт малтмалын нөөцийн комиссын дүрэм", "Хатуу ашигт малтмалын ордын нөөцийн ангилал", "Ашигт малтмалын хайгуул хийсэн ордыг үйлдвэрийн ашиглалтанд шилжүүлэх журмын тухай дүрэм" СНЗ-ийн 190 дүгээр тогтоол;
- 1960.04.11-ний "Геологи-шинжилгээний ажлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" СНЗ, Намын төв хорооны 171/112 дугаар тогтоол;
- 1960.03.31-ний БНМАУ-ын "Геологи-шинжилгээний газрын дүрмийг батлах тухай" СНЗ-ын 143 дугаар тогтоол;
- 1941 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль;
- 1960 оны БНМАУ-ын Үндсэн хууль;
- 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль;
- 1961.12.16-ны өдрийн "Ашигт малтмалын шинэ ордыг олж нээсэн урьд нээгдсэн ордыг үндсээр нь шинэчлэн үнэлсэн хүмүүст тусгайлан мөнгөн шагнал олгож байх журам" СНЗ-ийн 634 дүгээр тогтоол;
- 1962.11.23-ны "Геологи-шинжилгээний ажлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" СНЗ-ийн 582 дугаар тогтоол;
- 1963.03.30-ны "Геологи хайгуулын бүх ажлыг заавал бүртгүүлж байх тухай" СНЗ-ийн 114 дүгээр тогтоол;
- 1965.07.14-ний "Улсын геологийн хяналт тогтоох" СНЗ-ийн 226-р тогтоол;
- 1977.04.22-ны "Барилгын түгээмэл эрдэс түүхий эдийг ашиглахад уулын эдэлбэр газар олгох журам" СНЗ-ийн 115-р тогтоол;
- 1977.11.25-ны "Үнэт, хагас үнэт чулууг олборлох, фондлох, боловсруулах журам" СНЗ-ийн 341 дүгээр тогтоол;
- 1984.11.25-ны "Улсын ашигт малтмалын нөөцийн дүрэм, бүрэлдэхүүн" СНЗ-ийн 74 дүгээр тогтоол;
- 1988.11.29-ний "Газрын хэвлийн тухай хууль"
- 1989.09.08-ны "Түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалтыг батлах тухай" СНЗ-ийн 232-р тогтоол гэсэн олон эх сурвалжийг дурьдаж болно.

Энэ үед хувийн өмчийг хүлээн зөвшөөрөгтүй байсан учир зөвхөн улсын буюу төрийн өмчийн үндэсний хэмжээний уул уурхайн томоохон үйлдвэрүүд үүсч, аж үйлдвэрийн болон

23 *Олон зүйлийн уурхай нээн шийтгэх дүрэм. 7 дугаар зүйл. Үндэсний төв архив. Фондны № А-2. Дансны №1. Х/Н 105*

24 *Ардын засагт Монгол Улсын уурхайн дүрэм. II зүйл. Үндэсний төв архивын номын сан.*

25 *М.Эрдэнэбаяр. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх шалгахад анхаарах зарим асуудал. УБ., 2010 он, 67 дахь тал*

эдийн засгийн салбарт чухал байр суурь эзлэх болжээ.

Цаг үеийн байдлаас хамаарч энэ үеийн хууль тогтоомж нь жас ёсноос гажсан хэдий ч чухамхүү эрдэс баялгийн талаархи хууль тогтоомжийн хөгжлийн үе байсан гэж дүгнэж болно. Тухайлбал, жирийн нэг түшмэл уурхайд сууж ажил хэргийг өдөр тутам хянадаг байсан тогтолцоог геологийн буюу мэргэжлийн хяналтаар сольсон, энэ салбарын төрийн захиргааны байгууллага байр сууриа олж бэхжив. БНМАУ нь тухайн үедЗХУ-тай социалист хамтын ажиллагаатай байсан учир эрдэм баялгийн олборлолт, ашиглалт нэг улсаас хараат байсан учир Зөвлөлтийн хөрөнгө оруулалттай уулын үйлдвэрүүд гол үүрэг гүйцэтгэж байсан.

ЗХУ-ын мэргэжлийн болоод техник, хөрөнгө оруулалтын талаар голлох үүрэг гүйцэтгэж 1940 онд "Монголнефть транс",1949 онд "Совмонголметалл",1973 онд "Монголсовцветмент" зэрэг хувь нийлүүлсэн нийгэмлэгүүдийг байгуулсан нь Монголын баялгийг ЗХУ ашиглах хэлбэр нь болж байсан.

1960-1990 онд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өнгө төрхийг сум-нэгдэл тодорхойлж байсан. Зарим түгээмэл тархацтай ашигт малтмал болох чулуун нүүрс, шохой зэргийг орон нутаг ашиглах эрх мэдэлтэй байсан. 1977 онд СНЗ-ийн 115 дугаар тогтоолоор "Барилгын түгээмэл эрдэс түүхий эдийг ашиглахад уулын эдэлбэр газар олгох журам" баталсан нь газрын зөвшөөрлийг аймаг олгох маягаар түгээмэл тархацтай эрдэс баялгийг ашиглах зөвшөөрлийг орон нутаг мэддэг болсон. Энэ үед уул уурхайн аж үйлдвэр хөгжсөн хэдий ч тэд улсаас баталсан төлөвлөгөө графикийн дагуу ажиллаж, олборлосон бүтээгдэхүүнээ улсадтушаадаг байсан тул нэгждээ шууд өгөөж байсангүй.

Харин сум-нэгдэл давсаа ашиглаж чамгүй ашиг олдог байсан баримт олдсон нь 1960-1962 онд Төв аймгийн Дэлгэрхаан зэрэг давс хужраар баялаг сум-нэгдэл нь давсаараа мал, төлөвлөгөө биелдэггүй тэмээний ноос, машин техник хэрэгсэл авдаг байсан. Үүнээс үзэхэдсоциалисттогтолцооны үед аймаг албан ёсоор түгээмэл тархацтай эрдэс баялгийн зөвшөөрлийг олгодог, сум-нэгдэл нь давс, хужир, элс хайрга зэрэг баялгийг ашиглаж байсан нь тодорхой юм.

Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн хувьд 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 7 дугаар бүлэгт "Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг" гэсэн бүлэг анх удаа хуульчлагдсан[26].

Уг хуулийн 181 дүгээр зүйлд "Недрийг ашиглах, алт бусад үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журам зөрчих" гэмтхэргийн бүрэлдэхүүнийг заасан.

Үндсэн бүрэлдэхүүн нь "...Недрийг ашиглах, түүнчлэн олборлосон алт бусад үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журмыг зөрчсөн бол олборлосон зүйлийг хурааж 2 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх,эсхүл 2 мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Хүндрүүлэх бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо "...энэ үйлдлийг недрийг ашиглах, алт бусад үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журам зөрчсөн гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд хийсэн, эсхүл уг хэргийн улмаас улсад их хэмжээтэй хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

Гэмт хэргийн халдлагын зүйл нь газрын недрт байгаа төрөл бүрийн ашигт малмал, алт, үнэт болон хагас үнэт металл чулуу зэрэг болно.

Улсад тушаах ашигт малтмал, үнэт чулуу, алт, үнэт металл нь түүхий эдийн хэлбэртэйгээр анхны төрөх байдлаар байх ёстой бөгөөд харин хүний хөдөлмөр шингэж боловсруулалт хийгдсэн алт, үнэт металл, үнэт чулуу бол энэ гэмт хэргийн халдлагын зүйл болохгүй[27].

Энэхүү 181 дүгээр зүйл нь 2 төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нэгтгэсэн бөгөөд Үүнд: а) зарим хүнээс недрийг ашиглах журам зөрчих;

Б) олборлосон үнэт металл, чулууг улсад тушаах журам зөрчих зэрэг болно.

2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23 дугаар бүлэг болох "Байгаль орчны эсрэг гэмт хэрэг" гэсэн бүлэгт 12 гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан ба 214 дүгээр бүлэгт "Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар хуульчилжээ.

Үндсэн бүрэлдэхүүнийг "...Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулж үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван

26 *БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ хот. 1986 он. 218 дахь талд*

27 *БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ хот. 1986 он. 21 дэх талд*

сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ" гэж зааж[28].

Харин хүндрүүлэх бүрэлдэхүүнийг энэ гэмт хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл уг үйл ажиллагааг тусгай хамгаалалттай газар нутагт явуулсан бол эд хөрөнгийг нь хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах,эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Түүнчлэн онцлон хүндрүүлэх бүрэлдэхүнийг заахдаа "...тусгай зөвшөөрлийн дагуу ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй, эсхүл химийн хорт болон аюултай бодис хэрэглэх журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд,мал,амьтан,байгаль орчиндих хэмжээний хохирол бусад хүнд хор уршиг учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөн зуун тавиас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж тус тус хуульчилжээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 214 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж чадахгүй байсан гол шалтгаан нь хохирол заавал шаарддаг,хохирлын үлэмж хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-125 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хохирол учирч байж гэмтхэрэг болдог байсантай холбоотой.

Тухайлбал, 2013 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192,000 төгрөг байсан ба багадаа 9,7 сая төгрөгийн хохирол учирсан тохиолдолд л эрүүгийн хэрэг үүсгэн шалгах боломжтой байв.

Гэтэл бодит байдал дээр хохирлын үнэлгээ тогтооход хүндрэл учирч, цагдаагийн байгууллага үнэлгээний мэргэжлийн компаниудыг шинжээчээр томилсон атлаа дүгнэлтээ авч чаддаггүй,шинжээчийн үардлыг гаргуулж чадахгүйдхүрсэн,хувиараа алт,үнэт металл олборлогч 60,000 орчим иргэний үйлдлийг хохирол учраагүй гэдэг үндэслэлээр хөөн тараахаас хэтрэхгүй байдалтай байв.

Энэ бүх хүндрэлтэй тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр 2015 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга УИХ-р батлагдан гарч хэрэгжиж эхэлсэнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн боловч шийдвэртэй ахиц дэвшил ажиглагдахгүй байгааг нийтээрээ харж байна.

28 *www.Legalinfo.mn веб хуудас. 2002 оны Эрүүгийн хуулль.*

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ШИНЭ ЭРИН ҮЕИЙН ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙГ СУДЛАХ НЬ

А.Хандмаа
Их Засаг ОУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант

Н.Цэдэнбалжир
Их Засаг ОУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, дэд профессор

Түлхүүр үг: Шинэ эрин[1], хуульч, мэргэжлийн ёс зүй

Хураангуй: БНХАУ нь социалист эрх зүйн системийн нэг томоохон төлөөлөгч бөгөөд хууль зүйн салбарын шинэчлэлийн үйл явц тасралтгүй гүнзгийрч,социалист эрх зүйн тогтолцоо улам бүр боловсронгуй болж байна. Шинэ эрин үед Хятадулсын нийгэмдзарим обьектив нөхцөл байдал өөрчлөгдөж,хууль,эрх зүйн боловсрол нь хүмүүсийн өдөр тутмын амьдралд эрх зүйн харилцаанд оролцоход илүү их анхаарал хандуулж эрх ашиг сонирхолоо хамгаалахын тулд хуульчдад хандах, хууль зүйн туслалцаа авах зэрэг иргэдийн шүүхэд хандах, туслалцаа авах эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаагийн хэрээр мэргэжлийн хуульчид гол үүрэг оролцоотой байгааг илтгэн харуулж байна. Энэхүү нийтлэлд Хятадын шинэ эрин үеийн социалист эрх зүйн тогтолцоонд хуульчдийн мэргэжлийн ёс зүйн агуулгыг судалж, шинэ эрин үеийн хуульчдад мэргэжлийн ёс зүйн төлөвшүүлэхэд тулгамдаж буй асуудлыг судлан гаргаж ирэхийг зорьсон болно. Монгол улс болон БНХАУ нь найрсаг хөршийг харилцаа хамтын ажиллагааны хүрээнд хуульчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харьцуулсан эрх зүй судлалд социалист эрх зүйн тогтолцоотой улсын хувьд судалгаа хийх ач холбогдолын хувьд судлах замаар өнөөгийн Хятадын шинэ эриний хуульчдад мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхэд баримталж буй чиг баримжааг олж илрүүлэн жишиг болно.

1. Хуульчийн мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал

1.1. Хуульчийн мэргэжлийн ёс зүйн үзэл баримтлал

Мэргэжил нь нийгмийн амьдралд ямар нэг төрлийн ажил эрхлэхийг тодорхойлох бөгөөд ёс зүй нь хүмүүсийн өдөр тутмын амьдралд нийгмийн харилцааг зохицуулдаг хэд хэдэн хэм хэмжээний нийлбэр цогц юм.[2] Мэргэжлийн ёс зүй гэдэг нь нийгмийн амьдралд тодорхой ажил эрхэлдэг хүмүүсийн дагаж мөрдөх ёстой нийгмийн хэм хэмжээний нийлбэрийг хэлнэ.[3] Орчин үеийн нийгэмд хөдөлмөрийн хуваагдал, хамтын ажиллагаа маш чухал байхын зэрэгцээ хүмүүсийн нийгмийн амьдралд буй нэг төрлийн үндсэн хэлбэр юм. Хэрвээ нийгмийн амьдралд илүү үр нөлөөтэй, эмх цэгцтэй, дэг журамтай байхыг хүсэж байвал олон төрлийн ажил мэргэжилтэй хүмүүс нийтлэг хэм хэмжээг дагаж мөрдөх шаардлагатай. Тухайн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн нийтээр дагаж мөрдөх ёстой нийтлэг хэм хэмжээ бол тухайн салбарын мэргэжлийн ёс зүй гэж тодорхойлж болно. Төрөл бүрийн салбарын мэргэжлийн ёс зүйд нийтлэг зүйл байдаг ч зарим талаараа ялгаатай байдаг бөгөөд хуульчийн мэргэжлийн ёс зүйн зарим агуулгад дүн шинжилгээ хийсэн.[4]

1.2. Шинэ эрин үеийн хуульчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхэд тавигдах шаардлага

БНХАУ-д хууль дээдлэх зарчмыг удирдлага болгон хуулийн дагуу улс орныг удирдах ажлыг эрчимжүүлж, нийгэмд зарим нөхцөл байдал тасралтгүй өөрчлөгдсөөр байгаа нь шинэ эрин үед хуульчийн мэргэжлийн ёс зүйдтавигдах зарим шинэ шаардлагыг бий болгож байна.[5] Тодруулбал, зарим шаардлагад: юуны түрүүнд улс төрийн шинж, Хятад улс бол социалист орон, иргэдийн эрх ашиг бол

1 *The new era of socialism with Chinese characteristics is a new historical orientation for China's development. 2017 оны 10-р сарын 18-ны өдөр БНХАУ-ын удирдагч Ши Жиньпин Коммунист намын 19-р их хурлын илтгэлдээ "Хятадын онцлогтой социализм шинэ эринд орлоо" гэж онцлон тэмдэглэв.*

2 *Zhang Zhen Ming."Benevolence" and the norms and development of lawyers' professional ethics" [J]. 2017 (05).88-91*

3 *Yu Xiao Xin. БНХАУ-ын хуульчдын мэргэжлийн ёс зүйн дүрэм [J]. Хууль. эрх зүйн тогтолцоо ба нийгэм сэтгүүл . 2017(16). 290-291.*

4 *Gao Jun. Research on the construction of lawyers' professional ethics from the perspective of rule of law [J]. Legal system and Society. 2019 (03): 139-140.*

5 *Yu Xiao xin. "Lawyers' Professional Ethics Regulations in my country" [J]. Legal System and Society. 2017(16): 290-291.*

төрийн үйлчилгээний гол обьектболно.Мэргэжлийн хуульчид ч энэ улс төрийн зарчмыг баримталж,ард түмэндээ үйлчлэх үндсэн зарчмыг сайтар санаж байх ёстойг тодорхойлсон байна. Мэргэжлийн үйл ажиллагаанд хуульчид, нэн тэргүүнд иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахын зэрэгцээ хуульчид бид улс эх орныхоо улс төрийн тогтолцоо,эрх зүйн тогтолцоог хамгаалахад анхаарч ажиллах ёстой; мөн мэргэжлийн ур чадварын асуудал хамаарах ба хуульчид мэргэжлийн өндөр ур чадвартай хуульч хүн бусдад зохих хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлж чадна хэмээн тодорхойлсон байна. Иймд мэргэжлийн агуулгад мэргэжлийн ёс зүй гол түлхүүр ойлголт юм;сүүлийн ойлголт нь хуульчид сахилга баттай байх зэрэг шаардлагууд хамаарч байна.[6] Хятад улсын хуульчид мэргэжлийн хувьд бизнес, арилжааны салбарын хуульчид, төрөөс томилогдсон нийтийн халамжийн хуульчид, нийгмийн халамжийн салбарын хуульчид буюу төрөөс томилогддог. Хуульчдийн хувьд аж үйлдвэрийн салбарын хэвийн тогтвортой хөгжлийг хангаж ажиллахын зэрэгцээ олсон ашиг орлогоо төрийн халамжийн байгууллагад хөрөнгө оруулалт хийдэг зэргээс харахад хуульчийн мэргэжил нь нийгмийн сайн сайхан болон арилжаа, худалдааны үйл ажиллгааны тэнцвэрт байдал гэж үзэх үндэслэлтэй юм.

2.Хуульчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхэд тулгарч буй асуудлууд

2.1. Үнэнч,шударга байдал,итгэл үнэмшилтэй байх үндсэн зарчмын ойлголт учир дутагдалтай

Үнэнч шударга,итгэлтэй байх зарчим болон бүх хүмүүсийн баримтлах үндсэн суурь зарчим бөгөөд хуульчийн мэргэжлийн хувьд тэдний заавал дагаж мөрдөх ёстой үнэнч шударга байх, итгэл тэй байх зарчим нь нэг талаас үйлчлүүлэгчиддээ үнэнч, шударга хандах, нөгөө талаас хууль шүүхийн байгууллагад хариуцлагатай байхыг санууулж буйн илрэл юм.[7] Гэвч бодитбайдалдзарим хуульчидилүү их ашиг хүртэхийн тулд талуудад худал амлалт өгөх, өндөр төлбөр авах, шүүхэд худал мэдүүлэг өгөх, тэр ч бүү хэл зохигчид нотлох баримтыг хуурамчаар үйлдэх зэрэг ноцтой үйлдлүүдийг гаргасаар байна. Нэг талаас хуульчид шударга, итгэл үнэмшилтэй байх гэсэн зарчмыг зөрчиж байгаа нь хятад улсын шүүхийн хэвийн тасралтгүй үйл ажиллагаандсөргөөр нөлөөлсөн бол нөгөө талаас худал амлалт өгөх, зэргээр үнэнч шударга байдал, итгэл үнэмшилийн үзэл баримтлалыг зөрчсөн нь зарим хуульчдийн зохисгүй үйлдэл нь хууль тогтоомж зөрчсөн гэж сэжиглэх үндэслэл болж болзошгүй.Энэ нь тухайн хуульчийн өөрийнх нь байр суурь болон хуулийн фирмийн нэр хүндэд ноцтой нөлөөлөхөөс гадна хуулийн хариуцлага хүлээх хангалттай үндэслэл болно.[8] Дээрх нөхцөл байдлыг дүгнэн үзэхэд, Хятад улс болон манай улсын хууль зүйн салбарт ажиллаж буй хуульчид мэргэжлийн ёс зүйн хувьд шударга байх, үнэнч, итгэл үнэмшил гэсэн үндсэн суурь ойлголт учир дутагдалтай байгааг харж болохоос гадна эдийн засгийн ашиг сонирхолд хэтэрхий анхаарал хандуулж байна.

2.2. Хуульчдийн хувь хүний бие даасан байдал тийм ч хүчирхэг биш

Хуульчидтэр дундаа өмгөөлөгчиднь өөрийн үйлчлүүлэгчдэд мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, хууль шүүхийн өмнө үйлчлүүлэгчийн хууль ёсны эрхийг хамгаалдаг мэргэжил бөгөөд энэ нь хуульчдаас бие даасан байдлаа хадгалах, улмаар бодит нөхцөл байдлын талаар үнэн зөв дүгнэлт хийж,мэргэжлийн үнэ цэнэтэй саналуудыг үйлчлүүлэгчдэдхүргэх боломжийг олгодог.[9] Хуульч, судлаач Zhang Xiao kang өөрийн бүтээлдээ: Өнөөгийн нийгэмд зарим хуульчид хувь хүний бие даасан хараат бус байдал сулрах, илүү их мөнгөн урамшуулал авах зорилгоор талуудын үндэслэлгүй, хууль бус шаардлагыг хүлээн авах, нөгөөтэйгүүр үйлчлүүлэгчдээ илүү таатай шийдвэр гаргахын тулд шүүгчдэдавлига өгөхөөс буцахгүй байх,мэргэжлийн мөн чанараа эрхэмлэхгүй зүй бус үйлдэл гаргаж буй талаар дурдсан байна.[10] Дээрх зүй бус үйлдэл нь хуульчдийн хувь хүний бие даасан байдлаа алдаж, эд хөрөнгийн ашиг сонирхолтой, хууль зөрчсөн төдийгүй хатуу шийтгэл хүлээж магадлал өндөр байгааг илтгэн харуулж байна.

3. Шинэ эринд хуульчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх санал, санаачлага

3.1. Олон нийтэд ухуулга сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх нь

Юуны түрүүнд олон нийтэд хуульчийн мэргэжлийн ёс зүйг хэрхэн төлөвшүүлэх талаарх ухуулга, сурталчилгааны ажлыг эрчимжүүлж,шинэ

6 *Huang Ke. An Analysis of the Legal Phenomenon of Distorted Professional Ethics of Chinese Lawyers——Taking the "Li Zhuang Case" as an example [J]. Legal System and Society. 2017(10):59-60.*

7 *Cai Yongqing. "Problems in the construction of lawyers' professional ethics and their solutions" [J]. Law System and Society. 2017(04):206-207.*

8 *Zhang Chun. "Discussion on the issue of lawyers professional ethics" [J]. The rule of law and society. 2016(25):113-114.*

9 *Wen Xiaoyan. "Socialist core values and the construction of lawyers' professional ethics" [J]. reason On Observation. 2016(01):64-65.*

10 *Zhang Xiaokang. "On the construction of professional ethics of lawyers in my country " [J]. Legal Expo. 2019 (03):189-190.*

эрин үеийн хуульчдад мэргэжлийн ёс зүйн стандарт шаардлагыг ойлгуулах,өмгөөлөгч хуульчдаас тусламж хүсэхдээ бид хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, стандартыг дагаж мөрдөж, баримталж байгаа эсэхэд хяналт тавих замаар өөрсдийн хууль ёсны эрхийг хамгаалахад анхаарах, шинэ залуу хуульчдад мэргэжлийн ёс зүй ямар байх ёстойг ойлгоход мэргэжлийн холбоо,хууль зүйн яамны зүгээс анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай. Эцэст нь дэлхий дээрх улс орнуудын эрх зүйн тогтолцоо нь өөр хэдий боловч хуульчдийн мэргэжлийн ёс зүйн талаар салбарын холбоод, нийгэмлэг холбогдох байгууллагууд мэргэжлийн ёс зүйг хэрхэн төлөвшүүлж буйг сурталчилах, хурал зөвлөгөөнийг хуульчдийн дунд зохион байгуулах, мэргэжлийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх тухай хэлэлцүүлэг өрнүүлэх, бусад хуульчдад сурталцахад нь тусламж дэмжлэг үзүүлэх нь чухал асуудал юм.

3.2. Хуульчдийн ажиллах орчныг цэвэршүүлэх ажилд анхаарал хандуулах нь

БНХАУ-ын шинэ эрин үеийн хуульчдын мэргэжлийн ёс зүйн талаар судалгааны ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх явцад Хятад улсын хуульчдийн ажил мэргэжлийн эргэн тойронд олон төрлийн асуудал байгааг олж харж болно.Олон хуульчид эдийн засгийн ашиг сонирхолын төлөө хэт их анхаарал хандуулж,мөнгөний төлөө өрсөлдөхөөс буцахгүй байх,хуурам сурталчилгаа хийх, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх зэргээр хууран мэхэлж буй үйлдэл байсаар байна.Энэ бүхний эцэст Хятад улсын хуульчдийн ажиллах орчин нөхцөлийг цэвэршүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлж байна.[11] Хятад улсын хуульчдийн дунд хуурамч сурталчилгаа хийж хууран мэхэлж буй хууль зүйн фирмүүд,нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан хэдий боловч учир дутагдалтай,хуурамч зарга,мэргэжлийн ур чадваргүй байдал,мэргэжлийн ёс зүйгүй байдал зэрэг асуудлуудамь бөхтэй байсаар байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах шаардлагатай.

3.3. Олон нийтийн хяналтыг бэхжүүлэх нь

Хятад улс бол социалист орон бөгөөд улс орны бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх талаар тунхагласан нь ард иргэдэд байдаг хамгийн чухал хяналтын эрх мэдэл гэж тодорхойлж болно. Хуульчийн мэргэжлийн ёс зүйд тавих хяналтын хэлбэрт төрийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх нь нэг талаас холбогдох мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх нь олон нийтийн эрх ашигт илүү нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах бүрэн боломжтой. Нөгөөтэйгүүр хуульчдийн мэргэжлийн ёс зүйг олон нийтэд таниулан сурталчилах ач холбогдолтой.Тухайлбал, олон нийтийн хяналтын механизмыг бэхжүүлэхийн тулд оновчтой арга замыг эрэлхийлэх,олон нийтийн зүгээс хуульчдийн мэргэжлийн ёс зүй үл хайхарсан үйлдэл гаргаж буй хуульчдийг холбогдох салбарын холбоо,нийгэмлэгт мэдэгдэх үүрэг хүлээнэ. Түүнчлэн олон нийтийн хяналтыг чангатгах нь хуульчийн мэргэжлийн ёс зүйн тодорхой агуулга, хууль ёсны эрхийн талаар олон нийтэд нэгдмэл нэг ойлголттой болгох шаардлага нь нэн тэргүүний ажил юм.

ДҮГНЭЛТ

Хуульчид бол тухай улс орны эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чухал үүрэгтэй. Хятад улс нь манай улсын сайн хөрш, найрсаг хамтын ажиллагааны хүрээнд эрх зүйн тогтолцооны хувьд өөрийн гэсэн өвөрмөц социалист эрх зүйн тогтолцоотой улсын томоохон төлөөлөл учир хуульчдийн мэргэжлийн ёс зүйн асуудлыг судлан танин мэдэх гол зорилгын хүрээнд судалж үзлээ. Хятад улсын хувьд шинэ эринд улс эх орны хөгжлийн нэг гол тулгуур нийгмийн сайн сайхан байдлын төлөө хуульчдийн мэргэжлийн ёс зүйд шинэ стандарт шаардлага өөрчлөлтүүд гарч байгааг анзаарахгүй байх аргагүй юм. Хуульчийн мэргэжлийн ёс зүйг бэхжүүлэх талаар судлах нь Хятадын өвөрмөц онцлог бүхий социализм бүхий нийгмийг цогцлооход чухал үүрэгтэй.Хуульчдийн мэргэжлийн ёс зүйн өнөөгийн нөхцөл байдалд үнэнч шударга байдал,итгэл үнэмшилгүй,хуульчийн мэргэжлийн бие даасан шинж чанаргүй байдал, мэргэжлийн ур чадварын хангалттай бус байгаа зэрэг асуудалд дүгнэлт хийж, олж илрүүлэхийг оролдсон болно.Эдгээр тулгамдсан асуудалддүгнэлт хийх замаар хуульчдийн мэргэжлийн ур чадварыг өсөн нэмэгдүүлэх, салбар холбоод, нийгэмлэгийн үйл ажиллагаа, хяналтын чиг үүргийг чангатгах, хуульчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх,олон нийтийн хяналтыг идэвхжүүлэх нь зөвхөн Хятад улс төдийгүй манай улсын хувьд ч хууль зүйн салбарын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах,дэмжлэг үзүүлнэ гэж найдаж байна.

11 *Ye Zemin. " On the Regulation of Lawyers' Professional Ethics in my country" [J]. Legal System and Society. 2017 (21):297-298*

Ашигласан материал, эх сурвалж:

1. Zhang Zhen Ming."Benevolence" and the norms and development of lawyers' professional ethics [J]. 2017 (05)
2. Yu Xiao Xin. БНХАУ-ын хуульчдын мэргэжлийн ёс зүйн дүрэм [J]. Хууль,эрх зүйн тогтолцоо ба нийгэм сэтгүүл ,2017(16)
3. Gao Jun. Researchon the construction of lawyers' professional ethics from the perspective of rule of law [J]. Legal system and Society,2019 (03)
4. Yu Xiao xin. "Lawyers' Professional Ethics Regulations in my country" [J]. Legal System and Society,2017(16)
5. Huang Ke. An Analysis of the Legal Phenomenon of Distorted Professional Ethics of Chinese Lawyers——Taking the "Li Zhuang Case" as an example [J]. Legal System and Society, 2017(10)
6. Cai Yongqing. "Problems in the construction of lawyers' professional ethics and their solutions" [J]. Law System and Society,2017(04)
7. Zhang Chun. "Discussion on the issue of lawyers' professional ethics" [J]. The rule of law and society,2016(25)
8. Wen Xiaoyan. "Socialist core values and the construction of lawyers' professional ethics" [J]. reason On Observation,2016(01)
9. Zhang Xiaokang. "On the construction of professional ethics of lawyers in my country " [J]. Legal Expo,2019 (03)
10. Ye Zemin. " On the Regulation of Lawyers' Professional Ethics in my country" [J]. Legal System and Society,2017 (21)

ТЭНСЭХ ИНСТИТУТЫН ШИНЭЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

Г.Хишигсүрэн
Их Засаг ОУИС-ийн докторант, өмгөөлөгч

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлд тэнсэх институтыг өмнөх Эрүүгийн хуулиудаас зарчмын өөр агуулгаар хуульчилсан, "хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" тухай ойлголтыг шүүхийн практикт нэг мөр ойлгож хэвшүүлэх зорилгоор энэ сэдвийг сонголоо. Тэнсэхийг үг зүйн хувьд авч үзвэл: - юмс үзэгдлийн үнэн болон ташаа, сайн болон мууг сорих, үйл хэргийг турших гэсэн утгатай[1] хэмээн тайлбарлажээ. Ял, хариуцлагыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэх хоёр үндсэн хэлбэр дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэгжиж байгаа бөгөөд манай улс 2017 он хүртэл хорих ял оногдуулсаны дараа биелэлтийг нь хойшлуулж, түдгэлзүүлдэг /**Parole**/ хэлбэрийг хэрэглэж ирсэн. Хоёрдахь хэлбэр нь /**Probition-пробация**/ буюу ял оноохгүйгээр тэнсэж, тодорхой үүрэг хүлээлгэдэг хувилбар нь Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнууд төдийгүй эх газрын эрх зүйн бүлд хамаарах цөөнгүй улсууд хэрэглэгддэг бөгөөд 2015 оны Эрүүгийн хуулиар ял тэнсэх "пробация" хэмээх тогтолцоог сонгож авсан нь дэвшил болсон гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Монгол Улсын шүүхийн тоо баримтаас үзэхэд жилд дунджаар 8000 орчим хүн ял шийтгэгддэгээс 6400 орчим хүнд хорих ял оногдуулдаг, тэдгээрийн тал хувьд нь буюу 3200 шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж хянан харгалзжээ[2].

Он	Ял шийтгүүлсэн хүн	Тэнссэн хүний тоо	Тэнссэн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн хүний тоо
2013	8065	3342	112
2014	8178	3396	188
2015	7696	3197	189
2016	6566	3266	199

Түүхэн уламжлалын хувьд авч үзвэл 1926 оны БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг"-ийн 8 дугаар зүйлд "..шүүх газраас тогтоосон ялын хугацаа нь 5 жилээс хэтрэхгүй бол ялыг нь биечлэн эдлүүлэхгүйгээр түдгэлзүүлж болно, уг ялтан зөрчил гаргавал оноосон ялыг биечлэн эдлүүлнэ[3],9 дүгээр зүйлд "...хэрэв уг ялтан тэнссэн хугацаа дуусахын өмнө дахин хэрэг үйлдвээс шинэ хэргийн улмаас оногдуулсан ял дээр түдгэлзүүлсэн ялыг нэмж хамтатган хорих ялаар шийтгэнэ"[4].

Дээрх заалт нь 1929, 1934 оны Шүүх цаазын бичгүүдэд агуулгын хувьд ойролцоо байдлаар тусгагдсан ба дараа нь БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуулийн "Ял шийтгэл ба ялаас чөлөөлөх тухай" 4 дүгээр бүлгийн 33 дугаар зүйлд[5] "ял тэнсэх" үндэслэл,журмыг хуульчилжээ.

Хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэсэн ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл тухайн шалтгааныг тодорхойлон тэнсэхээр тогтоож, 1-5 жилийн хугацаагаар хянан харгалзана гэж 33 дугаар зүйлд заасан бол дараа нь 1986 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын "Ял оногдуулах ба ялаас чөлөөлөх" 4 дүгээр бүлгийн 40 дүгээр зүйлд[6]мөн дээрх агуулгаар хуульчлагдсан байна.

Ял тэнсэх талаар манай олон эрдэмтэн санал бодлоо илэрхийлсэн ба доктор (Sc.D) Б.Содовсүрэн "...шүүх ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг баримтлан хорих болон засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хянан харгалзах тодорхой хугацааны дотор ялыг биечлэн эдлүүлэхээс түдгэлзүүлэхийг хэлнэ[7]" гэсэн бол академич С.Нарангэрэл "...ял тэнсэх нь гэмт этгээдэд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр ялын хүмүүжүүлэх зорилгод хүрэх, ялыг биечлэн эдлүүлэх болзлыг төр,олон нийтийн хяналт-шалгалт, олон нийтийн нөлөөллөөр төрийн өмнөөс зөмлэл шийтгэсэнээр илэрдэг арга хэмжээ мөн[8] гэжээ.

1 *Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1976 он. 903 дахь тал.*

2 *ШЕЗ-с эрхлэн гаргадаг Шүүн таслах ажиллагааны тайлан. 2011-2016 он.*

3 *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011 он. 283 дахь тал*

4 *Ж.Болдбаатар. Д.Цэндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997 он, 156 дахь талд.*

5 *БНМАУ-ын Хуулиуд. 1 дүгээр боть. УБ., 1980 он, 74 дэх талд*

6 *БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1986 он, 57 дахь талд.*

7 *Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн эрх. УБ., 1969 он, 138 дахь талд*

8 *С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/. 1996 он, 340 дэх тал*

1926-2002 он хүртэл хорих ялаас гадна засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж болдог, тэнсэгдсэн ялтанд нэмэгдэл ял, тодорхой үүрэг ногдуулдаг байсныг 2002 оны Эрүүгийн хуулиар өөрчилж зөвхөн хүндэвтэр гэмт хэрэгт 1-5 жилийн хугацаатай хорих ял оногдуулсан тохиолдолдуг ялыг нь биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж хянан харгалздаг, тэнсэгдсэн ялтанд үүрэг ногдуулдаггүй байхаар тогтоожээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд "...анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан этгээдэд оногдуулсан хорих ялыг тэнсэж 1-5 жил хүртэл хугацаагаар хянан харгалзана[9] гэж заасан нь тэнсэх институтын харьцангуй хумигдмал хэлбэр байсан. 2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийг хүчин төгөлдөр болсон Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйл заалттай харьцуулан судлахад дараах нөхцөл байдлууд өөрчлөгдөж, шинэчлэгдсэн байна. Үүнд:

Нэг. 2002 оны Эрүүгийн хуульд хорих ял оногдуулаад тэнсдэг байсантай холбоотойгоор "тэнсэгдсэн ялтан" гэж нэрлэж байсан, шинэ Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахгүй тэнсдэг болсон учир цаашид "тэнсэгдсэн этгээд" гэж нэрлэж хэвших нь зүйтэй.

2002 оны Эрүүгийн хуульд "хянан харгалзах хугацаа" гэсэн ойлголтыг хэрэглэж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар дээрх ойлголтыг халсан болно.

Хоёр. Тэнсэх журмыг өмнө нь хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдэд л хэрэглэдэг байсныг шинэ Эрүүгийн хуулиар гэм буруугаа хүлээсэн хөнгөн гэмт хэрэг" үйлдсэн этгээдэд хэрэглэх бөгөөд 2002 оны Эрүүгийн хуульд байсан "анх удаа гэмт хэрэг үйлдсэн" гэх шинжийг хассан. **Тэнсэхгүй байх хязгаарлалтыг тогтоохдоо "..Эрүүгийн хуулийн тусгай ангид** заасан хоёр, түүнээс дээш гэмт хэргийг санаатай үйлдсэн, эсхүл хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн бол тэнсэхгүй" гэж тодорхойлсоноос үзэхэд хөнгөн ангилалд багтах хоёр төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тэнсэхгүй бөгөөд ялыг нь биечлэн эдлүүлнэ.

2002 оны Эрүүгийн хуульд тусгай ангийн өөр зүйл хэсэгт заасан 2 ба түүнээс дээш тооны хүндэвтэр гэмт хэргийг үйлдсэн байхад ялыг нэмж нэгтгэх буюу багтааж тухайн этгээд урьд нь гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хохирол төлсөн байхад тэнсэх боломж нээлттэй байсан бол шинэ Эрүүгийн хуулиар хаалттай болж байна.

Түүнчлэн зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн нь хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн, хохирол төлсөн ч тэнсэх боломжгүй, хүнд ангилалд хамаарах гэмт хэрэг буюу 5 жилээс дээш хорих ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тэнсэх журмыг хэрэглэхгүй бөгөөд ялыг оногдуулна.

Гурав. Өмнө нь хохирлыг бүрэн төлсөн, гэмт хорыг арилгасан тохиолдолд л хорих ялыг тэнсэх боломжтой байсныг шинэ хуулиар өөрчилж хохирол төлсөнөөс гадна хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн байхад тэнсэх боломжийг шүүхэд олгосон.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ялын дээд хэмжээг 3 жил болон түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэгт ялаас чөлөөлөх эсхүл 3 жил хүртэл хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх сонголт байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасны дагуу хөнгөн гэмт хэрэг үйлдэж хохирлоо нөхөн төлсөн ч ялаас чөлөөлөхгүй бөгөөд харин тэнсэх сонголт байгааг анхаарах нь зүйтэй.

Дөрөв. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн этгээдэд л тэнсэх журам үйлчлэхээр 2015 оны Эрүүгийн хуульд заажээ. Өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэрэг үйлдсэн боловч гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй, мэтгэлцэж байгаа хүн хохирлоо нөхөн төлсөн ч тэнсэх журмыг хэрэглэхгүй. Жишээ нь зам тээврийн ослын улмаас хүний амь нас үрэгдсэн хэрэгт ихэнх жолооч нар буруугаа хүлээдэггүй, гэм буруугийн талаар мэтгэлцдэг ба төрийн энэрэнгүй ёсны илрэл болсон тэнсэх зохицуулалтыг зөвхөн гэм буруугаа хүлээсэн этгээд хохирлоо нөхөн төлсөн буюу хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн тохиолдолд хөнгөлөлт эдлэхээр хууль тогтоогч тогтоожээ.

Тав. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхэд шилжсэн хэргийг нэг удаагийн шүүх хуралдаанаар гэм буруутай эсэх болон оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээний талаар хамтатган хэлэлцэж шийдвэр гаргадаг байсан. Энэ нь шүүх хурлын өмнө гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй мэтгэлцэж байгаа шүүгдэгч талыг "хохирлоо төлөх

9 *Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2002 он. №5. Эрүүгийн хууль.*

үү болих уу" гэсэн эргэлзээнд хүргэж, улмаар хохирол төлөхгүй шүүх хуралдаанд оролцсоноор шүүхээс шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож хорих ял оноож шууд цагдан хорьсоноор тэнсэгдэх боломжоо алдах тохиолдол цөөнгүй гарсан.

Тэгвэл 2017 онд батлагдсан "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуулиар анхан шатны шүүх хуралдааныг гэм бурууг тогтоох болон ял оногдуулах хурал гэсэн 2 үе шатанд хуваасанаар шүүгдэгч нь гэм бурууг тогтоох шүүх хурлын дараа ажлын 5 хоног хүртэл завсарлага авах эрхтэй болж энэ хугацаанд хохирлоо төлөх бололцоогоор хангагдаж дараа нь ял оногдуулах шүүх хуралд оролцож, улмаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдэх боломжтой болсон нь олон улсын жишигт нийцэж байна.

Зургаа. 2002 оны Эрүүгийн хуулиар тэнсэгдсэн ялтанд шүүхээс үүрэг ногдуулдагүй байсан нь учир дутагдалтай байсан бөгөөд шинэ Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхийн хамт үүрэг ногдуулах болон эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг давхар хэрэглэж болно гэж хуульчилсан. Гэвч шүүх 2017 оны 07 сараас 2018 оны 05 сар хүртэлх хугацаанд 1000 гаруй хүн тэнссэнээс 50 орчим хувьднь ямар нэгэн үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ ногдуулалгүй тэнссэн нь хариуцлагын механизмыг ашиглахгүй байгааг харуулж байна.

Иймд Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээтэй хамт оногдуулна гэж өөрчлөх нь зүйтэй..

Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан 5 төрлийн үүргээс дангаар нь сонгох болон давхардуулан оногдуулах эрхийг шүүхэд олгожээ. Үүрэг хүлээлгэх арга хэмжээний төрлүүдийг дурьдвал:

Долоо. Цагдаагийн байгууллага тэнсэгдсэн ялтанд хяналт тавина гэж 2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд хуульчилжээ. Судалгаагаар цагдаагийн байгууллагыг төлөөлж тэнсэгдсэн ялтанд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа хэсгийн байцаагч нартай уулзаж ярилцахад тэдний олонх нь ажлын ачаалал ихтэйгээс хяналтыг хэлбэрийн төдий хэрэгжүүлж тэнсэгдсэн ялтныг хааяа дуудаж бүртгэдэг,заримтай нь утсаар ярьдаг, зарим нь сүүлийн 2-3 сарын хугацаанд ялтантай уулзаагүй, хаана юу хийж явааг нь мэдэхгүй байдалтай байна.

Өмнө нь тэнсэгдсэн ялтанд хяналт тавих харилцааг Улсын ерөнхий прокурор, ЦЕГ-ын даргын хамтарсан 2016.01.18-ны А/05, А/09 тушаалын хавсралтаар батлагдсан "Тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих журам"-аар зохицуулж байсан бол шинэ Эрүүгийн хууль батлагдсанаар энэ журам хүчингүй болсон бөгөөд шинэ Эрүүгийн хуулиар тэнсэгдсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавих болсоноор хяналт сайжрах байх гэсэн хүлээлттэй байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар бүлэгт **"Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх" ажиллагааны талаар хуульчилсан бөгөөд шийдвэр гүйцэтгэгч тэнсэгдсэн ялтанд хувийн хэрэг нээж тодорхой хяналтын ажиллагаа явуулахаар хуульчилсан боловч өндөр хөгжилтэй орнуудын** Пробацийн албанаас явуулдаг бодитой, үр дүнтэй хяналтын хэлбэрүүдийг хуульд тусгаж чадаагүй л байна. Гадаадын эрх зүй хөгжсөн орнуудын туршлагаас харж байхад "Пробацийн алба" нэртэй төрийн тусгай алба тэнсэгдсэн этгээдэд хяналт тавьдаг бөгөөд хяналтын үйл ажиллагааны хэлбэр нь манайх шиг зөвхөн бүртгэл хийж идэвхигүй хяналт тавьж оромдох бус ажиглалт хийх,гэр орон,ажлын байранд нь очиж уулзах,архидан согтуурах,мансуурах донтой этгээдийг сар бүр тестерээр шалгах, гэнэтийн шалгалт хийх, хөршүүдээс нь лавлагаа, камер, GPS зэрэг техникийн дэвшлийг ашиглаж хяналтыг явуулдаг байна. Хэрэв тэнсэгдсэн этгээд шүүхээс оногдуулсан үүргийг зөрчсөн бол пробацийн албанаас зөрчлийн шинж байдлаас хамаарч шүүхэд хандаж тэнссэн шийдвэрийг хүчингүй болгох, эсвэл хуульд заасан ялыг оногдуулах санал гаргах эрхтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Манай улсад хорих ялыг тэнссэн ялтны 13 хувь нь тэнссэн хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн байхад АНУ, Их Британи, ХБНГУ, Франц зэрэг улсад тэнсэгдсэн этгээдийн 2-3 хувь нь дахин гэмт хэрэгт холбогдсон нь дээрх орнуудын "Пробацийн алба" тэнсэгдсэн этгээдэд тавих хяналтыг илүү бодитой хэрэгжүүлдэг байх нь.

САНАЛ ДҮГНЭЛТ

Нэг. Шинэ Эрүүгийн хуульд зөвхөн гэм бууруугаа хүлээн зөвшөөрсөн этгээдэд "хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" журмыг хэрэглэх болсон нь иргэдийн Үндсэн хуульд заасан эрхэнд халдсан байж болзошгүй. 2002 оны Эрүүгийн хуульд дээрх шаардлага тавигддагүй байсан учир шүүгдэгч гэм бууруугийн талаар мэтгэлцээд гэм бууруугаа хүлээн зөвшөөрөөгүй байсан ч шүүхээс хохирлоо нөхөн

төлсөн, анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн бол оногдуулсан хорих ялыг тэнсдэг байсан жишиг уламжлалыг хадгалах нь зүйтэй болов уу.

Хоёр. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчид оногдуулах ялыг тэнсэх тухай зохицуулалт нь хамрах хүрээ ач холбогдол багатай учир 8 жил хүртэл хорих ялтай хэргийг шүүгч дангаараа хянан шийдвэрлэх болсон жишгийг харгалзан 8 жил хүртэл хорих ялтай гэмт хэрэгт тэнсэх боломжийг нээж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Гурав. Тэнсэгдсэн этгээдэд Англи, АНУ-д "Пробацийн алба" гэдэг тусгай алба хяналт тавьдаг, Герман болон Франц ад тусгай төлөөлөгч хяналт тавьдаг жишгийг харгалзан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд Пробацийн албыг тусад нь байгуулах шаардлагатай.

Дөрөв. Тэнсэгдсэн этгээдэдтавих хяналтыг боловсронгуй болгохын тулд тухайн этгээдийн зан үйлд хяналт тавих ажиллагааг боловсронгуй болгож Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой. Тухайлбал дээр дурьдсанаар АНУ, Их Британи зэрэг улсад пробацийн алба нь тэнсэгдсэн этгээдийг ажлын байранд зуучлах, эрх зүйн албан бус сургалтанд хамруулах, ажлын газар болон гэрт нь гэнэт очиж шалгах, ажиглалт хийх, сар бүр мансууруулах бодис, архидан согтуурсан эсэхийг шалгах тестер хийх, хөршийн хяналт, камер, GPS зэрэг техникийн дэвшлийг ашиглах зэрэг олон ажиллагаа явуулдаг туршлагыг нэвтрүүлж хяналтыг хэлбэрийн төдий бус бодит ажил болгоход анхаарах шаардлагатай.

ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ ТООЦОХ, ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ АРГА ЗАМ

Г.Хишигсүрэн

Их Засаг ОУИС-ийн докторант, Татварын мэргэшсэн зөвлөх.

Түлхүүр үг: Татвар, татвараас зайлсхийх, хохирол, хор уршиг.

Хураангуй: Монгол Улс дахь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргээс үүдэлтэй хохирол хэрхэн учирдаг, хохирлын хэмжээг хэрхэн тооцох, хор уршгийг барагдуулах үр дүнтэй арга замыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Татвар байх шалтгаан нь агуулгаараа нийгмийн хэрэгцээ байх бөгөөд татвар нь хэлбэрийн хувьд нийгмийн харилцааны нэг элемент болдог бол татварыг төлөх нь агуулгаараа нийгмийн хэрэгцээнээс үүсэлтэй үүрэг хэмээн хүлээн авах үзэл нь хэлбэрийн хувьд философийн ойлголтонд багтаж байдаг бол **татварын ногдуулалт нь** агуулгаараа эдийн засгийг зохицуулагч, татварын нөөц боломжийг бодитоор тодорхойлогч эдийн засгийн ойлголтонд багтана.

"Төр байгаа цагт татвар байна, татвар байж төр оршино"[1] гэсэн зарчим бүхий л улс оронд үйлчилдэг.

Татвар нь нэг талаас төр тогтоож, түүний эрх бүхий байгуулага нь хэрэгжүүлж буй нөгөө талаас татвар төлөгч болох хувь хүн, хуулийн этгээдийн зүгээс хууль тогтоомжийн шаардлагыг өндөр хариуцлагын дор сахин биелүүлж улсын төсөвт мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх нэг талт харилцаа болно.

Татвар нь нэг талт харилцаа болохын хувьд албадлагын шинжтэй. Төр нь татвар төлөгчийн мөнгөн хөрөнгийг эдийн засгийн шууд хариу төлбөргүйгээр хураан авдаг учраас татвар төлөгчийн сонирхол нь аль болох бага татвар төлөх,боломжтой бол төлөхгүй байхад чиглэсэн хандлагатай байдаг. Татвар төлөхөөс зайлсхийх тохиолдолд сөрөг үр дагавар буюу хуулийн хариуцлага үүсдэг байна.

Татвар нь улсын төсвийг бүрдүүлж, иргэдийг нийгмийн зүгээс хамгаалах баталгаа болохоос гадна төр үйл ажиллагаагаа хэвийн явуулах үндсэн нөхцөл болдог бөгөөд улс орныхоо эдийн өсөлтийг хангаж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, төсөв бүрдүүлэх **чиг үүрэг** татварын бодлогоор дамжин хэрэгждэг.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг зөрчлийг эрүүгийн бусад төрлийн гэмт хэргээс эдийн засаг,нийгмийн хор уршиг,үр дагаврын хувьд илүү ноцтой түвшний гэмт явдал гэж үзэж энэ гэмт хэрэгтэй улс орон бүр өөрийн арга хэрэгсэл, эрх зүйн зохицуулалтаар тэмцсээр ирсэн.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн улмаас улсын төсөвт орж ирэх мөнгө багасч энэ нь улс орны эдийн засаг,аж ахуйн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлнэ.

Гэмт хэргийн хохирол, хор уршиг: Гэмт хэргийн хохирол гэдэгт бусдын өмчлөх эрхэнд шууд учирсан эд материалын хохирлоос гадна гэмт хэргийн хор уршгийг арилгахад шууд гарсан зардал, гэмт хэргийн улмаас хүлээсэн эд хөрөнгийн алдагдал, алдагдсан ашиг, орлого хамаардаг бөгөөд **хохирлыг нөхөн төлөх** гэдэгт шууд учирсан, мөнгөн илэрхийллээр хэмжигдэх эд хөрөнгийн хор уршгийг нөхөн төлөх, шилжүүлэн өгөх, арилгахыг ойлгох бол **гэм хорыг арилгах** гэдэгт Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх,ашиг сонирхолд учирсан хохирлоос бусад шууд учирсан хор уршиг, үр дагаврыг арилгахыг хэлнэ. **"Гэмт хэргийн хор уршиг"**-ийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Хүнд учрах хор уршиг;
- Байгаль орчинд учрах хор уршиг;
- Төрд учрах хор уршиг;
- Нийгэмд учрах хор уршиг зэрэг болно.

Гэмт хэргийн хохирол, хор уршиг: Гэмт хэргийн хохирол гэдэгт бусдын өмчлөх эрхэнд шууд учирсан эд материалын хохирлоос гадна гэмт хэргийн хор уршгийг арилгахад шууд гарсан зардал, гэмт хэргийн улмаас хүлээсэн эд хөрөнгийн алдагдал, алдагдсан ашиг, орлого хамаардаг бөгөөд **хохирлыг нөхөн төлөх** гэдэгт шууд учирсан, мөнгөн илэрхийллээр хэмжигдэх эд хөрөнгийн хор уршгийг нөхөн төлөх, шилжүүлэн өгөх, арилгахыг ойлгох бол **гэм хорыг арилгах** гэдэгт Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх,ашиг сонирхолд учирсан

1 *С.Нямаагд. Г.Алтанзаяа. Татвар, татвар ногдуулалт. УБ., 2004 он. 29 дэх тал.*

хохирлоос бусад шууд учирсан хор уршиг, үр дагаврыг арилгахыг хэлнэ.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хохирол нь улсад төлөгдөөгүй татварын хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд жилдээ 100 орчим тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

Өнөөдөр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 120,000 ААН, байгууллагын 90 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй хэмээн "Х" (икс) тайлан өгч байгаа, үүний дотор жилдээ тэрбум төгрөгнөөс дээш төгрөгийн эргэлттэй үйл ажиллагаа явуулж, олон орон сууц ашиглалтанд оруулсан барилгын 10 орчим компани олон жилийн турш "Х" тайлан өгч байсан тухай саяхан хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлагдсан. Үүнээс үзвэл татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлт муу, олон тэрбум төгрөгийн татварын хохирол барагдахгүй татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь маш нуугдмал шинжтэй байдгийн нэгэн илрэл гэж үзэхэд хүргэж байна.

Өөр нэг жишээ гэхэд жижиг дунд компаниудын олонх нь санхүү татварын тайлангаа хэд хэдэн янзаар гаргаж татварын байгууллагад орлогоо нуун дарагдуулсан тайлан өгдөг, түншүүддээ болон банкнаас зээл хүсэх үедээ жинхэнэ тайлангаа гаргаж өгдөг жишиг нэгэнт тогтсон байна.

Манай улсад жилд 75 орчим үйлдэлд цагдаагийн татвараас их хэмжээгээр зайлсхийсэн байж болзошгүй хэмээн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгадаг ч 2-3 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шүүхэд шилжүүлж сүүлийн 2 жилд 2 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгджээ.

Эдгээр шалтгааны улмаас улсын төсөвт төлөх татвар багасч, улсын эдийн засгийн аюулгүй байдалд хүнд хохирол учирдаг байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсад татвараас зайлсхийх гэмт хэрэг нуугдмал шинжтэйг харуулсан бөгөөд миний бие судалгааны явцад бүртгэгдсэн 1 актын ард 100 татвараас их хэмжээтэй зайлсхийсэн үйлдэл нуугдаж байна гэж дүгнэсэн, өөрөөр хэлбэл Монголд жилд 7500 орчим татвараас их хэмжээтэй зайлсхийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл гардаг ч илрүүлж чаддаггүй, илрүүлсэн хэргүүдээ шүүхээр оруулж эрүүгийн хариуцлага тооцож чадахгүй байна.

Үүний гол шалтгаан нь 2002 оноос хойш Эрүүгийн хуулийн тусгай ангид байгаа татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн объектив талтай холбоотой бөгөөд "...Татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол" гэж тодорхойлсон нь ойлгомжгүй байдал үүсгэж байна гэж судлаачийн зүгээс үзсэн.

Өөрөөр хэлбэл "их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээ" гэдэг нь маргаан дагуулж ирсэн бөгөөд "их хэмжээний" гэдэг үгийг судлаач, өмгөөлөгч, хуульч нар янз бүрээр тайлбарлаж улмаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар "хуулийг тайлбарлахад эргэлзээ гарвал яллагдагч этгээдэд ашигтайгаар тайлбарлаж шийдвэрлэнэ" гэсний дагуу хэрэгсэхгүй болгох хандлага гаддаж байна.

Харин Улсын дээд шүүхээс "их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээ" гэдгийг Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.1-д заасан "их хэмжээний хохирол"-той адилтган ойлгоно гэж шийдвэрлэсэний дагуу мөрдөн байцаалт, шүүхийн практик тогтож эхэлсэн.

Түүнчлэн 2020 оны 1 дүгээр сарын 10-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүртэл татвараас зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 1 жил байна, мөн эрүүгийн хэрэг үүсгэсэнээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоохгүй, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр хүртэл тоолно[2]" гэсэн заалт үйлчилж байсан нь татвараас зайлсхийх бараг бүх хэргүүдийг шүүхийн шатанд хүргүүлэхээс өмнө хөөн хэлэлцэх хугацаа дуусаж байв. Энэ байдлыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 1.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг нэмж оруулан "татвар төлөхөөс зайлсхийх" гэмт хэргийн хугацааг онцгойлон 5 жилийн хугацаатай байхаар тогтоосон, мөн яллагдагчаар татсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох тухай хууль эрх зүйн орчин үйлчилж эхэлсэнээр ял завших том үүд хаалгыг хааж чадсан.

Иймээс татвар төлөхөөс их хэмжээтэй зайлсхийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлж илрүүлсэн хэргүүдээ шүүхээр оруулж эрүүгийн хариуцлага тооцож хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь татвар төлөхөөс зайлсхийх нөхцөлийг хааж боломж нээгдэнэ гэж дүгнэж байна.

---

2 *www.Legalinfo.mn веб хуудас. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2015 он. 2020.01.10-ны нэмэлт өөрчлөлтөөр ЭХЕА-н 1.10 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлт*

САНАЛ

Татвараас зайлсхийх гэмт хэргийн субъект нь зөвхөн хувь хүн байгаа нь олон улсын жишиг, хариуцлага гарцаагүй байх зарчимтай нийцэхгүй байна. 2015 оны Эрүүгийн хуульд 38 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар заасан ч хуулийн этгээдийн хамгийн их үйлддэг татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг заагаагүй нь алдаатай бодлого гэж судлаачийн зүгээс дүгнэсэн.

Иймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг шинээр нэмж хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг тусгайлан зохицуулах шаардлагатай.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлд хүндрүүлэх бүрэлдэхүүн байхгүй, ялыг ялгамжтай оногдуулах талаар заагаагүй нь гадаад улсуудын сайн туршлагатай нийцэхгүй, шударга ёсны зарчмыг зөрчиж байгаа учир ялын бодлогыг өөрчлөх саналтай.

Ашигласан материал

1. Монгол улсын эрүүгийн хууль. 2015.
2. Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. УБ.,2017
3. Цагдаагийн Ерөнхий газрын 2018-2019 оны статистик мэдээ
4. www.Legalinfo.mn веб хуудас. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2015 он. 2020.01.10-ны нэмэлт өөрчлөлтөөр ЭХЕА-н 1.10 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлт
5. С.Нямзагд. Г.Алтанзаяа. Татвар, татвар ногдуулалт,УБ.,2004 он. 29 дэх тал.
6. Эдийн засгийн гэмт хэрэг. ШЕЗ-с эрхлэн гаргасан. УБ хот,2017 он.

ТҮҮХ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ

НАЙМАН ЗУУН ЖИЛИЙН ӨМНӨХ АГУУ ХҮН ЧИНГИС ХААНЫ ТӨРСӨН НУТГААР АЯЛСАН НЭГ УДААГИЙН ГАНЗАГА ДҮҮРЭН ХЭЭРИЙН ДАДЛАГА

Банзар
Өвөр Монголын багшийн их сургуулийн
Түүх, соёлын дээд сургуулийн багш

1206 оны хавар Онон мөрний хөвөөнөө Их Монгол улс байгуулагдсаныг тунхаглаж, соёл иргэншлийн хуучин хэв маягтай ертөнцөд шинэ мянган эхэлснийг зарлан дуудав. Энэ бол суурьшмал үндэстэн нуун хуримтлуулсан соёл иргэншлээс шал өөр нүүдлийн шинэ соёл иргэншлийн уриа дуудлага болсон юм.

Энэхүү уриа дуудлагад Алтан улс, Хорезм, Тангуд улс ялагдаж суурьшмал үндэстний соёл иргэншилд хүчит дайралт болж монголчуудын эрин зуун эхэлснийг дэлхий даяар тунхаглан зарласан билээ. Энэхүү сүр жавхлант түүх эхэлснээс хойш эдүгээ 800 жил өнгөрсөн байна. Энэ үеэр Монгол улсад Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх олон арван үйл ажиллагаа болж явагдав.

Зол завшаанаар манай Өвөр Монголын Багшийн их сургуулийн Түүх соёлын дээдсургуулийн багш,оюутнууд дэлгэр эуны сайхан улиралд Монгол улсад очиж, Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохиогдсон олон үйл ажиллагааг үзэж сонирхох сайхан боломж олдсон юм.

800 жилийн тэртээх агуу хүн Чингис хаан, түүний үйл ажиллагааг хайн шинжлэхээр гол зорилтоо болгосон манай сургуулийн энэ удаагийн аялал 2006 оны 7-р сарын 19-ны өдрөөс эхэлж, Хятад улсын умард хилийн хот болох Эрээн хотыг чиглэн хөдөллөө. Эрээн хот бол Өвөр Монгол орны хамгийн жижиг хот байсан боловч өөрчлөлт хийгдэж, худалдааг чөлөөтэй явуулах төрийн бодлогын сайнаар маш түргэн хөгжсөн хот юм. Одоо энэ хот Хятад улсын чухал нэг хилийн худалдааны хот болж хувираад байна. Цэцэглэн хөгжилтийнхөө ид үе дээр байгаа болохоор зээл (худалдааны зах) гудамж,барилга,хүн ардын хувцас хэрэглэл үйлдвэрлэх, худалдаалах нь орчин үеийн болж, хөгжилт дэвшилтийн агуу их хүчин чадлыг харуулсан томоохон хот болж хувирсан байна.

Бид бүхэн энэ хоттой сайн танилцаж чадалгүйгээр Эрээн хотоос Монгол улсын хилийн боомт болох Замын-Үүдийг зорин очоод, Монгол үндэстний голомт Монгол орондоо хөл тавихад сэтгэл дотор нэг л таатай санагдаж, өөрийн эрх үгүй (ямар уудам юм бэ? Монголын тал нутаг, яасан уужуу юм бэ? Монгол хүний сэтгэл) гэдэг Монголын нэг сайхан дуу нь сананд урган орж ирлээ.

Энэ жил их ган, хавсарга ихтэй зун болж буй нь илхэн харагдаж, өвс бэлчээр мөн л хаврын өнгөөрөө харагдаж байв. Говь нутаг гэгч ийм л хатуу ширүүн байгальтай байдаг байх гэсэн сэтгэгдлийг төрүүлэхийн хамт Монголын түүхнээ үргэлж харагдаад байдаг говийн ар, говийн өмнө гэдэг хэллэгийг бодогдуулж, өргөн их говь нутаг бол Ар, Өвөр Монголыг хооронд нь зааглах мөртлөө түүхэн дэх Умардын нүүдэлчид, дотор газрын суурьшмал иргэд хоёрын соёлын хоорондох байгалийн халхавч болж байсан юм.

Иймэрхүү гантай хуурай говь нутаг Монгол улсын өмнөд хязгаарт зүүнээс баруун тийш Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай аймгийн нутгаар үргэлжилж, Монгол улсын тэмээ өсгөн маллах гол нутаг болдог байна.

Энэ бүхнийг эрэгцүүлэн сэтгэсээр өдрийн дөрвөн цаг гаруй болоход Монгол улсын 275 дугаар номерын галт тэргэнд сууж, Монгол улсын нийслэл Улаанбаатар хот буюу түүхэн дэх Их хүрээг чиглэн хөдлөв. Галт тэрэгний цонхоор гадагш харвал энэ жилийн ганд гансарган говь нутаг их хүнд ноцтой болсон гэдэг нь туйлын ил тод харагдахын хамт төмөр замын хажуу дахь эзэн үгүй хаягдсан Оросын цэргийн баазууд (цэргийн ангийн сууж байсан газар) хаяа нэг харагдах нь дарийн үнэр ханхуулсан "хүйтэн дайн"-ы үеийг санагдуулж байлаа.

Ингэж явсаар байгаад дараа өдрийн үдэд Улаанбаатар хотын өртөөнд хүрч ирээд буухад бид бүхнийг тосохоор ирсэн Монгол улсын Чингис хааны нэрэмжит Их Засаг их сургуулийн багш Д.Чулуунбилэг болон Номингэрэлтэй уулзаж, тэднээр газарчилуулан Их Засаг их сургуульд дээр ирээд байрлах газартаа буудаллав.

Тэгээд үдээс хойш нь бид Монголын Үндэсний түүхийн музей, Сүхбаатарын талбай, Зайсан толгой зэрэг газруудаар тойрон аялаж, Улаанбаатар хоттой танилцлаа.

8-р сарын 12-ны өдөр,энэ өдөр бол бидний Улаанбаатарт ирсний дараах хоёр дахь өдөр байлаа. Бид өглөөний хоолоо идсэний дараа аян замдаа гарч,Чингис хааны өлгий нутаг болох Хэрлэнгийн хөдөө арлыг чиглэн хөдлөв. Зам зуурт дайрах Багануур зэрэг газрыг дайрч гараад тэндээс хээр талын шороон замаар давхиулж эхлэв.

Зам байдаг болохоор хүн явдаг биш,харин хүн явдаг болохоор зам гардаг гэгчийг одоо л ухаарч танилаа. Манай жолооч Бямбаа гуай бол олон жил машин барьсан хашир эр байв. Жолооч олон салаа замын дундуур эргэлзэлгүй ямарч харш саададторолгүй давхисаар үдээс хойш таван цагийн үеэр бидний зорьж ирсэн газар болох Хэрлэний хөдөө арал дахь Их Засаг их сургуулийн Хүннү Хөдөө арал жуулчны баазад хүрч ирлээ. Тэнд Их Засаг их сургуулийн захирал, доктор, профессор Н.Ням-Осор багш халуун дулаан угтан авч, бид буудлах орон байраа олж тухтай буудаллав.

Шөнө болоход орон дээрээ гаргаад таатайхан хэвтэж,Монгол гэрийн тооноор од мичид анивчин гялалзаж,голио царцааны жиргих дуу,үхэр малын мөөрөн майлалдах дуу сонсогдох нь Монгол нутгийн амар тайван амьдралын сэтгэгдлийг санагдуулж байлаа. 800 жилийн өмнөх агуу хүн Чингис хаан түүний өрлөг баатруудч эндмөн ингээд л амгалан тайван сайхан нутаглаж байсан байгаа даа! "Монголын нууц товчоон"-ыг энд ямар хүн яаж бичсэн бол? гэх зэргийн элдвийн хачин сонин бодол яахын арга үгүй төрж,толгойд минь эргэлдэж байсаар удалгүй унтаж, эүүдний ертөнцдөө орсон боловч Чингис хааны морьт баатруудын сэлмээ далайж, хашгиралдан давхилдах, сүр жавхлант байдал бүрэг бараг зүүдэнд минь орсоор байлаа.

8.22-ны өдөр, өнөөдөр нарийн бороо шивэрсэн сайхан өдөр болов. Үдээс өмнөхөн Н.Ням-Осор багш бидэнд Хэрлэнгийн хөдөө арлын соёл, түүхийн байдлыг танилцуулж өгснөөр Хөдөө арлын тухай анхны ойлголттой болж чадсан юм. Хэрлэнгийн хөдөө арал бол Их Монгол улсын тоонот нутаг болохоор барахгүй Чингис хааны залуу цаг үедээ амьдарч байсан нутаг ус юм. Мөн Их Монгол улсын бүхий л хаадын төрж өндийсөн нутаг болохоор барахгүй Өгэдэй,Гүег хоёр их хаан, хаан сууриндаа суусан газар юм.

Газар зүйн байдлаас үзвэл Хэрлэнгийн хөдөө арал нь газар доор элбэг дэлбэг нүүрсний ордтой мөртлөө чулуун тос (газрын тос)-ны нөөцтэй байна. Тарваганы нүхнээс хар нүүрсний хэмхэдэг (үүрмэг) гарч ирдэг байна. Чингис хаан болон Өгэдэй, Гүег хаан нар бүгд Хөдөө арлын Аураг хотод байсан болохоор Чингис хаан болон түүний залгамжлагчдын аливаа цэрэг дайны үйл ажиллагаа нь цөм эндээс эхэлж мөн эндээ буцаж ирснээр төгсдөг байжээ. Тухайлбал: Чингис хаан эндээс Хорезмыг дайлж, Тангудад морилсноор барахгүй Алтан улсыг дайлах дайныг ч эхлүүлж байжээ. Монгол үндэстний түүхэн дэх хамийн алдартай түүх,утга зохиолын тулгуур бичиг болох "Монголын нууц товчоон" мөн Хэрлэнгийн хөдөө аралд бичигдэж дуусжээ. Үүний тухай "Монголын нууц товчоон"-ы 282-р зүйлд "хулгана жил (1240 он)-ын хуран сар (7 дугаар сар)-д Хэрлэний хөдөө арал Долоон болдог, Шилхэнцэг хоёрын завсар хааны орд бууж байхад бичиж дуусгав.[1] хэмээн тэмдэглэсэн байдаг. Иймээс Монгол улсын засгийн газраас энэхүү түүхт үйл явдлыг сүртэй тэмдэглэхийн тулд "Монголын нууц товчоон" бичигдсэний 750 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үеэр Хөдөө аралд том чулуун хөшөө босгож,мөнхийн дурсгал болгосон байна.

Хэрлэнгийн хөдөө арлын газар зүйн байрлалыг аваад үзвэл,баруун талдаа Баян хан уул, хойд талаараа Жаргалант хан, Дэлгэр хан уул, зүүн талаараа Өндөр хан уултай, зүүн талаараа Сэнгүр горхи, өмнө талаараа Хэрлэн мөрнөөр хүрээлүүлж, яг л хоёр их голын арал мэт харагддаг болохоор Хөдөө арал гэж нэрлэсэн гэнэ.

Өмнөд талын Хэрлэн Тоонот уул бол Чингис хааны амьдарч байсан шүтлэгтэй уул юм. Мөн Чингис хааныг оршуулсан газар мөн гэж олонхи судлаачид үздэг. Чингис хааны онгон бол Хэрлэн Тоонот уулын өмнө энгэрт буй гэдэг үзэл монголчуудын дотор оршиж байдгаар барахгүй Хятадын жуулчдын тэмдэглэлд ч иймэрхүү тэмдэглэлүүд байдаг.

Үүний хамт Хэрлэн Тоонот уул бол Чин улсын Энх-Амгалан хаан ба Занабазарын уулсан газар юм. Ойрадын Галдан бошгот хаан Халхад дайран орж ирсэн үеэр Занабазар Их хүрээнээс

1 *"Монголын нууц товчоон". Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1993. 496-р тал*

зугтан Хэрлэн Тоонот ууланд нуугдаж байгаад Галдан бошготхаантай байлдахаар ирсэн Чин улсын Энх-Амгалан хаантай уулзаж, Манжид дагаар орох тухай хэлэлцээрийг хийснээр Энх-Амгалан хаан эндээс буцаж Бээжин хотын зүг морджээ.

Энэхүү түүхт хэрэг явдлын тухай баримт бол Хэрлэн Тоонот ууланд босгож байсан чулуун хөшөө юм. Энэхүү чулуун хөшөөн нь эдүгээ Монгол улсын Үндэсний түүхийн музейд хадгалагдаж байдаг. Хэрлэн Тоонот уулнаас гадна эндэхийн маш олон газрын нэр нь "Монголын нууц товчоон"-д тэмдэглэгдсэн байдаг. Жишээлбэл: Сэнгүр горхи, Хурхунаг Жубурын хөндий, Харилт нуур, Аураг хот, Аварга тосон нуур, Долоон болдог, Аураг гол зэрэг газрын нэрс цөм "Монгол нууц товчоон"-д тэмдэглэгдсэн байдаг.

Онцгойлон дурдууштай нэг газар бол Аураг хот юм. Аураг хот бол Чингис хаан, хаан сууринд сууж, Европ, Азийг дамнасан их эзэнт улсыг жолоодон захирч байсан орд гэр юм. Үүний тухай "Монголын нууц товчоон"-д Чингис хаан Татарын Мэгүжин сүүлтийг алж, Алтан улсын Вангин Чинсанаар Жаутхури цолоор шагнуулсаны дараа "Чингис хааны Аураг гэж (ар гэр) Харилт нууранд байсан бүлгээ." Энэхүү Харилт нуур нь Их Засаг их сургуулийн жуулчны баазаас баруун өмнө зүг Аураг хотын баруун зүгт тийм хол үгүй газарт байрлаж байдаг болохоор бид бүгд тэндочиж, энэхүү нуурын өнгө үзэмжийг бахдан сонирхсон нь нэг сайхан явдал байлаа.

Үдээс хойш нь үүл арилж, бороо зогсоод долоон өнгийн солонго татсан онцгой сайхан уур амьсгалтай өдөр боллоо. Бид бүхэн энэхүү цэвэр сайхан уур амьсгалыг амьсгалан аян замдаа гарч, Хөдөө арлын түүх, соёлтой танилцахаар мордов. Тэгээд урьд хожид "Монголын нууц товчоон"-ы бичигдсэн 750 жилийн ойд зориулан босгосон чулуун хөшөө, Аурагийн гол, Чингисийн рашаан, Аураг хотын туурь, Харилт нуур, Долоон болдог зэрэг газруудаар сурвалжлан тойрон аялав.

Аурагийн гол, Аураг хотын туурийн урдуур мушгиралдан урсч, Чингис хаан болон түүний гэр бүл, жанжин түшмэдийн ус ундаа болж байснаар барахгүй Аурагийн голын хажуу дахь Чингисийн рашаан бол Чингис хааны ууж байсан онцгой амттай булгийн ус юм. Тэр рашаан ходоод гэдэсний шархлааг туйлын сайн эмчлэх үйлдэлтэй гэж бидний хөтлөгч багш Д.Чулуунбилэг ярьсан учраас бид бүгдээрээ цөм энэхүү Чингисийн рашаанаас ходоод гэдэсээ рашаанаар ангаасан юм.

Энд ирсэн монголчууд бүгд Чингисийн рашаанаас амталж байснаар барахгүй лонх савандаа савлан авч, гэр бүл төрөл садандаа уулгахаар авч байв. Аураг хотын туурьд ил тод харагдах хот хэрмийн туурь байгаагүй боловч элсэнд дарагдсан гэр, барилгын туурь тодхон харагдаж байлаа.

Д.Чулуунбилэг багшийн бидэнд танилцуулснаар Монгол улсын археолгичид энд олон удаагийн малтлага хийж сүм хийдийн ором, байшингийн туурийг олж илрүүлснээр барахгүй хожим үргэлжилсэн малтлага хийхээр төлөвлөж, Аураг хотын туурийг бүхэлд нь малтаж, эрт үеийн байдал төрхийг илрүүлэн гаргах төлөвлөгөөтэй байгаа ажээ.

Харилт нуур бол Аураг хотын туурнаас нилээд баруун өмнө зүгт байрлах жижиг хулс зэгэстэй нуур юм. Нууранд галуу, нугас ганганалдаж, адуу малын ус ундаа болсон сайхан ч үзэмжтэй нуур байлаа. Нуурын хөвөөнөө зундаа дөрвөн зүгийг бараалах, Монгол нутгийн үзэгслэнт байдал яахын арга үгүй хараанаа тодорч, хөвөн үүл хөвөлзөн, адуу мал алагшаад, нуурын ус мэлтэгнэн эндээс холдолгүй суумаар бодогдож байлаа.

Гэвч бид энд саатаж их удалгүй Долоон болдогийг зүглэн хөдлөв. Долоон болдог бол Харилт нуураас баруун хойш нилээд зайтай газарт байрладаг. Долоон болдог уулаар бүрэлдсэн уулс болно.

Долоон болдогийн тухай "Монголын нууц товчоон"-д "Зүрхэн (Жүрхэн) нар Хэрлэнгийн хөдөө арлын Долоон болдог хэмээх газар байхад дайран орвоос Сэчэ бэхи, Тайчухоёр цөөн хүмүүсийг авч дутаав. Хойноос нь нэхэж Далдам хэмээх газар гүйцэж Сэчэ бэхи, Тайчу хоёрыг барив."[2] хэмээн тэмдэглэсэн байдаг билээ. Н.Нам-Осор багшийн бидэндярьснаар бол Долоон болдог ууланд Хайрхан уул, Хоёр улаан, Бор овоо, Сагил толгой гэх мэтийн уулс байх бөгөөд Долоон болдогийн баруун талд нь Сүүж хад гэж Чингис хааны хүйг дарсан чулуу байдаг. Үүнээс баруун тийш Шорвог нуур гэж давс гардаг нуур байдаг ажээ. Үүний хамт Долоон болдогийн Хана дугуй ууланд маш арвин булш байдгийг судлаад Түрэгийн үеийн булш гэж үздэг боловч зарим судлаачид монголчуудын булш мөн гэж үздэг байна. Өнөөдрийн аялал маань эндхүрээд түр амс хийлээ. Бид таших нарны улбар туяаны доор Долоон болдог уулсын бараг бараалсаар Их Засаг их сургуулийн жуулчны баазаа буцан ирж бие амраан хоноглов.

8.23-ны өдөр, энэ өдөр нар тунарсан сайхан өдөр боллоо. Өнөөдрийг уулын болон

2 *"Монголын нууц товчоон". Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1993. 278-р тал*

хээрийн аяллын өдрөөр тогтжээ. Иймээс бид жуулчны баазын дарга Т.Шагдаржав эгч болон Д.Чулуунбилэг багшийн хамтаар Дэлгэр хан уулын Хайлантын аманд хүрч ирэхэд хээрийн амьдралын ёсоор тулга тулан цай чанаж, хорхог хийж идээд Хайлантын амны хоёр талын өндөр уулаад гарч эндхийн гоё сайхан байгалийн үзэмжийг ханатлаа сонирхлоо.

Ардын уламжлалт яриагаар бол энд Өгэдэй хааны булш байдаг гэнэ. Гэвч одоог болтол илрүүлээгүй байгаа ажээ. Энэ бол манай Монгол соёлын нэг товойсон онцлог гэж үзвэл таарах юм. Хятадын хаадын булш гэж нэг их юм байдаг мөртлөө олонх нь тоногдож малтагдаад эдүгээ болоходүй түмэн хүмүүсийн тойрон жуулчлах газар болж хувирсан байдаг. Гэвч манай Монголын хаадын онгон булшыг нэгийг малтаагүй байгаа нь гайхалтай юм.

Хайлантын амны уулын орой дээр гараад харахад Хөдөө арлын үзэмж байдал тодхон харагдаж, алагшин бэлчсэн адуу мал, бөмбөгөр цагаан Монгол гэрүүд,мэлтэлзэн туналзах Аварага тосон нуур,сүндэрлэн сүгнийх Хэрлэн Тоонот уул, Дэлгэрхан сумын байгаа газар харааны үзүүрт тодорч, Монгол нутаг гэгч ийм л амгалан тайван, монголчуудгэгч ийм л тэнгэрлэг заяатай байж дээ гэсэн сэтгэгдлийг төрүүлж байлаа.

Буцах зам зуурtаа бид Хайлантын ам, Дэлгэрхан уулын энгэрээр маш арвин чулуугаар хашсан булшнууд байхыг олж харснаар барахгүй олон арван тарваганууд нүхнийхээ аманд зогсоод энэ олон танил бус харь улсын хүмүүсийг ажин сонирхож байсныг харав. Тэгээд зам зууpаа хэдэн Монгол айлаар орж айраг ууж, эндэхийн малчдын аж амьдралын байдлын тухай өдий төдий ойлголттой боллоо.

Эндэхийн малчидАрхангай,Булган аймгийн малчдыг бодвол айраг их хийдэггүй болохоор хэдэн айлаар орсон боловч тийм элбэг айраг гэж үгүй байлаа. Тэндэхийн нэг айл их олон морь уядаг айл байв. Тэднийх сум,аймгийн наадамд олон удаа морь уралдуулж,олон морины медалиудтай байлаа.

Ингээд манай нэг өдрийн аялал төгсөв. Их Засаг их сургуулийн жуулчны бааздаа буцан ирээд хоолоо идэж,Монгол гэртээ ороод өнөөдрийн аяллаа эрэгцүүлэн бодож үзвэл их арвин олоltиой байсан боловч хамгаас их дурсгалтай нь үдийн хоол болох хорхог хийж идсэн явдал болох шиг санагдсан билээ.

Хорхог бол Монгол улсад л байдаг нэг онцгой хоол юм. Үүнийг тусгай бэлтгэсэн битүү төмөр саван дотор мах,сонгино,давс,амтлагч зэргээ бүгдийг хийж оруулаад галын цог дээр тавьж аажуу болгодог ёстой гэнэ. Манай оюутны зарим нь түлээ мод түүж, зарим нь хорхогны ус авахаар явж, зарим нь гал түлэн хорхогоо хийж бүлтгэн нэгдлийн хүчинд түшиглэж байгаад гоё сайхан үнэр амттай хоолыг хийж идээд хүн болгоны царай тодрон сэтгэлд нь хүрч таалагдсан байдал илэрч байсан юм. Бодоод үзвэл энэ хорвоогийн явдал учир гэгч бүр л ийм байдаг байгаадаа, бүлэглэж нэгдвэл бүтэж,эс эв эвдэрвэл устаж бөхдөг жамтай байдгийг хүн болгон мэдэж байдаг боловч явдал учир бүхэн дээр цөм бүлэглэн нэгдэж чаддаггүй нь үнэхээр харамсалтай явдал юм.

8.24-ны өдөр, өнөөдөр бид эртлэн босож, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотыг чиглэн хөдөллөө. Зам зуур хүн, мал ерөөсөө харагдахгүй зээрийн сүрэг бэлчсэн хээр тал ахин дахин тааралдаж, Монголын уудам тал гэгч үнэхээр нэрэндээ таарсан уудам тал юм гэдэг сэтгэгдлийг төрүүлж байлаа. Ингэж давхиулсаар үдийн үеэр Өндөрхаан хотод ойртож ирэхэд хүн хар үймэлдэн уяатай морьд бөөн бөөнөөрөө харагдаж, аймгийн их наадам болох гэж байгаа нь тодхон харагдаж байлаа.

Бид юуны урьдаар талбайд болсон ёслолыг үзэж сонирхоод дараа нь бөх барилдах талбай ба сур харвах талбайд хүрч бөх барилдах, нум сум харвах явдлыг үзэж сонирхов. Тэгээд хоолны газар нь орж үдийн хоолоо идээд дахин морин уралдааны газарт хүрч очиход хүн, мал үймэлдэн туйлын хөгжөөн наргиантай байлаа.

Энэхүү морин уралдааны талбай нь Өндөрхаан хотын баруун өмнө тал дахь Хэрлэн мөрний хойд эрэгт байрлаж, хол ойрын уяачид, зорчигчид, арилжаа наймаа хийгчид туйлын олон байж эмх замбараагнь олоход туйлын хүндрэлтэй юм шиг санагдаж байв.

Энд ирээд бид Өндөрхаан хотыг харвал, хотын өмнүүр Хэрлэн мөрөн тунаран тогтуухан урсаж, хотын баруун талын дэнж дээр Оросын цэргийн бааз их өндөр сүрлэг тодхон харагдаж байлаа. Манай Хятад улсын дэд тэргүүлэгч байсан Ли Би юу улсаасаа урван тэрсэлж, Зөвлөлт рүү дутаагаад Монгол улсын Өндөрхаанд унаж үхжээ гэсэн тэмдэглэлийг бид олонтаа олж харсан юм.

Энд ирээд манай дэд тэргүүлэгчийн унаж үхсэн газрыг үзэхээр Өндөрхаан хотоос зүүн хойш Бэрх гэгч газарт очив. Ли Би юу-ын Өндөрхаанд унаж үхсэн шалтгааны тухай уул нь ерөөс тодорхой мэдэгдэж өнгөрсөнгүй байжээ.

Уржнан жилийн мэдээллийг үндэслэвэл, тэр бол нислэгээр дутаагаад Зөвлөлтийн хилд хүрсний дараа зориг алдарч дахин буцаж улсдаа буцах зам зууpаа Монгол улсад суугаа Зөвлөлтийн цэрэгт буудуулан Өндөрхаанд унаж үхжээ гэж мэдээлсэн явдал бол үнэн бодит байдалтай нийцсэн мэдээлэл мөн гэж би олон ном бичгээс олж харсан юм.

Эдгээр Монгол улсын газар болгонд харагдах эзэнгүй хаягдсан Оросын цэргийн баазууд нь бидэнд "хүйтэн дайн"-ы үед Зөвлөлт Орос улс, Монгол улсад үлэмж их цэрэг суулган манай улсын амар түвшинд туйлын их сүрдүүлэг болж байжээ гэдэг нь бодит баримтаар харуулж байх шиг байлаа.

Тэгээдбидморин уралдааны байдлыг тиймч сайхан сонирхож чадсангүйгээр замын холоо санаж буцах замдаа гарч Хөдөө арлын ойролцоох Аварга Тосон нуурт хүрч ирээд, нуурын усанд нь орж сэрүүцэв. Манай хөтөч Д.Чулуунбилэг багшийн хэлснээр Аварга Тосон нуурын эргэ дэх шингэн хар шавар бол олон зүйлийн эмчилгээний чанартай гэнэ. Тухайлбал: арьсны өвчин, хөл нурууны өвчинд туйлын их сайн үйлчилгээтэй гэнэ.

Ийм болохоор энд Монгол улсын газар бүрээс хүмүүс хуран цугларч нуурын хөвөөгөөр майханаа босгон буудаллаж, суугаад сар, хорь хоногоор нуурын усанд орж, хар шаврыг нь өвчин хуучтай газраа түрхэж суудаг байна. Ингээд энд хүрээд манай өнөөдрийн аялал өндөрлөв.

8.25-ны өдөр, өнөөдөр бид Хөдөө арлаас алгуур буцах замдаа Монгол улсын алдартай үзэмжит нутаг болох Тэрэлжийг зорин хөдлөв. Тэрэлж орох зам зууpаа бид бас Зуун мод, Зуун ламын агуйг тойрон сурвалжилснаар барахгүй Тэрэлжийн сонин жигтэй уул хадыг хачирхан сонирхож явсаар Тэрэлж дэх Их Засаг их сургуулийн жуулчны баазад хүрч ирээд тухлан буудаллав.

Зуун мод бол Монгол улсын Төв аймгийн нутагт байгаа Галдан бошготын хамгийн эцсийн ялагдсан газар болох юм. Тус газар нь одоо ч зуугаад модтой мөртлөө газрын гадарга нь ч энхэл донхол яг л нэг удаагийн ширүүн дайн тулалдаан болж өнгөрсөн мэт харагдаж байлаа.

Холбогдол бүхий тэмдэглэлийг үндэслэвэл, 1696 оны 5-р сарын 13-ны өдөр Галдан бошгот хаан одоогийн Улаанбаатар хотоос холгүй байгаа Тэрэлжийн Зуун модхэмээх газар хүрч иртэл, Чин улсын Галдан бошгот хааны дайлаар ирсэн Баруун замын цэрэг нэгэнтЗуун модондхүрч ирээдашигтай байрыг амжин эзэлж, Галдан бошгот хааныг ирэхийг хүлээж байжээ. Чин улсын Баруун замын цэргийн жанжин Баянгу, Галдан бошгот хааны их цэрэг Тэрэлжидхүрч ирсэн мэдээг олж авмагц нэг салааг өдөөх цэрэг болгон томилон явуулж, Галдан бошгот хааны цэрэгтэй нэг талаар байлдан нөгөө талаар ухарч явсаар Зуун модонд хүрч ирэхэд Чин улсын отсон цэргүүд цохилт өгч, хоёр цаг гаруйгийн хурц ширүүн тулалдаан болж, гурван мянга гаруй хүн нь олзлогдож, таван мянга гаруй хүнээ алдаад дөнгөн данган ухран гартал ихэнх жанжин баатрууд нь амь үрэгдсэн болохоор үлдсэн хүмүүс нь гурван хэсэг болж хагацсан байна.

Нэг хэсэг нь Чин улсын цэрэгт буун өгч, үлдсэн хэсэг нь Далай лам ба Цэвээнравданг дагахаар баруун тийш дутаажээ. Иймэрхүү байдлын доор Галдан бошготхаан арга буюу баруун аяг ухран, Тамирын Тайхар чулууны хавьд хүрч ирээд үлдэж хоцорсон хүмүүсээ бүртгэж үзэхэд таван мянга гаруйхан хүн үлдсэн байв. Иймээс Галдан бошгот хаан үргэлжлүүлэн баруун тийш Хүрэн бэлчир, Сэгс дүүрэн зэрэг газруудыг дамжин 1697 оны эхээр Ац амттай гэдэг газарт хүрч ирээд 1697 оны 3-р сарын 13-ны өдөр хор идэж амиа хорлож үхсэн байна.

Үдийн хойно нь бид голдуу Их Засаг их сургуулийн жуулчны бааз дахь Чингис хааны есөн цагаан өргөөг тойрон үзэж сонирхлоо. Эдгээр есөн цагаан өргөөнд Чингис хаан түүний хатан болон залгамжлагчдын хөрөг зураг мөн Монголчуудын эдлэл хэрэгсэл, судалгааны бүтээл зэрэг зүйлсийг эгнүүлэн тахиж байв.

8.26-ны өдөр, нарийн бороо зүсэрсэн бүрхэг бороотой өдөр боллоо. Энэ өдөр бид үргэлжлүүлэн Тэрэлжийн сонин сайхан байгалийг тойрон сонирхон явжээ. Тэрэлжийн хойд мухарт Мэлхий хад байх бөгөөд түүний хойд талын уулын хяр дээр нэг Христосын шашны жижигхэн мөргөлийн сүм байв. Зүүн, баруун талын уул хадны үзэмж байдал онцгой сайхан байснаар барахгүй хад чулууны дүрс байдал нь олон зүйлийн хэлбэр янзтай байж зорчигч олны анхаарал сонирхлыг ихэд татаж байлаа. Бид эдгээр бүхнийг амтархан сонирхож яваад буцах замдаа явганаар уулыг даван гарч бартаатай замаар буудал зүг явах зууpаа байгалийн болор чулуу эрж их л хөл үймээн болцгоов.

Энд байгалийн болор чулуу арвин байдаг бөгөөд болор чулууны уурхай ч байдаг гэж манай хөтөч багш Д.Чулуунбилэг хэлснээс бид бүгдээрээ болор чулуу эрж хайн зарим нь нилээд болор чулуу олсон байхад зарим нь юу ч үгүй гар

хоосноор буудалдаа буцаж ирсэн юм. Ингээдманай өнөөдрийн аялал төгсөж, Тэрэлж дэх тойрон аялал ч энд хүрээд төгсөв.

8.27-ны өдөр, борооны дараах Тэрэлжийн уул ус хачин сайхан байж, үүл, уул залгалдан манан буланы дундах уул хаднуул нэн сүрлэг эрхэмсэг болж харагдаад явах гэж байгаа биднийгээ үдэн мордуулж байгаа юм шиг л байлаа. Бид бүхэн энэ сайхан байгалиас салж ядан аялаад, Улаанбаатар хотын зүг мордож, Их Засаг их сургуулийн төв байранд ирлээ.

Үдийн хойно цагийг ашиглаж байгаад бид Гандан хийд, Улсын их дэлгүүр, Солонгос дэлгүүр болон Нарантуул захаар орж явах бэлтгэл ажлаа түргэн хийж бэлэг дурсгалын эд зэрэг элдвийн зүйлийг цуглуулж авсан юм.

8.28-ны өдөр, энэ өдөр бол биднийг Улаанбаатар хот дахь хамгийн сүүлийн өдөр байлаа. Үдийн өмнөх цагийг ашиглан бүгдээрээ буцах бэлтгэлээ хийж дуусгаад үдийн хоолоо идэж дуусаад, Улаанбаатар хотын галт тэрэгний өртөөнд хүрч ирээд Монгол улсын 274 дүгээр номерын галт тэргэнд сууж, Монгол улсын өмнөд хязгаарын хилийн боомт болох Замын-Үүдийг чиглэн хөдлөв.

8.29-ны өдөр, нэг үдшийн аяныг өнгөрүүлээд, энэ өдрийн нар мандахын үеэр Замын-Үүдэд хүрч ирээд Галт тэрэгнээс буухтай зэрэгцэн биднийг тосохоор ирсэн Насан жолоочтой уулзаж түүний машинд суугаад, тиймч удалгүй Эрээн хотод хүрч ирэв. Тэгээд нэг өдрийн чөлөөтэй ажиллагаа болж, Эрээн хотын зах зээл, худалдааны газраар тойрон өөр өөрийн сонирхсон зүйлсээ хөөцөлдөж явсан юм.

8.30-ны өдөр, энэ өдөр бид Эрээн хотоос гарч Хөх хотдоо буцаж ирээд манай энэ удаагийн Монгол улсад хийсэн хээрийн дадлага амжилттай төгслөө. Эрэгцүүлэн бодож үзвэл, энэ удаагийн дадлага маань санасанаас илүү амжилттай болж, ганзага дүүрэн буцаж ирсэн байна. Энэ удаагийн аялалд маань Их Засаг их сургуулийн Н.Нямосор захиарал, ДЧулуунбилэг багш болон Бямбаа жолооч зэрэг хүмүүс тусламж дэмжлэг үзүүлсэн ба бид бүхний нэгдэж сэтгэл нийлснээс болж маш сайхан дадлалга болсон гэж бодож байна. Үүний хамт дээд сургуулийнхаа удирдлага нарын дэмжлэг ба зам зуурт тааралдсан найз нөхдийн дэмжлэг эдгээр хүмүүст баярлан, талархаж байхын хамт тэдгээр биднийг дэмжиж, хайр халамжаа хүртээж явсан хүмүүст аз жаргал сайн сайхныг хүсээд энэ удаагийн аяллын тэмдэглэлээ төгсгөл болгов.

ЖАМСРАНГИЙН ЦЭВЭЭН-МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮНДЭСЛЭГЧДИЙН НЭГ БОЛОХ НЬ

Ж.Цэцэгмаа
Их Засаг ОУИС-ийн I проректор, доктор (Sc.D), профессор

Оросын нэрт эрдэмтэн А.Д.Рудневын хэлсэнчлэн "Төгөлдөр их эрдэмтэй, Монголын төр, нийгмийн соёлд дааны хайртай"[1] хүн бол Монголын нэрт соён гийгүүлэгч, нэрт эрдэмтэн Жамсрангийн Цэвээн байсан юм. Петробургийн их сургуульд суралцаж байсан цаг үеэс Жамсрангийн Цэвээний соён гэгээрүүлэх болон эрдэм судалгааны нөр их ажил эхэлсэн бөгөөд Их сургуульдсуралцаж байхдаа монгол судлаач А.Д.Руднев, В.Л.Котвич, академич С.Ф.Ольденбург, сибирь судлаач эрдэмтэн Д.А.Клеменц зэрэг томоохон эрдэмтэдтэй багш шавийн харилцаа тогтоон хамтран ажиллаж байсан нь монгол судлалыг Орос болон Монгол оронд буй болгож, цэцэглүүлэн хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулсан юм.

Америкийн нэрт монголч эрдэмтэн Н.Н.Поппе бичихдээ "Доктор Жамсрангийн Цэвээн бол манай цаг үеийн хамгийн гарамгай монголч эрдэмтдийн нэг юм" хэмээн бичсэн байдаг. Өнөөдөр Жамсрангийн Цэвээний бүтээлүүдмонгол судлалд томоохон байр суурь эзэлж, түүний олж цуглуулсан, бичиж туурвисан бүтээлүүд судалгаа шинжилгээний арвин их эх сурвалж болсоор байна.

Нэрт эрдэмтэн Жамсрангийн Цэвээний ухамсарт амьдрал XX зууны эхний хагаст болсон хувьсгалт тэмцэл, үймээн самуун, нугалаа, завхарлын хүнд үед өнгөрсөн юм.

Тэрвээр үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ид өрнөж байсан 1911 онд Нийслэл Хүрээн дэх Оросын элчингийн зөвлөхөөр ирсэн хэдий ч Богдын засгийн газрын боловсролын асуудал хариуцсан зөвлөхөөр хавсран ажиллаж эхэлсэн нь билэг оюунаа дайчилж монголчуудынхаа төлөө зүтгэх өргөн их боломжийг түүнд олгосон юм.

1912 оны 3 дугаар сард Жамсрангийн Цэвээн Монгол оронд боловсролын шинэтгэл хийх саналаа Монголын засгийн газарт тавьсан байдаг. Түүндээ аймаг болгонд бага сургууль нээж, улмаар дацангуудын зэрэгцээ дунд сургуулиудыг байгуулан хүн ардын дотор эрдэм мэдлэгийг өрнүүлэн дэлгэрүүлж иргэний боловсрол олгуулах зорилтыг тодорхойлсон байна.

Жамсрангийн Цэвээн 1912 оны тэрхүү бичигт "Орос, Франц, Англи мэтийн орнуудын жишгээр одоо цагийн бага, дунд, дээд сургуулиудыг байгуулж, тэндэх хэл, тоо бодлого, газар зүй, бодисын зүй, хувилахуйн ухаан, гадаад хийгээд өөрийн орны түүх, бусад шинжлэхүй ухааныг зааж бас хажуугаар нь цэргийн хэрэг, аж үйлдвэр, худалдаа, эдийн засаг, газар тариалан, мал аж ахуй, анагаах ухаан гэх мэт салбарын мэргэжилтэн бэлтгэх төрөлжсөн сургуулиудыг байгуулан, тэдгээрт англи, орос, хятад, манж хэл бичгийг зааж сургаж, бүх хичээлийг монгол хэл дээр явуулах нь зүйтэй..."[2] гэжээ.

Жамсрангийн Цэвээн бага сургуулийн 18 зүйл бүхий, дунд сургуулийн 5 бүлэг, 29 зүйл бүхий, дүрмийг тус тусад нь боловсруулаад Богд хаант улсын гадаад яаманд толилуулсан байна.

Жамсрангийн Цэвээний санаачилгаар, чин ван Ханддоржийн халуун дэмжлэгтэйгээр 1912 оны 3 дугаар сарын 24-нд Өргөө хотноо анхны иргэний бага сургууль 47 сурагчтай нээгдсэн байна.

Өргөө хийгээд өөр гурван аймагт 1912 оны зун сургууль байгуулах тухай засгийн газрын тогтоол гарч гадаад хэргийн яаманд гэгээрлийн хэлтэс байгуулахаар заагаад "яамны дэргэд бага сургууль байгуулахыг Петербургийн их сургуулийн монгол хэлний багш Жамсрангийн Цэвээн үүсгэн санаачлав"[3] гэжээ. Үүнээс үзэхэд Жамсрангийн Цэвээн нь шинэ цагийн сургуулийг монголд анх санаачилж, шууд гардан байгуулсан хүн гэдэг нь ойлгогдож байна.

Монгол сургуулиудад багшлуулахаар Буриадаас Н.Т.Данчинов, Г.Вамлилов, Д.А.Абашеев нарыг Жамсрангийн Цэвээн урьж ирүүлсэн ба 1913 онд Монголын хөвгүүд, охидыг Эрхүүгийн сургуульд суралцуулахаар дагуулан явж, дунд сургуульд оруулж, байр сууцаар хангах зэрэг ажлыг гардан зохион байгуулж байсан тэр цагаас хойш Жамсрангийн Цэвээний гаргасан эрдмийн

1 *Ж.Цэцэгмаа. Жамсрангийн Цэвээн Монголын боловсролын байгууллагыг үндэслэгч. Өдрийн сонин №293. УБ., 2001*

2 *Б.Ренчин. Монгол бичгийн хэл зүй. I дэвтэр. УБ., 1964. х.40*

3 *Б.Цыбиков. Ш. Чимитдоржиев. "Цыбен Жамцарано". Улан-Удэ., 1997. х.11*

гэрэлтзамаар олон үеийн хөвгүүд,охид ЗХУ-дэрдэм мэдлэг эзэмшихээр суралцаж эхэлсэн түүхтэй.

Ардын сургуулийг байгуулж, бэхжүүлэх, боловсронгуй болгох, хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх гэсэн Жамсрангийн Цэвээний хичээл зүтгэлийг Богд хаант монгол улсын засгийн газар өндрөөр үнэлж байжээ. Богд хаант улсын гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас 1912 оны 6 дугаар сард гаргасан бичигтээ "Орос үсгийг сургагч Жамсранов сургуулийн гэрт ирснээс нааш сургуулийн хөвгүүдэд бичиг үсэг зааж сургахад өчүүхэн төдий ч залхууран хойргошихгүй өдөр тутам үнэн сэтгэлээр шамдан сургаж буй нь нэн сайшаалтай. Манай улс төрийн хэрэгт бага хөвгүүдийг сурган хүмүүжүүлж сонгон хэрэглэх хэрэгт магадтус болно"[4] гэж тэмдэглээдБогд хааны зарлиг" ёсоор дээд зэрэг, жинсээр шагнасан тамга дарсан тэмдэгт бичгийг Жамсрановт гардуулсан нь улсын нийтийн номын сангийн Жамсрангийн Цэвээний хавтаст хадгалагдаж байна.

Мөн улсад туслагч гүн цол, "Эрдэнийн очир" одонгоор шагнаж байсан бөгөөд Богд хан уулын Эрдэнэ уулын хошууны Эрдэнэ сумын нутагт газар заан олгож байжээ.

Гамин, бароны харгислалын үед иргэний сургуулиуд хаагдаж багш нарын зарим харгислалд өртөгдөн, зарим нь ийш тийшээ дүрвэн нуугдаж байсан хүнд хэцүү үед ч Жамсрангийн Цэвээн ардын сургуулийг шинэчлэн байгуулах, шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэх гэсэн ариун зорилгоосоо огтхон ч ухарч байгаагүй юм.

Жамсрангийн Цэвээн 1921 оны ардын хувьсгалын ялалтын дараа Ардыг гэгээрүүлэх яамны зөвлөхийн үүргийг гүйцэтгэж байсан нь нэгэнт байгуулагдсан 93 бага сургууль дээр нэмж дунд сургууль байгуулах ажилд гар бие оролцож, бага, дунд сургуулийн дүрмийг боловсруулсан байна.[5]

Ардын засгийн 1921 оны 7 дугаар сарын 31-ний хурлаар Жамсрангийн Цэвээнийг Дотоод яамны дэд сайдын үүрэгт ажлаас чөлөөлөөд эрдэм боловсролын ажил, сургуулийн хэргийг эрхлүүлэн түмэн олны оюун ухааныг нээгдүүлэхэд чухал хэрэгтэй ном судар орчуулах, зохиох, цуглуулах даалгаврыг түүнд өгч байжээ.

Жамсрангийн Цэвээн багшийн сургууль байгуулахад гар бие оролцож, цорын ганц дээд мэргэжилтэй монгол хүн байсныхаа хувьд өөрийн биеэр багшилж, сурах бичиг зохион, гарын авлага боловсруулахад биечлэн тусалж байлаа. Жамсрангийн Цэвээн дунд сургуулийн сурах бичгийг орчуулах, боловсруулах, хэвлүүлэх зэрэг ажлуудыг голчлон санаачилж байв. Түүний зохиосон "Оюун түлхүүр" хэмээх сурах бичиг /1921 онд/ олон үеийн уншигчдын хийгээд монгол хэл соёл судлаачдын ширээний ном болсон юм. Жамсрангийн Цэвээн 1911-12 оны үед 100 орчим ном буюу 8 төрлийн ном хэвлэхээр төлөвлөж, идэвхийлэн ажилласны үр дүнд 1930 оны эхэн хүртэл төлөвлөгдсөн номын 50 орчим нь хэвлэгдэн гарчээ.[6]

Нэрт эрдэмтэн Жамсрангийн Цэвээн тэртээ 1921 онд Ардын Засгийн үйл хэрэгт идэвх зүтгэлтэй, ихээхэн санаачлагатай оролцож олон ажлыг санаачлан хэрэгжүүлж, байсны дотор өнөөгийн шинжлэх ухааны академийн үндэс суурь болсон "Судар бичгийн хүрээлэн" үүсгэн байгуулсан явдал юм.

Жамсрангийн Цэвээний эрдэм судалгааны ажлаа эхэлсэн цаг үеэсээ хүсч мөрөөдсөн эрхэм зүйл бол Монгол оронд орчин цагийн Шинжлэх Ухааны үндэс суурийг тавьж цэцэглүүлэн хөгжүүлэх явдал байлаа. Түүхэнд тэмдэглэснээр 1921 оны 11дүгээр сарын 9 ны өдөр засгийн газрын 22-р хурлаас "Эрдэмт түшмэл Жамсрановын зааварлан зөвлөснөөр судар бичгийн хүрээлэн байгуулсан ба түүний хэлж зөвлөснөөр анхны даргаар Онходын Жамъянг ажиллуулахаар болж, эрдэмтэн нарийн бичгийн даргаар Жамсрангийн Цэвээнийг томилсон"[7] хэмээжээ. Жамсрангийн Цэвээний нэгэн бичигт дурдсаныг үзвээс "хүн төрөлхтөний явдлын магнай суурь нь эрдэм, соёл бөгөөд шинжлэх ухааныг эс эрхэлвээс улс урагш давшихгүй, бас улсад эрдэмтэн үгүй бол шинжлэх ухаандмэрэгжигсэдгарахгүй... Үүний тулдшинжлэх ухааны газар нь ганц нэг хүний тусын тулд оршин байх бус, энэ газар болбоос харъяат улсаар хязгаарлагдахаар үл барам бүх дэлхий дахинаа тус бүхий ба хүн төрөлхтөний боловсролд хувь нэмэр болох болой"[8] гэжээ.

Мөн Жамсрангийн Цэвээн Монгол Улсын эрдэм шинжилгээний ажлын ач холбогдлыг өгүүлэхдээ "Шинжлэх Ухаан цэцэглэн хөгжиж байгаа газар л амьдралын ая тохь бий болж, ард түмэн соёлын бүх үр шимийг хүртдэг. Шинжлэх ухаангүй газар хүн байгалийн хүчний боол байдаг. Шинжлэх ухаан цэцэглэн мандсан газар ард түмэн

4 *Ж.Цэвээний хавтас. Улсын төв номын сан. Дугааргүй*

5 *Ж.Цэцэгмаа. Жамсрангийн Цэвээн Монголын боловсролын байгууллагыг цэцэглэгч. Өдрийн сонин №293. УБ., 2001*

6 *МАХН-ын тууҳэнд холбогдох баримт бичиг. I боть УБ., 1966. х.32*

7 *Ж.Цэвээний хавтас. Улсын төв номын сан. Дугааргүй*

8 *Ж.Цэвээний. Түүвэр зохиолууд. УБ., 1997. х.52*

нь соёлжин гэгээрсэн, тохилог амьдралтай байдаг, шинжлэх ухаангүй газрын ард түмэн харанхуй, соёлгүй, амьдрал нь хүнд "байдаг"[9] хэмээн бичжээ.

Шинжлэхүй ухааныг үүсгэн хөгжүүлэх ажил нь олон түмэн огтоловсрол мэдлэггүй байсан цаг үед хэрэгжиж байсан учраас Судар бичгийн хүрээлэнгийн үйл ажиллагаа соён гэгээрүүлэх үйлстэй салшгүй холбоотой байв.

Жамсрангийн Цэвээн судар бичгийн хүрээлэнд 1921-1932 онд эрдэмтэн нарийн бичгийн дарга, жинхэнэ гишүүнээр ажиллаж байхдаа тус хүрээлэнг хэвлэлтэй болгох, улсын номын сан, архив, орон нутгийг судлах музей байгуулах, экспедицийн судалгаа явуулах, гадаадын шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэдтэй холбоо харилцаа тогтоох, хамтран ажиллах зэрэг олон ажлуудыг хийж амжуулж байв. Мөн түүх, монгол хэл, утга зохиолын танхим, цаг уурын станц байгуулсан бөгөөд тэр бүгд нь Монголын шинжлэх ухааны академийн нахиа мөчир болж өгсөн юм.

Улаан-Удийн Буриад-Монголын шинжлэх ухааны хүрээлэнтэй харилцаа холбоо тогтоох, Монголын Шинжлэх Ухааныг хөгжүүлэхтэй холбоотой зохион байгуулах бүхий л асуудал Жамсрангийн Цэвээн дээр төвлөрч байв.

Монголын Судар бичгийн хүрээлэн Буриад Монголын Судар бичгийн хүрээлэнгийн хоорондбат бэх хэлхээ холбоо тогтоож, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах, эртний судлал, хэл шинжлэлийн экспедицид оролцох зорилгоор Монголын Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн, Буриад Монголын Судар бичгийн хүрээлэнгийн дарга, профессор Б.Барадин БНМАУ-д хэд хэдэн удаа хүрэлцэн ирж байжээ. Мөн 1927 онд Буриад Монголын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга профессор Цэвэгийн Гомбожав Улаанбаатарт айлчилж, Буриадын судлаач Г.Р.Ринчин Монголын Судар бичгийн хүрээлэнд удаан хугацаагаар дадлагажин ажиллаж байв. Буриад Монголын Судар бичгийн хүрээлэнд монголын эрдэмтэн С.Буяннэмэх, Санжмятав нар ажиллаж байлаа. Ийнхүү Буриад Монголын Судар бичгийн хүрээлэнтэй нягт хамтын ажиллагааг тогтоосон байна.

1925 оноос Монголын Судар бичгийн хүрээлэн, Сибирийн шинжлэх ухааны хүрээлэн ба ЗХУ-ын ШУА-ийн Монголын комисстой харилцаа тогтоосон (Уг комисс Монгол, Буриад, Тува улсыг шинжлэх ухааны үүднээс гүнзгий судлах, эдгээр бүгд найрамдах улсуудад шинжлэх ухааны боловсон хүчнийг бэлдэхэд нь туслах зорилгоор зориуд байгуулагджээ).

Судар бичгийн хүрээлэн тус хүрээлэнд ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгоор Ленинград, Лейпциг, Парис руу залуучуудыг явуулж суралцуулж байв.

Мөн Жамсрангийн Цэвээн Монголын Шинжлэх Ухааны байгууллагыг гадаадын эрдэмтэдтэй холбох ажлыг хийж байсны дотор нэрт эрдэмтэн С.Ф.Ольденбург, А.П.Карпинский, В.Л.Комаров, Б.Я.Владимирцов болон Ф.И.Щербатский, Г.Е.Грумм Гржимайло, В.А,Обручев, П.К.Козлов, В.В.Бартольд, В.Л.Котвич, Н.К.Поппе, Эренжен Хар Даваа, В.А.Рязановский зэрэг олон эрдэмтэдтэй холбоо харилцаатай байж хамтран ажиллаж байсан баримт бичиг, захидал, материалууд хадгалагдан үлдсэн байдаг юм.[10] Тэдгээр захидал, бичиг баримтуудад хэрхэн хамтран ажиллаж байсан талаар болон үйл ажиллагааны санхүүгийн тайлан тооцоог хөтөлж, төсвийг зарцуулж байсан тухай тодорхой туссан байдаг. Тэдгээр захидал харилцаанд олон мянган төгрөг, рубль, долларын талаар дурьдаж, төсөв, төсөл, унаа хөсөг гэх мэт асуудлыг тусгасан байдаг нь Монгол оронд шинжлэх ухаан хөгжүүлэх талаар өргөн хүрээнд ажиллаж байсны илэрхийлэл юм.

Гадаад дотоодын олон эрдэмтэдтэй харилцаж байсан нь Жамсрангийн Цэвээний орчин тойронд их соёл, боловсрол, гэгээрлийн өвөрмөц орчин үүсэн бүрэлдэж байжээ. Энэхүү орчинд улс үндсээ мандуулах эх оронч үзэл санаа төлөвшиж, эрдэм шинжилгээний ажил үйлс, Монгол угсаатан улсуудын эх түүх, утга зохиол, аман зохиолын болон эртний олдворын судалгаа шинжилгээний, орчуулгын зэрэг олон төрлийн ажил ундарч, өргөжин хөгжиж, залуу төр улсын хойч үеийнхнийг төгөлдөржүүлэн боловсруулах үйл хэргийн үндэс суурь тавигдаж байсан нь ойлгогддог.

Монголын өргөн уудам нутагт судалгаа шинжилгээ хийж, олсон олдвор, эд өлгийн зүйлийг судалж шинжилсний дараа Монгол улсын мэдэлд шилжүүлэх талаар байгуулсан гэрээнүүд байх бөгөөд Жамсрангийн Цэвээн мөнгө төсөв, хөрөнгө сүйтгэлийг гаргах бүрэн эрхтэй, нөлөө бүхий хүн байсан болон уг ажилд Жамсрангийн Цэвээн ихээхэн эрч хүч, идэвх санаачилга гаргаж, шинжлэх ухаанчаар хандаж байсан нь харагдана.

Хорин хэдэн оны үед Монгол нутагт эртний түүх, байгалийг судлах эрдэм шинжилгээний хэд хэдэн экспедицийнхэн ажиллаж байлаа.

9 *Монголын шилдэг нийтлэл УБ. 2010. х.80 х.81*

10 *Ж.Цэвээний. Түүвэр зохиолууд. УБ.. 1997. х.15*

Тэдний хамгийн том нь 1923-1926 оны үед П.К.Козловын удирдсан ЗХУ-ын ШУА, Оросын геологийн нийгэмлэгийн болон 1922-1925 оны үед Р.Ч.Эндрюсийн удирдсан Америкийн төв Азийн судалгааны экспедицийнхэн байлаа. Жамсрангийн Цэвээн энэ хоёр экспедицийнхэнтэй хэрхэн харилцаж байсан талаар олон баримтууд байдаг.

Ольденбург нэгэн захидалдаа П.К.Козловын Монголд хийсэн судалгааны багийнхны ажлын товч тайлангийн 50 ширхэгийг илгээх[11] тухай, Ноён уулын булшнаас олдсон эд зүйлийг Орост судалж шинжилсний дараа Их хүрээний музейд эргүүлж илгээх шийдвэрийн тухай өгүүлсэн байдаг. Мөн Ноён уулын булшнаас олдсон Хүннү улсын үеийн ховор нандин олдворыг асар үнэ цэнэтэй гэдгийг Жамсрангийн Цэвээн тооцож тэдгээрийг Монголд эргүүлэн авчруулах асуудлыг тавьсан болох нь захидлаас тодорхой байдаг. Энэ нь түүний эх оронч сэтгэлгээг илэрхийлэх төдийгүй түүхэн олдворын үнэ цэнийг мэдэж Монголын түүх соёлын нандин өвийг хадгалж үлдэхийн ач холбогдлыг ойлгож байсны илэрхийлэл юм. Ноён уулын булшны олдворын ихэнх хувь өдгөө Монгол улсын төв музейд хадгалагдаж байгаа нь Жамсрангийн Цэвээний хүчин зүтгэлийн үр дүн байсан байж болох юм.

Америкийн шинжээч Р.Ч.Эндрюсийн анги Хятадаас Монголын говь нутгийн өмнө хэсгээр орж үлэг гүрвэлүүдийн араг ясыг цуглуулж аваад Америк руу зөөвөрлөн одсон нь Америкийн музейнүүдэд тэр чигээрээ үлдсэн гэж Монголын ихэнх сэхээтнүүд үздэг билээ.

Дээрх захидлаас үзэхэд Р.Ч.Эндрюсийн экспедицийнхэн Судар бичгийн хүрээлэнтэй албан ёсоор харилцаж байсан төдийгүй Монголын засгийн газрын нөлөө бүхий хүмүүстэй ч харилцаж байсан болон тус экспедицийнхэн судалгаа шинжилгээ хийх албан ёсны зөвшөөрөлтэй байсан бололтой. Р.Ч.Эндрюс захидалдаа бичихдээ: "Би хувиасаа танд, танай засгийн газарт чин сэтгэлээсээ хайртай ханддаг юм"[12] гэжээ. Үүнийг батлах мэт холбогдох цуглуулгыг Жамсрангийн Цэвээний нэр дээр юм уу, Монголын Судар бичгийн хүрээлэнд илгээнэ, бас хайгуул судлалын ном, газрын зураг зэргийг явуулна гэж Р.Ч.Эндрюс амлажээ. Үнэхээр тийм бол манайд байгаа газрын зургуудыг Р.Ч.Эндрюс илгээсэн байж таарна.

Жамсрангийн Цэвээн П.К.Козлов тэргүүтэй Оросын, Р.Ч.Эндрюс тэргүүтэй Америкийн судалгаа шинжилгээний хоёр том экспедицийнхэнтэй хэлэлцээ хийхдээ хайгуулын олдворыг хэрхэх талаар маш их анхаарч, нутагтаа зохих судалгаа шинжилгээ хийсний дараагаар тэдгээрийг Монголд буцаан ирүүлнэ гэж амлатал нь тэдэнтэй тийнхүү хэлэлцэн тохиролцож байсан байна. Хүн төрөлхтний өлгий нутаг нь Төв Ази, түүний дотор Монгол орон гэсэн гайхалтай таамгийг Р.Ч.Эндрюс тэр үед дэвшүүлж, дэлхий дахиныг шуугиулж байжээ.

Судар бичгийн хүрээлэн тэр үеийн аль дорвитой бүтээлүүдийг монгол хэл рүү хөрвүүлж шинээр гарч буй сэхээтнүүдэд болон олон түмэнд утга агуулгыг нь танилцуулах зорилгоор их ажил хийж байлаа. Монголын ард түмнийг оюун санааны хувьд дэлхий нийтийн соёлын гольдролд татан оруулах, дэлхий дахинд Монгол улсын байр суурийг буй болгох зорилго тавьж байлаа. 1896 онд Леон Коэний бичсэн "Азийн түүхийн удиртгал" бүтээлийг орчуулсан Жамсрангийн Цэвээний хичээл зүтгэлээр манай өвөг дээдсийг элдвээр гутаан, зэрлэг бүдүүлгээр дуудан "цус урсгадаг зандалчид" хэмээн үздэг Европынхны сэтгэлгээг няцаасан Францын энэ эрдэмтний номыг сонгож авснаар монгол хэл дээрх орчуулгын зохиолын түүхэнд чухал ач холбогдолтой ном болсон юм. Гарамгай монголч эрдэмтэн В.В.Бартольд тэрхүү "Азийн түүхийн удиртгал" зохиолыг "Монголын байлдан дагуулалын талаархи Европынхны хуучин төсөөллийг няцаасан анхны чухал бүтээл"[13] хэмээн үнэлсэн байдаг.

Тухайн үед ийнхүү монголын ард түмнийг Европын болон Барууны түүх, соёлтой танилцах, дэлхийн сонгодог зохиолуудыг төрөлх хэл дээрээ унших боломжийг бүрдүүлж, дэлхийн хэмжээний шинжлэх ухааны мэдлэгийг хоцрогдсон буурай ард түмэнд сурталчлах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулахад онцгой үүрэг гүйцэтгэсэн анхдагчийн хувьд Жамсрангийн Цэвээнийг орчуулга үндэслэгч гэж үзэж болно.

Жамсрангийн Цэвээн бүхий л албан тушаалд ажиллаж байхдаа эрдэмтэн хүний ёсоор онолын үндсийг боловсруулахыг гол болгож, олны үйл хэрэгт зөвлөгөө өгөх, туслалцахыг илүүд үзэж, зарим албан тушаалаас татгалздаг байсны нэг жишээ бол Судар бичгийн хүрээлэнгийн захирал биш эрдэмтэн нарийн бичгийн дарга байсан явдал юм.

Хэдэн мянган жил ард түмний дунд хэлэлцэгдэн уламжлагдан ирсэн ардын аман зохиолуудыг олж цуглуулж, судалж Жамсрангийн

11 *Ж.Цэвээний түүвэр зохиолууд. УБ., 1997. Х.148*
12 *Ж.Цэвээний түүвэр зохиолууд. УБ., 1997. Х.159*
13 *Монголын түүх I боть. УБ., 1966. х.41*

Цэвээний оруулсан хувь нэмрийг үнэлж Оросын ШУА-аас 1936 онд хэл бичгийн ухааны доктор болсон юм. Дараа нь Оросын ШУА-н сурвалжлагч гишүүн болжээ.

Монгол туургатны анхны доктор Их эрдэмтэн Жамсрангийн Цэвээн Лев Гумилев, Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж нарын зэрэг олон арван эрдэмтэн зохиолчдыг сурган хүмүүжүүлж, эрдэм шинжилгээний ажил, зохиол бүтээлд нь зөвлөгөө өгч, хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзагандхүргэсэн тухай олон хүн дурсан бичсэн байдаг.

Үнэхээр монголын шинэ цагийн сэхээтнийг сургаж боловсруулах их үйл хэрэгт бие сэтгэл, оюун санаагаа зориулсан, шинэ цагийн боловсрол, соёл шинжлэх ухааны байгууллагыг үүсгэн санаачилсан эрхэм гавъяатай хүн бол 1920,1930-аад оны дэвшилтэт сэхээтнүүдийн оюун санааны загалмайлсан эцэг нь болсон Жамсрангийн Цэвээн байлаа.

Францын монголч эрдэмтэн А.Морстерт "Би энэ хүнийг маш их хүндэлж, өндөр үнэлдэг. Яагаад гэвэл энэ хүн өөрийн бүхий л мэдлэг чадвараа шинжлэх ухаанд зориулсан аугаа их эх оронч хүн. Зөвхөн эх оронч хүн төдийгүй бүхий л амьдрал,оюун ухаанаа эх монгол хэлэндзориулсан"[14] юм гэж бичиж байжээ. Энэ бүхнээс үзэхэд Жамсрангийн Цэвээн нь шинэ үеийн Монгол судлалыг хөгжүүлж,дэлхий дахинаа алдаршуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Дээрх түүхийн баримтуудаас үзвэл Жамсрангийн Цэвээн анхны сургуулийг үүсгэн байгуулах саналыг дэвшүүлж дүрэм журам, сурах бичгүүдийг зохиож орчуулж, багшлах боловсон хүчнээр хангаж байсан төдийгүй Судар бичгийн хуралцлан байгуулах тухай санаачлага гаргаж Ардын засгийн газраар дэмжүүлж,уг хүрээлэнгийн даргаар Онходын Жамъянг томилуулж өөрөө эрдэмтэн нарийн бичгийн дарга,жинхэнэ гишүүнээр 10 орчим жил хүчин зүтгэж, судалгаа шинжилгээний нөр их ажил өрнүүлж,эрдэмтэн судлаачдыг бэлтгэж,гадаад харилцааг хөгжүүлж,дэлхийн монгол судлалын гол төв болж өргөн цар хүрээтэй ажиллаж байсан үйл ажиллагаа нь түүнийг шинжлэх ухааны академи болон боловсролын байгууллагын үндэслэгч мөн болохыг гэрчилж байна.

Ашигласан материал

1. Жамсрангийн Цэвээн. Түүвэр зохиолууд. УБ.,1997
2. Цыбиков.Б,Чимитдоржиев.Ш. "Цыбен Жамцарано". Улан-Удэ.,1997.
3. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1дүгээр дэвтэр. УБ.,1966.
4. Ж.Цэцэгмаа. Жамсрангийн Цэвээний Монголд ажилласан он жилүүд УБ.,1999.
5. Ж.Цэцэгмаа. Монгол оронд Жамсрангийн Цэвээний өрнүүлсэн эрдэм шинжилгээ, соён гэгээрүүлэлт,нийгэм-улс төрийн үйл ажиллагаа. (1911-1931)УБ.,2008.

14 *Ж.Цэцэгмаа. Монгол оронд Жамсрангийн Цэвээний өрнүүлсэн эрдэм шинжилгээ, соён гэгээрүүлэлт, нийгэм-улс төрийн үйл ажиллагаа. (1911-1931)УБ., 2008. х.139*

ЗХУ-ЫН ГАДААД БОДЛОГОД ДИПЛОМАТЧ Г.В.ЧИЧЕРИНИЙ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРГИЙН ТУХАЙ

Д.Чинбаяр

Их Засаг ОУИС-ийн Чингис Соосэ ОУХС-ийн багш, Докторант

1. Георгий Васильевич Чичерин гэж хэн бэ?
2. Г.В.Чичериний үзэл бодол,түүхэн замнал
3. Г.В.Чичериний ЗХУ-ын гадаад бодлогод гүйцэтгэсэн үүрэг
4. Г.В.Чичериний тухай дүгнэлт

Георгий Васильевич Чичерин (1872-1936) Зөвлөлт Оросын гадаад харилцааг 12-хон жил удирдан ажиллахдаа нугарашгүй ноён нуруутай, бие даасан үзэл бодолтой хүн байв. Тэрээр Зөвлөлт Оросын гадаад улс төрийн бодлогод өөрийн байр сууриа эзэлж чадсан хүн байсан бөгөөд үзэл бодлоосоо хэзээ ч ухарч байгаагүй юм. Ийм ч учраас түүний хувь хүний гүйцэтгэх үүрэг нь капиталист орнууд ялангуяа олон улсын тавцанд Зөвлөлт Орос Улсын Засгийн газрыг хүлээн зөвшөөрүүлэхэд үнэтэй цэнэтэйд тооцогдох юм. Ялангуяа түүхийн эгзэгтэй хүнд хэцүү үед Монголын тусгаар тогтнолын талаар нааштай байр суурь баримталж байсан нь талархууштай юм.

1. Георгий Васильевич Чичерин гэж хэн бэ?

Г.В.Чичерин 1872 онд Оросын язгууртны гэр бүлдтөржээ. Г.В. Чичерин хэдийгээр язгууртны гаралтай байсан хэдий боловч хөрөнгөтөн дээдэс байх хүсэл, баян чинээлэг амьдралаа хаян, үзэл бодол нь өөрчлөгдөн мэргэжлийн хувьсгалч болж төлөвшжээ. Түүний аав тэтгэвэртээ гарсан дипломатч байсан тул Георгий түүний замналаар явж,ГХЯ-ны Улсын болон Санкт-Петербург хотын төв архивт ажиллаж эхэлжээ. 1900-аад оны эхээр хувьсгалчидтай ойр дотно болсон. 1904 онд тэрээр Герман руу сурахаар явснаар Гадаад хэргийн яамны архивт бүртгэгджээ. 1905 онд Германы Большевик намын гишүүнээр элссэн бол 1907 оны 1 дүгээр сараас Зөвлөлт Оросын Гадаад товчооны нарийн бичгийн дарга нарын газрын гишүүн болжээ. Гэвч 1908 онд Хувьсгалт үйл ажиллагаанд оролцсон тул Гадаад хэргийн яамнаас халагдсан байна. Тэрээр аавынхаа асар их өв хөрөнгийг өвлөн авсан боловч Большевик намд ихэнх мөнгөө хандивлажээ. 1908 оноос Меньшевик намд элсэв. Гэвч Хаант Засаг түүнийг 1905 оноос хойш Хувьсгалт хөдөлгөөнд оролцсон хэргээр баривчлахаар хайж эхэлсэн тул Их Британи руу цагаачилжээ. Тэрээр Лондонд дайны эсрэг суртал ухуулга явуулж байсан тул 1917 оны 8-р сарын 22-нд Британийн эрх баригчид түүнийг баривчилж, шоронд хийсэн байна. 1918 оны Нэгдүгээр сард тэрээр суллагдаж, эх орондоо буцаж ирээд, Большевик намд элсэв. Түүний аав дипломатч хүн байсан учир нийгэмд нэр хүндтэй гэр бүлд хэвээр тооцогдож байв. Энэ хугацаанд аав нь сүрьеэ өвчнөөр нас барж,зовлонт амьдралыг ээжтэйгээ хамт туулж байсан хэдий ч шантралгүй Санкт-Петербургийн их сургуулийг төгсөж, англи, франц хэлийг төгс эзэмшсэн байна. Ингээд тэрээр өндөр боловсролтой дипломатч болох гараагаа эхлүүлжээ.

2. Г.В.Чичериний үзэл бодол, түүхэн замнал

1894 онд түүнийг 22 настай Санкт-Петербургийн их сургуулийн оюутан байх ахуйд түүний авга ах Борис Николаевич Москвагийн их сургуулийн профессор байв. Тэрээр ахдаа хандан "...хүнд хэцүү амьдралд маш их зовлоо. Цаашид хийх зүйл, хүсэл мөрөөдөл их байна..." хэмээн хэлж байв. 1907 онд тэрээр мөн ахынхаа эхнэр Б.Николаевнад хандан: "Өнөөдрийн амьдралын агуу зорилгын төлөө би бүхнээ золиослож,их тулалдаанд оролцсон..." гэх зэргээр бичсэн нь түүнийг хэдийн большевик болсныг илтгэдэг. Олон жилийн турш Чичеринтэй хамт ажиллаж байсан Зөвлөлтийн нэрт дипломатч Майский дурсахдаа, "...түүний нүд хурц бөгөөд тогтворгүй, хурдан хөдөлгөөнтэй..." гэсэн бол, тэр үед хамт ажиллаж байсан хүмүүс түүнийг дурсахдаа, "Чичерин их онцгой хүн байсан. Тансаг хэрэглээнд дуртай, ганган хувцасладаг, эрүүл мэнддээ анхаарч цагаан хоол идэж, үнэтэй дарс уудаг байв. Орой үдшийг үдэшлэг, зугаа цэнгэлд зориулдаг байсан бол дорхноо хувирч энэ бүх дадал зуршлаа нэг л өдөр хаяж, өөрийгөө өөрчилж чадсан..." хэмээжээ. Үүнд юу нөлөөлөв өө? Г.В.Чичерин Оросын социал демократ ажилчдын намд элссэний дараа 24 цагийн минут бүрийг хувьсгалд, зөвхөн хувьсгалын төлөө зарцуулах

ёстой хэмээн үздэг болжээ. Г.В.Чичерин амьдралын аар саар зүйл, ахуйн асуудлыг хойш тавьж бие сэтгэлээ хувьсгалын үйл ажиллагаанд зориулж эхэлжээ. Г.В.Чичерин бага унтдаг,үүрээр л нүдний хор гаргадаг байв. Заримдаа яаралтай үед Гадаадын элчин сайдуудыг ч хүртэл шөнийн цагаар албан өрөөндөө дуудаж ажил хэрэг ярьдаг байв. Шөнө бичгийн ажлаа боловсруулж гарын үсгээ зурж ширээн дээр бэлэн болгож тавьдаг байв. Зөвлөлтийн Ардын комиссариатарын хэрэг эрхлэх газрын дарга В.Д.Бонч Бруевич хувьсгалын дараах жилүүдийн өлсгөлөнгийн талаар дурсахдаа: "... хүнсний талон олддогүй нэн хэцүү үе байлаа. Түүхий овъёосыг гэртээ боловсруулж кофе,кисель болгон хэрэглэдэг байв. Нэг өдөр би Гадаад хэргийн яам руу Чичериитэй ажил хэргээр уулзахаар очсон юм . Албан өрөөнд нь ормогц намайг хачирхалтай дүр төрх угтав. Чичерин ажлаа хийх зуураа тавагтай түүхий овьёосноос гараараа түүж аван ам руугаа яаралгүй хийн зажлах нь яг л адуу овьёосоо идэж буй мэт. Георгий Васильевич та чинь яаж байна вэ? гэхэд минь, "Өөрт ноогдсон юмаа л хэрэглэж байна. Би адуу биш ч овъёос идэхээс өөр яалтай..." хэмээв.

Г.В.Чичерин дипломат ажлыг үр бүтээлтэй явуулахад улс дотроо хоёр зүйл саад болж байна хэмээн үзсэн. Нэгдүгээрт, Хувьсгалт Комментерн. Тэрээр Коммунтерны нам нь гадаад орнуудыг хувьсгалдуриалан дуудаж,мөнгө,зэр зэвсгээр тусалж байгаа нь тус улсыг гадаад орнуудтай дипломат харилцаа тогтооход төвөгтэй байдлыг үүсгэдэг гэж үздэг байв. 1920-иод онд ЗХУ-д улс төрийн хоёр бодлого байсны нэг нь Г.В.Чичериний дипломат бодлого, нөгөө нь коминтерний үзэл сурталжсан бодлого байв. Г.В.Чичерин коминтерний үйл ажиллагааг "балмад" гэж нэрлэн улс төрийн товчоонд гомдол гаргадаг байв. Тэрээр хоёр дахь дайснаа Улс төрийн удирдах газар (Дотоод хэргийн яам) гэж үздэг байв. Тэрээр,"Улс төрийн газрын удирдлагууд ямагт биднээс баримтыг нуун дарагдуулж, хуурч мэхлэн, үйл ажиллагааг тасалдуулж, тэвчишгүй байдал гаргадаг. Зарим нь гадаадын иргэдийг хууль бусаар шүүлгүйгээр цаазалсан..."," ... Гадаадын элчин сайдуудтай найзын холбоотой оросуудыг хоморголон баривчилдаг. Элчин сайдын яамны үйлчлэгч, хаалгач, жолооч нарыг сүрдүүлж байгаад дотоод хэргийн яамныхаа мэдээлэгч болгодог хэмээн шүүмжлээд, өөрийг нь ардаас байнга мөшгиж, тагнадаг хүний эрх, ёс зүй зөрчсөн бүдүүлэг арга хэрэглэж байна гэх зэргээр ил тод дургүйцлээ илэрхийлж, Гадаад яамны удирдах газартаа гомдолсон байдаг. Г.В.Чичерин тухайн үеийн Дотоод хэргийн яамны хууль бус хэлмэгдүүлэх ажиллагааг өөрийн уугуул соёл, өргөн боловсрол дипломатчийн ухаанаар харж энэ бусармаг ажиллагааг нь дотоодод төдийгүй олон улсын хэмжээнд Зөвлөлт Оросыг нээлттэйгээр хүлээн зөвшөөрч хөгжин дэвжихэд нь харшилж байна хэмээн эрс эсэргүүцэж байв. Тэрээр язгууртан боловсролтой гэр бүлээс гаралтай, эцэж цуцашгүй хөдөлмөрлөдөг, идеалист үзэлтэй, үйл хэрэгтээ үнэнч байсан учир хир баргийн хүн түүнээс эмээн сүрддэг байжээ.

Г.В.Чичерин хөгжмийн урлагийн гоц авъастай төгөлдөр хуурч байсныг амьдралынх нь туршид болж байсан цөөнгүй үйл явдал гэрчилдэг аж. Тэр амьдралынхаа туршид Моцартыг хайрлаж бүтээлийг нь гарамгай тоглож хүмүүсийн талархлыг хүлээдэг байсан төдийгүй Австрийн хөгжмийн зохиолч В.А. Моцартыг судалж "Моцарт" хэмээх сонирхолтой ном бичиж байжээ. Г.Чичерин уг номондоо: "Моцарт" нь 18 дугаар зуунаас 19 дүгээр зуунд илүү, 19 дүгээр зууныхаас 20 дугаар зуунд бүүр илүү түүнээсээ ч тасран ирээдүй рүү шагшигдан одох бүтээл мөн" хэмээн онцолж байв. Тэрээр А.В.Моцартын зохиолыг төгөлдөр хуураар гарамгай тоглодог байсан нь гадаадын дипломатчдыг гайхшруулдаг байсан төдийгүй Зөвлөлт Оросын гадаад бодлогод маш сайнаар нөлөө үзүүлдэг байв. Кремлийн удирдлага ямар ч бэрхшээлтэй,ярвигтай,ээдрээтэй асуудлыг ганцхан Г.Чичеринд өгч шийдүүлэхийг хүсдэг байсан нь үүнтэй холбоотой юм. 1916 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Лондон дахь Орос цагаач дүрвэгсдийн үдэшлэгт Г.Чичерин рояль хөгжмөөр "Фауста"-ын маршийн хэсгээс тоглож дуусахад үзэгчид нижигнүүлэн алга ташиж сэтгэл хөдлөлөө барьж дийлэлгүй өндөр дуугаар "браво" хэмээн дэмждэг байлаа гэж Майский дурсамж номондоо бичсэн байдаг. Хамгийн сүүлд тэрээр 1922 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Генуе-гийн Империал зочид буудалд болсон үдэшлэгт Людвиг ван Бетховен (герм. Ludwig van Beethoven) -ний "Сарны сонат" болон П.И.Чайковский, В.А. Моцарт, К.Дебюсси (фр.Achille-Claude Debussy) нарын хөгжмийн сонгодог бүтээлүүдээс төгөлдөр хуураар тоглож үзүүлэхэд Италийн төлөөлөгчид өвдөг дээрээ мэхийн ёсолж, тэргүүнээ гудайлган хүндэтгэж байсан талаар,мөн 1922 оны 11 дүгээр сарын эхээр харанхуй бүрийд Гадаад хэргийн яамнаас цахилгаан мэдээ ирж, Владвистокоос Японы цэргүүдийг хөөн гаргасан тухай сонсоод Моцартын бүтээлийг

тоглож баярлан хөөрч байсан тухай дипломатч А.Н.Эрлих дурссан байдаг.

3. Г.В.Чичериний ЗХУ-ын гадаад бодлогод гүйцэтгэсэн үүрэг

Г.В.Чичерин Зөвлөлтийн төлөөлөгчдийг тэргүүлэн 1918 оны 2-р сарын 24-ний өдөр Германд айлчилж хоёр талын хэлэлцээ хийж, гуравдугаар сарын 3-нд Брестийн энх тайвны гэрээнд гарын үсэг зурав. 1925 онд Туркстэй Найрамдал, төвийг сахих тухай гэрээ, 1927 онд Ирантай "Аюулгүй байдлын болон төвийг сахих тухай" гэрээнд гарын үсэг зурсан нь анх удаа тэдгээр орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрүүд байгуулсан явдал байлаа.

1922 оны 4-р сарын 10-ны өдөр Генуе дэх Сан Жордын ордондолон улсын бага хурал боллоо. Бага хуралд хүрэлцэн ирсэн 29 орны төлөөлөгчид зөвлөлтийн төлөөлөгчдийн тэргүүний илтгэлийг тэсэн ядан хүлээж байв. Учир нь тэдгээр нөхдүүд Оросын Хаант засгийн үеийн болон дайны өмнөх үеийн төлбөр, мөн Октябрийн хувьсгалын үеэр тус улсад оршин сууж байсан гадаадын иргэдийн өмч хөрөнгийг хүчээр хураасны төлбөр нийт 18.5 миллиард рублийг эргүүлэн өгөхийг нэхэмжлэн шаардаад байв. Зөвлөлт Оросын Гадаад хэргийн сайд Г.В.Чичерин бага хурал болохоос өмнө эртнээс бэлтгэж олон шөнийг нойргүй өнгөрөөсөн нь хий хоосон байгаагүй юм. Тэдний шаардлагын хариу сөрөг нэхэмжлэлээр няцааж чадсан юм. Тэрээр гадаадын түрэмгийлэгчдээс Зөвлөлт Орост учруулсан 39 их наяд рублийн хохирлыг өөдөөс нь нэхсэн байна. Г.В. Чичерин, " ... олон улсын хууль дүрмийн дагуушинээр байгуулагдсан Зөвлөлт Орос Улс нь капиталисторнуудтай шинэ харилцааг хөгжүүлэх сонирхолтой байна. Үүнд өмнөх Хаант засгийн үед байгуулагдсан гэрээ хэлэлцээрүүдийг хүчингүй болгож байна хэмээн мэдэгдсэн байна. Ингэхдээ Г.В.Чичерин франц хэлээр чөлөөтэй ярьж мэтгэлцсэн нь тэдний сэтгэл зүйд цохилт болж байжээ. Тэрээр Английн төлөөлөгчдийн тэргүүн Лойд Жорж франц хэл мэдэхгүйг нь мэдээд францаар асуудлыг шийдвэрлэх нөхцөл байдлыг үүсгэж, дайралтыг өөртөө ашигтайгаар эргүүлсэн байдаг. Г.В.Чичерин илтгэлийнхээ явцад франц хэл үл мэдэхгүйгээс болж алмайрч суугаа Лойд Жоржид хандаж төрөлх англиар үг бүрийг давтан хэлж ойлгуулж байсан нь бусад төлөөлөгчдийн анхаарлыг өөртөө татаж байсан байна. Энэ нь тухайн үедээ түүний дипломат ур чадварын илэрхийлэл байсан гэж үздэг . Бага хурлын эхний өдрөөс л Чичеринийг барууны төлөөлөгчид урьд байгаагүйгээр хүлээн зөвшөөрч эхэлсэн гэдэг. Бага хурлын үеийн хүлээн авалтад төлөөлөгчид Г.В.Чичеринг тойрон түүний үгийг сонсч талархалтай хүлээн авч эхэлсэн аж. Генуегийн бага хурлын индэрээс олон улсын харилцааны түүхэнд анх удаа Зөвлөлт Орос улс гадаад улс орнуудтай дайн хийхгүй, энх тайвнаар зэрэгцэн орших байр сууриа илэрхийлж, бүх нийтээр зэвсэглэлийг хорогдуулах тухай саналыг гаргаж буйгаа мэдэгдсэн билээ. Италийн Засгийн газрын төлөөлөгч Виктор Эммануэл хүндэтгэлийн дайллагад Г.В.Чичеринтэй ярилцаж байхдаа түүний ярианд ховсдуулсан мэт улам шимтэж хаана буйгаа мартсан байсан гэдэг.

1928-1929 онд Германд удаан хугацаагаар эмчлүүлж, улмаар 1930 оны долдугаар сард Гадаад харилцааны Ардын комиссариатын ажлаас чөлөөлөгджээ. Г.В.Чичерин Зөвлөлт Оросын Гадаад хэргийн Ардын комиссариатын даргаар ажиллаж байхдаа Бүх Оросын Төв Гүйцэтгэх Хороо, Зөвлөлт Оросын Коммунист намын Төв Хорооны гишүүнээр сонгогдож байв. Тэрээр 1936 онд өвчний улмаас нас баржээ.

4. Г.В.Чичериний тухай дүгнэлт

Г.В.Чичерин бусад улс орнуудтай бүтээлч харилцааг хөгжүүлэхийг дэмжиж, Коминтерний удирдлагуудтай байнга үзэл бодлын зөрчилдөөн дундах тэмцэл нь Монголын тусгаар тогтнолын асуудал сөхөгдөх бүрт харагддаг байв. Г.В.Чичериний гол гавьяа нь ЗХУ-ыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж чадсанд оршино.

Тэрээр Зөвлөлт засагт Оросын уламжлалт дипломат ёсыг эргүүлэн авчирсан юм. Улс төрийн тогтолцооны хувьд бусад улс гүрнүүдтэй энх тайвнаар зэрэгцэн орших нь уриа байсан бол Чичериний хувьд бодитой зорилго болсон юм. Тэрээр хувьсгалч гоё үгийг хэрэглэхгүй өөрийн үйл ажиллагааг практик амьдралаасаа ургуулдаг байв.

Гадаад хэргийн комиссар Г.Чичерин Монголын тусгаар тогтнолын асуудлаар өөрийн бат байр сууринаас нааштай ханддаг байв. Тухайлбал, тэрээр В.И.Ленинд 1921 оны аравдугаар сарын 18-нд нэгэнд явуулсан захидалдаа[1], "...Монголын Хувьсгалт Засгийн газар нь бидний гарт байгаа томоохон хөзөр юм. Энэ Засгийн газар байгуулагдсан явдал Номхон далайгаас Каспийн тэнгис хүртэл хувьсгалын эсрэг фронт

1 *Эх сурвалж: "Хятад-Зөвлөлт Орос улс хоорондох Монгол улс" Эцэн Хойд Ази судлал сэтгүүл №8 УБ., 1996 он*

тогтоох Японы төлөвлөгөөнүүдийг хөмрүүлэн няцаасан билээ. Манай асар урт хил хязгаар нь нөхөрсөг Монголоор халхалагдсаны хувьд бүрэн аюулгүй" хэмээн дурдаж байснаас харж болно.

Монгол, Зөвлөлтийн Найрамдлын хэлэлцээр байгуулах зорилгоор Д.Сүхбаатар тэргүүтэй төлөөлөгчид Зөвлөлт Орос улсад айлчлахад тэрээр зуучлалын үүрэгтэй оролцож, Д.Сүхбаатар, В.И.Ленин нарын уулзалтыг зохион байгуулсан бөгөөд анх В.И.Ленинд Монголын талаар эерэг дэлгэрэнгүй ойлголтыг өгч, дэмжүүлж чадсан ухаалаг дипломатч байлаа.

Ашигласан материал

1. Спутник.- дайджест советской пресси №7 Москва 1987. стр 90
2. Спутник сэтгүүл №7 Москва 1987. стр 81
3. Л.Млечин УАХ-ын дарга нарын илчлэгдсэн хувь заяа 2007,УБ. х/с 19
4. С.Зарницкий и Сергеева "Чичерин" 2002 г.

ХАБУЛ ХААН МОНГОЛ УЛСЫН АНХНЫ ХААН МӨН ҮҮ?

Х.Төмөрбаатар

Их Засаг ОУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн багш, түүхийн ухааны магистр

Хураангуй: XI-XII зууны үеийн Монголын түүхийн нэгэн чухал үе болох түрүү Монголын улсын хаан нь хэн бэ? Өмнөх түүх судлалд тогтсон түрүү Монгол улсыг байгуулсан анхны хаан Хабул хэмээх үзлийн дахин нягталж, судлаачдын үзэл баримтлал, сурвалжийн мэдээг тодруулан авч үзлээ.

Монголын дунд үеийн түүх судлалд XI-XII зууны дунд үе хүртэлх Монголын түүх бага судлагдсан байдаг билээ. Энэ үеийн түүхээр доктор Ч.Далайн "Хамаг Монгол улс"[1] гэсэн нэгэн сэдэвт зохиолоос өөр далайцтай бичигдсэн ном одоогоор гараагүй байна. Түүхчид Чингис хааны үеийн түүхийг сайтар судалсан атлаа түүнээс өмнөх үеийн түүхийг харьцангуй бага судласан байдаг. Энэ нь тухайн үед холбогдох сурвалж бага байдагтай холбоотой юм.

1130-аад онд Хабул хаан "Mongyol ulus"[2] буюу түрүү Монгол улсыг байгуулсан анхны хаан мөн үү? гэдгийг тодруулан авч үзье. "Монголын нууц товчоон", "Шашдирийн чуулган", "Дай Ляо улсын судар" зэрэг энэ үеийн түүхийг бичиж үлдээсэн сурвалжийн мэдээг нягталж үзэхүл Хабул хааныг Монгол улсыг байгуулсан анхны хаан гэж шууд үзэх үндэслэл алга байна.

Монголын дунд үеийн түүх бичлэгт Хабул хааныг Монгол улсын анхны хаан байсан[3] гэж бичиж, тодорхойлсоор иржээ. Энэ тухай түүхч А.Амар[4], доктор Д.Гонгор[5], Ш.Нацагдорж[6], Ч.Далай[7], Сүрбадрах[8], Р.Сайшаал[9], Н.Ишжамц[10], Ж.Гэрэлбадрах[11] нарын олон эрдэмтэд Хабул хаан Монгол улсыг байгуулсан анхны хаан хэмээх үзэл баримтлалыг дагажээ. Тухайлбал: түүхч А.Амар "Түүнээс олон монголчуудыг Хабул хаан захиран бөлгөө."[12], доктор Д.Гонгор "Хамаг Монголын анхны хан нь Чингисийн элэнц эцэг, Тумбинай сэцэний ахмад хөвгүүн Хабул (1101-1148?) болно."[13], доктор Ч.Далай "миний бодохул, Хабул хааны үеэс Хамаг Монгол хэмээх гол улсын эх суурь тавигдсан нь тодорхой мэт байдаг."[14], "Хамаг Монголын тухай дурдахын тулд түүнийг үндэслэн байгуулсан Хабул хааны тухай товч өгүүлэх нь зүйтэй"[15], доктор Р.Сайшаал "Хэрэг дээрээ арван хоёрдугаар зууны эхээр Хабул хаан зөвхөн "Нирүгүн Монголчууд"-ыг анх удаа нэгтгэж, "хаан" цолыг эхлэн өргөмжилжээ"[16], доктор Н.Ишжамц "XII зууны 20-иод оны эцэс, 30-аад оны эхээр язгуурын Монгол аймгийн зонхилогч Хабул Онон, Хэрлэн, Туулын гурван голын эхний бусад Монголыг нэгтгэн захирч биеэ хан өргөмжилжээ."[17], Ж.Гэрэлбадрах "Их Монгол улсын үеийг түүх сударт ... тодорхой тэмдэглэн үлдсэн Монголын анхны хаан Хабулаас эхлүүлэх нь зүйтэй юм."[18] хэмээн Хабул хааныг Монгол улсын анхны хаан байсан хэмээх үзлийг баримтлан бичиж иржээ.

Ингэж үзэх болсон гол үндэслэгээ нь "МНТ"-д "qamuq mongqol-I qabul-qahan meden abai"[19](Хамаг Монголыг Хабул хаан мэдэн авай.) хэмээн өгүүлсэн мэдээ болон Рашид ад-диний "Хабул хааны намтар цадиг их бөгөөд тэрвээр монгол аймгийнхан дотроо ихээхэн нэр хүндтэй, тэрвээр өөрийн аймгийн хийгээд бусад дагагсдын эзэн бөгөөд тэргүүн байвай."[20] гэж бичсэн хоёр

1 *Ч.Далай. Монголын түүх. Хамаг Монгол улс (1101-1206). УБ., 1996*
2 *"Хамаг Монгол улс" хэмээх нэрийг доктор Ж.Гэрэлбадрах "Монгол улс" гэж нэрлэх санал гаргасан.*
3 *Монгол улсын түүх. Дэд боть. УБ., 2003. т.54*
4 *А.Амар. Монголын товч түүх. УБ., 1989. т.97*
5 *Д.Гонгор. Халх товчоон. I. УБ., 1970. т.72*
6 *Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ., 1991. т.22*
7 *Ч.Далай. Их Монгол улс. УБ., 2006*
8 *Сүрбадрах. Монгол үндэстний уг гарлын тухай шинээр судлах нь. Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан. №1. Хөх хот. т.90*
9 *Р.Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. УБ., 2006. т.39*
10 *Н.Ишжамц. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 2002*
11 *Ж.Гэрэлбадрах. "Qamuq Mogyol" улсын нэр мөн үү. УБ., 2006. т.124*
12 *А.Амар. Монголын товч түүх. УБ., 1989. т.97*
13 *Д.Гонгор. Халх товчоон. I. УБ., 1970. т.72*
14 *Ч.Далай. Их Монгол улс. УБ., 2006. т.85*
15 *Ч.Далай. Их Монгол улс. УБ., 2006. т.87*
16 *Р.Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. УБ., 2006. т.39*
17 *Н.Ишжамц. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 2002. т.38*
18 *Ж.Гэрэлбадрах. "Qamuq Mongyol" улсын нэр мөн үү. УБ., 2006. т.124*
19 *Index to The Secret history of the Mongols. by the Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.22*
20 *Рашид ад-дин. Шаштирийн чуулган. Англи хэлнээс орчуулсан Г.Аким. Тэргүүн боть. УБ., 2013. т.193*

мэдээ юм. Энд Хабул хаан бүх, нийт Монголыг захирч байв хэмээн өгүүлснээс биш гурван голын монголчуудыг нэгтгэж, Монгол улсыг байгуулж, анхны хаан болов гэж бичээгүй байна.

"МНТ"-ы мэдээ болон Рашид ад-дины бичсэнийг няцаалж үзэхэд Монгол улс Хабул хаан болсон 1130-аад оноос өмнө байгуулагдсан гэдэг нь илт байна. Хабул хаан 1130 онд Монгол улсын язгууртны хурлаар хаан[21] сонгогдсоныхоо дараа улсаа баруун, зүүн жигүүр, төв гэсэн гурван хэсэгт хувааж, цэрэг-засаг захиргааны байгууламжаа шинэчлэн, түшмэдийн ёсыг төлөвшүүлэх (баруун, зүүн жигүүр, төвийн хэсгийн захирагчид) зэрэг засаг захиргааны өөрчлөлт, шинэчлэлийг хийжээ. Мөн Монгол улсын улс төрийн төвийг Хэрлэн голын хойд биед орших A'uruγ* (Ауруг) ордыг[22] байгуулж, улсаа улам бүр хүчирхэг болгосныг "МНТ"-ы зохиогч тодотгон бичсэн ажээ. Хабул хаан засаг захиргааны шинэчлэлийг өвөг эцэг Хайду хааны үед байгуулагдсан улсдаа хийжээ.

Хабул хааны үеийн Монгол улс 1135 он гэхэд тухайн үеийн Монголын бага, жижиг улсуудаас товойн ялгарч байсныг Зүрчидийн Алтан улс аргагүй эрхэнд хүлээн зөвшөөрч, хаан Хабулыг төрийн айлчлал хийхийг урьжээ.[23] Энэ бол Монгол улс Хабул хаанаас өмнө байгуулагдсан болохыг илтгэж буй баримт байна.

Монгол улсыг Хабул хаан байгуулсан хэмээвэл тэрээр 1130 онд хаан суусан билээ. Зүрчидийн Алтан улс, байгуулагдаад тав хүрэхгүй жил болж байгаа Монгол улсыг шууд хүлээн зөвшөөрч,хааныг нь төрийн айлчлал хийхийг урьсан байх үндэслэл багатай юм. Харин Зүрчидийн Алтан улс,Хабул хааныг төрийн айлчлал хийхийг урьж байсан[24] нь энэ үедМонгол улс зарим талаар Зүрчидийн Алтан улстай эн тэнцэхүйц хүчирхэг улс болсныг харуулж буй түүхэн баримт юм.

Хабул хаан, Алтан улсад айлчилж очин хааны ордонд нь найрлаж байгаад,"Алтан хаан руу алгаа ташин,бүжиглэж очоод,Алтан хааны сахлаас нь зүрхтэйгээр дуггарч орхивой. [Алтан хааны] жанжид,торгон цэргүүдтүүний тэгэж адарч,наргиан хийхийг хараад, "Манай хааныг басамжиллаа" хэмээн түүнрүү бүчин дайрсанд тэрвээр Алтан хааны инээн баясч буйг үзэхдээ урагшлан давшин өгүүлрүүн:"Хэтнүүрэмгий авирлаж адрав,би. Алтан хаан намайг шийтгэнэ үү, өршөөнө үү түүний дур болой. Би өөрийгөө хамгаалах чадалгүй баймуй. Нэгэнт хийснийг яалтай билээ" гэжүхүй. Алтан хаан сийрэгхэн ухаалаг хаан байсан тул Хабулыг овог аймаг, дагасан харьяат олонтойг мэдэж байвай. Хэрэв энэ ялигүй юмны төлөө түүнийг алчих юм бол хамаатан садан нь орыг нь авах гэж өширхөн босоод,нэхэл хатуутайгаар дайн тулааныг хийх болно гэж тэр хаан дор нь ухажхуй. Алтан хаан ууpаа дарж,[Хабул хааны авирыг] тоглоом наадам болгон өнгөрөөж, амийг нь хэлтэрүүлсэн авай. Тэрвээр сангаасаа алт эрдэнэс, торго дурдан өч төчнөөнийг гаргуулж, Хабул хааны нуруутай чацуу овоолоод, бүгдийг түүнд өгөн, ёслол төгөлдөр буцаажхуй."[25] гэжээ. Энэ бол Хабул хааны үеийн Монгол улс үнэхээр цэргийн хүчээрээ Зүрчидийн Алтан улстай эн тэнцэхүйц хүчирхэг улс болсныг давхар нотлож буй баримт юм. Монгол улс 1130-аад онд байгуулагдсан бол 1135 онд Зүрчидийн Алтан улс Хабул хааныг төрийн айлчлал хийхийг урихгүй байв. Айлчлалын үеэр Хабул хаан, Алтан улсын хааны сахлаас нь татаж,доромжлож чадахгүй байсан бизээ.

Хабул хаан өвөг хаадын төр ёсны уламжлалд тулгуурлан Монгол улсыг Зүрчидийн Алтан улстай эн тэнцүү хүчирхэг улс болгосон бодит байдал ийм байсаар атал Хабул хаан Монгол улсын хаан болсон 1130 оныг Монгол улс байгуулагдсан он хэмээн үзсээр иржээ.

Умард Хятад, өмнөд Монголоор оршиж байсан Хятан улсын манж хэлээр бичсэн түүхэнд Зүрчидийн Алтан улс, Өмнөд Сүн улстай хүч хавсран Хятан улс руу довтолоход 1122 онд Монгол улсаас цэргийн тусламж хүссэнд Монгол улс таван түмэн цэргээр тусласан тухай тэмдэглэсэн байдаг. Түүнд "mongγo gurun-i sunja tumen ĉooha-de aĉafi"[26](Монгол улсын таван түмэн цэрэгт нийлж), "mongγo gurun-i ĉooha-de γaifi dailame"[27](Монгол улсын цэргийг авч дайлах) гэх зэргээр "Монгол улс" гэж өгүүлжээ. Хабул хааныг хаан болохоос өмнө 1122 он гэхэд Монгол улс таван түмэн цэрэг гаргаж хөрш улсдаа туслах хэмжээний хүчирхэг улс байжээ. Энэ таван түмэн цэрэг бол Монгол улсаас Хятан улсад тусласан цэрэг бөгөөд Монгол улс бүх цэргээ Хятан улсад тусалуулахаар илгээгээгүй нь тодорхой юм. Тиймээс Хабул хаанаас өмнө

21 *Ж.Гэрэлбадрах. Монгол улсын Дээд, Доод хурал. УБ., 2011. т.7*

22 *Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг, дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006. т.44*

23 *Рашид ад-дин. Шаштирийн чуулган. Англи хэлнээс орчуулсан Г.Аким. Тэргүүн боть. УБ., 2013. т.193-194*

24 *Рашид ад-дин. Шаштирийн чуулган. Англи хэлнээс орчуулсан Г.Аким. Тэргүүн боть. УБ., 2013. т.193*

25 *Рашид ад-дин. Шаштирийн чуулган. Англи хэлнээс орчуулсан Г.Аким. Тэргүүн боть. УБ., 2013. т.193-194*

26 *Dailiyoo gurun-i suduri. ИхЛяо улсын судар. 8-р дэвтэр. УТНС. ГБС*

27 *Dailiyoo gurun-i suduri. ИхЛяо улсын судар. 8-р дэвтэр. УТНС. ГБС*

"Монгол улс" байгуулагдсан байсныг Их Ляо улсын сударт тэмдэглэн үлдээсэн байна. Учир иймийн тул Хабул хаан, Монгол улсын дөтгөөр хаан байсан гэж үзэх бүрэн үндэслэл байна.

Доктор Ж.Гэрэлбадрах "Монголын анхны хаан Хабулыг язгууртны хурлаас сонгосон"[28] гэж үзжээ. Хабул хаан,Монгол улсыг байгуулсан гэхүл язгууртны хурлаас бус өөрөө хурлыг хуралдуулж, Монгол улсыг байгуулсныг албан ёсоор зарлан тунхаглах байв. Хабул хааныг сонгох хуралд Монгол улсын "язгууртнуудын дийлэнх нь"[29] оролцсон ажээ.

Хабул хаанаас өмнө Монгол улсад хааны угсаа залгамжлах нарийн ёс тогтож,төрийн тогтолцоо хэлбэршин тогтсон байсан нь тодорхой байна. Хабул хаан, Тайчуудын Амбагайг хаан болгохоор гэрээслэн үлдээхэд, Монгол улсын язгууртнууд, түүнийг Хабул хааны нэгэн адил язгууртны хурлаас хаанаар сонгосон ажээ. Энэ үеийн Монгол улсад эртний Монгол улс (Хүннү, Сяньби, Жужан)-уудын нэгэн адил хааныг язгууртны хурлаас сонгох ёс нарийн тогтсон байжээ.

Хабул хаан нас барахынхаа өмнө хаан ширээг залгамжлагчийг гэрээслэн үлдээсэн тухай "МНТ"-д "qabul qahan-nu qoyina qabul-qahan-nu ьge-ber dolo'an kцd'ьd-iyen bцd'getele senggьm-bilge-yin kцd'ьn ambagai-qahan qamuq mongqol-i meden aba"[30](Хабул хааны хойно Хабул хааны үгээр долоон хөвүүнээ бөгөөтөл Сэнгүм билгийн хөвүүн Амбагай хаан хамаг Монголыг мэдэн авай)хэмээн өгүүлдэг. Хабул хааны төрийн айлчлалынхаа дараа Зүрчидийн Алтан улсыг олон удаа довтолж, умард хилийн 27 цайзыг эзлэн авч, Алтан улсын их цэргийг олон удаа бут цохиж байсан[31] байдаг. Тиймээс Монгол улс, Зүрчидийн Алтан улс хоёрын түр зуурын найрсаг харилцаа тасарч,дайны байдалтай болжээ. Иймд Хабул хаан нөхцөл байдлыг харгалзан, өөрийн хөвүүдээс бус Тайчуудын Сэнгүм Билгэ-гийн хөвүүн Амбагайг хаан болгохоор гэрээслэн үлдээсэн бололтой. Энэ үед Тайчууд аймаг, Нирун-Хияд аймагтай эн тэнцүү хүчирхэг аймаг байсан учир Хабул хаан Монгол улсын эв нэгдлийн хадгалж, үлдэхийг илүү чухалчилж, Тайчуудын Амбагайг хаан болгохоор гэрээслэн захисан байна. Хабул хаан өөрийн хөвүүдээс хаан ширээг залгамжлах хүнийг гэрээслэн үлдээгүй нь Зүрчидийн Алтан улстай дайтаж байсантай холбоотой юм.

Хабул хаан Монгол улсын анхны хаан бус харин Монгол улсыг өвөг хаадаасаа илүү хүчирхэг Зүрчидийн Алтан улстай энэ тэнцүү хүчирхэг улс болгосон дөтгөөр хаан байсан гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Монгол улсын түүх. Дэд боть. УБ.,2003
2. Монголын нууц товчоо. Шинээр хөрвүүлж, тайлбар үйлдсэн Ш.Чоймаа. УБ.,2011
3. Рашид ад-дин. Шаштирийн чуулган. Англи хэлнээс орчуулсан Г.Аким. тэргүүн боть. УБ., 2013
4. Лувсандан. Алтан товч. Шинээр орчуулж, тайлбар үйлдсэн Д.Пүрэвдорж. УБ.,2009
5. Dailiyoo gurun-i suduri. ИхЛяо улсын судар. 8-р дэвтэр. YTHC.ГБС
6. Х.Пэрлээ. Монгол Ардулсын дундад үеийн хот суурины товчоон. УБ.,1961
7. Х.Пэрлээ. Чингисийн чулууны бичиг. Гурван өгүүлэл. УБ.,1962
8. Д.Гонгор. Халх товчоон. I. УБ.,1970
9. А.Амар. Монголын товч түүх. УБ.,1989
10. Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ.,1991
11. М.Санждорж. Монгол төрийн түүхээс. УБ., 1998
12. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр,гүн ухааны сэтгэлгээ. УБ.,2002
13. Н.Ишжамц. Монголднэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ.,2002.
14. Р.Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. УБ.,2004
15. Монгол улсын төр эрх зүйн түүх. Тэргүүн боть. УБ.,2005
16. Ч.Далай. Их Монгол улс. УБ.,2006
17. Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг, дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ.,2006
18. Ж.Гэрэлбадрах. "Qamuγ Mongγol" улсын нэр мөн үү? УБ.,2006
19. Ж.Гэрэлбадрах. Монгол улсын дээд, доод хурал. УБ.,2011
20. Монголын түүхийн үечлэл. Эрхэлсэн Ж.Гэрэлбадрах. УБ.,2014
21. Сүрбадрах. Монгол үндэстний уг гарлын тухай шинээр судлах нь. Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан. №1. Хөх хот
22. Index to The Secret history of the Mongols. by the Igor de Rachewiltz. Bloomington. 1972.
23. Acta historica. Tomus XIV. УБ.,2013
24. Acta historica. Tomus XV. УБ.,2014

28 *Ж.Гэрэлбадрах. Монгол улсын дээд, доод хурал. УБ., 2011. т.7*

29 *Ж.Гэрэлбадрах. Qamuγ Mongγol улсын нэр мөн үү? УБ., 2006. т.90*

30 *Index to The Secret history of the Mongols. by the Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.22*

31 *Рашид ад-дин. Шаштирийн чуулган. Англи хэлнээс орчуулсан Г.Аким. Тэргүүн боть. УБ., 2013. т.196*

БОЛОВСРОЛ СУДЛАЛ, ХЭЛ ШИНЖЛЭЛ

СУРГАЛТЫН ОРЧИН ДАХЬ БАГШ НАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Л.Баттогтох
Их Засаг МСҮТ-ийн хими, биологийн багш

Түлхүүр үг: Багшийн хөгжлийн хөшүүрэг-хамт олон

Хураангуй: Нийгэм болон хувь хүн тогтвортой хөгжих эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн боловсролын чанарҗйлчилгээндгавигдахшаардлагыг дэлхийн хөгжлийн чиг хандлагад баримжаалж, үндэсний соёлын дэвшилтэт уламжлалыг дээдлэн, онол, практикийн шинэлэг үзэл санааг тусган шинэчлэх,түүнийг хэрэгжүүлэхдээ хүүхэд нэг бүрт тохирсон сургалтын арга,технологийг боловсруулан хичээл, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь боловсролын байгууллага бүрийн өмнө тавигдаж байгаа хариуцлага,шаардлага болжээ.

Нэг. Онолын үндэслэл

Боловсролтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ. Бага ангийн боловсрол ч эзэмшээгүй хэрнээ хоёр гурван их,дээд сургуулийн диплом өвөртөлсөн нөхдөөс илүү сайн ажил хийж,сайхан амьдарч яваа хүн олон. Тэгвэл боловсрол гэж чухам юу вэ гэсэн асуулт урган гарч байна. Энэ нь нөхцөл байдалд дүгнэлт хийж, зөв шийдвэр гаргах чадвар юм. Ер нь боловсролын зорилго бол эцсийн дүндээ хүн аз жаргалтай амьдрахад л чиглэнэ. Энэ зорилго хэрэгжихгүй бол улс орны эдийн засаг өсөхгүй, улс орон хөгжихгүй. Хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын зорилго нь сурагчдад бие дааж суралцах, ажиллаж амьдрах арга чадвар эзэмшүүлэх, тэдэнд мэдлэг чадвараа өөрөө дээшлүүлж, өөрийгөө бүх талаар хөгжүүлэх, хурдацтай өөрчлөгдөж буй орчиндоо дасан зохицох,шинийг хүлээн авах,хийж бүтээх, өрсөлдөх чадвартай хүнийг төлөвшүүлэх явдал юм. Энэ зорилгыг хангахын тулд тодорхой жорыг тохируулсан хичээлийн нарийн төлөвлөлт хийх хэрэгтэй ба төлөвлөлт нь хүний сэтгэн бодох, танин мэдэхүйн үйлдлийг системчлэх загварчлал, нөгөө талаасаа хүнийг хүн болгон төлөвшүүлэх өвөрмөц урлаг юм. Энэ утгаараа эзэлжит хичээлийн төлөвлөлт дээр маш их анхаарах ёстой.

Сэтгэл судлаач А.Адлерийн “Хүн бол мөн чанарын хувьд- аас+рүү,төгс бусаас төгс рүү дэгжин дээшлэх гэсэн аугаа их хэрэгцээг илтгэж байдаг” гэжээ. Үүнээс үзэхэд багшийн хөгжил бие сэтгэхүйн болоод бүтээгч үйлээр тасралтгүй явагдах ахиц дэвшил байх ёстой.

1. Ахмад багш нартай хамтран ажиллах

Ахмад багш нарт өөрийн гэсэн тогтсон арга барил, хэв маяг байдаг. Бид өөрийн эргэн тойронд байгаа боломж бололцоог ашиглах, харах билгийн нүд муутай байна.

Ажилласан жилийн дадлага туршлага нь залуу багш нартай харьцуулахад илүү бөгөөд ахмад багш нар гарын авлага ном зохиох, олимпиадад хүүхдүүд бэлтгэх, залуу багш нарын номыг редакторлах, боловсролын заах аргазүйг сайжруулахад өөрийн туршлагаа хуваалцан туслах, хүүхэд эх хэл,монгол ёс заншлаа хадгалж,хамгаалж өвлүүлэн үлдээхэд санаачлагатай оролцох зэрэг нэлээд туршлагжсан байдаг. Иймд залуу багш нар ахмад багш нартай хамтран ажиллаж тэднээс суралцах шаардлагатай.


2. Хамт олны хөгжих бусад багш нартаа хамтран ажиллах

Багш заах аргын нэгдэл, тэнхимийн багш нар, мэргэжил нэгт багш нартай хамтран сургалтын хөтөлбөр боловсруулах, ээлжит хичээлд бэлдэх,хичээлийн судалгаа хийснээр бие биенээсээ суралцаж хөгжих боломжтой байдаг.


Хоёр. Судалгаа, цаашид анхаарах зүйл

Сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх нь ажлын байран дээрээ хөгжих,хөгжиж буй явцаас шалтгаалах тул багш нарын хамтын ажиллагаа,бие биедээ өгч буй дадлага туршлага болон хамтын ажиллагааны одоогийн нөхцөл байдлын талаар хийсэн судалгааны дүнг танилцуулъя.

Ажлын байран дахь багшийн хөгжил гэж юу вэ таны бодлоор?



Багш та ахмад багш болон бусад багш нараас ямар зөвлөгөө туслалцаа авч байсан бэ?



Зөвхөн энэ 2 судалгаан дээр дүгнэж үзэхэд багш нар ажлын байран дээр хөгжих арга зам гэж юу болох, хэрхэн яаж хамтран ажиллах хөгжих вэ? гэдэг мэдлэг дутмаг байгаа нь ажиглагдаж байна,

САНАЛ

Тулгамдсан бэрхшээлийг даван туулахын тулд:

1. Ээлжит хичээл, үйл ажиллагаа нь хүүхэд бүрийг хөгжүүлэх боломжитарга зүй бөгөөд үүнийг хэрхэн яаж чанартай төлөвлөж хийх арга туршлага ажлын байран дээрээ ахмад багш нараасаа суралцах, дотоод нөөц бололцоог судлах
2. Ахмад багш нар залуу багштай хамтарч ажиллах нөөц боломжийг судлах, бий болгох
3. Хичээлийн жилийн эхэнд багш нарын хөгжих хэрэгцээ шаардлагын судалгаа авч төлөвлөгөө гарган ажиллах
4. Ямар ч мэргэжлийн багш сонголттойгоор хичээлийн арга зүй, загвар, ажлын хуудас авч ашиглах нөхцөлийг бүрдүүлэх

ДҮГНЭЛТ

XXI зуун бол хөгжил цэцэглэлтийн зуун юм. Энэ зуунд боловсролын бүтээмжийг дээшлүүлж багшийн хөгжил рүү хандсан бодлогыг түлхүү хэрэгжүүлэх нь зөв юм. Өнөөгийн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтууд ихэвчлэн багш руу биш санхүү рүү чиглэсэн, чанар өгөөж муутай байх явдал ажиглагддаг. Үүнээс үүдэн багш нар сургууль дээрээ бусдаас туслалцаа авахгүйгээр өөрөө өөрийгөө хөгжүүлэх чиглэл илүү давамгайлж байна.

Ном зүй:

1. Жадамбаа Б. Сургуулийн хөгжлийн онол практикийн зарим асуудал. УБ 2008.
2. Монхор Д. Дамдинсүрэн Б. Дорж П. Сургалтын технологийн онол, арга зүйн зарим асуудлууд. УБ 1997.
3. Багшийн гарын авлага МУБИС УБ 2012 он
4. Хичээлийн технологийн шинэчлэл ... УБ 2019 он

БАГШИЙН ХӨГЖИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

А.Бибиш
Их Засаг ОУИС-ийн СЭЗС-ийн багш, магистр

Д.Элбэгзаяа
Их Засаг ОУИС-ийн СЭЗС-ийн багш, магистр

Судалгааны үндэслэл: Хувь хүний хөгжлөөс өрх гэрийн болон улс эх орны хөгжил хамаардаг болсон өнөө үед үүний гол хөдөлгөгч хүч болсон багшийн хөгжлийн тухай асуудал манай улс төдийгүй дэлхий нийтийн нэн тэргүүний тулгамдсан асуудал болоод байна. Иймд багшийн хөгжил багш ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх, хамт олон дунд нь тэдний дэмжлэгээр хөгжих арга зам боломж байгаа эсэхийг судлах өнөөгийн багш нарын хөгжил хэрхэн явагдаж байгаад дүн шинжилгээ хийх багш хөгжихөд юу саад болж байгааг тодорхойлоход тус дөхөм болох үүднээс энэхүү сэдвийг сонголоо.

Судалгааны зорилго: Багшийн хөгжил, багшийн хөгжих арга зам, багш өөрийгөө хөгжүүлэхэдбусдын дэмжлэг туслалцаа,боломжийг судалж дүн шинжилгээ хийх

Судалгааны зорилт: Багш ажлын байрандаа хамт олныхоо тусламжтайгаар өөрийгөө хөгжүүлэх боломжийг авч үзэх,судлах * Багш нар хэрхэн хөгжиж байгаа болон тэдний хөгжихөд юу саад болж байгааг судлах

Судалгааны обьект: Чингис Соосэ цогцолборын 60 багшаас судалгааг авсан.

Судалгааны аргууд Эх зохиол судлах, цуглуулсан баримт бичиг боловсруулалт хийх арга баримт бичгийн шинжилгээ, нэгтгэн дүгнэх, Анкет судалгаа авах

Судалгааны ач холбогдол: Уг судалгааны ажил нь багш ажлын байрандаа хэрхэн хөгжих нөхцөл боломж байгаа эсэхийг судлан илрүүлхэд оршино.

Нэгдүгээр бүлэг: ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Багшийн хөгжил

Өнөө үед багш гэдэг бол өсвөр залуу үеийнхэндамьдралднь хэрэгтэй мэдлэг чадвар олгох, тэднийг бие хүн болгон хүмүүжүүлж төлөвшүүлэх, амьдрах арга ухаан олгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй хийх мэргэжлийн ур чадвартай хүн юм.Боловсролын салбарын бүх шатны байгууллагын үр нөлөө, ашигтай үйл ажиллагаа явуулах гол нөөц нь өндөр мэдлэгтэй, чадварлаг багш бөгөөд гадаад дотоод орчны байнгын өөрчлөлт нь багш нараас цаг үргэлжид өөрчлөгдөн хөгжиж байхыг шаардаж байна.

Багшийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйл:

- ✓ Сурах таатай боломж
- ✓ Сурах хүсэл тэмүүлэл гэсэн 2 үндсэн хүчин зүйлтэй.


Таатай орчин Сонирхол хүсэл тэмүүлэл /Схем 1. Боловсролын таатай орчинг:



схем 2 / Боловсрол мэдээлэл- 2001. 64 дахь тал /

схем 2 /Боловсрол мэдээлэл- 2001. 64 дахь тал/

2001 оны багш нарын бага хурлаас дараах гурван үзэл баримтлалыг гаргасан байна.



1.2. Багш хөгжих арга зам: Өнөө үед багш мэдлэг, чадвараа үргэлж дээшлүүлж, сурган хүмүүжүүлэх арга барил,ур чадвараа боловсронгуй болгож,сурган хүмүүжүүлэх сэтгэлгээгээ шинэчлэх шаардлагатай болсон. Үүнтэй холбогдон дараах хэрэгцээ гарч байна.

- Нийгмийн хэрэгцээ:Шинжлэх ухаан техникийн хөгжил,өндөр мэдлэг чадвартай боловсон хүчин бэлтгэх шаардлагатай байна.
- Нэр хүндээ өсгөх,албан тушаал ахих,ашиг орлогоо дээшлүүлэх хэрэгцээ:
- Багшийг хөгжүүлэх арга хэмжээ нь багш нарын болон сургуулийн эрэлт хэрэгцээ байх.
- Багшийг хөгжүүлэх явдлыг үр ашиг, нөлөөтэй болгохын тулд бүх нөөц бололцоогоо ашиглах
- Багшийн хөгжил нь урамшуулан дэмжихийг шаардаж байх.

Багш сургалтанд хамрагдсанаар шинэ мэдлэг олж авах, түүнийгээ ажилдаа хэрэглэх, ур чадвараа дээшлүүлэх боломж болно. Гэвч багшийг хөгжүүлэх арга замыг дан ганц сургалт гэж үзэж болохгүй. Тэрчлэн судалгаа хийх, илтгэл бичих, ном бүтээл туурвих, хурал семинар дадлага зохион байгуулах, туршилт хийх зэрэг нь хөгжүүлэх арга зам юм.


Багш ажлын байрандаа бусдын дэмжлэгээр өөрийгөө хөгжүүлэх нь

Өнөө үед нийгмийн амьдрал эрчимтэй өөрчлөгдөхийн зэрэгцээ хүүхдийн эрэлт хэрэгцээ, сонирхол улам их өөрчлөгдөх боллоо.Эдгээрийг багш байнга мэдэрч сурган хүмүүжүүлэх ажлаа зохицуулан өөрчилж боловсронгуй болгох чадвартай байх ёстой. Үүний тулд багш шинэ үзэл санаа арга барилыг эрэн хайж сурч мэдэх, нээн гаргах хэрэгтэй болдог.

Хоёрдугаар бүлэг. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1. Багш хөгжих шаардлагатай юу?, Багш өнөөдөр хэрхэн хөгжиж байна вэ?


Орчин үед багш бол "Мөнхийн сурагч" тэрээр өөрөө болон бусдаас байнгын суралцагч байх шаардлагатай байна. Багш бусадбагш нараас, сурагчдаас, эцэг эхээс, ном сонин сэтгүүл, радио телевиз зэргээс суралцаж байх хэрэгтэй. Ер нь өнөө үед багшид өөрийгөө хөгжүүлэх нөөц боломж байгаа ба энэ нь гагцхүү багшийн идэвх зүтгэл, бүтээлч байдал,хүсэл тэмүүлэл,итгэл үнэмшлээс их шалтгаална. Сурган хүмүүжүүлэх ёс зүй бол багш биеэ авч явах, хүүхэдтэй харьцах харьцааг хэрхэн зохицуулахад чиглэл болох үүрэг бүхий норм, хэм хэмжээний систем юм. Энэ нь ёс зүйн тухай мэдлэг, итгэл үнэмшил, эв дүй, ур чадвар,хэвшил зэргээс бүрддэг. Судлаач И.И.Чернокозовын судалснаар багшийн ёс зүйд:



- Багш та хаанаас их мэдээлэл авдаг вэ? гэсэн санал асуулгад 62 % нь Сургуулиас зохион байгуулж байгаас ургалтсеминариас, 13 % нь албан бус сургалтаас, 25% нь өөрөө олж мэддэг гэсэн байна.Багш шинэ мэдээллийг мэргэжлийн сэтгүүл,ном зохиолоос олж судлах, мэргэжлийн курс, семинар, хэлний дамжаанд суралцах, бусад багш нарын туршлага судлах, хичээлдээ шүүмжлэлтэй хандах, бусдын шүүмжлэлд анхааралтай байх, бага дунд төсөлд орох хэрэгжүүлэх замаар олж авах юм.

2.2. Багш бусадтай хамтран, бусдын дэмжлэгээр хөгжих арга зам, боломж

Багш та бие даан өөрийгөө хөгжүүлж чадаж байна гэж үздэг үү? гэсэн санал асуулгад




Судалгаанд хамрагдсан 12% нь тийм, 28% үгүй, 28,4% нь бага зэрэг, 31,6% нь мэдэхгүй гэсэн хариулт өгснөөс харахад **Багш хөгжих. хамтран хөгжих** нь өнөөгийн эрэлт хэрэгцээ болсон гэдгийг ухаараагүй,сайн ойлгоогүй байгааг харуулж байна..Багш дан ганцаараа өөрөө бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэн хөгжинө гэдэг нь өрөөсгөл ойлголт юм. Сургуульд багш нарын бүтээлч хамтлаг байгуулан ажиллах нь багш хөгжихөд чухал байр суурь эзэлдэг. Багш хамтран хөгжихөд тэнхимийн зүгээс:


- Төлөвлөгөөтэй, тасралтгүй, үр дүнтэй ажлаа явуулах
- Багш бүрийг татан оролцуулж байх
- Багш бүрийн нийгмийн асуудлыг мэддэг байх
- Хийсэн ажлынхаа үр дүнг тооцдог байх хэрэгтэй.

2.3. Багш өөрийгөө хөгжүүлэхэд юу саад болж байна вэ?

Багш өөрийгөө хөгжүүлэхийн эхлэл нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа бүтээлчээр хандах буюу өөрийнхөө нөөц боломжийг ашиглах явдал юм.

Багш ажлын байрандаа бусадтай хамтран хөгжихөд юу саад болж байна вэ?







Багш та ажлын байрандаа бусадтай хамтран хөгжихөд юу саад болж байна вэ? гэсэн санал асуулга авахад:

- Багшийн цалин бага— 98%
- Багшийн нийгмийн асуудал шийдэгдээгүй- 90%
- Сургуулиас үзүүлэх тусламж бага- 36,3%
- Багшийн ажлыг муу үнэлдэг- 86%
- Багшийн хөгжих цагийн боломжийг сургууль бүрдүүлж өгдөггүй — 54 %
- Хэдий чинээ саадбэрхшээл байвч багш хүн мэргэжлийнхээ онцлог үүрэг, хариуцлагаа ухамсарлан, өөрийгөө тасралтгүй хөгжүүлж сэтгэлгээнийхээ хүрээг байнга тэлж, шинэчилж өөрчилж байх нь багш хүний өнөөгийн хандлага юм.

ДҮГНЭЛТ

Улс орны хөгжил боловсролын хөгжлөөс, боловсролын хөгжил сургуулийн хөгжлөөс, сургуулийн хөгжил багшийн хөгжлөөс шалтгаалдаг учир юуны өмнө багш нарын ажиллах сурах хүсэл тэмүүллийг дэмжих, урамшуулах тодорхой зорилго, зорилттой байж хамтран ажиллах чадвартай хамт олныг бүрдүүлэх бодлого барих нь чухал байна. Багш нар өөрийн бүтээлч хүчээ чөлөөтэй дайчлан хөгжүүлэх бүрэн боломжтой ба тийм орчныг бий болгосноор сургууль багш хөгжих юм. Боловсролын тогтолцоог боловсронгуй болгохын тухайд гоёмсог сайхан мэргэн цэцэн ярианууддаас ерийн тодорхой ажилд шилжих, боловсрол улс орны тэргүүлэх чиглэл гэдгийг амьдралд бодитойгоор үзүүлэх цаг нэгэнт болсон байна.

Багшийг хөгжүүлэх талаар сүүлийн жилүүдэдгадаад дотоодын олон төсөл хэргэжүүлсэн, сургуулиуд компьютер, интернеттэй болсон, багш нар гадаад хэл сурацах, өөрийгөө хөгжүүлэх хүсэл тэмүүлэлтэй болсон, гарын авлага ном сурах олноор гардаг болсон, сургалт семинарууд явагдаж байгаа зэрэг олон сайшаалтай ажлууд хийгдэж байна. Мөн багш нарт орон сууц хуваарилах, нийгмийн асуудлыг нь шийдэх, шагнах урамшуулах, хөдөлмөрийг нь үнэлэх ажлууд төр засгийн зүгээс маш хангалттүй хийгддэг. Багш мэргэжлийг хүндэтгэн багшийн хөдөлмөрийг зөв үнэлэхийн тулд багшийн мэргэжлийн онцлогийг мэдрэх, ойлгох шаардлагатай байна.

Дундаж сурлагатай сурагч дундаж оюутан болно. Дундаж оюутан дундаж чадвартай багш болно. Иймд чадвартай багшаас мөн тийм л хэмжээний шавь төрнө. Судалгааны явцаас үзэхэд багшийг хөгжүүлэхийн тулд дараах зүйлүүдийг анхаарах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

1. Багшийн ажлын үнэлэмжийг сайжруулах
2. Багшийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, хөгжих цагийн боломжийг гаргах
3. Багшийг хөгжүүлэх, хөгжихөд нь туслах, ойрын ба хэтийн төлөвлөгөө боловсруулах
4. Багш нарыг хамтарч ажлаа төлөвлөх, гүйцэтгэх, мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах, заах аргын нэгдэл, секцээрээ хамтран ажиллах нөхцөл боломж гаргаж өгөх, зэрэг бүтээлч ажлууд явуулах үр дүнг нь тооцох, хянах, урамшуулах шаардлагатай байна

Ашигласан материал

1. Ш.Ичинхорлоо С.Цэнд "Сурган хүмүүжүүлэх зүйн ерөнхий үндэс"
2. Д.Ванчигсүрэн "Сурган хүмүүжүүлэх технологи"
3. Ш.Ичинхорлоо "Судалгааны аяллын үндэс"
4. Ч.Лхагважав, Н.Нэргүй "Багш хөгжлийн чиг хандлага"
5. "Багш боловсролын хөгжил, шинэчлэл" илтгэлийн эмхтгэл
6. "Багшийн хөгжил" сэтгүүл

"БАГШ НАРЫН СЭТГЭЛГЭЭГ ШИНЭЧЛЭХЭД АХМАД БАГШ НАРЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО"

В.Мандухайцэцэг
Их Засаг МСҮТ-ийн МХУЗ-ын багш, заах аргач

Хураангуй: *Багшийн хөгжил нь боловсролын салбарын болон тухайн байгууллагын өөрчлөлт шинэчлэлтийн цэнэс юм. Учир нь улс орны хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь боловсролын байгууллага бөгөөд энэ ч утгаараа манай улс боловсролын салбараа "тэргүүлэх салбар" хэмээн зарласан. Тэгвэл Монгол улсын хөгжил нь боловсролын салбарын хөгжлөөс буюу хүний хөгжлөөс, боловсролын салбарын хөгжил нь боловсролын байгууллагаас, байгууллагын хөгжил нь багш сурган хүмүүжүүлэгчдээс хамааралтай байх нь тодорхой юм. Боловсролын шинэчлэлийн алхам тутамд ил тод болж байгаа нэг зүйл бол багшаа хөгжүүлж өөрчлөхгүйгээр боловсролын шинэчлэл амжилттай явагдахгүйг нийгэм цаг цэ бидэнд мэдрүүлж байна. Ер нь хүний хөгжлийн асуудлыг бие, сэтгэл, оюуны хөгжлийн нэгдэл дунд нь цогцоор авч үзэж байж л жинхэнэ утгаараа хэрэгждэг бөгөөд манай багш нарын хувьд мэдлэг боловсролоор нэг их гологддогүй бөгөөд сэтгэлийн боловсрол дутмаг байгаа нь багшийн хөгжлийн гол асуудал юм. Ийм учраас багш нарын амжилттай хөгжих эх цндэс нь сэтгэлийн боловсрол буюу багшийн сэтгэлгээний шинэчлэл юм.*

Түлхүүр үг: Багшийн хөгжил, сэтгэлийн боловсрол, сэтгэлгээний шинэчлэл, боловсролын шинэчлэл

Үндсэн хэсэг: Багшийн хөгжлийн асуудал нь багш бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоон дахь тасралтгүй үйл явц юм . Монгол улсын засгийн газраас баталсан "Бага дунд боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр" т тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон ажлуудыг төлөвлөөд байна.

Багшийг хөгжүүлэх үйл явцын хэрэгцээ, шаардлага, арга замыг 4 түвшинд тодорхойлж байна.

1/. Шинэчлэлийн бодлогын гол агуулга, зарчим болон тавигдаж байгаа хэрэгцээ шаардлагын түвшинд

2/. төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутаг, бүсийн онцлогийг харгалзан бүс нутгийн түвшинд

3/. Тухайн сургууль, өсвөр үеийг нийгмийн эрэлтэд тохирсон мэдлэг боловсролтой иргэн болгон бэлтгэх үүргээ амжилттай биелүүлэхийн тулд өөрийгөө мэдлэг чадвартай боловсон хүчнээр бэхжүүлэх зорилгоор сургуулийн түвшинд

4/. Боловсролын шинэчлэл, багшийн хөгжлийг гардан хэрэгжүүлэгч багш сурган хүмүүжүүлэгчдийн түвшинд тус тус тодорхойлж байна .

Дээрх түвшин тус бүрийн хүрээнд шийдвэрлэх олон олон асуудлуудбайгаа бөгөөдүүний дотроос хамгийн чухал, хамгийн хойшлуулшгүй нь багшийн өөрийгөө хөгжүүлэх арга зам юм. Энэ тухай эрдэмтэн багш нар ингэж хэлсэн байна.

"Багш нь насан туршдаа хөгжигч юм. Багш хөгжих олон арга зам байдаг ч тэдгээрийн дотроос өөрөө өөрийгөө хөгжүүлэх шиг үр дүнг нь дор бүрд нь мэдрэх арга зам ховор "[1]

"Бурхан гагцхүү өөртөө тусладаг хүнд л тусладаг. Өөртөө туслахын ухаан бол хүмүүс өсөлт хөжилтөө шулуутгахын тулгын чулуу мөн. Хүн бүр илүү шилмэл амьдралын үзэл санааг өөртөө шингээгээгүй цагт ямарч зөв хууль тогтоолоо гэсэн хүн хувьсан өөрчлөгдөж чадахгүй .[2]

"Өөрөө өөрийгөө хөгжүүлэх хамгийн энгийн алхам бол хийж буй зүйл болгоноо чанартай хийх ба богино хугацаанд ихийг амжуулахдаа гол нь биш, цөөхөн ч бай барьж авсан зүйлээ үнэн сэтгэлээсээ хийж байх нь гол юм"[3]

1 *Боловсрол судлал [21]*
2 *Самуэл Смайл [10]*
3 *Өөрийгөө хөгжүүлцгээе [11]*

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь багш мэргэжлийн

- Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг
- Арга барил
- Ур чадвар
- Үзэл бодол
- Харилцаа
- Хандлага
- Сэтгэлгээгээ бие дааж ухамсартайгаар өөрчлөн сайжруулах чиглэлтэй үйлүүд юм .

Багш хүн өөрийгөө хөгжүүлэхийн тулд яах хэрэгтэй, түүнд ямар боломж байгааг авч үзье.

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон чиглэлтэй. Үүнд:

1/. **Өөрийн суурь мэдрэмжийг хөгжүүлэх** шаардлагатай бөгөөд үүнд дараах зүйлүүд багтана.

Нийгэмд гарч буй өөрчлөлтүүдийг соргогоор мэдрэх мэдрэмж. Тухайн нийгэмд гарч буй аливаа өөрчлөлт, шинэчлэлт нь сургууль, багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд заавал нөлөөлдөг бөгөөдбагш түүнийг ажилдаа тусган ажиллаж чадвал нийгэм цаг үетэйгээ хөл нийлүүлж байх болно.

Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаанд ямар шинэ зүйл, өөрчлөлт гарч байгааг мэдэрч эдгээрт дүн шинжилгээ хийх, шинжлэх ухааны шинэ зүйлээс хэрэгтэйг нь хүлээн авах ба өөрийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлдэг байх Жишээлбэл: өнөөгийн сурган хүмүүжүүлэх ухаан буюу боловсрол судлалдгарч байгаа томоохон өөрчлөлт бол суралцагч төвтэй сургалтын үзэл санаа, конструктивист үзэл санаа дэлгэрч улмаар прагматик сургалтыг чухалчлах болсон зэрэг юм.

Багш өөрийнхөө хэлсэн үг, хийж буй үйлийн нөлөө үр дагаварыг урьдчилан тооцоолж мэдрэх мэдрэмжтэй байх

Багшид цаг хугацааны, орон зайн, гоо зүйн, ёс суртахууны гэх зэрэг олон талын мэдрэмж заавал хөгжсөн байх ёстой.

2/. Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ, сурган хүмүүжүүлэх ажилдаа хандах хандлага, харилцаа зэргээ өөрчлөх

Энэ нь маш нарийн нийлмэл ойлголт бөгөөд сурган хүмүүжүүлэх ажлын талаар багш өөрийн гэсэн үзэл санаа, итгэл үнэмшилтэй байх, сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл зүйн тогтолцоот мэдлэгтэй байх

- Мэргэжилдээ дур сонирхолтой, үнэнч байх
- Үүрэг хариуцлагаа ухамсарласан байх
- Сурган хүмүүжүүлэх ажил нь багшийн амьдралын утга учир болсон байх
- Эрэл хайгуул хийдэг, бүтээлч байх
- Аливаад шүүмжлэлтэй ханддаг байх
- Болохгүй байгаа зүйлийг хэзээ ч тэр хэвээр нь орхидоггүй, бусдад тохдоггүй байх, ямар нэг хэмжээгээр шийдэхийг эрмэлздэг байх
- Өөрийн гэсэн өнгө, дүр төрхтэй байх гэх мэт

3/. **Багш сурган хүмүүжүүлэх арга барил, ур чадвар, эв дүй, технологио шинэчлэн боловсронгуй болгох үйл ажиллагаа юм.**

Багшийн урьд өмнө хэрэглэж байсан уламжлалт сургалтын технологи нь мэдээлэл дамжуулахад чиглэдэг байсан бол суралцагч төвтэй сургалтын технологийг эзэмшин мэдлэгийг өөрсдөөр нь бүтээлгэх, өөрийн гэсэн ойлголтыг бий болгох, сургалтын идэвхитэй аргуудыг өргөн ашиглах шаардлагатай байна.

Мөн зохион байгуулах, сургах, харилцах, суралцагчийг үнэлэх зэрэг ур чадвараа байнга сайжруулж байх нь чухал юм.

4/. Багш өөрийн сурган хүмүүжүүлэх ёс зүйд байнга анхаарч байнга төгөлдөржүүлэх явдал юм.

Бодит нөхцөл байдал дээр харахад манай багш нар мэдлэг, боловсролын хувьд хэнд ч гологдохооргүй мөртлөө ёс зүйн шинжтэй алдаа гаргах нь цөөнгүй байдаг учир багшийн мэргэжлийн нэр хүндэд нөлөөлдөг.Энэ нь эргээд сургалтын чанар, хүүхдийн хөгжил, төлөвшилд сөрөг үр дагавартай юм .

"Багшийн ёс зүйн дүрэм " — ийг батлан хэрэгжүүлж байгаа нь энэ асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болсон бөгөөд эдгээр нь биелүүлэхэд тийм ч боломжгүй зүйл биш ба бусад хэн нэгнээс биш багшийн өөрийн хичээл чармайлтаас шалтгаалдаг.

5/. Багш өөрийгөө хөгжүүлэх цагийг гаргаж энэ цагаа өөртөө үр бүтээлтэй ашиглах, хөдөлмөрийн хуваариа оновчтой зохион байгуулах явдал юм .

6/. Багш хүн дан ганцаараа хүүхдийг сургаж,төлөвшүүлэх нь үр дүндхүрэхгүй бөгөөдбусад багш нар болон эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах нь чухал

7/. Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд зөвхөн мэргэжлийн мэдлэг, ур чадвараас гадна нийгэм, эдийн засгийн, хууль эрх зүйн, улс төрийн мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж байх хэрэгтэй.

8/. Дэлхийн улс орны багш нар өөрийгөө хөгжүүлэх ямар арга,туршлагатайг судлаж ашиглах хэрэгтэй.

9/. Багшийн өөрийгөө хөгжүүлэх нилээд чухал,найдвартай арга зам бол сурган хүмүүжүүлэх судалгааны ажлын арга зүйг эзэмших явдал юм.

Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд дээрх чиглэлүүдийг анхаарч ажиллах шаардлагатай бөгөөд энэ бүхнийг эргэцүүлэн бодож үзэхэд хамгийн чухал нь багшийн сэтгэлгээг шинэчлэх нь нэн тэргүүний асуудал юм.

Боловсролын бүх шатны байгууллагын багш нараас авсан "Багшийн хөгжил ба сэтгэлгээний шинэчлэл" сэдэвт судалгааны явц, үр дүн

"Багшийн хөгжил ба сэтгэлгээний шинэчлэл " сэдвийн хүрээнд богино хугацаанд их хэмжээний баримт,мэдээлэл цуглуулахын зэрэгцээ боловсруулалт, анализ хийхэд харьцангуй хялбар байдгийг харгалзан судалгаанд асуулгын аргыг хэрэглэлээ. Асуулгыг хаалттай хариултгайгаар бэлтгэсэн бөгөөд судалгаанд хамрагдагчид санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж бүрдүүлэх үүднээс асуулгын төгсгөлд

-"Багшийг хөгжүүлэх арга замуудаас таны бодлоор хамгийн оновчтой нь юу вэ ?
-"Багшийн сэтгэлгээг шинэчлэхэд хэн юу хийх ёстой вэ?" гэсэн нээлттэй хариулт бүхий асуултыг оруулсан болно .

Судалгаанд нийслэлийн цэцэрлэг, сургуулиудын нийт 70 багш хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан багш нарыг ажилласан жилээр нь авч үзвэл:
0-5 жил ажилласан багш 22,5−10 жил ажилласан багш 16, 11−15 жил ажилласан багш 8, 16−20 жил ажилласан багш 12, 21−25 жил ажилласан багш 6, 26 − аас дээш жил ажилласан багш 6 тус тус байна .

График−1



Харьцуулалтаас харахад судалгаанд хамрагдсан нийт багш нарын 31 % нь 0−5 жил ажилласан багш, 23 % нь 6-10 жил ажилласан багш байгаа нь сүүлийн жилүүдэд багш нар залуужих хандлагатай байгааг харуулж байна .

Судалгаанд хамрагдсан багш нарыг насаар нь авч үзвэл:


20−25 нас 5, 26-30 нас 19, 31-35 нас 16, 36−40 нас 15 , 41−45 нас 9 , 46−50 нас 3, 51 − дээш нас 3 тус тус байна . Үүнийг графикаар харуулбал

График−2



Судалгаанд хамрагдсан багш нарыг мэргэжлийн зэргээр нь харьцуулбал: зөвлөх багш байхгүй, тэргүүлэх 13, заах аргач багш 21, үлдсэн 36 багш нь зэрэггүй байна. Энэ нь судалгаанд оролцогчдын ихэнх нь залуу багш нар байгаатай холбоотой болов уу.

График −3



Асуулт−1 "Багшийн хөгжлийн тухай асуудалд таны бодлоор хамгийн чухал гэж үзсэн 3 хүртэл зүйлийг сонгоно уу" гэсэн сонголтод дараах байдлаар сонголт хийжээ.

Үүнд:

А. Боловсролын зэргээ ахиулах / бакалавр , магистр ,доктор / - 22

Б. Мэргэжлийн зэргээ ахиулах / заах аргач - зөвлөх / - 11

В. Байнга тасралтгүй суралцах - 54

Г. Уралдаан тэмцээн олимпиадад өөрөө болон шавь нараа амжилттай оролцуулах -15


Д. Сургалтын арга зүйг шинэчлэх- 17

Е. Мэдээлэл харилцааны технологийг өргөн ашиглах - 37

Ё. Заах арга зүй, ур чадвараа сайжруулах - 45 тус тус сонгожээ.

Дээрх тоон үзүүлэлтийг графикаар харуул бал:

График – 4



"Багшийн хөгжлийн тухай асуудалд таны бодлоор хамгийн чухал гэж үзсэн 3 хүртэл зүйлийг сонгоно уу" гэсэн асуултын сонголтоос харахад хамгийн өндөр хувьтай нь

- Байнга тасралтгүй суралцах - 27%
- Заах арга ур чадвараа сайжруулах -22%
- Мэдээлэл харилцааны технологийг өргөн ашиглах -18%-тай байна.

Үүнээс үзвэл багш нарын дийлэнх нь байнга тасралтгүй суралцах шаардлагатай байгаа ба бодит нөхцөл байдлын хувьд авч үзвэл тасралтгүй суралцах нөхцөл бололцоо харилцан адилгүй бүрдсэн байна.

Судалгаанд оролцсон багш нарын хамгийн чухал гэж үзсэн дээрх 3 чиглэлийн хүрээд интернетийн сүлжээг ашигласан зайны сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй сонгон шалгаруулалт явуулж багшийн судалгааны ажлыг санхүүжүүлэх зэргээр багш нарын идэвхи оролцоог нэмэгдлүүж болох юм.

Багш нарын заах арга, ур чадварыг сайжруулах нь бидний хувьд маш чухал байгаа бөгөөд ихэнхи багш нар уламжлалт сургалтын технологи,арга барилаасаа салж чадахгүй хөгжүүлэх сургалт буюу суралцагч төвтэй сургалтын арга барилыг жинхэнэ утгаар нь эзэмшиж чадахгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Асуулт–2 "Таны бодлоор багшийг тасралтгүй хөгжихэд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл нь аль вэ?" /Зөвхөн нэгийг сонгоно уу./

А. Иж бүрэн орчин бүрдсэн байх / Багшийн хөгжлийн төв / - 13

Б. Багшийн цалин хөлс ,нийгмийн үнэлэмжийг сайжруулах - 16

В. Багшийн сэтгэлгээг өөрчлөх,ахмад багш нарын сургалтад суух - 22

Г. Сургалтанд өргөн хамруулах - 14

Д. Бусад - 0

гэсэн сонголтуудыг тус тус хийжээ .

Асуулт– 3 : "Та өөрийн хөгжилд саад болж буй 3 хүртэл зүйлийг сонгоно уу " гэсэн асуулт нь дараах сонголттой бөгөөд судалгаанд оролцогчид

А. Орчин бүрдээгүй байна / ном ,гарын авлага компьютер / - 28

Б. Өөрийн хүсэл тэмүүлэл дутмаг / өөрийгөө дайчилдаггүй / - 25

В. Цалин хөлс, нийгмийн баталгаа -40

Г. Төгссөн сургуулийн чанар - 8

Д. Үр дүн муутай сургалтууд -12

Е. Багшийн хөдөлмөрийн үнэлэмж оновчтой биш - 22

Ё. Ажлын ачаалал - 24

Ж. Байгууллагаас шалтгаалж байна - 5

тус тус сонгожээ. Үүнийг гарфикаар үзүүлбэл:

График – 5




Графикаас харвал багшийн хөгжилдхамгийн их саад болж байгаа асуудлуудад "Багшийн цалин хөлс, нийгмийн баталгаа", "Багшийн нийгмийн үнэлэмж", "Ажлын ачаалал" зэрэг орсон байгаа харагдаж байна. Энэ нь өмнө дурьдсан улс орны хэмжээндбайгаа нийгэм,эдийн засгийн асуудлуудаас урган гарч буй сөрөг үр дагаварууд юм.

Дээрх асуултын бас нэг анхаарал татаж буй асуудал бол "Өөрийн хүсэл тэмүүлэл дутмаг " гэсэн сонголт юм . Энэ сонголтыг нийт 25 багш сонгосон нь судалгаанд оролцсон нийт багш нарын 36 хувь байгаа бөгөөд өөрийн хүсэл тэмүүлэл дутмаг байгаа тухай асуудал энэ судалгааны ажлын хамгийн чухал гогцоо асуудал юм.

Асуулт–4 "Багш хөгжих арга замуудаас хамгийн оновчтой нь таны бодлоор юу вэ?" гэсэн нээлттэй хариулт бүхий асуултад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулжээ. Үүнд

- Ажлын ачааллыг багасгах - 3
- Чанартай сургалт явуулах /ахмад багш нараар/ - 15
- Цалин хөлс, нийгмийн үнэлэмжийг нэмэгдүүлэх - 4
- Багшийн заах арга, ур чадварыг нэмэгдүүлэх - 3
- Ажлын үнэлгээг оновчтой болгох - 2
- Өөрийн идэвхи чармайлтыг нэмэгдүүлэх - 19
- Ажиллах, хөгжих орчин нөхцлийг сайжруулах - 5 гэсэн хариултыг тус тус өгчээ. Дээрх тоон үзүүлэлтийг графикаар харуулбал:

График - 6



Энэ асуултад судалгаанд оролцсон нийт 70 хүний 47 нь буюу 67% нь хариулсан бөгөөд үлдсэн 13 хүн буюу 33% нь хариулаагүй байна. Дээрх хариултуудаас хамгийн олон давтагдсан нь "Өөрийн идэвхи чармайлтыг нэмэгдүүлэх" гэсэн хариултыг 19 багш сонгосон нь багш нар өөрийн хөгжлийн тухай асуудлаа өөртэйгээ холбож үздэг болсон сайшаалтай тал харагдаж байгаа ч энэ нь судалгаанд оролцсон нийт багш нарын 27% байна.


Асуулт–5 : "Багшийн сэтгэлгээг шинэчлэхэд хэн юу хийх ёстой вэ?" гэсэн нээлттэй хариулт бүхий асуултаас судалгааны ажлынхаа хамгийн чухал асуудал болох "багшийн сэтгэлгээг шинэчлэх" мөн багшийн хөгжлийн тухай онол, үзэл баримтлалын хамгийн дэвшилттэй онол, үзэл баримлалд дурьдсанаар " Багш өөрөө хөгжинө" гэсэн зарчим бодит нөхцөл байдалд ямар байгааг олж харахыг зорьсон юм. Энэ асуултад судалгаанд оролцогсодолон зүйлүүдийг дурьдсан байсан бөгөөд агуулгаар нь нэгтгэж дараах байдлаар гаргалаа. Үүнд:

- Багш бие хүн өөрөө л сэтгэлгээгээ шинэчлэх хэрэгтэй – 28
- Байгууллага , удирдлагууд энэ ажлыг хийх ёстой - 18
- БСШУЯ – наас тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх - 9
- Улс орны хэмжээнд бодлого боловсруулан хэрэгжүүлэх - 7
- Мэдэхгүй буюу огт бичээгүй - 8

гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна .

Үүнийг гарфикаар харуулбал:

График –7



Судалгааны үр дүнгээс харахад багшийг хөгжүүлэхэд хэн юу хийх ёстойг хамгийн олон буюу 28 хүн өөрөөл хэлбэл нийт багш нарын 40% нь "Багш өөрөө сэтгэлгээгээ шинэчлэх ёстой" гэж хариулсан байна.

Багш нарын сэтгэлгээг шинэчлэхэд ахмад

багш нарын ажлын туршлага, зөвлөгөө зааварнэн чухал бөгөөд ахмад дунд, залуу үеийн хамтарсан оролцоо бий болж чадвал багшийн хөгжил сэтгэлгээний шинэчлэлд нэн чухал билээ.

Багш сэтгэлгээгээ шинэчлэхэд баримтлах зарчмууд

Багш бид сэтгэлгээгээ шинэчлэхийн тулд дараах зарчмуудыг өдөр тутмын амьдрал, ажил цйлдээ хэвшцлбэл амжилтанд хцрэх болно. Үцнд:

- *Өөрийн сэтгэлгээг шинэчлэх суурь зарчмууд*
- Өөрийгөө ялж биеэ дайчлах зарчим
- Цаг мөч бүрийг мэдрэх зарчим
- Муу дадал зуршлаа халах зарчим
- Өөрийгөө зөв удирдах зарчим
- Цаг баримтлах зарчим
- Өөртөө туслах зарчим
- Хамгийн дээд боловсрол өдөр тутмын амьдрал байх зарчим
- Өөдрөг байх зарчим
- Өөрийгөө хөгжүүлэх зарчим
- Бүтээлч чадвартай байх зарчим зэрэг болно .

Эдгээр зарчим алхмуудыг биелүүлж мөрдлөг болгож ажиллавал багш нарын сэтгэлгээ шинэчлэгдэж багшийн хөгжилд ахиц үр дүн гарна.

ДҮГНЭЛТ

Багш хөгжих олон арга замууд байдаг бөгөөд эдгээрээс хамгийн оновчтой нь багш нарын өөрсдийн нь үзсэнээр "Багш өөрөө өөрийгөө хөгжүүлэх, аливаад хандах хандлагаа өөрчлөх" нь хамгийн оновчтой гэж үзсэн байна.Үүнээс үзэхэд багш бидэнд боловсролын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, нийгэм цаг үеийнхээ өөрчлөлтийг мэдэрч,ирээдүйн өөрчлөлтөд шавь нараа бэлтгэхийн тулд хэн нэгэн хүн ч юм уу эсвэл ямар нэгэн зүйлд найдаж, хүлээгээд амжилт олохгүй бөгөөд өөрөөсөө эхлээд л өөрчлөгдөж өдөр, цаг мөч бүрийг өөртөө зориулах нь чухал юм. Гэхдээ өөрчлөгдөнө гэдгийг шууд утгаар нь хүлээн авч миний одооны байгаа бүхэн огт болохгүй байгаа юм байна тэгэхээр би өөрийгөө өөрчлөх хэрэгтэй болох нь гэж хүндрүүлж ойлгох биш өөрөө өөрийгөө үнэлж дүгнээд миний чухам аль тал нь учир дутагдалтай байна, би юун дээр илүү алдаа гаргаад байдаг билээ гэдгээ бодож тунгаагаад л түүнийгээ олсон л бол тэр дутагдлаа засахын тулд яг тэр мөчөөсөө эхлээд бага багаар,алхам алхмаар өөртөө шаардлага тавьж засаж залруулахыг эрмэлзэх хэрэгтэй юм. Энэ л бидний өөрийгөө хөгжүүлэх, өөрчлөгдөхийн үндэс болно .

Багшийг хөгжццлэхэд хамгийн оновчтой арга зам нь багш өөрөө өөрийгөө өөрчлөх, сэтгэлгээгээ шинэчлэх нь чухал, ингэж чадсан тохиолдолд цр дцнд хцрэх бөгөөд эдгээр шинэчлэлтццдийг хийхэд ахмад багш нарын ццрэг оролцоо, идэвх зцтгэл нэн чухал" гэж үзэж байна.

Ашигласан материал

1. "Багш боловсролын хөгжилд хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүйн үүрэг, ач холбогдол" Л. Алтансувд УБ.,2004.2 х.
2. "Багшийн ном" Ш. Ичинхорлоо УБ.,2004. 74 х.
3. "Боловсролын шинэчлэл хөгжлийн онол арга зүйн асуудалд" Ч.Пүрэвдорж УБ., 1999.15х
4. "Өөртөө туслах ухаан" Самуэл Смайлс УБ.,2001.14х.
5. "Өөрийгөө хөгжүүлэхийг хүсэгчдийн амьдралын суурь зарчим С. Ганбаатар УБ., 2006 он.11х
6. "Сэтгэл судлал" 1- р дэвтэр О. Мягмар УБ.,2006.21 х
7. "Сургууль соёлын хөгжлийн шинэ чиг хандлага" У. Доёд, Н.Нэргүй нар УБ.,2002.26 х .
8. " Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага" МУИС – ийн мэргэжлийн дидактикийн сургалт судалгааны төв УБ.,2003.30х
9. " Багшийн хөгжил – Сургалтын шинэчлэл" "Чанартай боловсрол хөгжлийн баталгаа" бага хурлын эмхтгэл УБ.,2001.37х
10. "Багш боловсролын хөгжил, шинэчлэл" МУБИС ийн Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл УБ.,2006.60х
11. "Боловсролын шинэчлэл – хамтын ажиллагаа" МУБИС – ийн Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл УБ.,2006. 75х.
12. "Монгол улсын боловсролын салбарыг 2006 – 2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө" Монгол улсын Засгийн Газар УБ.,2007.31х
13. "Өөрийгөө хөгжүүлцгээ" Емос клуб . УБ.,2004.26 х.
14. "Хөгжих цагийн боловсрол" Багш нарын

улсын. Анхдугаар зөвлөгөөний эмхтгэл УБ.,2007.31х

15. “Хориннэгдүгээр зууны чанартай боловсрол – Багшийн хөгжил“ Зүүн Азийн боловсролын 6-р чуулган УБ.,200216 х.
16. “Монголын боловсролын тогтолцоо ба монголчуудын сэтгэлгээ“ Я. Хишигт ”Боловсрол судлал“ УБ.,2005 №06 .58 х.
17. “Бүтээлч багш түүнийг дэмжих, үнэлэх тухай асуудлууд” Р. Нарантуяа
18. ”Боловсрол судлал“ УБ.,2007 №01.63 х.
19. “Багшийн хөгжлийн өнөөгийн байдал, түүнийг өөрчлөх арга замууд” ”Боловсрол судлал“ УБ.,2007 №02.35 х.
20. “Багш нарын мэргэжлийн ёс зүй ба нийгмийн үүрэг хариуцлагын асуудалд” Н.Бэгз “ Боловсрол судлал” УБ.,2006 №01 . 7 х

Интернет хаяг:

21. http://www.e-pada.com
22. www.yaruus.amjilt.com

БАГШИЙН ЁС ЗҮЙ, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Б.Индра
Их Засаг ОУИС-ийн ҮИТС-ийн багш, магистр

Түлхүүр үг: Ёс зүй,мэргэжлийн ёс зүй,ёс суртахууны хэм хэмжээ

Хураангуй: Ёс суртахуун нь нийгмийн амьдралын олон талт үзэгдлийг тусгасан ухагдахуун юм. Ёс суртахууны ухагдахуунд юуны өмнө хэм хэмжээ буюу хүнээс нийгэм хамт олон, бие биетэйгээ харьцах харьцааг тодорхойлогч аль нэг илэрхий шаардлагууд болох зан үйлийн дүрэм гэрим багтана. Аль ч нийгэм өөрийн гэсэн үзэл санааг гүйцэлдүүлэхийг зорилгоо болгодог, энэхүү үзэл санаа хүмүүсийн оюун санаанд нөлөөлж тухайн нийгэмд аж төрөх ёс суртахууны хэм хэмжээг бий болгож өгдөг. Ес суртахууны хэм хэмжээ нь хүний үйл ажиллагаанд юу сайн, юу муу зааж өгнө. Үүнгүйгээр нийгэм оршин тогтнох аргагүй.

Оршил

Өнөөдөр дэлхий нийтээрээ хүний хөгжилд анхаарлаа хандуулж, улс орны хөгжил хүний хөгжлөөр тодорхойлогдож байна. Хүний хөгжлийн үндэс нь мэдлэг боловсрол. Гэхдээ боловсрол нь хувь хүний ёс суртахууны ухамсар, төлөвшилгүйгээр биелэгдэх боломжгүй юм. ёс суртахуун нь нийгмийн харилцааг зохицуулдаг төдийгүй "нийгмийн ёс суртахуун"-ыг тодорхойлдог[1]. Иймээс нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны бүхий л хүрээнд ёс суртахууны шаардлага зайлшгүй тавигдсаар байна. Өнөө үеийн боловсролын өөрчлөлт,шинэчлэлийн тулах цэг нь болсон "багш" мэргэжилдтавигдах ёс зүйн шаардлага улам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энэхүү хэрэгцээ шаардлага дээр тулгуурлаж багшийн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварт тавих шаардлагыг өндөржүүлж,багшийн ёс зүй,нэр төрийг эрхэмлэн сахих, тэдний үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор төрөөс тухайн түүхэн цаг үед холбогдох хууль тогтоомж,дүрэм журмуудыг баталсаар ирлээ. Үүний нэг тод илрэл нь Монгол улсын Боловсролын тухай хуулинд багшийн үндсэн үүргийн нэгдүгээрт заахдаа "Багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахина" гэжээ[2]. Энэ нь багшийн үйл ажиллагаанд түүний нэг шалгуур нь ёс зүй болохыг онцлон заасан байна. Гэвч бүх багш иймшаардлагын хэмжээнд ажиллаж чадахгүй байгаа нь боловсролын салбарын нэр хүнд,багшийн нэр төрийг унагаж байна.

Иймд боловсролын шинэчлэлийн алхам тутамд ил тод явагдаж байгаа "багш" мэргэжлийн ёс суртахууны тухай асуудлыг дэвшүүлэн тавьж боловсролд багш оюутнуудын харилцааны ёс суртахууны үүрэг яагаад чухал болох,түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодруулахыг зорьлоо.

Судалгааны зорилго

Багшийн ёс зүйн асуудлыг судалж, багш мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх арга замыг тодорхойлж,санал дэвшүүлэхэд оршино.

Судалгааны зорилт

- Багшийн ёс суртахууны өнөөгийн байдлыг авч үзэж,түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах
- *Судалгааны* мэдээлэлд боловсруулалт хийж, үр дүнг гаргах
- *Багшийн ёс зүйг төлөвшүүлэх талаар* санал дэвшүүлэх

Судлагдсан байдал

Сая сая жилээр хүний хөгжиж, хадгалж, удамшуулж ирсэн чадавх дээр нэгэн насанд нэмэгддэг дуслын төдий шинэ зүйл бол чадвар юм хэмээн судлаач, эрдэмтэд хэлсэн нь бий. Уг чадвар гэж нэрлэж буй шинэ хүчийг хүнд нэмэн олгодог эх сурвалжийг юуны өмнө боловсрол,соёл, ёс суртахуунтай нь холбон ойлгох нь чухал. Учир нь нэг буюу нэг хэсэг, бүлэг хүн, тэр ч байтугай тухайн тодорхой улс орны танин мэдэж, олж нээсэн шинэ санаа,шинэ арга барил,шинэ үр дүнг бусдад нь түгээн дэлгэрүүлж, даяаршуулж чадсан зүйл бол боловсрол,соёл,ёс суртахуун юм.

Ёс суртахуун нийгмийн дотор хүмүүсийн зан үйлдлийг хэм хэмжээгээр зохицуулах үндсэн аргын нэг,нийгмийн харилцааны онцгой төрөл мөн.[1]

Хүмүүсийн хоорондын харилцааны талаар маш олон төрлийн тодорхойлолт байдаг.

- ✓ Харилцаа нь хүмүүсийн сэтгэл ходлөлийн илрэл
- ✓ Харилцаа бол соёл

Оросын эрдэмтэн Б.Ф.Ломов" харилцааны сэтгэл зүйн үндсэн бүрдлүүдийг 4 хүчин зүйлээр

тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Мэдээлэл
- ✓ Сэтгэл хөдлөл
- ✓ Хандлага, хувийн өвөрмөц онцлог

Багшийн ёс суртахууны талаар олон эрдэмтэд судалгаа шинжилгээ хийж өөрийн зохиол бүтээлдээ тусгасан байна.

Багш хүн нийгэмд гүйцэтгэх ёс суртахууны үүргийг сайтар ухамсарласан,ёс суртахууны үнэтэйлийг өөртөө шингээсэн байх төдийгүй үлгэрлэгч байх ёстой гэж бичжээ (Д.Тунгалаг "ёс зүй", 2012 он).

Багш мэргэжлийн онцлог, багш мэргэжлийн ёс зүйн ойлголт, багш ёс суртахууны ухамсар, үүрэг хариуцлага, нэр төр, нэр хүндийг дээшлүүлэх нь орчин үеийн боловсролын шинэчлэлийн нэгэн тулгамдсан асуудал болох тухай авч үзжээ (Р.Дарьхуу багшийн ёс зүй").

Өнөөгийн нийгмийн болон хувь хүний бодит хэрэгцээ шаардлагын үүднээс ёс суртахууны хөгжил, төлөвшлийн үндэс болсон ёс зүйн боловсролыг нэн тэргүүнд авч үзэх, улмаар ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн боловсролын тогтолцооны агуулгыг дэлхийн жишигт нийцүүлэн эрс шинэчилнэ, тэгэхдээ багшаас өөрөөс нь эхлүүлэх арга замын тухай дэвшүүлэн тавьжээ (Р.Дарьхүү, Б.Оюунцэцэг нарын "ёс зүйн боловсролын асуудалд").

Багшийн авир үйлдэл, ёс суртахууны харилцаа нь хүүхдийн бие бялдар, оюун сэтгэхүй, сэтгэц нийгэмшихүйд юутай ч зүйрлэшгүй нөлөөг шууд үзүүлдэг тухай дэлгэрэнгүй авч үзжээ (Л.Отгонсүрэн "Янз бүрийн багш").

Багш нарын сурган хүмүүжүүлэх ёс зүй нь багш өөрийн мэргэжилд үнэнч байх, багшийн мэргэжлийн хариуцлага нэр төрийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг гэж бичжээ (Я. С.Котигер, В. Ч. Чамлер нар "Сурган хүмүүжүүлэх ёс зүй").

Өнөөгийн нийгмийн болон хувь хүний бодит хэрэгцээ шаардлагын үүднээс ёс суртахууны хөгжил, төлөвшлийн үндэс болсон ёс зүйн боловсролыг нэн тэргүүнд авч үзэх, улмаар ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн боловсролын тогтолцооны агуулгыг дэлхийн жишигт нийцүүлэн эрс шинэчилнэ, тэгэхдээ багшаас өөрөөс нь эхлүүлэх арга замын тухай дэвшүүлэн тавьжээ (Р.Дарьхүү; Б. Оюунцэцэг нарын "Ёс зүйн боловсролын асуудалд").

Багшийн авир үйлдэл, ёс суртахууны харилцаа нь хүүхдийн бие бялдар, оюун сэтгэхүй, сэтгэц нийгэмшихүйд юутай ч зүйрлэшгүй нөлөөг шууд үзүүлдэг тухай дэлгэрэнгүй авч үзжээ (Л.Отгонсүрэн "Янз бүрийн багш").

Багш нарын сурган хүмүүжүүлэх ёс зүй нь багш өөрийн мэргэжилд үнэнч байх, багшийн мэргэжлийн хариуцлага нэр төрийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг гэж бичжээ (Я. С.Котигер, В. Ч. Чамлер нар "Сурган хүмүүжүүлэх ёс зүй").

Багшийн ёс суртахууны хэм хэмжээ нь тэдний хувийн онцлогоос хамааралгүйгээр багш, сурагчдын харилцааг зохицуулах, нийтлэг ач холбогдолтой бөгөөд багшийн ёс зүйн соёлын түвшинг харуулдаг гээд, багш мэргэжлийн баримталвал зохих ёс зүйн үндсэн хэм хэмжээнүүдийг дурджээ (И.И. Чернокозоеын багшийн мэргэжлийн ёс зүй").

Ёс суртахуун ба түүний хэм хэмжээ

Ёс суртахуун нь нийгмийн амьдралын олон талт үзэгдлийг тусгасан ухагдахуун юм. Ёс суртахууны ухагдахуунд юуны өмнө хэм хэмжээ буюу хүнээс нийгэм хамт олон, бие биетэйгээ харьцах харьцааг тодорхойлогч аль нэг илэрхий шаардлагууд болох зан үйлийн дүрэм горим багтана. Аль ч нийгэм өөрийн гэсэн үзэл санааг гүйцэлдүүлэхийг зорилгоо болгодог, энэхүү үзэл санаа хүмүүсийн оюун санаанд нөлөөлж тухайн нийгэмд аж төрөх ёс суртахууны хэм хэмжээг бий болгож өгдөг. Ес суртахууны хэм хэмжээ нь хүний үйл ажиллагаанд юу сайн, юу муут зааж өгнө. Үүнгүйгээр нийгэм оршинтогтнохаргагүй Бйёэ авч явахэнэ хэм хэмжээ нь гэр бүл, үндэстэн ястныуламжлал, шашны номлолд батжин биелэдэг бөгөөд төрд хамгийн чухал нь эрхийн хэм хэмжээ болон тусагддаг.

Ёс суртахууны хэм хэмжээ нь нийгмийн зайлшгүй шаардлага, анги бүлэг, хамтолон, гэр бүл, хувь хүний ашиг сонирхол, тэдний харилцааг зүй зохистой, эмх журамтай, үнэ цэнэтэй болгон "хуульчлан захирамжилсан" маягтайгаар тусгасан зан суртахууны цогцос юм. Ёс суртахууны хэм хэмжээ нь "Ингэвэл зөв, тэгвэл буруу", "Хулгай бүү хий", "Худал бүү ярь", "Шударга бай"... гэхчлэн хүний биеэ авч явах ёсыг захирамжлан тогтоосон шинжтэй ёс суртахууны хууль юм. Хүн хүний нийгэмдзөв амьдрахын тулднийгмийн даган мөрдвөл зохих дүрэм, горим, ёс суртахууны хэм хэмжээг танин мэдэж эзэмших нь чухал. Гэхдээ энэхүү ёс суртахууны хууль нь, ёс суртахууны үндэслэл сайтай нотолгоо нь хүмүүсийн хамтын амьдралыг баялаг, хоорондоо илүү зохицож чадахаар, бузар булайгаас чөлөөтэй болгож чадах тэрхүү чанар байхад л чиглэгдэх ёстой.

Ёс суртахууны хэм хэмжээ тохиолдлоор гэнэт бий болдоггүй. Энэ нь хүн төрөлхтний

олон үеийн турш хуримтлагдсан ёс суртахууны хамгийн шилдэг сайныг нь эзэмших замаар бүрэлдэн тогтдог. Тийм ч учраас олон зууны турш хэвшин зуршиж, яваандаа хүмүүсийн зан суртахууны нэгэн хэмжүүр болсон ёс дэглэмийг хүндэтгэн түүний дагуу бие сэтгэл оюунаа авч явж сурвал ёс зүйтэй хүн тэр мөн. Энэ нь өнгөрсөн цаг үед таарч тохирч байсан одоо тохирохоо больсон, эсвэл нийгмийн дээд ангийн ашиг сонирхолд нийцүүлэн зохиосон ёс суртахууныг үг дуугүй өвлөн авч даган мөрдгэсэн үг биш ээ. Тийм ч учраас ёс суртахууны хэм хэмжээ түүний утга агуулга нь байнга шинэчлэгдэн оюжиж байх зүй тогтолтой гэсэн үг. Ёс суртахууны сургаал нь өөрөө дэвшилтэт шинжлэх ухаан дээр тулгуурлах ёстой.

Мэргэжлийн ёс зүйтэй холбогдуулан тэмдэглэхэд, сурагчидтай хамтран ажиллах явцад багшийн зан төлөвийн хэдхэдэн загвар ажиглагддаг байна. Тухайлбал:

- Дарангуйлах загвар - хөндий хүйтэн хандлага голлодог учраас сурагчидтай холбоо харилцаа муутай. Багшлах үйл ажиллагаа мэдээлэл дамжуулахад чиглэж, сурагчид идэвхгүй сонсогчид болно.
- Харилцаа холбоо тогтоодоггүй загвар - психологи шинжээрээ түрүүчийнхтэй төстэй. Гэхдээ багш, сурагчийн хооронд заримдаа санамсаргүй бэрхшээл тохиолдоно. Жишээлбэл багш, сурагчийн хамтран ажиллах сонирхол буурах, хэлэлцүүлэг багатай болох, багш байр сууриа хяналт болгоомжгүй дөвийлгөх, сурагчид хүлцэнгүй хандах зэрэг болно.
- Психологи онцлогийг харгалзан хандах загвар - багш сурагчдыг шилж сонгох байдлаар хандана. Бүлгийг нийтээр нь баримжаалахгүй,

Судалгааны хэсэг


Монгол улсын боловсролын тухай хуулинд заасан багш, сурагчийн эрх үүргийн харьцуулсан шинжилгээ

Монгол улсын боловсролын тухай хууль	
Багшийн үүрэг	Сурагчийн үүрэг
44.2 Багш дараах үүрэгтэй /Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	45.2.1 сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших
44.2.1 багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих	45.2.2 багшаас тавьсан шаардлага өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
44.2.2 боловсролын стандартыг хэрэгжүүлэх	45.2.3 бие даан сурагчах арга барилыг эзэмших
44.2.3 онолын мэдлэг заах арга, ур чадвараа дээшлүүлэх	45.2.4 багш шавийн харилцааг хүндэтгэн дээдлэх
44.2.4 сурагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах	45.2.5 сургуулийн дотоод журмыг хүндэтгэн сахих
44.2.5 сурагчбүрийн онцлог байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг харьцах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, бие хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх	45.2.6 сургалтын төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлөх
44.2.6 сурагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах	
44.2.7 сурагчийн эрүүл мэнд аюулгүй байдалд анхаарал тавих	
44.3 багш сурагчдын бие махбодид халдах тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглоно.	
44.4 багш нь хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхдээ багшийн ёс зүйн дүрмийг баримталж ажиллана.	

Монгол улсын боловсролын тухай хууль	
Багшийн эрх	Суралцагчийн эрх
44.1 багш дараах эрхтэй	45.1.Суралцагч дараахь эрхтэй:
44.1.1 сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангуулах	45.1.1.суралцах нөхцөл бололцоогоор хангуулах;
44.1.2 сургалтад шинжлэх ухааны дэвшилтэт арга барил, боловсролын стандартад нийцсэн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх	45.1.2.сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгаагүй хичээлээс сонгон судлах;
44.1.3 суралцагч болон түүний эцэг эх асран хамгаалагчид шаардлага тавих, зөвлөгөө өгөх	45.1.3.сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих;
44.1.4 суралцагчийн мэдлэг, чадвар дадлыг үнэлэх, тэдний авьяас, бие сэтгэцийн хөгжилтөд тодорхойлолт өгөх	45.1.4.суралцах хугацаа, хэлбэрийн талаар санал тавьж шийдвэрлүүлэх;
44.1.5 суралцагчийг сонгон суралцуулах, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах	45.1.5.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх;
44.1.6 судалгаа шинжилгээний ажил хийх, багшийн мэргэжлийн болон боловсролын зэрэг хамгаалах, мэргэжлийн цол хүртэх	45.1.6.гэрээнд өөрөөр заагаагүй бол сургууль төгсөгч эзэмшсэн буюу сонирхсон мэргэжлийн дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр чөлөөтэй сонгох;
44.1.7 хүүхдийн эрүүл мэнд, эрх ашгийг хохироосон эцэг эх, асран хамгаалагчийн талаар насанд хүрээгүй суралцагчаа төлөөлөн зохих байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх	45.1.7.сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;
	45.1.8.уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах.
	/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

Судалгаанд I курсын нийт 78 оюутан оролцсон. Судалгаанд хамрагдсан сурагчдыг хүйсийн талаас авч үзээхэд харьцангуй тэнцвэртэй, харин насны хувьд авч үзэхэд 19 настай оюутнууд дийлэх хувийг эзэлж байна.

Насны байдлаар ангилбал



хүйсийн ангилал



Багш суралцагсдын хооронд зөрчил гардаг уу? гэсэн асуултад нийт оролцогчдын 62 хувь нь тийм гэж хариулжээ. Харин үгүй гэдэг хариултыг цөөнх оролцогч буюу 10 хувь хариулсан байна.

Нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 44% нь аль альнаас шалтгаалдаг гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогсдын 93% нь багш суралцагч тодорхой үүрэг хүлээх нь зүйтэй гэж хариулсан тэдийгүй ямар үүрэг хүлээж болохыг дурдсан байна. Үүнд:

- Багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
- Сурч боловсрохын төлөө өөрөө мэрийх
- Шаардлагыг хүлээж авах
- Өөрийнхөө бүрүүтай үйлдлийг хүлээх
- Багшид хүндэтгэлтэй хандах
- Багшийг ойлгох гэх мэт.

ДҮГНЭЛТ

Багш сурагчдын хоорондын харилцаанд үл ойлголцол гардаг уу? гэсэн асуултад нийт оролцогчдын 62 хувь нь тийм гэж хариулжээ. Харин үгүй гэдэг хариултыг цөөнх оролцогч буюу 10 хувь хариулсан байна. Иймд багш сурагчдын хоорондын харилцаанд үл ойлголцол байнга байдаг болох нь үүнээс харагдаж байна.

Үл ойлголцол хэнээс шалтгаалдаг вэ? Гэсэн асуултад нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 44% нь аль альнаас шалтгаалдаг гэж үзсэн байна.

Сурагчдын үзэж байгаагаар багштайгаа үл ойголцож байгаа шалтгаан нь ялгаварлан харьцдаг гэж 31%,хүүхдийг ойлгодоггүй гэж 27% нь хариулсан байна.

Судалгаанд оролцогсдын 93% нь багш оюутнуудын хоорондын үл ойлголцлыг багасгахад сурагчаг тодрхой үүрэг хүлээх нь зүйтэй гэж хариулсан төдийгүй ямар үүрэг хүлээж болохыг дурдсан байна. Үүнд:

- Багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
- Сурч боловсрохын төлөө өөрөө мэрийх
- Шаардлагыг хүлээж авах
- Өөрийнхөө бурууталй үйлдлийг хүлээх
- Багшид хүндэтгэлтэй хандах
- Багшийг ойлгох гэх мэт.

Дэвшүүлж буй санаа:

Насанд хүрсэн хүн(багш) хүүхэд (сурагчаг) 2 дэндүү их ялгаатай байдаг. Сурагчаг буюу хүүхэд нь цайлган , гэнэн, сэтгэлийн дархлаа сайтай байдаг учраас зарим юмыг амархан мартдаг. Харин багш буюу насанд хүрэгсэд нь стандартыг(заавал тийм байх ёстой, тэгэхгүй л болохгүй) илүү баримталж байдаг нь тэдний хоорондын харилцааны зөрчлийг үүсгэдэг. Зөрчилд багш хүн илүү ёс суртахуунлаг тайван аядуу хандаснаар энэ байдлыг эерэг тийш нь залах боломжтой.

Ялангуяа залуу багшийн ёс суртахууны хэм хэмжээ:

- Багш хүн тухайн сурагчаг буюу хүүхдэд аядуу хандах
- Тухайн хүүхдийг байгаагаар нь хүлээж авах
- Тэрхүү сурагчийн үйлдэлд хүлээцтэй *хандах*
- Өөрийгөө илэрхийлэх ярилцах боломжийг олгох

Иргэн хүн ёс суртахуунтай байсан нь дээр үү, аль эсвэл эрдэм боловсролтой байсан дээр үү гэдэг хүнд асуултын өмнө бид тулгарахад Ж.Ж.Руссо ёс суртахуунтай байсан дээр хэмээн ямар эргэлзэж тээнэгэлзээ зүйлгүй хариулсан байдаг. Тэгээх бид ирээдүйн Монголын олон салбар дахь боловсон хүчнийг бэлтгэн гаргаж байгаа багш хэмээх алдар цолтой албанд зүтгэж байгаа болохоор ёс суртахуунтай,эерэг хандлагатай, зөв төлөвшилтэй иргэн бэлтгэхэд бидний хувь нэмэр зүйрлэшгүй их билээ.

Ашигласан материал

1. Монгол улсын боловсролын тухай хууль
2. Аристотель "Евдемийн ёс зүй" 2008 он
3. Д.Тунгалаг "Ёс зүй",2012 он.
4. Р.Дарьхүү,Б.Оюунцэцэг нарын "Ёс зүйн боловсролын асуудалд"
5. Л.Оттонсүрэн "Янз бүрийн багш"
6. Я. С.Котигер,В. Ч. Чамлер нар "Сурган хүмүүжүүлэх ёс зүй"
7. Р.Дарьхүү; Б. Оюунцэцэг нарын "Ёс зүйн боловсролын асуудалд"
8. Л.Оттонсүрэн "Янз бүрийн багш"
9. Я. С.Котигер,В. Ч. Чамлер нар "Сурган хүмүүжүүлэх ёс зүй".
10. И.И. Чернокозоеын багшийн мэргэжлийн ёс зүй".
11. В.Н.Столетов "Хүмүүжлийн тухай харилцан яриа" 1988 он

БАГШИЙН БҮТЭЭЛЧ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АРГА

Б.Мөнгөнтуяа
Их Засаг ОУИС-ийн СЭЗС-ийн багш, магистр

Түлхүүр үгс: *Багш, сурган хүмүүжүүлэгч, оюутны сэтгэл зүй, сэтгэл судлал, багшийн ур чадварын өсөлт*

Хураангуй: *Ихэнх их дээд сургуулийн багш нар багш мэргэжилтэй байдаггүй бөгөөд ахмад багш нараа дагалдан суралцах эсвэл сурган заах арга зүйн сургалтанд хамрагдаж энэ төрлийн мэдлэг, мэдээллийг олж авдаг нь тэр бүр хангалттай байж чаддаггүй. Шинэ залуу багшийн хувьд оюутны сэтгэл зүйн онцлогийг ойлгож, тэдний ертөнцийг үзэх үзэл, насны онцлогт тохируулан хичээлийг үр өгөөжтэй заах, цаашид улам гүнзгийрүүлэн судалж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь энэхүү сэдвээр илтгэл бичих үндэслэл болсон.*

Багш хүн сурган хүмүүжүүлэх ажлынхаа өвөрмөц шинжээрээ зохион байгуулагч байх ёстой. Иймд аливаа зүйлд идэвхи зүтгэлтэй ханддаг, зохион байгуулах авъяастай, сэтгэл санааны хувьд байнга өөдрөг байж, өөрийнхөө хүч бололцоонд бүрэн итгэлтэй ажилладаг байх шаардлагатай.[1]

Их дээдсургуулийн багш нь оюутны бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй. Учир нь сэтгэл зүйн хувьд оюутан нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас ялгаатай. Оюутны суралцах явцад асуудал шийдвэрлэх, сэтгэхүйн болон танин мэдэхүйн цар хүрээг тэлэх, шинжлэх ухааны байр сууринаас судлаачийн хувьд асуудалд хандахад их, дээд сургуулийн багш шийдвэрлэх үүрэгтэй. Их, дээд сургуулийн сургалт нь мэргэжил эзэмшихэд багш бус, харин оюутан өөрөө шийдвэрлэх үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулагдсан байдаг[2].

Оюутанд хэрхэн нөлөөлөх вэ гэдэг асуудал их, дээд сургуулийн багшийн ажлын нэг чухал хэсэг юм. Учир нь багшийн нөлөөллөөс оюутны ажил, мэргэжлийн шинж чанар, ур чадвар, эзэмшиж буй тухайн мэргэжлийг хүндлэх эсэх, түүнчлэн ёс зүйн хэм хэмжээ, нийгэмд биеэ авч явах байдал, амьдралын идэвхи зэрэг шалтгаалдаг. Багш зөвхөн өөрийн лекц, семинарын агуулгаар бус, бие хүний болон шинжлэх ухааны шинж, судлаачийн хувьд, биеэ авч явж буй байдал, хувцаслалт, дуу хоолой, дохио зангаа, харц, зуршил, дадал, хандлага зэргээрээ оюутанд нөлөөлж байдаг.

Багшийн ажлын онцлог хүний нүдэнд үргэлж ил байдаг ба алдаа оноо эсвэл амжилт бүтээлээс оюутан суралцагчийн ирээдүйд хэрхэн хандах нь шалтгаалдаг. Сайн багш буюу оюутнаа ойлгодог, тэднийг аливаа сайн зүйлд уриалан, амжилтанд чиглүүлж, дэмжиж чаддаг багш шавийнхаа амьдралыг бүхлээр нь өөрчилж, насан туршийнх нь үлгэр дууриалал болж байдаг. Харин эсрэг тохиолдолд бас л бүх амьдралынх нь хар бараан дурсамж болж үлддэг. Тиймээс багшийн ажил хамгийн хариуцлагатай, хүндтэй, хэцүү алба юм.

Оюутны сэтгэл зүйг ойлгож, тэдний итгэл, хүндлэлийг олоогүй цагт тэдэнд хичээл зааж үр дүнд хүрнэ гэдэг бараг боломжгүй юм.

Энэхүү судалгааны ажлаар их дээд сургуулийн багшийн сэтгэл зүйн мэдлэг, түүнийг дээшлүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах талаар судлахыг зорьсон болно. Үүний тулд өөрийн ажиллаж байгаа сургууль болох Их Засаг СЭЗ сургуулийн оюутнуудын багш нараа үнэлэх үнэлэмж ямар байгааг судлах, нөгөө талаас багш нарын сэтгэл зүйн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд хэрхэн ажиллаж байсан талаар сүүлийн 6 жилийн багш нарын сургалт, судалгааны ажлын талаарх мэдээллийг харьцуулан дараах байдлаар дүгнэлээ. Үүнд:

- Сургууль, тэнхимийн зүгээс багшийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалт судалгааны ажилд хамруулдаг боловч энэ нь зөвхөн мэргэжлийн болон заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх сургалтууд байдаг.
- Ихэнх багш нар багшийн мэргэжлээр сургуульд сурч төгсөөгүй, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн учир

1 *Профессор Х.Буяннэмэх, Л.Болдбаатар "Их, дээд сургуулийн багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх асуудалд" илтгэлээс*

2 *Ш. Ичинхорлоо "Дээд сургуулийн сургалт: онол арга зүй" 2011 он*

сэтгэл судлалын талаар мэргэших хэрэгцээ шаардлага үүсэн бий болж байна.

- Их Засаг СЭЗ сургуулийн оюутнууд багш нараа өөрсдийг нь ойлгодог тусалж дэмждэг байхыг уриалан санал дэвшүүлсэн байгаа нь оюутнуудаас авсан судалгаанаас тодорхой харагдаж байна. Мөн эндээс багш нарын харилцаа өөрчлөгдөж, оюутнаа хүндэтгэх, хэрэглэгчээ дээдлэх үзэл санааг түлхүү дэмжиж ажиллавал оюутан багш нарын хамтын ажиллагаа дээшилж, үр дүнтэй бүтээлч хандлага бий болж оюутнуудын сурлагын амжилт чанар дээшлэх боломжтой байна.
- Их дээд сургуулийн оюутнуудын сэтгэл зүйг нарийн судалж, түүнд тохирсон сургалтыг явуулах шаардлагатай учир нь насанд хүрсэн хүний хэрэгцээ, хүсэл сонирхол хүүхэд насныхаас илүү төлөвшин тогтсон, ертөнцийг үзэх үзэл зэргийг харгалзан үзэх шаардлагатай.
- Багш бүр өөрийн ажилдаа үргэлж үнэлэлт дүгнэлт өгч байх хэрэгтэй. Үүний тулд оюутнаасаа суралцаж, нээлттэй байж харилцан ойлголцох нь чухал.
- Мөн өөрийн ажилдаа байнга эргэцүүлэл хийж миний багшлах ажлын юу нь болж юу нь болохгүй байгааг тодорхойлж байх хэрэгтэй байна. Багш өөртөө эргэлзэх нь итгэлтэй бус байгааг биш харин хийж байгаа ажлаа улам төгөлдөршүүлэх, хэт бардамналаас сэргийлэх ач холбогдолтой.
- Манай сургуулийн хувьд оюутнуудыг мэргэжлийн сургалтаас гадна спорт, урлаг соёл хүмүүжлийн ажилд ач холбогдол өгч, цогц боловсрол олгодогоороо давуу талтай учир багш оюутны харилцаа зөвхөн хичээлийн хүрээгээр хязгаарлагддагтүй. Тиймээс энэ нь оюутны сэтгэл зүйг танин мэдэхэд чухал үүрэгтэй.
- Мөн 1 курсын оюутнууд бүлэг даасан багштай, 2-4 курсын оюутнууд оюутан хариуцсан багштай байдгаараа давуу талтай боловч, тэр бүр багшдаа өөрийгөө бүрэн ойлгуулж чадахгүй, сурлага муудах, муу зуршилд хөтлөгдөх хандлага ажиглагдсан.
- Ихэнх оюутнууд хөдөө орон нутгаас ирдэг, тэдэнд эхний жилд учраа мэдэхгүй сандрах, бэрхшээх зовлон ихээхэн тохиолддог учраас энэ үед голчлон сэтгэл санааг ойлгон хичээл сурлага, амьдрал ахуйд нь анги даасан багш илүү үүрэгтэй оролцох хэрэгтэй байна,

Судлаач миний хувьд энэ илтгэлийг бичих явцдаа хийсэн ажиглалт, судалгаагаа дээрх байдлаар дүгнэлээ.

Ашигласан материал

1. Б. Энхтүвшин "Багшлах урлаг" 2011 он
2. Д. Санжжав, Л. Жамц "Ерөнхий сэтгэл судлал"
3. МУИС НШУС "Дээд сургуулийн сургалтын технологи" 2007 он
4. Ш. Ичинхорлоо "Дээд сургуулийн сургалт: онол арга зүй" 2011 он
5. Ч. Пүрэвдорж " Багшлахуйн менежмент" анхны хэвлэл

Ашигласан илтгэл, сайт:

6. Профессор Х.Буяннэмэх, Л.Болдбаатар "Их, дээд сургуулийн багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх асуудалд" илтгэлээс
7. http://oudbs.must.edu.mn/
8. *www.mecs.gov.mn*

АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТАД ДУУ, ДҮРСНИЙ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БОЛОН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ НЬ

Ч.Оттончимэг
Их Засаг ОУИС гадаад хэлний хөтөлбөрийн багийн багш, магистр

Түлхүүр үг: Англи хэлний сургалтад үзүүлэх, харуулах, дүрс бичлэг, кино хичээлийг ашиглах нь

ОРШИЛ

Танин мэдэхүйд таван мэдрэхүйг ашиглах нь үнэнд хүрэх хамгийн дөт зам болдог. Ялангуяа гадаад хэлний сургалтад үзүүлэх, харуулах, сонсгох аргыг түлхүү хэрэглэх нь мэдлэгийг гүнзгийрүүлж тогтооход мэдэгдэхүйц нөлөөлдөг. Багш үзүүлэн таниулах олон төрлийн аргыг бусад аргатай хэрхэн хослуулан ашиглах талаар судалж мэдэн, ашиглаж, туршиж, эзэн нь болсноор хичээл заах аргаа ихээхэн хөнгөвчилж болно. Энэ нь сурах үйл явцад *чухал үүрэг гүйцэтгэж, багш, оюутны аль алиных нь* ажлыг хялбарчилж, мэдлэг, дадал, чадварыг гүн бат болоход үлэмж тустай.

"Мэдрэхүйгээр дамжуулж сурах хэрэгтэй", "Сурах үйлнээ олон мэдрэхүй оролцох тусмаа мэдлэг нь бат, нарийн болно", "Сурах үйл явцыг хялбар дөхөм ба ухамсартай байлгахын тулд олон мэдрэхүйг ашиглах нь зүйтэй" гэх зэргээр эрдэмтэд /Н.К.Гончаров, К.Д. Ушинский г.м/ онцолсон байдаг. Оросын нэрт эрдэмтэн К.Д. Ушинский "... аливаа хүн хэлбэр дүрс, дуу авиа, өнгө будаг хийгээд сэрлээрээ" сэтгэн боддог гээд "Зураг үзүүл, хэлгүй хүүхэд ч хэлтэй болно"[115] хэмээн үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүний тус эрдмийг үнэлж сайшаасан байхад монголын орос судлалын анхны эрдэмтэн доктор С. Галсан: "Үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүн гэдэг нь зөвхөн зураг, биетүүдийг үзүүлэх, мөн үйлдэх төдий зүйл биш юм. Энэ бол судалж буй хэрэглэгдэхүүнийг тусган авч, тогтооход хамаг мэдрэх эрхтэн оролцох явдал гэжээ.

Дуу дүрсний хэрэглэгдэхүүн болон техник хэрэгсэл ашиглах нь

Орчин үеийн техник технологийн зуунд гадаад хэл судлахад зурагтаас цахим хэрэглээнд, дуу хураагчаас гар утасны бичлэгт шилжиж, цахим ном, сурах бичиг, амьдралд нэвтэрч, зайн сургалтын ачаар цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах сайхан боломж бүрдэж байна. Гадаад хэлийг амжилттай сурах нэг үндсэн нөхцөл бол биет үзүүлэн, макет/, загвар, чихмэл, ном, үзэг, цүнх гэх мэт биет зүйл/; тэмдэгт үзүүлэн/ бүдүүвч, тэгшитгэл, схем/; дүрст үзүүлэн/ хар болон өнгөт, тайлбартай /-гүй. зураг, гэрэл зураг, уран зураг, үйл явдлыг илтгэсэн цуврал зураг, график диаграм, газрын зураг, дэлгэцийн болон дүрс бичлэгийн кино/ зэрэг үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүнийг сургалтад сайн ашиглах явдал юм. Эдгээр төрлийн үзүүлэн нь суралцагч гадаад хэлээр санаа бодлоо илэрхийлэх бодит нөхцлийг бүрдүүлж, хэлний нөөцөө эргэлтэд оруулах боломж бүрдүүлж, багш, *суралцагчийн ажлыг хөнгөвчлөн, үгийн сан, хэлний* зүйн мэдлэгийг батжуулахад гол тулгуур нь болж, сургалтсэтгэл зүйн талаас илүү үр дүнтэй байдгийг судлаачид тэмдэглэсэн байна.

Үзүүлэн таниулах болон техник хэрэгсэл ашигласнаар дараах нөхцлийг бүрдүүлнэ. Үүнд:

1. Сургалтын үйл явцыг бүхэлд нь хурдасгаж, хугацааг нь багасгана.
2. Суралцагчидтай ганцаарчлан ажиллах боломж бүрдэнэ.
3. Цаг хугацаа, хөдөлмөр хэмнэнэ.
4. Сургалтын бодит харилцаанд дээд зэргээр дөхүүлнэ.
5. Сургалтыг удирдах таатай нөхцөл бүрдэнэ.
6. Яагаад хэмээх асуултад хариулах бүтээлч боломжийг бүрдүүлнэ.

Ямар мэдрэхүйгээр дамжуулж орчин тойрноо мэдрэн, ухаарч байна гэдгээс болж, үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүн нь харах, сонсох, харах-сонсгох болон тэр ч бүү хэл хүртэх, амтлах байж болно. Хэрэглэгдэхүүнийг хэрхэн ухааруулж байгаагаас шалтгаалан тогтмол болон хөдөлгөөнт гэж ангилдаг ба тогтмолд бүдүүвч, хүрд, хүснэгт зэрэг ордог бол хөдөлгөөнтөд хөдөлгөөнт хүрд, хүснэгт, сургалтын кино орно. Үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүн хөдөлгөөнтэй байвал үр бүтээл сайтай байдаг.

Сонсгох, харуулах хэрэглэгдэхүүн болон техник хэрэгсэлд тавих шаардлага

1. Урьдчилан бэлдэж боловсруулан, тогтмол ашиглах
2. Сурацагчдын насны онцлогт тохирсон байх
3. Өнгө үзэмж сайтай, тод, ойлгомжтой, сурагчдын хүсэл сонирхлыг татсан, тэдний гоо зүйн хүмүүжил, төлөвшилд нааштай нөлөөлөхүйц байх
4. Сургалтын тухайн үеийн зорилго, зорилтод нийцсэн байх
5. Хичээлийн цогц бүрдлийн нэг хэсэг, сургалтын хэрэгсэл болж байх
6. Багш уг хэрэгслийг ашиглах чадвар, бэлтгэлтэй байх
7. Техник хэрэгслийн техөөрөмж нь байнга бүрэн ажиллагаатай байх гэх мэт.

Англи хэлний сургалтад кино хичээлийг ашиглах аргачлал

Гадаад хэл заах явцад сонсох ой туйлын чухал боловч мэдээлэл хүлээн авахад харааны ой хавьгүй илүү багтаамжтай, тухайлбал, харааны ой нь сонорын ойгоос 16 дахин илүү их мэдээллийг хүлээн авдгийг эрдэмтэднэгэнттогтоожээ. [1] Үүнээс үзвэл, сонсож ойлгох үйлдэл нь маш нарийн төвөгтэй үйл явц, ийм учраас түүнийг хөнгөвчлөх зорилгоор үзүүлэн таниулах материалыг сургалтад их ашигладаг байна. Ийнхүү үзүүлэх, сонсгох материалыг хослуулан ашиглах нь гадаад хэлний сургалтыг илүү үр өгөөжтэй, сонирхолтой, баялаг хэлбэртэй болгоод зогсохгүй, хичээлийн агуулгыг нүд, чихэнд наалдуулж өвөрмөц сэдлийг төрүүлдэг байна. [2]

Гадаад хэл заах явцад сонсох ой туйлын чухал боловч мэдээлэл хүлээн авахад харааны ой хавьгүй илүү багтаамжтай, тухайлбал, харааны ой нь сонорын ойгоос 16 дахин илүү их мэдээллийг хүлээн авдгийг эрдэмтэднэгэнттогтоожээ.[3] Үүнээс үзвэл, сонсож ойлгох үйлдэл нь маш нарийн төвөгтэй үйл явц, ийм учраас түүнийг хөнгөвчлөх зорилгоор үзүүлэн таниулах материалыг сургалтад их ашигладаг байна. Ийнхүү үзүүлэх, сонсгох материалыг хослуулан ашиглах нь гадаад хэлний сургалтыг илүү үр өгөөжтэй, сонирхолтой, баялаг хэлбэртэй болгоод зогсохгүй, хичээлийн агуулгыг

1 *Профессор Х.Буяннэмэх. Л.Болдбаатар "Их, дээд сургуулийн багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх асуудалд" илтгэлээс*

2 *Ш. Ичинхорлоо "Дээд сургуулийн сургалт: онол арга зүй" 2011 он*

3 *Rogova G.V. teaching hearing and speaking \\ methods of teaching English. M. 1983. 183-р тал*

"Нүд чихэнд "наалдуулж", өвөрмөц сэдлийг төрүүлдэг байна"[4]. Энэ тухайд бол монголчууд "Чих худлаа, нүд үнэн", "Мянга сонсохоор нэг үз" гэдэг билээ.

Үзүүлэх, сонсгох хэрэглэгдэхүүнийг хослуулан хэрэглэж болох олон төрөл зүйлийн дотроос богино хугацаанд их мэдээллийг өгч, сургалтын орчин бүрдүүлэхэд юутай ч зүйрлэшгүй үүрэгтэй киног хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй авч үзье.

"Кино нь сурацагчдад хүчтэй сэтгэгдэл төрүүлж, гадаад хэлний орчинд тэднийг хөтлөн аваачдаг"[119], хүрээлэн буй орчны бүх нарийн ширийнийг хамгийн тод томруун, итгэл үнэмшилтэйгээр илэрхийлдэг урлаг юм. Киноны үйл явдлын өрнөл нь хүний анхаарлыг нэг зүйлд төвлөрүүлж чаддаг, баатрууд нь янз бүрийн нөхцөлд байдалд өөр өөр найруулга бүхий үг яриаг чанга, сул, хашгирах, уйлах, учирлах зэрэг олон хэлбэрээр өгүүлэх тул сонсох, ярих дадал, чадварыг хөгжүүлэх өргөн боломцоотой, хэлэх бодит орчинг бүрдүүлж, сургалтыг эрчимжүүлдэг олон давуу талтай сургалтын хэрэглүүр юм. Кинонд эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу, хүүхдийн г.м. янз бүрийн дуу хоолой байх тул сурацагчид зөвхөн багшийн бус, бодит амьдралд буй бүхий л дуу хоолойг сонсч, дасах боломцоотойгоос гадна кинонд хөндсөн сэдвийн дагуу ярилцлага, маргаан, мэтгэлцээн зохиож, эсээ бичүүлэх зэргээр хэл яриаг хөгжүүлж, сурацагчдыг төлөвшүүлэхэд нөлөөлөх сайхан боломжийг олгодог. Киног хэд хэдэн удаа үзүүлсний дараа уг кинонд дуу оруулах, ерөнхий агуулга, үзэл санаа, үйл явдлыг шүүмжлэн яриулах, санаа бодлыг сонсох нь хичээлийг сонирхолтой, амьдралд ойрхон болгож, ажиглах чадварыг хөгжүүлэн, хурдан тогтоох нөхцлийг бүрдүүлж, хэлний бэрхшээлийг даван туулахад тулгуур болдог.

Сүүлийн үеийн, сонирхолтой кинонуудаас сургалтанд тохирохыг нь сонгон ашиглавал бодит амьдралын хэл, яриа сурахадихэдтустай, бусад аргаас үр дүнтэй. Кино үзэж, сонсонгоо жүжигчдийг дуурайж хэлэх, ярих дасгал хийдэг нь хазгай хэлж сурахаас сэргийлдэг, хэл ярианы орчинг бүрэн бүрдүүлнэ. Хэлэх ярих зүйлээ эх хэлээрээ бодон орчуулах бус, тухайн гадаад хэлээрээ бодож сэтгэх, төсөөлөх байдлаар чанадын ухамсарт нөлөөлөх маягаар сурдаг тул сурацагчид кино хичээлийг амархан, сонирхолтой, хөгжилтэйд тооцдог. Киног дахин дахин үзэж, хамтран орчуулах, хэлэлцэх зэрэг арга нь гэрийн даалгавар хийх уйтгартай бөгөөд улигтажлаас огтөөр сэдэл төрүүлдэг. Жүжигчдийн

хурдыг гүйцэж ярьж сурах нь хурдан яриаг ойлгуулах, хөгжүүлэх тустай. Зориуд тусгайлан бэлдсэн кино хичээлээс гадна дараах төрлийн дүрс бичлэгийг ашиглаж болно. Үүнд:

- Уран сайхны болон баримтат кино;
- Хүүхэлдэйн кино;
- Зурагтын мэдээ болон бусад нэвтрүүлгийн бичлэгийн хэсэг;
- Дууны дагуул /клип/;
- Зар сурталчилгаа;
- Дэлхийн янз бүрийн хот болон музейгээр аялсан тухай бичлэг;
- Цахим бичлэг г.м.

Эдгээрийг ном, сурах бичиг дагалдан ирдэг бичлэгээс авахаас гадна багш нар өөрсдөө тухайн хичээлийн агуулгыг өргөжүүлэх зорилгоор тусгайлан хийж бэлтгэх, эсвэл бусдын бичлэгийг ашиглаж болно. Хүндийг нь хөнгөвчилнө. Дүрс бичлэг нь эх болон гадаад хэлээр байж болох бөгөөд хэлний хувьд хөнгөн хэрэглэгдэхүүнийг нийгэм, соёлын[4] харилцааны тухай хэлэлцүүлэгт ашиглаж,ярианы болон бичгийн хэлийг хөгжүүлэхэд хэрэглэнэ.

Дүрсийг хичээлд үр дүнтэй ашиглахын тулд дараах зүйлд анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Багш үүнийг ашиглах нь чухал юм гэдгийг ухаарсан байх;
- Ашиглаж буй дүрс бичлэг нь суралцагчдын ерөнхий мэдлэг,хэлний төвшинд тохирч байх;
- Хичээлийн цаг /сонгосон үе шатны/-аас хэтрэхгүй байх;
- Суралцагчдын хэл, яриа, нийгэм соёлын чадварыг хөгжүүлэх сонирхолтой боломжийг бүрдүүлэх;
- Хам сэдэв нь шинэлэг, гэнэтийн үзэгдэл мэт санагдуулах;
- Хичээлийн үечлэл, даалгавар бүрийг тодорхой,ойлгомжтой зөвлөмжөөр хангасан байх;
- Кино гаргах төхөөрөмжийг урьдчилан шалгаж тохируулсан, багш түүнийг ашиглаж дадсан байх;
- Багш өөрөө үзүүлэх зүйлээ урьдчилан үзээд, эхлэхэд бэлэн болгосон байх.

Техник хэрэгслийн үсрэнгүй хөгжлийн энэ зуунд гадаад хэлний сургалтад үлэмж ихээр нэвтэрч байгаа кино-хичээлийг ашиглах дараалал:

- Бэлтгэх үе: кино үзүүлж буй зорилгоо тодорхой тайлбарлаад, тулгуур үг хэллэг, ярианы загварыг өгч, кинотой холбоотой хэлний шинжлэлийн болон орон судлалын тайлбар хийх:
- Киноны үндсэн агуулгыг ойлгох зорилгоор эхэлж үзүүлэх;
- Ерөнхий агуулгыг ойлгосон эсэх талаар ярилцах;
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг тогтоож авах зорилгоор тусгайлан бэлдсэн дасгалуудыг хийх;
- Агуулгыг нь бүрэн ойлгох зорилгоор 2 дахь удаа үзэхдээ дотроо даган ярьж, зөв дуудах, зөв аялгатай хурдан ярьж, яриаг тогтоох дасгал хийлгэх;
- Киноны агуулгыг ойлгосон эсэхийг нарийвчлан шалгах;
- Шаардлагатай бол цаасан дээр урьдчилан бичсэн киноны яриаг ашиглаж,дасгал хийх, заримыг нь гэрийн даалгаварт өгөх;
- **Киноны дууг хасч үзүүлээд, суралцагчдыг баатрынх нь дүрд хувирган дуу оруулуулах** /Шууд яриа зохиоход хэрэг бүхий чухал хэсэг/;
- Суралцагчдын дуу хоолойг бичиж,эргүүлэн сонсгож, өөрийг нь өөрөөр нь, дараа нь бусад суралцагчдаар хянуулах, алдааг нь залруулах дасгал хийлгэх;
- **Хэлэлцүүлэг зохиох:** киноны нэр, гол агуулга, зохиолчийн дэвшүүлсэн санаа, жүжигчдийн ур чадвар, тэдний бүтээсэн дүрийг задлан шинжлэх, агуулгыг хэлэлцэх,зохиолыг үргэлжлүүлэн ярих г.м. Хэлэлцүүлэгт бэлтгэж ярианы чадварыг хөгжүүлэх сонирхолтой даалгаврыг урьдчилан зохиож болно. Тухайлбал:

✓ Зохиолын баатрын дүрд тоглох
✓ Киноноос жишээ татаж, зохиолын баатруудын зан байдлыг тодорхойлох;
✓ Зохиолын баатрын оронд байсан бол юу хийж болохыг ярих;

ДҮГНЭЛТ

1. Англи хэл дээр дэлхийн шилдэг, гайхамшигтай кинонуудыг үзэж, чөлөөтэй ойлгон инээж, догдолж баясан дэлхий ертөнцтэй нэгдэх сайхан боломж бидний өмнө нээгдэж байна. Бид үнэхээр зугаатай байдлаар цагийг өнгөрүүлж, ямар ч элдэв дарамт шахалтгүйгээр сурах үйл явцаасаа жинхэнэ таашаалыг мэдэрч, нэг мэдэхэд

4 *Черчоньян Р.Н. Обучение монгологической речи на среднем этапе обучения \\ИЯШ. 1974. №3.*

4 *Rogova G.V. teaching hearing and speaking\\ methods of teaching English. M. 1983. 183-р тал.*

л англи хэлээр чөлөөтэй ойлгодог, ярьдаг, инээдэг болох болно. Энд хэцүү зүйл огт байхгүй. Энэ ердөө л бидний дуртай кино шүүдээ.

2. Гадаад хэл заах явцад сонсох ой туйлын чухал боловч мэдээлэл хүлээн авахад харааны ой хавьгүй илүү багтаамжтай, тухайлбал, харааны ой нь сонорын ойгоос 16 дахин илүү их мэдээллийг хүлээн авдгийг эрдэмтэд нэгэнт тогтоожээ.[5]
3. Сонсож ойлгох үйлдэл нь маш нарийн төвөгтэй үйл явц, ийм учраас түүнийг хөнгөвчлөх зорилгоор үзүүлэн таниулах материалыг сургалтад их ашиглах учиртай. Ийнхүү үзүүлэх, сонсгох материалыг хослуулан ашиглах нь гадаад хэлний сургалтыг илүү үр өгөөжтэй, сонирхолтой, баялаг хэлбэртэй болгоод зогсохгүй, хичээлийн агуулгыг нүд, чихэнд наалдуулж өвөрмөц сэдлийг төрүүлдэг байна. [6]
4. Сүүлийн үеийн сонирхолтой кинонуудыг сургалтад ашиглан кинонд дуу оруулах, хэлэлцүүлэг зохиох, киноны дагуу урьдчилсан бэлтгэсэн асуултанд хариулах зэрэг үр дүнтэй аргуудыг ашиглаж болох юм.

Зөвлөмж

Дүрс бичлэгийг хичээлд үр дүнтэй ашиглахын тулд дараах зүйлүүдийг анхаарах нь зүйтэй.

1. Дүрс бичлэг нь суралцагчийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх.
2. Дүрс бичлэг нь суралцагчдын ерөнхий мэдлэгь хэлний төвшинд тохирч байх
3. Дүрс бичлэгийг үзэж дууссаны дараа хэлэлцүүлэг зохиох
4. Агуулгыг бүрэн ойлгох зорилгоор 2 дахь удаагаа үзэхдээ дотроо даган ярьж, зөв дуудах, зөв аялгатай хурдан ярьж яриаг тогтоох дасгал хийлгэх
5. Суралцагчдын дуу хоолойг бичиж,эргүүлэн сонсгож, өөрийг нь өөрөөр нь, дараа нь бусад суралцагчдаар хянуулах, алдааг нь засах,урамшуулах
6. Дүрс бичлэгийг сонсоод дууг нь хасч дүрд тоглох зэрэг үр дүнтэй аргуудыг ашиглах нь зүйтэй.

Ашигласан материал

1. Батмөнх.С,Гадаад хэл заах онол аргазүй, Уб,2014
2. Черчоньян Р.Н. Обучение монологиеческой Речи на среднем этапе обучения\\ ИЯШ,1974,№3
3. Rogova G.V. teaching hearing and speaking\Methods of teaching English\ M,1983
4. Черчоньян Р.Н. Обучение монгологической речи на среднем этапе обучения \\ИЯШ,1974, №3.
5. Дашдаваа Д. Гадаад хэл. Уб.,1967
6. Нямжав Д. Гадаад хэл заах аргазүйн онол,хэрэглээний асуудал. Уб.,2009
7. Kathleen Ricards Hopkins. Teaching how to learn in a What-to-learn culture. 2010.,USA

Цахим эх сурвалжууд

www.youtube.com
www.eslvideo.com
www.fluentu.com
www.TV 411.com
www.coursera.com
www.british Council.com
www.CNN Video News.com
www.Discovery.com
www.Funny or Die.com
www.collegehumor.com
www.PBS.com
www.Bigthink.com
www.TED.com
www.wonderhowto.com
www.Adam Savages' Tested.com

5

6 *Черчоньян Р.Н. Обучение монологиеческой Речи на среднем этапе обучения \\ ИЯШ. 1974.№3*

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ- ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Н.Тунгалагтамир
Их Засаг ОУИС-ийн багш, докторант

С.Түмэндарь
Их Засаг ОУИС-ийн ахлах багш, магистр

Түлхүүр үг: бүтээлч сэтгэхүй, дээд боловсролын стандарт агуулга, инноваци, танин мэдэхүй, хөгжил, өөрчлөлт, бүтээгдэхүүн

Хураангуй: Даяаршин өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд боловсролын салбар тэргүүлэх эгнээнд тавигдаж байна. Тухайн цаг үед ноёлж байсан боловсролын чиг шугам,сурган хүмүүжүүлэх арга, технологи, тэрчлэн хэл, сэтгэхүй, танин мэдэхүй, рациональ чанар болон логикийн талаархи философи үзэл, төсөөллүүдээс хамааарч янз бүрээр хэрэгжиж иржээ. Боловсрол нь өөрчлөлт хийхэд тун ярвигтайд тооцогддог нийгмийн институт юм. [1] Хамгийн гол нь цаг үедээ нийцсэн **зорилго**, түүнд хүрэх **арга хэрэгсэл** боловсролын салбарт дутагдаж, **"сурч байгаа хүн"** түүний **сэтгэхүй, танин мэдэхүй,** үнэлэмжүүдийг ойлгох ойлголт үгүйлэгдэж байна. Иймээс дээд боловсролын агуулга стандартанд тусгагдсан гол зүйл бол **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ** үүнийг орчин үеийн **ИННОВАЦИ** хэмээх ойлголттой хослуулбал бүтээлч сэтгэхүйтэй чадварлаг, боловсон хүчин бэлтгэх их дээд сургуулийн сургалтын ахисан түвшний зорилго бүрэн дүүрэн биелнэ.

Аливаа улс орны хөгжлийн түвшинг тодорхойлох гол хүчин зүйл нь боловсрол, иргэний боловсрол, боловсролын харилцаа юм. Боловсролын стратеги зорилго нь мэдлэгтэй, ухаалаг, нийгэм ёс суртахууны хувьд хариуцлагатай иргэн төлөвшүүлэхэд чиглэгддэг. Энэхүү зорилго нь тухайн цаг үед ноёлж байсан боловсролын чиг шугам, сурган хүмүүжүүлэх арга, технологи, тэрчлэн хэл, сэтгэхүй, танин мэдэхүй, рациональ чанар болон логикийн талаархи философи үзэл, төсөөллүүдээс хамааарч янз бүрээр хэрэгжиж иржээ. Профессор М.Липман өөрийн "Боловсрол дахь сэтгэхүй" зохиолдоо "Боловсрол бол судалгаа, бас сэтгэлгээний дадал хэвшил сургалт болох тухай, түүнчлэн шүүмжлэлт мэтгэлцээний соёл дах философи, философи мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх арга зүй"[1] гэх зэргээр тодорхойлжээ. Боловсрол нь өөрчлөлт хийхэд тун ярвигтайд тооцогддог нийгмийн институт юм. [2] Хамгийн гол нь цаг үедээ нийцсэн **зорилго**, түүнд хүрэх **арга хэрэгсэл** боловсролын салбарт дутагдаж, **"сурч байгаа хүн"** түүний **сэтгэхүй, танин мэдэхүй,** үнэлэмжүүдийг ойлгох ойлголт үгүйлэгдэж байна. Энэхүү судалгааны **ажлын зорилго нь** дээд боловсролын хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон шинэлэг арга хэрэгслүүр боловсруулахад оршино.

Энэхүү зорилгондоо хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлэн тавьлаа

- ✓ Дээд боловсролын тухай онолын материалтай танилцах
- ✓ Дээд боловсролын хуулийн хэрэгжилтэнд анализ хийх
- ✓ Шинэлэг арга замыг туршин нэвтрүүлэх

Судалгаандаа орчин үеийн хэл шинжлэл болон боловсрол сурган заах аргазүйд өргөн хэрэглэгддэг танин мэдэхүйн ерөнхий арга,онолын болон онолын бус аргууд болох индукци, дидукци, ажиглалтын аргыг тус тус хэрэглэсэн болно.

Хорьдугаар зууны сүүл үеэс монгол улсад дээд боловсролын тогтолцоо бүрэн утгаараа цэцэглэн хөгжиж, улс орны хэмжээнд боловсон хүчний нөөцийг хангах түвшинд хүрч, бүрэлдэн тогтсон боловч, төр нийгэм, эдийн засгийн өөрчлөлт өрнөсөн 1990-1991 онд Боловсролын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр өмчийн аль ч хэлбэрт үндэслэсэн сургалтын байгууллагыг байгууллага,иргэн үүсгэн байгуулж болохыг хүлээн зөвшөөрсөнөөр хувийн хэвшлийн их дээдсургуулиуд үүсэн бий болохын зэрэгцээ боловсролын зах зээл дээр төлбөртэй сургалтын хэлбэр давамгайлах болсон. Энэхүү хуулийн заалтын дагуу 1991-2009 оныг хүртэл 19 жилийн хугацаанд манай улсад хувийн өмчийн 100-иад их дээд сургууль, коллеж үүсгэн байгуулагдаж зохих байр сууриа олжээ.

Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан

1 *Ш. Ичинхорлоо "Дээд сургуулийн сургалт: онол арга зүй" 2011 он*

боловсролын үндсэн зарчим, **олон улсын нийтлэг жишиг**, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино. Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөдсуралцагчидшинжлэх ухаан,технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, **эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл**, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, **судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх**, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг,чадвар,дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. [3] хэмээн тодорхойлсон байдаг. Дээр дурьдсанчилан дээд боловсролын агуулга болон зорилгод цаг үедээ нийцсэн **зорилго**,түүнд хүрэх **арга хэрэгсэл**, "**сурч байгаа хүн**" түүний **сэтгэхүй, танин мэдэхүй, үнэлэмжүүдийг** ойлгох ойлголтыг тусгаж өгөөгүйгээс дээд боловсролын сургалтын чанар, нийүүлэлт нь суралцагч, ажил олгогч, олон нийтийн эрэлтэд тохирохгүй, төгсөгчдийн мэдлэг чадвар, хувийн төлөвшил нь орчин үеийн ажлын байрны шаардлагыг хангахгүй ажилгүйчүүдийн эгнээг нэмж байна. Зарим төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургуулиудын тухайд аль социализмын үеийн техник, технологи дээр тулгуурлан сургалт явуулж байгаа нь мэдлэгийн хүрээг тэлэх, технологийн хөгжлийг хөтлөх үүрэгтэй их сургуулийн систем бүрдэж чадаагүй эрдэм шинжилгээний ажил хангалттүй байгааг гэрчилж байна. Олон улсын түвшинд **эрдэм шинжилгээний ажилд** дээд боловсролын төсвийн 7-10 хувийг зарцуулдаг бол манайд 2.7 хувь нь зарцуулагдаж байна гэсэн статистик мэдээ байна. Ил бүгдээс шалтгаалан дээд боловсролын агуулга дахь эрдэм шинжилгээний ажлыг онол практиктай хослуулан орчин үеийн шинэлэг арга технологт нийцүүлэн хэрэглээ болгох асуудал нэн тэргүүний чухал асуудал болж буйг анхаарах хэрэгтэй.

Эрдэм шинжилгээний ажил гэдэг бол тухайн хүний **бүтээлч сэтгэхүйн** дүнд үүсэн буй болсон хэрэгжүүлж болохуйц **шинэ санаа** юм.

Сэтгэхүйн бүтээлч чанарын тухай ойлголт нь сэтгэл судлалын шинжлэх ухаандөнгөрсөн зууны 50-иадоноос судалгааны нэг салбар болон орж ирсэн. Энэ чиглэлийн анхдагч Ж. Гилфорд Америкийн сэтгэл зүйчдийн холбооны ерөнхийлөгч байхдаа мэргэжил нэгтнүүдийнхээ анхаарлыг бүтээлч сэтгэхүйн судалгаанд хандуулах оролдлогийг хийж байжээ. Одоогоор АНУ-ын хувьд сэтгэл судлалын тэнхимтэй 1200 их сургуулийн 76 нь "**Бүтээлч сэтгэхүйн**" тухай хичээлийг заадаг байна. Бүтээлч сэтгэхүйн нэр томъёо, ангилалын талаар авч үзэхэд энэ нь латериаль, вертикаль, логик сэтгэлгээ шиг бие даасан ойлголт биш бөгөөд хүний сэтгэхүйн далд гүнд орших тэр бүр илрээд байдаггүй ч хүний мөн чанарыг хамгийн тодорхой харуулдаг үзүүлэлт юм. Нэр томъёоны хувьд бүтээлч сэтгэхүй хэмээх ойлголтыг (англ. create — бүтээх,англ. creative — бүтээгч) креатив гэдэг үгээр төлөөлүүлэн хэлж болно.

Өөрөөр хэлбэл эрдэм шинжилгээний ажил нь **шинэ санаа** гаргахад байдаг үүнийг **Инноацитай** хослуулбал үр өгөөжтэй **сургалтын хэлбэр** болох төдийгүй өнөөгийн шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхийн сацуу улс орны эдийн засаг, боловсролын салбарт чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Эдийн засгийн онолдолон янзаар тодорхойлж байгаа инноацийн талаархи олон улсын стандарт ойлголтыг нэг мөр болгоход ач холбогдол бүхий 1993 оны Фраскатын удирдамжид "Инноваци" гэж шинэ бас шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессийг боловсронгүй болгох,нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн" гэж тодорхойлсон байдаг. [4]

Товчоор хэлбэл энэ ойлголтыг **аливаа шинэ бүтээмж, шинэ санааг** эдийн засгийн эргэлтэд оруулж, мөнгө олох **БОЛОМЖ** гэж ойлгож болно. Аль ч салбарт хэрэгжүүлж буй инноацийн үр нөлөөг боловсролын салбаруруулж суурьшуулах бүрэн боломжтой.

САНАЛ

I. Хичээл бүрийг **бүтээлч сэтгэхүйн хүрээнд эрдэм шинжилгээний** ажлын хэлбэртэй зохион байгуулах

Тухайлбал: П. М. Якобсоны дэвшүүлсэн үзэл баримтлал дээр тулгуурлан дараах хэлбэрээр зохион байгуулах (1934).

1. Оюун ухааны бэлтгэл үе.
2. Асуудлыг олж харах үе.
3. Шинэ санаа төрөх үе.
4. Шийдэл хайх үе.
5. Шийдлийн зарчмыг тодорхойлох үе.
6. Шийдлийг зураглаж,тодорхойлох үе.
7. Шийдлийн техникийн ажиллагаа хийгдэх үе

II. Эрдэм шинжилгээний ажлыг **бүтээгдэхүүн** талаас нь үнэлж дүгнэх \ тоо,чанар, ач холбогдол\ тухайн бүтээгдэхүүнийг хийж буй хүний ажлын бүтээмжийг илэрхийлдэг.

III. Тухайн хүнийг чадвар талаас нь үнэлэх \ бүтээлч сэтгэхүйн\ ингэснээр хэвшмэл

сэтгэхүйгээс татгалзах боломжтой

IV. Бүтээлч сэтгэхүйг эрдэм шинжилгээний ажил нарийн уялдаа холбоотой байснаар цорын ганц хариултыг хайх бус асуудлыг олон янзаар шийдэх боломжийн олж харахын зэрэгцээ сэтгэхүйн үйл явц хөгжүүлэх боломж байна.

В. Инноваци хөгжүүлэх үндсэн суурийг буй болгох

V. Эрдэм шинжилгээний үндсэн дээрхи шинэ санааг шинэ технологийн тусламжтайгаар амьдралд хэрэглэх, туршин нэвтрүүлэх

VI. Дээрхи технолгийг нэвтрүүлэх мэргэжилтэнг бэлтгэхэд туслан ажиллах

VII. Шинэ санааг олон түмэнд хүргэхэд үзүүлэх эдийн засгийн дэмжлэг

VIII. Сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагуудын уялдаа холбоо, түншлэлийг дээшлүүлэх

IX. Эрдэм шинжилгээ судалгааны орчин нөхцлийг сайжруулах, эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

X. Дээд боловсролын гурван талт харилцаа \ удирдлага, багш, оюутан\ нийгэм сэтгэлзүйн таатай орчинг бүрдүүлэх

XI. Төрийн болон төрийн бус хэвшлийн их дээд сургуулиудын дээд боловсролын агуулга стандартыг **МОНГОЛ ХҮНИЙ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНД СУУРИЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫГ**\ шинэчлэн сайжруулж олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүргэж ижил түвшинд дагаж мөрдөх Хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд боловсролын салбар тэргүүлэх эгнээнд эн тэнцүүхэн өрсөлдөх буюу хэдэн алхмын өмнө байх ёстой. Ийм ч учраас бидсургалтын агуулга аргазүй,үнэлэмж шинэчлэлээ өөрчлөн **бүтээлч сэтгэхүйг** хэрэглээнд оруулан ажлын бүтээмж, хүртээмжээ нэмэгдүүлэх шаардлага урган гарч байгаа билээ.

Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, **эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл,** үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг,чадвар,дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. [5] хэмээн тодорхойлсон байдаг. Дээр дурьдсанчилан дээд боловсролын агуулга болон зорилгонд цаг үедээ нийцсэн **зорилго**,түүнд хүрэх **арга хэрэгсэл**, **"сурч байгаа хүн"** түүний **сэтгэхүй, танин мэдэхүй, үнэлэмжүүдийг** ойлгох ойлголтыг тусгаж өгөөгүйгээс дээд боловсролын сургалтын чанар, нийлүүлэлт нь суралцагч, ажил олгогч, олон нийтийн эрэлтэд тохирохгүй, төгсөгчдийн мэдлэг чадвар, хувийн төлөвшил нь орчин үеийн ажлын байрны шаардлагыг хангахгүй ажилгүйчүүдийн эгнээг нэмж байна. Зарим төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургуулиудын тухайд аль социализмын үеийн техник, технологи дээр тулгуурлан сургалт явуулж байгаа нь мэдлэгийн хүрээг тэлэх, технологийн хөгжлийг хөтлөх үүрэгтэй их сургуулийн систем бүрдэж чадаагүй эрдэм шинжилгээний ажил хангалттүй байгааг гэрчилж байна. Олон улсын түвшинд **эрдэм шинжилгээний ажилд** дээд боловсролын төсвийн 7-10 хувийг зарцуулдаг бол манайд 2.7 хувь нь зарцуулагдаж байна гэсэн статистик мэдээ байна. Ил бүгдээс шалтгаалан дээд боловсролын агуулга дахь эрдэм шинжилгээний ажлыг онол практиктай хослуулан орчин үеийн шинэлэг арга технологт нийцүүлэн хэрэглээ болгох асуудал нэн тэргүүний чухал асуудал болж буйг анхаарах хэрэгтэй.

Дээд боловсролын агуулга стандартанд тусгагдсан гол зүйл бол **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ** үүнийг орчин үеийн **ИННОВАЦИ** хэмээх ойлголттой хослуулбал бүтээлч сэтгэхүйтэй чадварлаг, боловсон хүчин бэлтгэх их дээд сургуулийн сургалтын ахисан түвшний зорилго бүрэн дүүрэн биелнэ. Улмаар туршилт судалгааны үр дүнг сургалтын стандартад нэвтрүүлэн олон арван асуудлыг шийдэж болно. Нэг зүйлийг онцолж хэлэхэд бүтээлч сэтгэхүй нь оюун ухааны чадамжаас өөр сургалтын таатай орчин нөхцөл, агуулгыг өөрчлөн хэрэгжүүлбэл үр дүн нь бодитой ил тод явагдах сургалтын шинэлэг хэлбэр болно. Цаашлаад инновацитай хослуулсан тохиолдолдтухайн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зардал багатай,үр ашигтай шинэ технологи буй болохын сацуу нийгмийн шаардлагийг бүрэн хангасан боловсон хүчин бэлтгэгдэнэ.

Ашигласан материал

[1] Юлина Н.С Философия для детей.-М., 1996,с.57-58

[2] Lipman M., Sharp A. M., Wondering at the World. Instructional Manual to Accompany Kio and Gus. Lanham, N.Y., L.,1986.P.12-25Буян. Д .,(2009). "Нийгмийн тухай

мэдлэг",1 дүгээр дэвтэр,УБ,

[3] [5] Дээд боловсролын тухай хууль. .,(2007). Боловсролын салбарын хууль тогтоомж/Эмхэтгэл/,БСШУЯ,УБ,х.51-63.

[4] Богоявленская Д.Б. Интеллектуальная активность как проблема творчества.- Ростов-на-Дону,1983.

[5] Д. Доржжав Сэтгэл зүйд нэрэх сурахуйн нь. Улаанбаатар, 2005 он Дээд боловсролын тухай хууль.,(2007). Боловсролын салбарын хууль тогтоомж/Эмхэтгэл/. БСШУЯ, УБ, х.51-63

АВИАН ЗҮЙН ТУХАЙ

Н.Туул
Их Засаг ОУИС-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа эрхэлсэн захирал, докторант

Авиан зүй буюу phonetics (φωνή буюу «дуу авиа», φωνηεντικός буюу «дуу авианы» гэсэн грек үгнээс гаралтай) нь хэл ярианы авиа, авианы бүтэц, үе, авианы хослол, хэл яриан дахь дуу авианы нэгдлийн зүй тогтлыг судалдаг хэл шинжлэлийн нэг салбар юм. Хэл нь хүмүүс хоорондын харилцааны хэрэгсэл болохын хувьд аливаа утгыг дамжуулах болон хүлээн авахад хэрэглэгддэг. Хэлний утга агуулга аман ярианд авианы нэгжүүдээр дамжин хэрэгждэг бол бичгийн хэлбэрт үсгээр илэрхийлэгддэг. Хэлний оршин тогтнох ярианы хэлбэр нь үндсэн буюу анхдагч гэж тооцогддог бол бичгийн хэлбэр нь хоёрдогч буюу үүсмэл гэж тооцогддог[1] байна. Авиан зүй нь хэл шинжлэлийн салбарын хувьд хэлний нэгжүүдийг тэдгээрийн хэлний утга бүхий нэгжүүдийг үүсгэхэд гүйцэтгэдэг үүрэгтэй нь холбон судалдаг. Хэлний авиан зүйн нэгжүүдийн бусад (үгсийн ангийн, өгүүлбэр зүйн болон үг зүйн) нэгжүүдээс ялгарах онцлог нь бие даасан утга санаа агуулдаггүйд оршдог. Авиан зүйн нэгжүүдийг тодорхойлохдоо хэлний утга агуулгыг бий болгоход (гүйцэтгэх үүрэг талаас нь) гүйцэтгэдэг үүргийг нь харгалзан үзэх шаардлагатай бөгөөд тэдгээрийн үндсэн «материаллаг», авиан зүйн шинж чанарыг авч үзвэл зохино.

Үйл ажиллагааны болон авиан зүйн гэсэн хоёр тал нь фонемаас эхлээд бүхэл бүтэн үг хэллэг хүртэлх янз бүрийн үргэлжлэл бүхий хэлний нэгжүүдийг тодорхойлоход чухал үүрэгтэй. Авиан зүйн нэгжүүдийн бүх шинж чанар хоорондоо нягт холбоотой: нэг талаасаа, тэдгээрийн материаллаг буюу бодит хэрэгжилтийг мэдэхгүй байж авиан зүйн нэгжүүдийн гүйцэтгэх үүргийн талаар ярих боломжгүй, нөгөө талаас нь авч үзэхэд, материаллаг, авиан зүйн шинж чанарууд нь фонемийн болон үйл ажиллагааны харилцаагаар тодорхойлогддог. Авиа бол хэлний хийсвэр тогтолцооны материаллаг тал, хэлний дохионы тэмдэг мөн тул хэлний үгийн сан, хэл зүйг авианаас гадуур төсөөлөх аргагүй[2] билээ. Яриан дахь авианууудын холбоо, бичиг эх үсгийн холбоо нь үг, өгүүлбэр бүтээдэг, эдгээр үйлдлийн хооронд төсөөтэй тал байх боловч мөн ялгаатай тал бий. Авианы бичигт хэлний авиаг үсгээр тэмдэглэдэг. Авиа ба үг, үсэг ба бичиг, үг ба өгүүлбэр хоорондын харьцаа хамаарлын тухай асуудал бол авиан зүйн гол судлагдахуун мөн. Аливаа хэлний авианы бүтцэд түүхэн хөгжлийн явцад авиа солигдох, гээгдэх, нэмэгдэх ёс зэрэг хэл шинжлэлийн талаархи мэдлэг нь хүмүүст эх хэлнийхээ үг ярианы соёлыг дээшлүүлэхэдтөдиигүи, дотоод зүй тогтол, зөв бичих зүйг эзэмшиж ойлгох, аливаа зүйлийг тод томруун илэрхийлж сурах зэрэгт маш их ач холбогдолтой.

Оросын авиа зүй судлаач Л.Р. Зиндэр - Аливаа хэлний үгийн санг бүрдүүлж буй олон түмэн үгийг авиа талаас нь авч үзвэл, ердөө хэдхэн арваар тоологдох авиалбар буюу фонемыг олон янзын эрэмбэ дараалалд оруулсан байдаг[3] гэжээ. Хэлний нэгж үгийн бүтцийг бүрдүүлж байгаа салангид авианууд нь тухайн хэлээр ярилцагч хүмүүсийн ухамсарт байнга орших хэлний бодитой нэгж тул нэг авиа нөгөөтэйгээ холбогдох байршил зүйн нарийн хууль дүрэмтэй байдаг. Нэгэнт хэлийг авианаас гадуур авч үзэх боломжгүй учир эрдэмтэд олон хэлний авианы шинж чанар, харилцан уялдаа холбоог судалсаар иржээ. Орон зай, цаг хугацааны хүчин зүйлд автагүй аливаа мэдээллийг дамжуулах хэрэгцээ байнга оршиж авианы бичиг үсэг боловсруулах, боловсруулсан бичиг үсгийг сайжруулах, шинэчлэхдээ аливаа авиаг бичигт хэрхэн тэмдэглэх зэрэгтэй холбоотойгоор хэл шинжлэлийн судлал эрчимжиж байв. Авиан зүйн судалгааны эхэн үедсудлаачид ихэвчлэн нэг хэлийг тухайлан авч үзэх, нэг хэлний олон авианы тус тусын бүтэх арга, сонсогдох байдал, ялгарах онцлог, хэрхэн уялдан холбогддог зэргийг судалж байв.

19 дүгээр зууны эхэн үеэс харьцуулсан хэл шинжлэл үүсч хөгжин эрдэмтэн судлаачид хэлний хэв шинжийн түгээмэл ба ягаатай тал, авиа бүтэх арга, сонсогдох онцлог, мөн авиа сэлгэх, ондооших ёс, хэлний олон түвшинд авиа зүйн хэрэглүүрийн гүйцэтгэх үүрэг зэрэг асуудлыг олон хэлний материалд тулгуурлан судалж эхлэв.

1 *Бондаренко В.П., Вербицкая Л.А., Гордина М.В., Основы общей фонетики, Санкт-Петербург, 1991*

2 *Шархүү А., Авиазүй, фонем судлалын үндсэн асуудлууд, УБ, 2006*

3 *Зиндер Л.Р., Общая фонетика, Ленинград, 1979*

Хэлний авианы тал бол угтаа бүтэх аргын хувьд анатоми, физиологид, сонсогдох байдлаараа физик үзэгдэлд хамаардаг[4]. Учир иймд авиа зөвхөн хүмүүс хооронд харилцааны хэрэглүүр – хэлний утгат хэсэг, үг ба морфемийн бүтцэд гүйцэтгэх үүргийн талаасаа хэл шинжлэлийн судлагдахуун болдог[5].

Иймхүү, авиан зүй нь хэл ярианы эрхтэний тусламжтайгаар эгшиг авиа хэрхэн бий болж зохицон нийцэж уламжлагддагтай уялдуулан тэдгээрийг ангилан ялгах, дүгнэхэд чиглэгддэг байна.

Хэл ярианы эгшиг авианууд нь хүний дуу хоолойноос гардаг дуу чимээний нийт цогцыг илэрхийлж барахгүй хэдий ч бидний дуу хоолойн авиа гаргах боломж хичнээн олон янз байсан ч чимээ авианы зөвхөн нэгээхэн хэсэг нь хэл ярианд ашиглагддаг.

Гагцхүү авиан зүйн судлал нь дуу авиа болон хэлний тэмдгийг ялгаж салгах, таньж мэдэх, бусад хүмүүсийн хэлж ярьж буй зүйлийг нарийн нягт ойлгон тайлах дадал чадварыг хөгжүүлэх зэргээс гадна илүү их зүйлийг судалдаг.

Авиан зүй болон хэл ярианы чадварыг харьцуулж үзэхэд хэлийг хэрэглэх чадварт хоёр түвшин байдаг. Нэг нь хэл ярианы үйл ажиллагаа бөгөөд энэ нь хүний үр дүнтэй харилцах чадвар юм. Хоёр дох түвшин нь мета-лингвистик буюу хэлийг хэрхэн ашиглах тал болон хэл соёлын бусад хэсэгтэй хэрхэн харилцан уялдаж буйг, хэлний тодорхой дүрмүүд хэрхэн яаж хэрэглэгдэж байдгийг ойлгож тайлбарлах чадвар юм. Авиан зүйн судалгаанд эдгээр ойлголтуудыг хэрэглэгддэг.

Хэлний авиан зүйн дадал чадварууд гэдэг нь харилцаж буй хүнийхээ яриаг сонсох, хэлж ярьсан зүйлийг тайлан ойлгох чадвар юм.

Мета-фонетика буюу мета авиан зүй нь үг хэллэгүүд өөрөөр бус чухамхүү ийм байдлаар хэлэгдэж дуудагдах талаархи хуримтлагдсан мэдлэг юм. Үүнд үгсийн үүсч бий болсон түүхэн утга, тэдгээрийн дуудлага, зөв бичилт, үгийг хэлэх үеийн агаарын урсгалыг өөрчлөх арга болон хэл ярианы эрхтэний ажиллагаа, эгшгийн шинж чанар зэрэгт нөлөөлөх анатомын (биеийн) бүтэц зэргийн *талаархи ойлголтууд багтана.*

Хэлний авианы тал нь бүтэх аргын талаасаа анатоми, физиологид, сонсогдох талаасаа физик үзэгдэлд хамаардаг[6] ажээ. Ийм учраас аливаа авиа гагцхүү хүмүүс хооронд харилцааны хэрэглүүр – хэлний утгат хэсэг, үг ба морфемийн бүтцэд гүйцэтгэх үүгийн талаасаа хэл шинжлэлийн судлагдахуун болдог[7] байна. Морфем (morpheme) гэдэг нь үгийн хамгийн бага хэсэг юм. Салангид авиаг үг ярианд сонсогдох талаас нь авч үзэхэд авиа л үг ба морфемын бүтэц дэх байрлал, авианы зүйн бусад нөхцлөөс хамааран өөр өөр авианууд ижилсэх, эсвэл, ижил, төсөөтэй авиа ондооших зарим тохиолдлууд ажиглагддаг. Авиа үгийн бүтэц дэх байрлалаас шалтгаалахаас гадна авиа өөр хооронд харилцан хамаарч өөрчлөгддөг байна.

Хэлний нэг л авиа үг ба морфемын бүтэц дэх байрлал, авианы дуудлагад нөлөөлөх нөхцлөөсөө хамаарч хэлний тогтолцоонд авиа бүхэн бус, гагцхүү нэг үгийг өөр бусад үгээс ялгаж өгч чадах тийм л авиа чухал тул аливаа авиаг үг ба морфемыг зааглан тусгаарлах, үгийн утга ялгах хэрэглүүр болох тал, хэлэхүйд гүйцэтгэх үүрэг талаас нь судлах шаардлагатай[8] ажээ.

Авиа бол амаар өгүүлж чихээр сонсогддог хэлний материаллаг тал юм. Авиа салангид байдлаараа утга илэрхийлдэггүй боловч хүний хэл нь авианы дохио байдагчлан авианаас гадуур үгийн сан, үг зүй, өгүүлбэрийн тухай ярих аргагүй юм.

Авиан зүйд хэлний авианы бүтцийг хэлэх, өгүүлэх байдлаар нь өгүүлэх эрхтэний (өгүүлүүр) оролцоо талаас нь, сонгсогдох байдлаар нь сонсгол зүйн талаас нь судалдаг. Аливаа хэлний авианы бүрэлдэхүүнд багтаж байгаа авиа тус бүрийг өгүүлэхүйн эрхтэний оролцоо, авиа бүтэх орон, аргын талаас нь авч үзэхийг авиаг өгүүлүүр талаас нь ангилах зарчим гэж нэрлэдэг. Өгүүлэхүйн эрхтэнд хэл, уруул, хатуу тагнай, нармай, шүд, хүхэн хэл, дууны хөвч, төвөнх болон ам хамрын хөндий багтдаг.

Хэлний авианы бүрэлдэхүүнийг адилтгаж, эсвэл ялган зааглаж болох онцлох шинжээр нь зэрэгцүүлэх судлах зарчмыг хэл шинжлэлч Н. С. Трубецкой, О.О. Якобсон нар хэрэглэсэн байдаг. Монгол хэлний авиан зүйг эрдэмтэн Г.И. Рамстедт, Б.Я. Владимирцов, Г.Д. Санжиев, Ц. Дамдинсүрэн, Б. Ринчин, Ш. Лувсанвандан, С. Мөөмөө нарын зэрэг олон эрдэмтэн ихээхэн хүчин чармайлтгарган *судалж шинжлэн олон тооны зохиол бүтээлүүдээ* туурвисан байдаг.

Эгшиг авианы гийгүүлэгчээс ялгарах гол онцлог нь эгшиг авиа бүтэх явцадамны хөндийгөөр

4 *Шархүү А., Авиазүй, фонем судлалын үндсэн асуудлууд, УБ. 2006*

5 *Бодуэн де Куртенэ, Избранные труды по общему языкознанию, Москва, 1963*

6 *Шархүү А., Авиазүй, фонем судлалын үндсэн асуудлууд, УБ. 2006*

7 *Бодуэн де Куртенэ, Избранные труды по общему языкознанию, Москва, 1963*

8 *Соссюр Ф.Курс, Курс общей лингвистики, москва, 1933*

гарах хийн замд ямар нэгэн саад тохиолддоггүй учир өгүүлэхүйн эрхтэнүүд сулардаг. Үг ярианд тохиолдох авиа бол мөн чанартаа уушигнаас гарсан хийн урсгал өгүүлэхүйн эрхтэнүүд, амны ба хамрын хөндийг дамжин өнгөрөх замдаа олон янзын хэлбэлзэлд орж өөр өөр дуу шуугиан болж буй явдал юм. Авиа бүхэн сонсогдох чанга сул байдал, үргэлжлэх хугацаа, хөг, өнгө аясаараа ялгаатай байдаг. Үг ярианд хэлэгдэж буй зүйлийн утга агуулга, өгүүлэгч хүний сэтгэл хөдлөл зэргээс шалтгаалж авианы дуудагдах байдал өөрчлөгдөж байдаг. Ярианы хөг аялгуу өөрчлөгдөхийг авиан зүйд аялга гэж нэрлэдэг. Авиаг сонсгол зүйн талаас ангилахдаа үг ярианд тохиолдох олон авиаг хослуулан хуваж өөр хоорондын ялгарах онцлог, хувилбарууд, хэлэхүйн түвшинд гүйцэтгэх үүргийг нь тодорхойлдог. Авиаг сонсгол зүйн үүднээс судлах нь олон хэлний авиа, авиалбарын түгээмэл ба өвөрмөц шинжийг тогтоон тодорхойлоход ихээхэн ач холбогдолтойгоос гадна харь хэлний үгийг эх хэлэндээ галиглан буулгах, гадаад хэл сурах, сургахтай холбогдсон арга зүйн асуудлуудыг боловсруулах зэрэг хэл шинжлэлийн олон асуудлыг судлан тогтооход чухал ач холбогдолтой юм.

Хэлний авианы тогтолцоог өгүүлүүрийн болон сонсгол зүйн талаас ангилах нь хоорондоо шалтгаан үр дагаврын уялдаа холбоотой байна. Авиан зүйн судалгааны гол зорилго нь аливаа хэлний авианы бүрэлдэхүүнийг ялгарах, ижилтгэх шинжээр нь нарийн тодорхойлоход оршино.

Ашигласан материал

1. Бодуэн де Куртенэ, Избранные труды по общему языкознанию, Москва, 1963
2. Бондаренко В.П., Вербицкая Л.А., Гордина М.В., Основы общей фонетики, Санкт-Петербург, 1991
3. Зиндер Л.Р., Общая фонетика, Ленинград, 1979
4. Мөөмөө С. Монгол хэлний авиан зүй, УБ, 1979
5. Соссюр Ф. Курс, Курс общей лингвистики, москва, 1933
6. Шархүү А., Авиазүй, фонем судлалын үндсэн асуудлууд, УБ, 2006

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, АНАГААХ УХААН

ЗҮРХНИЙ БИЧЛЭГИЙН ЧАНАРТ БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ


М.Тунгалаг
ШУТИС-МХТС-ийн багш, доктор

Хураангуй: *Өгццллийн гол зорилго зүрхний бичлэгт шинжилгээ хийнэ. Ингэж шинжилгээ хийх нь ECG (Electrocardiogram – Зүрхний цахилгаан бичлэг) – ийн дохионы чанарт боловсруулалт хийх цндэс болно. Уг судалгааны ажил бол зүрхний бичлэгийн дохионы дундаж утгыг тооцоолж, цохилт бүрийн харьцуулах цэгийг тодорхойлох явдал юм.*

Түлхүүр үг: *Дохионы чанар, босго, оргил цэг, морфологи, ECG*

ОРШИЛ

Хэвийн зүрхний мөчлөгт P дохио эхлээд, дараа нь QRS цогцолбор болон T давалгаа харагддаг (Зураг 1).



Зураг 1. Зүрхний бичлэгийн бүрэлдэхцүн хэсэг


Долгион болон комплекс хоорондын интервалууд ECG-г **бүрдүүлдэг. Үүнд:** PR сегмент, ST сегмент, TP сегмент, PR интервал, QT интервал болон R-R интервал. Зүрхний цахилгаан үйл ажиллагаа илрээгүй үед ECG нь шулуун, хавтгай байдаг ба суурь гэж нэрлэнэ. Дохионы хамгийн оргил цэгийг R гэж тодорхойлоод түүнийг харьцуулах цэг болгон ашиглана. Зарим илрүүлэгч нь нэгэн зэрэг хоёр ECG удирдаж үйл ажиллагаа явуулдаг. Нэг сувагт илрүүлэгч нь системд ороогүй дэлгэц,зурвасын өргөнөөс хамааарсан алсаас хэмжих төхөөрөмжүүд, гэрийн нөхцөлд ашиглаж болох дуу хураагуур, зүрхний хэмнэлийг сайжруулагч хэрэгсэл, зүрхний электрон төхөөрөмж зэрэгт ашиглахад тохиромжтой.

QRS-ийн бүтэц нь ялгаатай морфологи, P ба T долгион, мөн ялгаатай өөр төрлийн бүтээгдэхүүн болон шуугианд алдаа илрүүлдэг. P ба T долгионуудын шуугианыг арилгаж, шаардлага хангасныг нь шүүж, дижитал хэлбэрт хувиргана. Гаралт нь шугаман бус өөрчлөлтийн R долгионыг сайжруулж чанартай болгон үзүүлдэг. Тодорхойгүй хугацаанд QRS ажиллавал үүнийг QRS комплекс боловсруулаагүй дохио хүлээн авсан гэж үзнэ.

Онцлох дохио (PNE) - ны тэг солбилцол болон R оргил цэгийн байршлыг тодорхойлно. Тэг солбилцол нь өөр хязгаарлалтууд эсвэл шуугианыг тасалсан үе юм. Хэрэв алдаа гарвал далайц болон хөрш хажуу талын цэгүүдэд харьцуулалт хийснээр засагдана. PNE дохио нь босго тогтоон тодорхойлдог. Босго нь дохионы утгуудаас хамаардаг учраас алдаа заадаг. Бид энэ босгыг цаг тус бүр дээр өөр утгуудаар үйл ажиллагаа явуулж байхаар хийсэн. R дохионы байршил тодорхой болмогц QRS комплексийн эхлэлийн цэг болон зогсонги цэгийн байршлыг PNE дохион дээрээс тодорхойлж болно. Хамгийн гол зүйл гаралт нь ороллтойгоо нийцэж байх ёстой.


1. Нам давтамжийн шүүлтүүр

ECG дохио нь 25Гц бол нам давтамжийн шүүлтүүрээр дамжина. Зүрхний бичлэгийн дийлэнх энерги нь (1-4)Гц хязгаарын хооронд оршдог. Нам давтамжийн шүүлтүүр нь зүрхний бичлэгийн 250Гц уттыг 50Гц хүртэлх давтамжийн хязгаартай болгохын тулд чиглэгдэнэ. Зарим тохиолдолд үр дүнг илүү сайжруулах зорилгоор илүү эрчимтэйгээр шүүж болно,гэвч энэ нь зөвхөн боловсруулаагүй хязгаарыг тогтооход хүргэнэ.



Зураг 2. Нам давтамжийн шүүлтүүр

Шүүсэн гаралтын дохио анхны дохионоос бага дуу чимээг агуулдаг. (Зураг 3) - т эхний болон хоёр дахь шүүгдсэн ECG дохиог харьцуулан харуулав.



Зураг 3. Бага шүүлтүүрийн гаралт ба жинхэнэ ECG дохио

QRS цогцолбор нь зогсонги үе болон эхлэх үеийн дохиог гажуудуулдаг. Энэ нь оргил цэгийг тодорхойлох үед магадгүй PNE дохиог нэмснээр саад болох магадлалтай. Дамжуулах шүүлтүүрийг хэрэглэхдээ хамгийн доод хязгаарын дамтамжийг 1Гц болгон хэрэглэсэн. Энэ нь суурь шугам хазайхыг багасгаж давтамжийг багасгаж байгаа юм. Гэсэн хэдий ч суурь хазайлт хязгаарын шуугианыг хангалттай шийдвэрлэж чадахгүй.

2. Шугаман бус хувиргалт


Үүсмэл шүүлтүүрийн үүрэг бол R долгион сайжруулах болон P ба T долгион, дуу чимээ зэргийг багасгах явдал юм.

Үүсмэл дохионд ашиглах тэгшитгэл нь:

$$[N] = (x[N+1] - x[N-1]) / 2, x[N] \qquad (1)$$

юм.

Үүсмэл шүүлтүүр нь non-QRS үзэгдлийн хэмжээг амжилттай бууруулдаг. Гэхдээ энэ нь өндөр давтамжийн шуугиан бага давтажийн шүүлтүүрийг давж гардаг. Ийм маягаар дохио шилжиж дундаж шүүлтүүрээр дамжин өнгөрч байна. Оролтын үнэмлэхүй утга нь d[n], тиймээс энэ үйл явц шугаман бус гарна. Энэ нь түр зуурын шуугианы дундаж хөдөлгөөнийг бууруулахад нэмэр болдог. Шүүлтүүрийн хэмжээ нь QRS цогцолборын ойролцоо өргөнтэй тохирч байна.




Зураг 4. Үүсмэл шүүлтүүрийн ир дүн

Энэ жишээн дээр бид (0.168sec) дараах тэгшитгэлийг ашигласан.

$$ymv[n]=\sum kk==020d[n+k] \qquad (2)$$


Үр дүнг (Зураг 5)-д үзүүлэв.



Зураг 5. Хөдөлгөөний дундаж шүүлтүүрийн гаралт


3. Хязгаарын функц

QRS цогцолбор өргөн бүсийг тогтоохын тулд бид хязгаарын хөдөлгөөний дунджийг шүүж гаргана. Өргөн бүс илрүүлж чадахгүй үед энэ нь тогтмол биш өндөр давтамжийн дуу чимээ, эсвэл хөдөлгөөн хуурамч дүрслэлийн хэт их хэмжээтэй холбоотой. Ихэнх тохиолдолд гэнэтийн өсөлт нь өмнөх үе нөлөөлж байгаатай холбоотой юм. Бидний туршилт заримдаа 0.5 Ч max (ymv [N]) нь голдуу сайн хязгаарын хэмжээ юм. Хэрвээ ymv дохионы далайцын хамгийн өндөр цэг нь гэнэт 2 дахин нэмэгдэж байвал хамгийн сайн хязгаарын функц нь ихэвчлэн дунджаар (ymv[n]) байна.



Зураг 6. QRS цогцолборын өргөн бүс


Энэ нь өргөн хязгаар тогтоох үйл ажиллагааны эцсийн үр дүн юм. QRS-н өргөн бүс нь хөдөлгөөнгүй байх цэгийг тодорхойлж шууд 0 болно.



Жинхэнэ ECG дохио нь ихэвчлэн үндсэн шугамаас шуугиан алдагддаг. Дохионы дууранмлыг олж аван энгийн хязгаарын функцийг ашигтай болгоно. Гаралтын үндсэн суурь нь хэт өндөр давтамжийн бүрэлдэхүүн хэсэгтэй. Тиймээс дуу чимээний түвшин гаралтын дохионы цахилгааны хэсгийг хараад тооцож болно.

Зураг 6. Эхний 5 секундын d[n]

Рne[n] дохио хянах улмаар QRS цогцолбор болон эхлэх цэгүүд оршин байрлаж байдаг. (Зураг 7)-д QRS эхлэл үе болон зогсонги үеийн амжилттай илрүүлэлтийг харуулав.



Зураг 7. QRS эхлэл це болон зогсонги цеийн байршил

ДҮГНЭЛТ

QRS илрүүлэгчийг боловсруулсан ба түүний зөрж байгаа учрыг олсон. Засагддаггүй төрлийн дохион дээр суурилагддаг ба хэрэв дасан зохицох үйл явц нь ирээдүйд том хязгаар олж хэрэгжүүлбэл, илрүүлэх түвшин болон бидний QRS илрүүлэгчийн мэдрэгч илүү сайжирна.

Хэрэв дохионы үлдэгдлийг боловсруулбал бид дундаж дохионы алгоритмыг хэрэгжүүлэх боломжтой. Энэ алгоритм гажуудал багасгахын тулд өөрчлөлтөнд шугаман бус суналт ашигладаг. Мөн эмнэлзүйн ач холбогдолтой байж болох дохионы дамжигдах бүрэлдэхүүн хэсгүүдийг авахын тулд шүүлтүүр ашигладаг. Хэдийгээр энэ санаа нь шинэ санаа ч үлдэгдэл шүүх хэсэгт илүү их судалгаа хийх шаардлагатай байна.

Ашигласан материал

[1] ECC Committee, Subcommittees and Task Forces of the American Heart Association. 2005 American Heart Association Guidelines for Cardiopulmonary Resuscitation and Emergency Cardiovascular Care. Circulation 2005;112:IV1 – 203.

[2] Pelleg A,Pennock RS,Kutalek SP. Proarrhythmic effects of adenosine: one decade

[3] of clinical data. Am J Ther 2002;9:141 – 7.

[4] Baerman JM, Morady F, DiCarlo LA Jr, de Buitleir M. Differentiation of ventricular tachycardia from supraventricular tachycardia withaberration: value of the clinical history. Ann Emerg Med 1987;16:40 – 3.

[5] Tchou P, Young P, Mahmud R, Denker S, Jazayeri M,Akhtar M. Useful clinical cri- teria for the diagnosis of ventricular tachycardia. Am J Med 1988;84:53 – 6.

[6] Akhtar M, Shenasa M, Jazayeri M, Caceres J, Tchou PJ. Wide QRS complex tachy- cardia. Reappraisal of a common clinical problem. Ann Intern Med 1988;109:

[7] 905 – 12.

[8] Morady F, Baerman JM, DiCarlo LA Jr, DeBuitleir M,Krol RB,Wahr DW. A prevalent misconception regarding wide-complex tachycardias. JAMA 1985;254:

[9] 2790 – 2.

[10] Alzand BS,Manusama R,Gorgels AP,Wellens HJ. An 'almost wide' QRS tachycar- dia. Circ Arrhythm Electrophysiol 2009;2:e1 – 3.

[11] Wellens HJ,Bar FW, Lie KI. The value of the electrocardiogram in the differential diagnosis of a tachycardia with a widened QRS complex. Am J Med 1978;64:

[12] 27 – 33.

[13] Wellens H, Bar F, Brugada P, Farre J. The differentiation between ventricular tachycardia and supraventricular tachycardia with aberrant conduction: the value of the 12 lead electrocardiogram. In: Wellens HJJ, Kulbertus HE (eds). What's New in Electrocardiography? The Hague: Martinus Nijhoff; 1981, p184 – 99.

[14] Massumi RA, Tawakkol AA, Kistin AD. Reevaluation of electrocardiographic and bedside criteria for diagnosis of ventricular tachycardia. Circulation 1967;36: 628 – 36.

ЗАРИМ НОМХОТГООГҮЙ ЭРДСИЙН ГАРАЛТАЙ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ХИМИЙН ЭРДЭСЖИЛТИЙН СУДАЛГАА

Э.Тэлмүүн
Их Засаг ОУИС, АУС-ийн багш, докторант

Ж.Оюун
Улаанбаатарын их сургууль химийн тэнхимийн зөвлөх профессор, доктор

Хураангуй: Монголын уламжлалт анагаах ухаан 5000 жилийн түүхтэй бөгөөд Уламжлалт анагаах ухааны эмэнд эрдсийн гаралтай түүхий эдийг ашиглаж байсан тухай эрдсийг таних, эмийн түүхий эд бэлтгэх уламжлалт аргууд, эм найрлагын талаар хэд хэдэн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Эдгээр сурвалж бичигт тэмдэглэсэн эрдсийн гаралтай түүхий эдийг хими, физик, геологи, геохими, геофизикийн салбарын судлаачид өөр өөрийн чиглэлээр судласан байдаг боловч тодорхой баримт материал ховор байдаг.[1] Дэлхий хөгжихийн хэрээр хүн төрөлхтөн илүү органик хоол хүнс, эм, гоо сайханы бараа зэргийг хэрэглэхийг илүүд үзэх болсон бөгөөд амьдралын нэн чухал хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг байгалийн цэвэр түүхий эдээс гарган авах технологийн эрэл хайгуул, дэлхийн улс орон бүрт эрчимтэй өрсөлдөж амжилтанд хүрч байна.[2] Иймээс эх орны эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн орчин үеийн шинжилгээ судалгааны үндсэн дээр зөв таньж олборлох,бүтцийн судалгааг орчин багаж тоног төхөөрөмжөөр таних, цаашлаад эм тан болон нэмэлт хоол тэжээлийн зориулалтаар боловсруулах шинэ технологи бүтээх нь хүн амын эрүүл мэндийн төлөө хийгдэж буй чухал судалгаа юм.

Түлхүүр үг: эмийн эрдэс, кальци, жонш

Зорилго:

Эрдсийн гаралтай эмийн түүхийн эдийн сонгож авсан дээжүүдийн химийн найрлагыг тогтоож бичил биогенны элементүүдийн харьцаагаар, зарим орагены эрдсийн үүслийг тогтоох

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:

Судалгаанд Баянхонгор аймгийн Баянлиг сумын Баян-Ааараг багийн нутагт орших Цагаан Агуй-н эрдсийн чулууг сонгон авч орчин үеийн физик химийн багажууд (ICP-OES, спектр фотометрийн) аргаар тодорхойлж үр дүнг тооцов.

Судалгааны үр дүн хэлэлцүүлэг:

Эрдсийн гаралтай эмийн эрдсэндагуулагдах эрдэсжилтийн бүрэлдэхүүйг орчин үеийн физик химийн аргаар тодорхойлоход дараах үр дүн гарав.

Химийн шинжилгээний дүн
Рентген флоурсценцийн тоон шинжилгээ

Хүснэгт №1

Дээжийн тодорхойлолт	SiO_2 %	TiO_2 %	Al_2O_3 %	Fe_2O_3 %	CaO %	MgO %	Na_2O %	K_2O %	MnO %	P_2O_5 %	ШХ %
Дээж №1 (Цагаан)	0.15	<0.005	<0.01	0.05	55.90	0.24	<0.10	0.03	0.011	0.007	42.68
Дээж №2 (Шаргал)	0.23	0.005	0.04	0.17	55.68	0.19	<0.10	0.03	0.025	0.019	42.92
Чанарын хяналт											
Аттутга	2,86	-	0.45	0.14	52.50	1.39	-	0.11	0.023	0.047	41.89
Шинжилсэн утаг	2,80	0.019	0.44	0.14	52.29	1.37	<0.10	0.11	0.029	0.042	41.78

Хүснэгт №2

Дээж №	Элемент %				Элемент, мг/кг												
	Al	Ca	Fe	Mg	Cu	Mn	Ti	V	Zn	Cd	Sn	Y	Li	Ni	Co	Mo	Sc
Дээж №1 (Цагаан)	0.02	>10.00	0.09	0.13	<5.00	60.84	19.99	<5.00	10.08	0.84	2.39	6.44	1.09	21.14	2.86	1.72	2.92
Дээж №2 (Шаргал)	0.03	>10.00	0.12	0.16	<5.00	155	19.54	<5.00	50.42	0.77	2.37	3.18	1.13	37.84	6.46	1.28	2.60
Чанары хяналт																	
Дээж №	Элемент %				Элемент, мг/кг												
	Al	Ca	Fe	Mg	Cu	Mn	Ti	V	Zn	Cd	Sn	Y	Li	Ni	Co	Mo	Sc
Аттутга	8.85	3.99	3.30	2.12	41.20	620	4256	123	71.50	-	0.86	11.80	13.20	61.20	19.20	0.60	11.80
Шинжилсэн утга	9.30	4.04	3.49	2.41	35.07	541	4383	117	65.81	0.13	0.61	10.23	13.38	61.69	18.41	0.75	11.16

Хүснэгт №3

Дээж №	Элемент, мг/кг															
	Rb	La	Ce	Pr	Nd	Sm	Eu	Gd	Tm	Yb	Pb	W	Ba	U	Cs	Lu
Дээж №1 (Цагаан)	2.76	2.16	1.57	0.90	2.21	0.46	<0.5	1.01	0.27	1.30	5.52	<0.5	11.29	0.98	0.65	0.64
Дээж №2 (Шаргал)	2.85	0.91	0.91	0.63	1.05	0.21	<0.5	0.68	0.23	1.09	2.57	<0.5	10.36	1.04	0.66	0.61
Чанары хяналт																
Дээж №	Элемент, мг/кг															
	Rb	La	Ce	Pr	Nd	Sm	Eu	Gd	Tm	Yb	Pb	W	Ba	U	Cs	Lu
Аттутга	49.70	26.20	55.20	6.77	27.20	5.16	1.44	3.93	0.17	1.00	18.70	1.70	672	1.96	1.09	0.15
Шинжилсэн утга	44.05	20.43	41.97	4.92	21.49	5.14	1.03	3.80	0.12	1.77	16.58	1.47	614	2.15	0.94	0.11

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харахад эрдсийн гаралтай эмийн түүхий эд нь CaO ихээр агуулагдаж байгаа нь эмийн чанартай кальцийн эрдэс гэж тодорхойлож байна. Дээр үеэс Монголчууд нүүрсхүчлийн эрдэс давсуудыг жонш гэж нэрлэсээр ирсэн бөгөөд кальцийн ($CaCO_3$), төмрийн ($FeCO_3$),магнийн ($MgCO_3$),маргенецийн ($MnCO_3$) гэх мэт олон төрлийн жонш байдаг . Уламжлалт анагаах ухаанд жоншоор эм тан бэлтгэж төрөл бүрийн өвчин анагаах эмчилгээнд хэрэглэсээр ирсэн.

Эмийн жоншинд дунджаар 46-56.5% нь кальци, 40 гаруй хувь нь нүүрсхүчлийн хий агуулагдах бөгөөд цайр, фтор, иод, стронций, кобальт, зэс, алт, мөнгө, лантануул зэрэг биогены чанартай олон төрлийн бичил элементүүд өчүүхэн хольц хэлбэрээр агуулагдаж байна.

Харин кальцитай ионы радиусаар ион солилцох урвалд идэвхтэй сарнимал байдлаар тархдаг стронци, бари, лантаны церийн бүлгийн элементүүд нь эдгээр эрдэст кальцийн мөнхийн дагуул болж хамт байдаг нь тодорхойлогдсон юм.

Кальци агуулсан эмийн эрдсийн судалгаагаар илэрсэн өчүүхэн хэмжээтэй агуулагддаг стронци, лантан, цери, неодим, самари, празеодим, иттери зэрэг нь органик биетээс хадгалагдаж үлдсэн буюу эрдэсжилтээр кальцийн орон тор, сүвэнд шингээгдэж кальцийтай ион солилцох урвалд орох боломжтой элементүүд юм. Эдгээр элементүүд тогтмол агуулгатай байдаг нь кальцийн орон тор тогтмол ион солилцох эзэлхүүнтэй холбоотой юм. Кальци агуулсан эмийн эрдсүүд нь органик гаралтай биомасс, бичил организмын нөлөөгөөр үүсэж ион солилцох, эрдэсжих, байгалийн хувиралд орсоныг батлана.

Ашигласан материал

1. XI зууны зохиогч нь тодорхойгүй, "Чжуд Ши" 1985 он
2. XVIII зуун. Цахарын гэвш Лувсанчүлтэм. Шороон эмийн судлал. Эм таних ухаан 1740-1810 он
3. XVII зуун Ишбалжир. Эмийн нэр ба

эмт эрдсийг таних болор толь. Рашааны дусал, Рашааны ундаа, Рашаа-4. 1704-1788 он

4. О.Сүхбаатар. Т. Цэндсэн. Чулуун эмийн нууцаас. Улаанбаатар " Утга зохиол сонин" 1990 №44
5. Ц.Хайдав, О.Шерхан. Монгол ардын эмэнд хэрэглэгдэж байсан эрдсүүд х-197
6. Д.Зандансүрэн,Ш.Болд Эрдсийн гаралтай эм болон синдэр орсон эмүүдийн тойм. Монголын анагаах ухаан 2008.3(145)
7. Ж.Оюун Эмийн эрдэс номхотгох Монголын уламжлалт нанотехнологи ба эмийн эрдсээс нано хэмжээстэмийн түүхий эд бэлтгэх судалгааны үр дүн. Монголын анагаах ухаан 2009.3(149):32,33,34,35
8. Анагаах ухааны дөрвөн үндэс. ӨМӨЗӨ-ын ардын хэвлэлийн хороо 1977. х-760,761

ШИНЭ НОМЫН ТАНИЛЦУУЛГА БУЛАН

Г.НАРАНБААТАР

“Өмгөөлөл хууль зүйн туслалцаа” Улаанбаатар хот, 2020 он

2019 онд УИХ-аас “Өмгөөллийн тухай” хуулийг батлан гаргасантай холбогдуулан өмгөөллийн үйл ажиллагааны төрөл,хэлбэр баталгаа, өмгөөлөгчийн эрх зүйн байдал,өмгөөллийн хуулийн этгээд түүний зохион байгуулалт онцлог, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд тулгамдаж буй байдал цаашдын шинэтгэлийн асуудал, гадаад орнуудын харьцуулсан судалгаа зэргийг уг бүтээлд тусгасан нь их дээд сургуулийн оюутнууд практикт ажиллаж буй хуульч,өмгөөлөгч,судлаачдад онолын болон арга зүйн чиглэлээр мэдлэг олгох чухал бүтээл болжээ.

Ялангуяа Өмгөөллийн үйл ажиллагааны онолын үндэслэл, уламжлал, шинэчлэл өмгөөллийн тухай үзэл баримтлал, мэргэшлийн чиг үүрэг, ёс зүй, хариуцлага, өмгөөлөгчийн ур чадвар, хууль зүйн зөвлөгөө туслалцааны арга хэлбэр, өмгөөллийн хуулийн этгээдийн харьцуулсан судалгаа,эрүү,иргэн, захиргааны процесст өмгөөлөгч оролцох эрх зүйн үндэслэл,арга зүйн болон тулгамдсан асуудлуудыг хөндөж гадаад улс орнуудын харьцуулсан судалгаа, Олон улсын гэрээ конвенцуудын нийтлэг чиг хандлагын талаар дэлгэрэнгүй судлаж эрх зүйн шинэтгэлтэй холбогдуулан өөрийн санаа бодол,байр суурыа илэрхийлэн үнэтэй саналуудыг дэвшүүлж өгсөнөөрөө ач холбогдолтой болжээ.

Н.НЯМ-ОСОР, Ж.ЦЭЦЭГМАА

“Их Засаг хууль судлал” сурах бичиг.,Улаанбаатар хот.,2019 он

Энэхүү сурах бичигт Тэмүүжин Чингис хаан XIII зууны эхэн үед Монгол овог аймгуудыг нэгтгэж, Монголын Нэгдсэн төр улсыг байгуулж, улмаар дэлхий ертөнцийн тавны дөрвийг хармарсан Их Эзэнт Гүрнийг буй болгосон түүхэн үйл явцад Их Засаг хууль асар их үүрэг гүйцэтгэсэн тухай өгүүлжээ. Их Засаг хууль нь өөрийн болон бусад улс орныг эзэмшин захирахад гол үндэс суурь нь болж, төр улсыг төвшитгөн тохинуулах нийгмийн олон талт асуудлыг зохицуулж байсан төдийгүй Монголын хууль цаазын тулгар бичиг болох энэ хуулийн үзэл санааны нөлөө тусгал нь орчин үеийн Монголын хууль тогтоомж болон ёс заншилд улбаалан ирснийг тодорхой судлан тэмдэглэж, орчин үеийн эрхзүйн тогтолцоог ёс уламжлалтайгаа уялдуулан хөгжүүлэхэд үнэлж баршгүй эх сурвалж болохыг нь үнэлж өгжээ.

Ц.ЦЭЛМЭГ, Д.МАЙЦЭЦЭГ

“Харьцуулсан эрүүгийн эрх зүй” гарын авлага., Улаанбаатар хот.,2021 он

Энэхүү гарын авлагад дэлхийн эрх зүйн тогтолцооны түүхэн хөгжил, чиг хандлага, Ром-Германы болон Англо-Саксоны эрх зүйн тогтолцооны онцлог, ялгаатай талууд, ХБНГУ, Франц, АНУ ,БНСУ, Япон зэрэг системийн төлөөлөгч улсуудын хууль тогтоомжийг судлах , түүнчлэн уламжлалт шашны эрх зүйгээс Исламын шашинт орнуудын эрүүгийн эрх зүйн онцлог, мөн социалист болон пост- социалист орнуудын хууль тогтоомжийн онцлог, хөрш орнуудын эрх зүйн тогтолцоо, эрүүгийн хуулийн талаар тодорхой тайлбарлаж өгсөн байна.

Мөн ОХУ–ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг орчуулан тавьснаараа судлаачдад харьцуулан судлах өргөн боломжийг тавьж өгснөөрөө ач холбогдолтой болжээ.

ЧӨЛӨӨТ БУЛАН

Хорвоогийн сонин хачнаас

ДЭЛХИЙН ШИЛДЭГ АМЬТНЫ ХҮРЭЭЛЭНГҮҮД

Амьтны хүрээлэн бүр хүүхдэд, насанд хүрэгчдэд, настайчуудад гээд олон янз байна. Тухайлбал Берлиний амьтны хүрээлэнд л гэхэд зөвхөн насанд хүрэгчид үйлчлүүлдэг гэнэ."Forbes Traveler" сэтгүүл "Дэлхийн хамгийн шилдэг амьтны хүрээлэн" жагсаалтыг гаргажээ.

Нэгдүгээрт: АНУ-ын Орланда дахь "Animal Kingdom" орсон байна. Диснейлэндамьтны хүрээлэнгээрээ дэлхийд хамгийн томд тооцогддог. Үндсэндээ долоон том хэсэгт хуваагдсан эл хүрээлэн нь 325 төрлийн амьтнаас бүрдсэн бөгөөд тэдний дунд "Микки Маус" ч бий.

Хоёрдугаарт: Швейцарийн "Basel Zoo" оржээ. Энэ амьтны хүрээлэн 1874 онд нээгдсэн юм байна. Эндхийн оршин суугчид амьтны хүрээлэнгээ "Zolli" гэж нэрлэдэг. Энэ нь 600 гаруй төрлийн, 6000 гаруй ан амьтнаас бүрдсэн аварга хүрээлэн юм. Амьтны хүрээлэнгийн хамгийн сонирхолтой хэсэг нь амьтны эволюцийг харуулсан том танхим байна.

Гуравдугаарт: Францын "Zoo de Beauval"*амьтны хүрээлэн орсон байна. Вовале* хотноо 1980 онд нээгдсэн эл хүрээлэн дан шувуудаар "чимэглэгджээ". Анааш, сармагчин зэрэг олон гоё чамин амьтантай "Zoo de Beauval" 4000 гаруй төрлүүдтэй байна.

Дөрөвдүгээрт: Берлиний "Berlin Garden" бичигдсэн байна. 1400 гаруй төрлийн 13900 ан амьтан энд бий. Берлиний амьтны хүрээлэн 1844 онд үүдээ нээжээ.

Тавд: Нью-Йоркийн "Bronx Zoo" бичигдсэн байна. 4000 гаруй ан амьтантай. Амьтны хүрээлэнгийн хамгийн сонирхолтой хэсэг нь "ЗэрлэгАзи" бөгөөд үнэхээр тансаг амьд үзмэртэй байдаг.

АНХНЫ КИБЕР СУРГУУЛЬ

Дэлхийн анхны кибер их сургууль Японд нээгджээ. Эндхийн 2000 орчим оюутан зөвхөн интернэт сүлжээгээр суралцдаг. Хүмүүс сурах цагаа өөрсдөө сонгодог тул кибер их сургууль дороо л нэрд гарчээ.

Одоо тус их сургууль маш завгүй ажилтай байдаг улсынхаа хүн амд зориулж, гар утасны тусламжтайгаар дээд боловсрол олохыг санал болгож байна. Суралцагчид лекц,дагалдах материал, текст,зургууд гээд бүх шаардлагатай юмаа утсаараа татаж авна. Түүнээс гадна хэдэн видео сувгаар шууд хичээлд холбогдож болно. Саяхан Токиогийн түүхийн анхны хичээлүүд явагджээ.

Кибер сургуулийг төгсөгчид шалгалтуудаа өгөөд бакалавр зэрэг авна. Кибер их сургуулийн 71 хувь нь Японы гар утасны "Softbank" операторт харъяалагддаг. Удахгүй гар утасны лекц, дамжааг сэтгүүлчийн болон Хятадын соёл, Английн уран зохиол гэсэн хэдэн чиглэлээр өргөтгөж 100-д хүргэх гэнэ. "Softbank"-ийн хэрэглэгчдэд сургалт үнэгүй, (зөвхөн энэ үйлчилгээнд холбогдоход) харин бусад нь төлбөр төлөх гэнэ.

ДЭЛХИЙН ХАМГИЙН ИХ ОРЛОГОТОЙ ЗАГВАР ӨМСӨГЧИД

Шилдэг загвар өмсөгч Линда Эвангелиста загварын түүхэн дэх хамгийн өндөр орлоготой загвар өмсөгч байлаа. 1990 оны үед загварын тайзнаа гялалзаж байсан тэрээр өдөрт 10 мянган ам.долларын ашиг олдог байв. Тухайн үед Линда болон түүний дагалдагч мөн шилдэг загвар өмсөгч Кристи Тарленгтон нар Холливудын одод, алдарт дуучид шиг чинээлэг амьдралтай байжээ.

Энэ оны хамгийн өндөр орлоготой загвар өмсөгчдийг тодруулсанд жагсаалтыг загвар өмсөгч Жизел Бундхен 33 сая ам.долларын ашиг олсноор тэргүүлсэн бол түүний араас гурав дахин бага орлоготой

Кейт Мосс 9 сая ам.доллар олсноороо оржээ. Мөн загвар өмсөгч Хейди Клум 8 сая, Адриана Лима 6 сая,Александра Амброзио 6 сая ам.долларын орлогоор уг жагсаалтанд бичигдсэн байна. Жизел ойролцоогоор 20 компанитай хамтран ажилладаг.

Харин жагсаалтад багтсан бусад загвар өмсөгч 2-3 компанитай хамтран ажилладаг юм байна. Жизел Бразил дахь Гренден гутлын үйлдвэрт өөрийн нэрээ ашиглуулснаар жилд 6 сая ам.доллар авдаг.

Мөн Victoria`Secret компаниас энэ сард 5 сая ам.доллар авсанаар өмнө нь тогтсон рекордыг эвдсэн ажээ. Одоо шилдэг загварөмсөгчдийн оронд гадаадын 15-16 настай охид Нью-Йорк, Парис, Миланы загварын тайзнаа зургаан долоо хоногийн дотор 70 шоунд оролцож цагт 250 ам.долларын хөлс авдаг байна. Шаргуу ажиллаж чадсан загвар өмсөгч улиралд 200 мянган ам.доллар цуглуулах бүрэн боломжтой аж.

ЭЗЭНДЭЭ ХАМГИЙН ҮНЭНЧ АМЬТАН БОЛ ЯАХЫН АРГАГҮЙ НОХОЙ

Сембернар хэмээх аварга том биетэй нохдыг Швейцарийн ариун Бернарын Августин хийдийн лам нар XVII зуунд манааны зорилгоор ашигладаг байжээ. Мөн замд төөрч, осгосон, цасан шуурганд ядарч туйлдсан хүмүүсийг эрэх, аврах ажилд ашигладаг байсан байна. Энэ төрлийн нохойноос хамгийн алдартай нь 1800-1812 оны хооронд 40 хүний амийг аварсан Барри нэртэй нохой аж. Одоо ч үүргээ гүйцэтгэсээр байгаа Ромын легионыхон Альпаас умард зүг рүү аян дайн хийхдээ дагуулж явсан дог маягийн нохойноос удамтай гэж үздэг байна. Ариун Бернарын лам нар уг нохойг зөв удамшуулан үржүүлсний дүнд одоогийн цэвэр үүлдрийн нохой бий болсон гэнэ. Аварга биетэй энэ нохойг 1865 оноос сембернар гэж нэрлэх болжээ.

"АРД ТҮМНИЙ УТАС" ХАМГИЙН ХЯМД НЬ

Энэтхэгийн авто машины "Ратан Тата" компани дэлхийн хамгийн хямд машин үйлдвэрлэн "Ард түмний хөлөг"хэмээн зарлаж байсан.Тэгвэл энэ удаа тус улсын "Спайс" компани "Ард түмний утас" хэмээх хамгийн хямдгар утсыг үйлдвэрлэжээ. 20 ам.долларын үнэ бүхий энэхүү утсыг "Спайс" компани жилд арван мянган ширхгийг борлуулах төлөвлөгөөтэй байна. Тус компани зөвхөн ярих зориулалттай төхөөрөмж тул дэлгэц хэрэггүй гэж үзсэн ажээ. "Спайс" компани арван ам.долларын үнэтэй гар утсыг гаргахаар ажиллаж байгаа гэнэ. Дэлхийн гар утас үйлдвэрлэгч компаниудч мөн хямд утасны төсөл дээр ажиллаж байгаа аж. Үүний нэг жишээ нь Шведийн гар утасны компани "Нокиа" нь өнгөрсөн сард 35 еврогийн үнэтэй "Nokia 1209" загварын гар утсыг худалдаанд гаргаад байгаа билээ.

ХАМГИЙН ЖИЖИГХЭН ГАР УТАСНЫ ЭЭЛЖИТ ЦУВРАЛ

Бидний амьдралд өргөнөөр хэрэглэдэг USB flash гэдэг зүйлийг бүтээсэн хүн гар утасны зах зээлийг өөрчлөх төлөвлөгөөгөө танилцуулж байна. Modu нь маш жижигхэн гар утас, гэхдээ ямар ч том хүчин чадал бүхий гар утасны адил дотроо хөгжим тоглуулагч, тоглоом гэвд бүх зүйлүүдийг багтаасан байх гэнэ. Modu гэдэг нэртэй утас Итали, Орос, Израилийн зах зээлд гаргана гэж мэдэгдлээ. Гар утас нь iPod Nano-гоос бага зэрэг жижиг, 42 граммын жинтэй, бяцхан өнгөт дэлгэц мөн жижиг стандарт бус хялбарчилсан товчлууртай гэнэ. Тусгай угсарах төхөөрөмжүүдийн тусламжтай утасны үйлдэл улам боловсронгуй болох юм байна. Тухайлбал, нэг төхөөрөмж холбоход таны гар утас зургийн аппарат өөр нэг төхөөрөмж угсрахад бүрэн товчлууртай болох гээд л олон үйлдлийг гүйцэтгэх чадвартай. Мораны хэлснээр, Италийн нийлүүлэгч түүний санаанд маш их баяртай байгаа ажээ. Яагаад гэвэл хэрэглэгчид утсаа сар болгон шинэчлэх хэрэг гардаг юм байиа. Харин угсарч суулгадаг төхөөрөмжүүдийн хувьд тэдгээр нь тийм ч үнэтэй зарагдахгүй гэнэ. Одоогийн байдлаар Modu нь GPRS систем л барьдаг. Компани 3G-тэй дүйцэхүйц болгох тал дээр нь ажиллаж байгаа. Энэ бяцхан гар утас ойролцоогоор 280 ам.долларааp зарагдах гэнэ.

ДЭЛХИЙН ХАМГИЙН ТАРГАН ЗАЛУУ 230 КГ-ААР ТУРЖЭЭ

Мексикийн иргэн Мануэл Урябыг дэлхийн хамгийн тарган хүнээр Гиннесийн дэлхийн амжилтанд тэмдэглэжээ. Тэр үед Уряб 560 кг жинтэй байсан байна. Тэрээр хойд Мексикийн нийслэл Монтеррэйд нь амьдардаг бөгөөд Уряб 230 кг-аар жингээ хассанаа олон нийтэд мэдээлжээ. Тэрээр жингээ амжилттай хасаж чадлаа. Одоо би гэрээсээ гадагшаа гарч алхаж явж чаддаг болсон гэжээ. 42 настай уг залуу 5 жилийн турш хэвтэрт байсан бөгөөд энэ үед ээж сүйт бүсгүй хоёр нь түүнийг халамжилдаг байсан байна.

Америк, Итали, Мексикийн эмч нар түүнийг жингээ хасахад нь 2 жилийн турш тусалж Zone-ний өдрийн дэглэм, дасгалыг зааж өгч байжээ. "Би одоо гайхамшгийг мэдэрч байна" гэж тэрээр хэлжээ.

АНХНЫ ХУУРАЙ СҮҮ

Хүн төрөлхтөнөөс хамгийн анх хуурай сүүг монголчууд хийж байсан байж болох гэнэ. 1215 онд хүрэлцэн ирж Хубилай хааны албанд 17 жил зүтгэсэн Италийн алдарт жуулчин Марко Поло монголчууд XIII зуунд хуурай сүү хэрэглэдэг байсан тухай бичжээ. Монголчууд хуурай сүү хийхдээ сүүнд шар,цагаан будааг бага багаар хийж удтал буцалгасаар цецгий шиг болгож хатаах нэг аргатай байв. Бас нэг арга нь бал болохгүй саванд дээрхийг бага багаар хийж хусамтуулах маягаар хадгалдаг байжээ.

ХАМГИЙН ЖИЖИГХЭН МОРЬ ТУМБЕЛИН

Дэлхий дээр буй хамгийн жижигхэн адууг Тумбелина гэдэг. Тумбелинагийн биеийн хэмжээ дунд зэргийн биетэй нохойноос ч жижигхэн гэнэ. Тэр энэ дэлхий дээр буй адуунаас хамгийн жижигхэн нь гэдгээрээ дэлхийн дээд амжилтуудыг бүртгэн авдаг Гиннесийн номд нэр нь бичигджээ. Тумбелина одоо таван настай бөгөөд эм хүйстэй,60 кг жинтэй ажээ. Мөн арьс нь маш гоёмсог гялалзсан хар өнгөтэй учир жижиг биетэй гэхээсээ илүүтэй хүмүүсийн анхаарлыг татдаг байна.

Түүний нэг өдөрт иддэг хүнсний хэмжээ хүмүүс бидний өдөр тутам иддэг хоолны хэмжээтэй ижил байгаад зогсохгүй заримдаа

бүр хүнээс ч бага идэх тохиолдол байдаг гэнэ. Тумбелина одоогоор дэлхийн хамгийн жижиг биетэй адуугэдэг нэрээр Гиннесийн номдбичигдэж үлдсэн ч дэлхийн хамгийн том морь бичигдээгүй л байгаа юм.

ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ ТУУЛАЙ

Дэлхийн хамгийн том туулай нь 105 см урт, 12.7 кг жинтэй, нэрийг нь Хамфней гэдэг ажээ. Тэрээр дэлхий дээр хамгийн том туулай гэж албан ёсоор бүртгэгджээ.

Хамфней Франц үүлдрийн туулай бөгөөд энэ туулай нь Британы хамгийн том туулай Дэнсин Стараас 11.3 кг-аар илүү том ажээ. Хамгийн гайхалтай зүйл бол Францын үүлдрийн ийм туулай нь дунджаар 4.4 кг байдаг. Хамфнейн эзэн 62 настай Колин Дуниган хэлэхдээ "Би туулайгаа яаж ийм том болсныг мэдэхгүй байна" гэжээ. Энэ туулайн өсөлт ерөөсөө зогсохгүй байгаа бөгөөд улам том болсоор байна. Тэрээр өдөрт 3 лууван, өвс,жигнэмэг,2 хэрээний нүд /ургамал/,тал байцаа, талх иддэг байна. "Би түүнийг анх авахад тэр дөнгөж миний алганы хэмжээтэй байсан. Тэгтэл одоо тэр өдөр ирэх бүр улам том болсоор байна. Удахгүй түүний өсөлт зогсоно гэдэгт найдаж байна" гэж туулайны эзэн хэлжээ.

ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ РЕСТОРАН 54000 КВ/М ТАЛБАЙТАЙ

Сирид дэлхийд хаана ч байхгүй хамгийн том талбайтай ресторан зоогийн газрын иж бүрэн цогцолбор байгуулагджээ. Дэлхийн улс орнуудын үндэсний хоол, зуушийг амтлах идэх боломжтой олон улсын хоолны ресторан сүлжээ нь нийтдээ 10 хөлбөмбөгийн цэнгэлдэхийг нийлүүлсэнтэй тэнцэх талбайтай гэнэ.

Үндэсний хоолоороо дэлхийд алдартай Сири улс одоо хамгийн том олон үндэсний хоолны сүлжээтэй гэж гайхагдаж байна. Бавабет Димашк буюу Дамаскийн хаалга нэртэй энэ ресторан, зоогийн газар нийтдээ 6012 үйлчлүүлэгчийн суудалтай юм. Суудлынхаа тоогоор өнөөдрийг хүртэл хамгийн томд тооцогдож байсан Бангкогийн таван мянган хүний суудалтай ресторанаыг ардаа орхисон Бавабет Димашк нь Дамаск хотын захад байрладаг. Цогцолбор нь олон үндэсний зоог бүхий ресторанаас гадна оргилуур, археологийн барилга байгууламжийн жижигрүүлсэн хувилбарыг байгуулсан зуны задгай хэсэгтэйгээс гадна Ойрхи Дорнод,Иран,Хятад,Энэтхэг зэрэг хоолны тусдаа ресторануудтай юм. Нэг онцлог нь энд лалын орны хатуу дэг жаягийг мөрдөн ямар ч төрлийн согтууруулах ундаагаар үйлчилдэггүй байна. Аялагч жуулчдын хөл хөдөлгөөн ихэсдэг зуны улиралд энэхүү цогцолборт 1800 гаруй ажилтан, албан хаагчид ажиллуулдаг. Нийтдээ хөлбөмбөгийн 10 талбайг нэгтгэсэнтэй тэнцүү буюу 54 мянган кв/м талбай бүхий ресторан цогцолбор хэмжээгээрээ Гиннесийн номд хэдийнээ багтжээ.

ДЭЛХИЙН ХАМГИЙН БЯЦХАН ЭЭЖ

1939 онд Андес нуруунд байдаг нэгэн жижигхэн тосгоноос таван настай Лина охиноо дагуулсан аав Перу улсын Писко хотын эмнэлэгт ирсэн байна.Охины хэвлийд томроод байгаа хавдрыг тосгоных нь бөө нар эдгээх боломжгүй гэсэн учир охины аав эмч нарт ханджээ. Гэтэл

эмчийн үзлэгээр хавдар гэх зүйл байсангүй. Лина охины аав Жерерадо Лозада эмчид охиных нь хэвлий гурван настай байхаас нь томорч байгаад сүүлийн гурван сар тогтворжсон гэж ярьжээ. Энэ ярианы дараа эмч нь охины хэвлийг чагнаж үзээд хоёрдогч бяцхан зүрх цохилж байв. Улмаар рентген гэрэлд харж үзэхэд таван настай Лина охин долоон сартай жирэмсэн байжээ. Ингээд охиныг Лима хотын эмнэлэгт хүргэж, жирэмсэн болох нь гарцаагүй батлагдсан байна.

Линагийн эцэг төрсөн охиноо доромжилсон хэргээр сэжиглэгдэн баривчлагдсан боловч нотлох баримт илрээгүй учир суллагджээ. 1939 оны "Эмэгтэйчүүдийн баяр"-ын өдөр таван нас найман сартай Лина охин мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн юм. 2700 гр жинтэй хүү төрсөн бөгөөд Линаг бие давхар болохыг зөв оношилсон эмч доктор Жерерадо Лозадагийн нэрээр хүүгээ нэрлэжээ. Перугийн гарамгай эмч судлаачдын нэг доктор Эдмундо Эскомел уг хачирхалтай тохиолдлыг судалж үзээд, Линагийн аавынх нь ярьж байсан хугацаанаас ч эрт наймхан сартай байх үеэс нь сарын тэмдэг нь үзэгдэж эхэлснийг олж тогтоожээ. Түүнчлэн Эскомел эмч үзлэгхийсний дараа Лина охин насанд хүрсэн эмэгтэй шиг өндгөвчтэй байсан байна.

ХАМГИЙН ҮНЭТЭЙ ГАМБУРГЕР 175 АМ.ДОЛЛАР

Дэлхийн хамгийн үнэтэй гамбургерыг Америкийн Нью- Йорк хотод худалддаг байна. Манхеттены нэгэн ресторан үйлчлүүлэгчдээ нэг бүр нь 175 ам.долларын үнэтэй гамбургер санал болгож байна. Ресторан эзэн өөр хаана ч байхгүй үнэтэй гамбургер санал болгохдоо ашиг хонжоо олохыг хүсээгүй, харин үйлчлүүлэгчийг гайхшруулж, сэтгэл ханамжийн баталгаа гаргаж өгөхийг голчилж байгаа гэнэ. Гамбургерийг талхыг бэлтгэхдээ энэ ресторан тогооч Японы алдартай үхрийн махны амт оруулж, хар малтуу мөөг, фуагра, Швейцарь бяслаг, ойн мөөг зэргийг хачирт нь хийжээ. Гэхдээ хэрвээ та нэг бүр нь 175 ам.долларын үнэтэй гамбургер идэж халаасаа сэгсрэхийг хүсэхгүй байгаа бол дөрвөн долларын үнэтэй жирийн гамбургер ч идэж болох юм.

ДЭЛХИЙН ХАМГИЙН НАМХАН ХҮН

Дэлхийн хамгийн намхан хүн бол 20 настай Хятадын иргэн Хи Пингпин ажээ. Түүний өндөр нь 73 см бөгөөд түүний төрөлх нутаг нь Өвөр Монгол ажээ. Тэрээр эхээс мэндлэхдээ том хүний алганы хэмжээтэй адил байсан гэнэ. Хигийн эцэг эх нь ердийн өндөртэй. Тэрээр 2 эгчтэй бөгөөд бас ердийн өндөртэй, эгч нар нь бүгд хүнтэй гэрлэж тусдаа амьдардаг. Хи төрөлхийн ясны өвчтэй бөгөөд уг өвчин нь түүний өсөлтөнд нөлөөлснөөс болж тэрээр өсөхөө больсон байна. 2007 онд Хи дэлхийн амжилтын номд тэмдэглэгдэхээр хүсэлт гаргасан тул түүний өндрийг өглөө, өдөр, орой 3 удаа Өвөр Монголын мужийн эмнэлэгт хэмжсэнээр тэрээр амжилтын номд бүртгэгджээ. Хи 2005 онд дэлхийн хамгийн өндөр хүнээр бичигдэж байсан Өвөр Монголын малчин 56 настай Бао Сишунтай хамт Хятадын телевизийн шоу нэвтрүүлгээдээр олон удаа гарч байсан. Түүнээс хойш Бао Гиннесийн номд бүртгэгдсэн амжилтаа алдсан юм. Одоо дэлхийн хамгийн өндөр хүн бол 2.57 м өндөртэй Леонид Стадник ажээ. Мөн Хятадад дэлхийн хамгийн намхан хосууд байдаг. Эхнэр Чен Гуилан 0.7 м өндөр бол нөхөр Ли Тангеон нь 1.1 м өндөр. Хосууд 2007 оны 9 сарын 27-ны өдөр гэрлэжээ.

МОСКВА ХАМГИЙН ҮНЭТЭЙ ЗОЧИД БУУДАЛТАЙ

Москва хот дэлхийд хамгийн өртөг ихтэй зочид буудлуудтай хотын хувиар тэргүүлэх байр суурыа баталгаажууллаа гэж Британийн "Дейли телеграф" сонин дүн шинжилгээний "Хогг Робинсон групп" компаний судалгааг иш татан дугаартаа бичжээ. Энэ судалгаанаас үзвэл одоо Москвагийн зочид буудлын өрөөний дундаж өртөг 250 фунтээс багагүй /500 орчим доллар/ байна. Өнгөрсөн онд зочид буудлын салбарт үнэ бага зэрэг буюу дөрвөн хувиар өссөн хэдий ч Британийн нийслэл энэ жагсаалтын 10-дугаарт оржээ. Энд зочид буудлын өрөөний дундаж өртөг 154 фунт /300 доллар/ байна. Дэлхийн ажил хэргийн болон аялал жуулчлалын томоохон төв болох Нью-Йорк, Парис хот зочид буудлын өрөөний өртгийн үзүүлэлтээр Лондон хотын өмнө орж байгаа аж.

ТЭМДЭГЛЭЛ

ISBN 999293077-2